



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ө.ШИЖИР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.06.29 № АХТ/2326
танай _____-ны № _____-т

**Асуулгын хариу хүргүүлэх
тухай**

Танаас 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 30 дугаартай албан бичгээр Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу хүргүүлж байна.

Асуулга 1:

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль 2018 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 4 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Тус хуулийн хэрэгжилтэд хийсэн дор дурдсан үнэлгээг хавсаргав:

-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгаар 2023 онд “Мэргэжлийн социологичдын холбоо” төрийн бус байгууллагаар уг хуулийн хэрэгжилтэд хийлгэсэн үнэлгээ;

-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны захиалгаар 2026 онд “Монголын эрх зүйн судалгаа хөгжлийн дэвшил төв” төрийн бус байгууллагаар хийлгэсэн уг хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгаа.

Асуулга 2:

Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 2018-2023 онд төрийн захиргааны 7, 21 аймагт залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны 36, төрийн үйлчилгээний 2, нийт 70 албан хаагч ажиллаж байсан байна. Үүнд:

Залуучуудын хөгжил, оролцооны бодлогын асуудал 2018-2023 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд харьяалагдаж байх үед тус яамны Хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэст төрийн захиргааны 2 албан хаагч, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын “Залуучуудын хөгжлийн газар”-т төрийн захиргааны 7 албан хаагч, нийслэлийн Залуучуудын хөгжлийн хэлтэст төрийн захиргааны 6 албан хаагч, 21 аймаг, 9 дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэст тус бүр төрийн захиргааны 1 албан хаагч, улсын хэмжээнд төрийн захиргааны 45 албан хаагч залуучуудын асуудлыг хариуцан ажилласан;

000265007547

Мөн 15-34 насны хүн амд хөгжлийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий Залуучуудын хөгжлийн төв 32 байгуулагдаж, 21 аймаг, 9 дүүрэг, 2 суманд тус бүр төрийн үйлчилгээний 3 албан хаагч ажиллаж эхэлсэн. 2023 оноос Өмнөговь аймгийн бүх сум, Сүхбаатар, Сэлэнгэ, Баян-Өлгий, Ховд, Завхан аймаг тус бүрийн 1 суманд төвийг нэмж байгуулан, улсын хэмжээнд нийт 48 төвд төрийн үйлчилгээний 108 албан хаагч ажиллаж байсан;

“Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 352 дугаар тогтоолоор Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн Ажлын албыг 7 орон тоотойгоор байгуулж, “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны 441 дүгээр тогтоолоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бүтцэд “Залуучуудын хөгжлийн хэлтэс бөгөөд Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн Ажлын алба” байгуулагдан төрийн захиргааны 7 албан хаагчтай ажилласан байна.

Өнөөдрийн байдлаар Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Биений тамир, спорт, залуучуудын бодлого зохицуулалтын газарт төрийн захиргааны 6, 21 аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны тус бүр 2, улсын хэмжээнд нийт төрийн захиргааны 48 албан хаагч ажиллаж байна.

Асуулга 3:

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 2018-2026 оны улсын төсөвт нийт 8,937,954,700.0 төгрөг батлагдаж, 7,888,335,885.18 төгрөг зарцуулсан. Жил бүрийн батлагдсан төсөв болон зарцуулалтын талаар дараах дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлж байна:

-Залуучуудын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний багцад 2018 онд 1,177,096,700.0 төгрөг батлагдаж, үүнээс Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 430,988,400.0 төгрөг, 21 аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 520,887,000.0 төгрөг, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 225,209,700.0 төгрөг тус тус хуваарилагдсан байна. Нийт 1,177,085,100.0 төгрөг зарцуулсан.

-Залуучуудын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний багцад 2019 онд 746,096,700.0 төгрөг батлагдаж, үүнээс 21 аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 520,887,000.0 төгрөг, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 225,209,700.0 төгрөг тус тус хуваарилагдсан байна. Нийт 746,096,700.0 төгрөг зарцуулсан.

-Залуучуудын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний багцад 2020 онд 746,096,700.0 төгрөг батлагдаж, үүнээс 21 аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 520,887,000.0 төгрөг, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 225,209,700.0 төгрөг тус тус хуваарилагдсан байна. Нийт 746,096,700.0 төгрөг зарцуулсан.

-Залуучуудын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний багцад 2021 онд 746,096,700.0 төгрөг батлагдаж, үүнээс 21 аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын

хөгжлийн газарт 520,887,000.0 төгрөг, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 225,209,700.0 төгрөг тус тус хуваарилагдсан байна. Нийт 746,096,700.0 төгрөг зарцуулсан.

-Залуучуудын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний багцад 2022 онд 943,975,400.0 төгрөгийн төсөв батлагдаж, үүнээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 140,000,000.0 төгрөг, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 199,436,800.0 төгрөг, 21 аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 384,538,600.0 төгрөг, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 220,000,000.0 төгрөг тус тус хуваарилагдсан байна. Нийт 916,927,535.0 төгрөг зарцуулсан.

-Залуучуудын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний багцад 2023 онд 856,967,100.0 төгрөгийн төсөв батлагдаж, үүнээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 294,184,400.0, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 139,605,800.0, 21 аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 269,176,900.0, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 154,000,000.0 төгрөг тус тус хуваарилагдсан байна. Нийт 652,217,250.18 төгрөг зарцуулсан.

-Залуучуудын хөгжил, оролцооны бодлогын асуудал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд харьяалагдаж байсан 2024 оны улсын төсөвт нийт 1,261,091,700.0 төгрөг батлагдсанаас Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 223,700,000.0 төгрөг хуваарилагдсанаас 1,049,191,500.0 төгрөгийг зарцуулсан бол мөн оны сүүлийн хагаст Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудалд залуучуудын хөгжил, оролцооны бодлогын асуудал нь 942,755,300.0 төгрөгийн төсвийн хамт шилжиж, үүнээс 549,872,000.0 төгрөгийг зарцуулсан байна.

-Залуучуудын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний 2025 оны төсвийн багцад 943,799,900.0 төгрөг батлагдаж, 556,353,900.0 төгрөгийг залуучуудад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ур чадвар олгох "Гроу виз Гүүгл (Grow with Google)" хөтөлбөр, БНХАУ-ын Торгоны замын ирээдүй өсвөр үеийнхний соёлын солилцооны арга хэмжээ, залуу гэрэл зурагчдын анхдугаар уралдаан, Залуучуудын хөгжлийн үндэсний 10 дугаар чуулган, "Эерэг хандлага-идэвхтэй залуучууд" нөлөөллийн арга хэмжээ, манлайлал, инновац, энтрепренершип чадавх бэхжүүлэх арга хэмжээ, "Иргэний андгай өргөх ёслол"-ын үйл ажиллагаанд тус тус зарцуулсан байна.

-Залуучуудын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний багцад 2026 онд 546,648,500.0 төгрөг батлагдаж, 506,580,000.0 төгрөгийг Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийх, Сайн дурын ажлын үндэсний стандартын төсөл боловсруулах, 2 удаагийн хэлэлцүүлэг хийх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ур чадвар олгох хөтөлбөр болон "Оюутны дэвжээ наадам" үйл ажиллагааг зохион байгуулах болон бусад төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан байна.

Асуулга 4:

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан залуучуудын хөдөлмөр эрхлэлт, бизнес эрхлэлт, нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын 2025 оны улсын төсвийн залуучуудын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний багцад

943,799,900.0 төгрөг батлагдсанаас 556,353,900.0 төгрөгийг залуучуудад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ур чадвар олгох “Гроу виз Гүүгл (Grow with Google)” хөтөлбөр, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Залуу гэрэл зурагчдын анхдугаар уралдаан”, “Хятадын Сун Чин Лин” сантай хамтарсан “Нэг бүс ба Нэг зам”-ын дагуух орнуудын өсвөр үе, залуучуудын соёлын солилцооны хөтөлбөр, Залуучуудын хөгжлийн үндэсний 10 дугаар чуулган, “Монгол Улсын иргэний андгай өргөх ёслол”-ын үйл ажиллагаа, “Эерэг хандлага-идэвхтэй залуучууд” нийгмийн нөлөөллийн аян, Залуучуудын манлайлал, инновац, энтрепренершип чадавхыг бэхжүүлэх “Технологийн салбарын залуучуудын чуулган” зэрэг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан байна.

Мөн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас боловсруулсан “Залуучуудын хөгжлийг дэмжих стратеги 2025-2030”-ийг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны А/192 дугаар тушаалаар батлан, хэрэгжүүлэн ажиллаж байна. НҮБ-ын хүн амын сан болон дотоодын төрийн бус байгууллагуудтай хамтран 6 зөвлөгөөн, 39 удаагийн хэлэлцүүлэг, олон улсын 3 хөтөлбөрийг хэрэгжүүлж, зохион байгуулсан байна.

Асуулга 5:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.31-д заасан “Залуусын оролцоо хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Удирдамж, төлөвлөгөө батлах тухай” Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/243 дугаар тушаал батлагдаж, 2026-2028 оны хугацаанд гурван арга хэмжээг орон даяар хэрэгжүүлэхээр төлөвлөн, бэлтгэл ажлыг хангаж байна (Залуусын оролцоо хөтөлбөрийн удирдамж, төлөвлөгөөг хавсаргав).

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тусгуулан батлуулсан болно.

Хавсралт ¹⁷¹ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА




Б.ЭНХБАЯР



“ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ”

ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

II. ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ, ОРОЦООИД ЧИГЛЭСЭН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО



Тайлбар: мөнгөн дүн нь 2020 оны тоо болно



Захиалагч байгууллага: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Зөвлөх байгууллага: Мэргэжлийн социологичдын холбоо ТББ



АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт:	3
Графикийн жагсаалт:	3
Зургийн жагсаалт:	3
Товчилсон үгсийн жагсаалт:.....	4
УДИРТГАЛ.....	5
НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ АРГА ЗҮЙН ТАНИЛЦУУЛГА.....	6
1.1 ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫГ ТӨЛӨВЛӨХ.....	11
1.1.1 Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох:	11
1.1.2 Үнэлгээ хийх хүрээг тогтоох:	13
1.1.3 Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг тогтоох:	13
1.1.4 Харьцуулах хэлбэрийг сонгох:	32
1.1.5 Шалгуур үзүүлэлтийг томъёолох:	33
1.1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох:	33
1.2 ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ	34
1.2.1 Мэдээлэл цуглуулалтын ажлыг төлөвлөх:.....	34
1.2.2 Мэдээлэл цуглуулалт:	35
1.2.3 Мэдээллийн сан үүсгэх:	36
1.3 ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ.....	37
1.3.1. Цуглуулсан мэдээллийг үнэлэх:	37
ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН	38
2.1 ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТӨРӨӨС ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ	40
8-р зүйл. Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих:.....	40
9-р зүйл. Залуучуудын боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих	45
10-р зүйл. Залуучуудын эрүүл мэндийг хамгаалах	50
11-р зүйл.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	53
12-р зүйл. Аюулгүй амьдрах, хөгжих орчныг бүрдүүлэх.....	58
2.2 ГУРАВДУГААР БҮЛЭГ: ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦООГ ДЭМЖИХ	65
13-р зүйл. Нийгмийн хөгжилд залуучуудын оролцоог дэмжих.....	65
14-р зүйл.Залуучууд шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөл үзүүлэх.....	69
15-р зүйл. Сайн дурын ажилд оролцох оролцоог дэмжих.....	71
16-р зүйл. Хүмүүнлэгийн ажилд оролцох оролцоог дэмжих	75
2.3 ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТАЛААРХИ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ БҮРЭН ЭРХ, ЧИГ ҮҮРЭГ	77
17-р зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх.....	77



18-р зүйл. Засгийн газрын бүрэн эрх	79
19-р зүйл. Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг	81
20-р зүйл. Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг	83
21-р зүйл. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын чиг үүрэг	89
22-р зүйл. Залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөл	93
2.4 ТАВДУГААР БҮЛЭГ: ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН	96
23-р зүйл. Залуучуудын хөгжлийг дэмжих сан	96
ГУРАВ. ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	97
3.1 Хуулийн ололттой тал	97
3.2 Хуулийн хэрэгжилтийн хүндрэл бэрхшээл	98
3.3 Хуулийг боловсронгуй болгох зөвлөмж	99
3.4 Хуулийн хэрэгжилтийн үнэлгээний нэгтгэл	101



Хүснэгтийн жагсаалт:

Хүснэгт 1. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд заасан бүлэг, зүйлд заасан заалтууд,
тэдгээрт хамаарах шалгуур үзүүлэлт 15

Графикийн жагсаалт:

График 1. Залуучуудын Залуучуудын хөгжлийн төвийн талаарх мэдлэг	47
График 2. Залуучуудын ЗХТ-ийн үйл ажиллагаанд хамрагдалт	62
График 3. Залуучуудын чиглэлийн үйл ажиллагааг мэддэг байдал	63
График 4. Залуучуудын оролцоог дэмждэг байдал	73
График 5. Залуучуудын байгууллагын үйл ажиллагааг мэддэг байдал	91
График 6. Хуулийн хүрээнд төрөөс авч буй дэмжлэг	92

Зургийн жагсаалт:

Зураг 1. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний аналитик үйл ажиллагааны хүрээ (Analytical Framework)	7
Зураг 2. ЗХДТХ-ийн оролцогч талуудын харилцан хамаарал	8
Зураг 3. Судалгааны мэдээлэл цуглуулсан аргууд	8
Зураг 4. ЗХДТХ-ийн хэрэгжилтийн үнэлгээний үе шат, дараалал	9
Зураг 5. Залуучуудын хөгжлийг дэмжих үндсэн чиглэл	13
Зураг 6. Үнэлгээний хамрах хүрээ	13
Зураг 7. ЗХДТХ-ийн хэрэгжилтийн үнэлгээний мэдээлэл цуглуулалт	33
Зураг 8. Үнэлгээнд хамрагдах түүврийг тооцсон байдал	35
Зураг 9. Үнэлгээний түүвэр	36



Товчилсон үгсийн жагсаалт:

АМЧБО - Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох
АШУҮИС – Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
АТГ – Авлигатай тэмцэх газар
БШУЯ - Боловсрол шинжлэх ухааны яам
БХЯ - Батлан хамгаалах яам
БХБЯ – Барилга, хот байгуулалтын яам
БЗДХ – Бэлгийн замаар дамжих халдвар
ГБХЗХГ - Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газар
ДОХ – Дархлалын олдмол хомсдол
ЕБС – Ерөнхий боловсролын сургууль
НҮБ - Нэгдсэн үндэсний байгууллага
НҮБХХ - Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
НЭМҮТ – Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
НЭМГ – Нийгмийн эрүүл мэндийн газар
МСҮТ – Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
МҮХАҮТ – Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
ИНБ - Иргэний нийгмийн байгууллага
ИДС – Их, дээд сургууль
УИХ- Улсын Их хурал
ҮСХ – Үндэсний статистикийн хороо
ЗГ- Засгийн газар
ЗГХЭГ – Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗХТ – Залуучуудын хөгжлийн төв
ЗХДТХ - Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль
ХНХЯ - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХҮГ - Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ХЭДС - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХХК – Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОБЕГ – Онцгой байдлын ерөнхий газар
ОУХНЦ – Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор
СЭМҮТ – Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТББ – Төрийн бус байгууллага
ШУА – Шинжлэх ухааны академи
ЭМЯ - Эрүүл мэндийн яам
ЭМБ – Эрүүл мэндийн байгууллага



УДИРТГАЛ



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



[2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр]

“ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ”

ХНХЯ-ны захиалгаар “Мэргэжлийн социологичдын холбоо” ТББ-ын хийсэн “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ” нь хуулийн хэрэгжилтийг үнэлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэхэд шаардлагатай зөвлөмжийг боловсруулах зорилготойгоор хийгдлээ. Тус үнэлгээ нь хуулийн 2-5 дугаар бүлэг, 7-23 дугаар зүйлийг хамарч хийгдсэн бөгөөд заалт тус бүрийн хэрэгжилтийг үнэлснээрээ онцлогтой юм.

Судалгааны мэдээллийг тоон болон чанарын судалгааны аргаар Олон улсын Социологийн холбооны “Ёс зүйн стандарт кодекс”, “Гүнзгийрүүлсэн болон өгөгдлийн шинжилгээг багтаасан зах зээлийн, нийгмийн болон олон нийтийн санаа бодлын судалгаа”-ны (ISO 20252:2019) олон улсын стандартыг баримтлан цуглуулж, зохих аргачлалын дагуу өгөгдөлд боловсруулалт хийж тайлан, үр дүнг боловсрууллаа.

Тайлан дахь дүгнэлт, үр дүн нь судалгаанд оролцсон залуучууд, төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийн байр суурь, үнэлгээ болон судалгааны явцад цуглуулсан анхдагч болон хоёрдогч өгөгдөл, мэдээлэлд шууд үндэслэсэн болно. Судалгааны ажлыг гүйцэтгэх, мэдээлэл цуглуулах, аргазүйн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан ХНХЯ болон яамны холбогдох албан тушаалтнуудад талархал илэрхийлье!



НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ АРГА ЗҮЙН ТАНИЛЦУУЛГА

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний гол зорилго нь Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход оршино. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэхэд шаардлагатай зөвлөмжийг боловсруулах зорилтыг дэвшүүлсэн.

Үнэлгээ хийх ажлыг дараах үе шаттай хэрэгжүүлсэн.

1. Төлөвлөх
2. Хэрэгжүүлэх
3. Үнэлэх

Энэхүү үнэлгээ нь улс орны хөгжлийн дунд болон урт хугацааны бодлого, олон улсын төсөл хөтөлбөр, тусламжийн хүрээнд залуучуудын эрх, хөгжил, оролцоог дэмжих цаашдын бодлого, чиг хандлага, төлөвийг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл, нотолгоог бүрдүүлэхэд чиглэсэн.


Гүйцэтгэсэн ажлын хүрээнд

1. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 2018-2022 оны хэрэгжилтийн тайлан, бусад мэдээллийг нэгтгэх, танилцах, шинжлэх
2. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг анхан шатанд зохион байгуулж буй Залуучуудын хөгжлийн аймгийн 3, дүүргийн 4 төвийн үйл ажиллагаа, тулгамдсан асуудал, бэрхшээлтэй биечлэн танилцах, судалгаа хийх, шинжлэх
3. Залуучуудын иргэний нийгмийн байгууллагын 5 төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж хуулийн хэрэгжилтийн хүрээнд сайжруулах шаардлагатай асуудлууд, шийдлийн талаар хэлэлцэх
4. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт, бодит нөхцөл байдалтай танилцаж үнэлсэн тухай үнэлгээний тайлан тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, нөхцөл байдлыг сайжруулах тухай зөвлөмжийг боловсруулах зэрэг юм.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээний Аналитик үйл ажиллагааны хүрээ (Analytical Framework)-г дараах байдлаар тодорхойлсон (Зураг 1).




Зураг 1. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний аналитик үйл ажиллагааны хүрээ (Analytical Framework)





Энэ хуулийн зорилт нь төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг тогтоож, нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоо, эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Залуучуудын хөгжил оролцооны асуудлыг цогцоор шийдвэрлэх үүднээс Залуучуудын хөгжлийг дэмжих хуулийг 2017 онд баталж, 2018 оноос хэрэгжүүлж байна. Иймд хуулийн хэрэгжилт, үр дагаварт хийх үнэлгээ нь залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр ҮҮРЭГ ХҮЛЭЭГЧ, залуучуудын хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлсэн бодлогын үр ашиг хүртэгч, ЭРХ АГУУЛАГЧ хоорондын харилцан хамаарал, тэдгээрийн харилцан үйлчлэлийн үр дагаврыг тодорхойлоход чиглэгдэнэ. (Зураг 1).


Зураг 2. ЗХДТХ-ийн оролцогч талуудын харилцан хамаарал



Судалгааны мэдээлэл цуглуулсан аргууд:

1. Баримт бичгийн шинжилгээний арга
2. Анкетын судалгааны арга
3. Фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын арга
4. Ажиглалтын арга

Зураг 3. Судалгааны мэдээлэл цуглуулсан аргууд






Энэхүү судалгааны мэдээллийг чанарын болон тоон судалгааны аргыг хослуулан цуглуулах нь илүү үнэн бодитой мэдээллийн бааз үүсэх боломжийг нэмэгдүүлнэ. Анкетын судалгааны аргаар хуульд заасан зорилтот бүлгийн тулгамдсан асуудал, уг хуулийн үйлчлэл, нөлөөлөл, үр дүнг шинжлэн тодорхойлох, ганцаарчилсан ярилцлагыг хуулийг хэрэгжүүлэгч анхан шатны байгууллагын ажилтнуудын дунд хийсэн бөгөөд судалгааны зорилтот чиглэсэн түлхүүр асуултуудаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийсэн нь үр дүнтэй болсон. Мөн ажиглалтын аргыг хавсарга байдлаар хэрэглэсэн. Судалгааны боловсруулалтыг SPSS Statistics 23 программ дээр нэгтгэж, харьцуулах, корреляци, жигнэсэн дундаж бодох замаар холбоо хамаарал, хүчин зүйлсийн нөлөөллийг тодорхойлж, судалгааны тайлан, зөвлөмжийг боловсрууллаа.

Залуучуудын хөгжлийг дэмжих хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний хүрээг тогтоох ажиллагааг “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.3-т заасны дагуу хийсэн бөгөөд хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад илэрсэн зөрчилдөөнтэй, хэрэгжилтийн явцад сөрөг үр дагавар бий болсон, хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл үүсгэж буй, хуулийн зорилтыг хангах үүргээ биелүүлэхгүй байгаа зохицуулалтыг агуулгын хувьд тодорхойлохыг зорьж ажилласан.

Зураг 4. ЗХДТХ-ийн хэрэгжилтийн үнэлгээний үе шат, дараалал





Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний ажлыг хийхдээ дараах баримт бичгийг удирдлага болгон ажилласан. Үүнд:

1. ХНХЯ-ны төрийн нарийн бичгийн даргын баталсан “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зөвлөхийн ажлын даалгавар”;
2. Засгийн 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал";
3. Засгийн 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлал";
4. "Гүнзгийрүүлсэн болон өгөгдлийн шинжилгээг багтаасан зах зээлийн, олон нийтийн санаа бодол болон нийгмийн судалгаа" — “Нэр томъёоны тайлбар болон үйлчилгээнд тавигдах шаардлага" олон улсын стандарт ISO 20252:2019 (Market, opinion and social research, including insights and data analytics);
5. Олон улсын социологийн холбооны ёс зүйн код;



1.1 ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫГ ТӨЛӨВЛӨХ

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлын төлөвлөх үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн:

- 1.1. үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- 1.2. үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- 1.3. шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- 1.4. харьцуулах хэлбэрийг сонгох;
- 1.5. шалгуур үзүүлэлтийг томъёолох;
- 1.6. мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1.1 Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох:

Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг тогтоож, нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоо, эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилго¹ бүхий Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр УИХ-аар баталсан.

Хууль тогтоомжийн тухай Монгол Улсын хуулийн 51.3-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан бөгөөд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг 6 дахь жилдээ дагаж мөрдөж байна. Иймд уг хуулийн 24.2 дугаар зүйлд заасны дагуу Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийх цаг хугацаа нь болсон.

Хууль тогтоомжийн тухай Монгол Улсын хуулийн 51.3-д заасны дагуу энэхүү хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний аргачлал дараах агуулгыг хамаарсан:

- 51.1.1. хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах;
- 51.1.2. хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлох;
- 51.1.3. зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хийсэн.

Түүнчлэн Залуучуудын хөгжлийг дэмжих хуулийн хэрэгжилтийг дэмжих хүрээнд Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг 2019-2022 онд хэрэгжүүлэхээр баталж, залуучуудын эрүүл мэнд,

¹ Залуучууд хөгжлийг дэмжих Монгол улсын хууль 2017, 1-р зүйл



боловсролын чанарыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн оролцоо, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх зэрэг үндсэн таван зорилтыг агуулсан.

Хөтөлбөр нь 2019-2021 онд 70.8-90 хувиар хэрэгжиж, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх хүрээнд Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүйд тооцсон.

Цаашид аймаг, орон нутгийн зарим сумдад Залуучуудын хөгжлийн төвийг шинээр нэмж байгуулах, төвүүдээр үзүүлэх үйлчилгээг цахимжуулах, цахим сургалт, мэдээллийн цэгийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон нутагт байгуулах зэргээр залуучуудын хөгжил, оролцоог дэмжих арга хэмжээ, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх агуулга, хэлбэрийг залуучуудын эрэлт хэрэгцээтэй уялдуулан шинэчлэн баяжуулахаар ажиллаж байна.

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд ХНХЯ-ны зүгээс дараах судалгаа шинжилгээг мэргэжлийн байгууллага, судлаач, эрдэмтэн, багш нартай хамтран гүйцэтгэж, дүгнэлт, зөвлөмжийг залуучуудын хөгжлийг дэмжих бодлого, чиглэл, төлөвлөлтөд тусгаж ажиллажээ.

- Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээ ажиллагааны нэгж зардлыг тооцох турших, НҮБХАС-ийн Монгол улсад хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлт, Засгийн газрын төсвийн залуучуудад зориулсан хувь хэмжээг тодорхойлох шинжилгээний тайлан - 2022 он
- Залуучуудын хөгжлийг дэмжих нийтлэг үйлчилгээний стандартыг НҮБХАС, ШУТИС-тай хамтран хийсэн судалгааны тайлан - 2020 он
- Залуучуудын хөгжлийн төвийн ажлын байрны чиг үүргийн шинжилгээг НҮБХАС, ШУТИС-тай хамтран хийсэн судалгааны тайлан - 2020 он
- НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүн амын сангийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсад тогтвортой хөгжлийн санхүүжилтийн нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд “Залуучуудад чиглэсэн зарлагын шинжилгээ”-ний тайлан - 2020 он
- Залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, нас сэтгэхүй, бие бялдар, түүх соёлын хөгжлийг тодорхойлох Монгол улсын засгийн газрын захиалгат төслийг Шинжлэх ухаан, технологийн сан МУИС-тай хамтран хийсэн судалгааны тайлан - 2021 он

Цаашид залуучуудын эрх, хөгжил оролцоог дэмжих бодлого, арга хэмжээний төсөвлөлт, төлөвлөлт, хүний нөөцийн хуваарилалт, хуулийн хэрэгжилтийн хүрээн дэх арга хэмжээ, үйлчилгээний стандарт шаардлага хангалт зэргийг цогцоор нь авч үзэх, мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг, тус хуулийн 24.2.Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу энэ хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийнэ гэж заасны дагуу тус хуулийн 2018-2023 оны хэрэгжилтийг үнэлэх хэрэгцээ нь энэхүү үнэлгээг хийх үндэслэл шаардлага болж байна.



1.1.2 Үнэлгээ хийх хүрээг тогтоох:


Монгол Улсын Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн (ЗХДтХ) хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний хүрээг агуулгын хувьд уг хуулийн II-IV дүгээр бүлгийн 7-22 дугаар заалтуудын хүрээнд авч үзсэн.

Зураг 5. Залуучуудын хөгжлийг дэмжих үндсэн чиглэл



Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний хүрээг цаг хугацааны хувьд хууль батлагдаж, хэрэгжиж эхлэхийн өмнөх суурь үе буюу 2018 оноос 2023 он хүртэлх 5 жилийн хугацааны динамик мэдээллийг хамруулан авч үзэх бөгөөд судалгаа, статистик тоо мэдээллийн бэлэн байдлаас шалтгаалан үзүүлэлт тус бүрийн мэдээллийн цаг хугацааны хамрах хүрээ харилцан адилгүй байж болно.

Зураг 6. Үнэлгээний хамрах хүрээ



1.1.3 Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг тогтоох:

Үнэлгээ хийхээр сонгосон хуулийн дээр дурдсан зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг бодитоор илэрхийлж тогтоох боломжтой үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар хийхээр сонгож тогтлоо. Үүнд:

- Зорилгод хүрсэн түвшин
- Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
- Практикт нийцэж байгаа байдал



Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл, хуулийн зохицуулалтын хийдэл байгаа эсэхийг практикт нийцэж байгаа шалгуур үзүүлэлтээр тодорхойлсон.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд нь уг үнэлгээний зорилгын дагуу дараах зүйлсийг тодруулахад чиглэгдсэн. Үүнд:

- 1) Хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах;
- 2) Гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг тодорхойлох;
- 3) Нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх;
- 4) Цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний хүрээнд хийгдэх тус хуульд заасан, 15-34 насны залуучуудын эрх, хөгжил, хамгаалал, оролцоог хувь хүний хөгжил, боловсрол, соёл урлаг, спорт, шинжлэх ухаан, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй амьдрах, хөгжих орчин зэрэг үндсэн 5 чиглэлээр Залуучуудын хөгжлийг дэмжих хуулийн хэрэгжилтийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг агуулгын хувьд дараах байдлаар тодорхойлов.



Хүснэгт 1. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд заасан бүлэг, зүйлд заасан заалтууд, тэдгээрт хамаарах шалгуур үзүүлэлт

Зүйл	Заалт	Шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх үүсвэр
ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРӨӨС ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ			
8-р зүйл. Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих	8.1.Залуучуудын хувь хүний хөгжлийг дараах чиглэлээр дэмжинэ: 8.1.1.ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн боловсролын төв, багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хичээлийн агуулгыг тусгах;	-Ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн боловсролын төв, багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хичээлийн агуулгыг тусгагдсан байдал	ХНХЯ, БШУЯ -Тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.2-т заасан хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, түүнийг баталсан тушаал;
	8.1.2.залуучуудад зориулан хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих;	-Дэмжсэн сургалтын тоо	-Залуучуудын хөгжлийн төв, Насан туршийн боловсролын төвүүдийн тайлан -Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2020 оны жилийн эцсийн биелэлтийн тайлан -Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 2021 оны биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан
	8.1.3.түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие дааж амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд чиглэсэн амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хөтөлбөрийн дагуу цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны залуучуудыг хамруулах;	-Цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан 18-27 насны залуучуудын тоо	
	8.1.4.залуучуудын гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа, уламжлал, зан заншлын тухай утга зохиол, уран сайхны бүтээлийг дэмжих;	-Дэмжсэн утга зохиол, уран сайхны бүтээлийн тоо	-Засгийн газар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын, хөтөлбөрийг зохицуулсан журмын хэрэгжилт -“Утга зохиол, уран сайхны бүтээл шалгаруулах журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/129 дүгээр тушаал түүний хэрэгжилт
	8.1.5.залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт тусгах; 8.1.6.энэ хуулийн 8.1.5-д заасан агуулга, хөтөлбөрийг зохицуулсан журмыг Засгийн газар батална.	-Залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөр хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт туссан байдал	
	8.2.Энэ хуулийн 8.1.1-д заасан хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	-Баталсан эсэх	БШУЯ



	<p>8.3.Энэ хуулийн 8.1.3-т заасан цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны эмэгтэйчүүд сайн дурын үндсэн дээр хамрагдаж болно.</p> <p>8.4.Энэ хуулийн 8.1.3 дахь заалт, 8.3 дахь хэсэгт заасан залуучуудад цэргийн мэргэжил олгох журмыг Засгийн газар батална.</p>	<p>-Цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан 18-27 насны эмэгтэйчүүдийн тоо -Баталсан эсэх</p>	<p>БХЯ Батлан хамгаалах яамны цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан 18-27 насны залуучуудын тоо (2018-2022 он байдлаар); -Сайн дурын үндсэн дээр цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан 18-27 насны эмэгтэйчүүдийн тоо (2018-2022 он байдлаар)</p>
	<p>8.5.Энэ хуулийн 8.1.4-т заасан бүтээлийг сонгон шалгаруулах журмыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.</p>	<p>-Баталсан эсэх</p>	<p>ХНХЯ -Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2020 оны жилийн эцсийн биелэлтийн тайлан -Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 2021 оны биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга</p>
	<p>8.6.Энэ хуулийн 8.5-т заасан журмын дагуу шалгаруулсан бүтээлийг Залуучуудын хөгжлийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.</p>	<p>-Шалгаруулсан бүтээлийг санхүүжилтийн дүн</p>	<p>ХНХЯ -Тус хуулийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.5-д заасан бүтээлийг сонгон шалгаруулах журам, түүнийг баталсан тушаал; - Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж, залуучуудын хөгжлийг дэмжих сангаас санхүүжүүлсэн он оны тайлан;</p>



Зүйл	Заалт	Шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх үүсвэр
<p>9-р зүйл. Залуучуудын боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих</p>	<p>9.1.Залуучуудын хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй, чанартай боловсрол эзэмшүүлэхийг дараах чиглэлээр дэмжинэ: 9.1.1.үндэстний цөөнх, шилжин суурьшигч, зорилтот бүлгийн залуучуудын боловсролын хэрэгцээнд суурилсан сургалтыг насан туршийн боловсролын хөтөлбөрийн дагуу эзэмшүүлэх;</p>	<p>-Зорилтот бүлгийн насан туршийн боловсролын хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдсан суралцагсдын тоо, үр дүн</p>	<p>-Залуучуудын хөгжлийн төвүүдийн тайлан, жил бүрээр, нэгдсэн тайлан Тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т заасны дагуу залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлсэн, цэргийн насны залуучуудын цэргийн алба хаах хүсэл, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээний 2017 оноос хойших тайлан;</p>
	<p>9.1.2.залуучуудыг эх орондоо болон гадаад улсад мэргэжил эзэмших, мэргэших боломжийг бүрдүүлэх;</p>	<p>-Мэргэжил эзэмших, мэргэших боломжийг бүрдүүлсэн байдал</p>	
	<p>9.1.3.номын сангийн үйлчилгээг залуучуудад хүртээмжтэй болгох арга хэмжээ авч, цахим номын сан хөтөлбөрийг хэрэгжүүлэх;</p>	<p>-Цахим номын сангийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэсэн байдал</p>	
	<p>9.1.4.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь хугацаат цэргийн алба хаасан, цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан суралцагчийн амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийн багц цагийг нөхөн тооцох;</p>	<p>-Амьдрах ухааны сургалтад хөтөлбөрийн багц цагийг нөхөн тооцсон байдал</p>	<p>Тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.3-т заасан багц цаг нөхөн тооцох журам, түүнийг баталсан тушаал;</p>
	<p>9.1.5.энэ хуулийн 8.1.3 дахь заалт, 8.3 дахь хэсэгт заасан цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан, их, дээд сургуульд элсэн суралцах болзол хангасан залуучуудыг Боловсролын зээлийн сангаас олгох оюутны хөгжлийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулах.</p>	<p>-Цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан, Боловсролын зээлийн сангийн оюутны хөгжлийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамрагдсан суралцагчдын тоо</p>	<p>Тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5-т заасны дагуу Боловсролын зээлийн сангаас олгох оюутны хөгжлийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулсан дээрх хуулийн 8.1.3 дахь заалт, 8.3 дахь хэсэгт заасан цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан, их, дээд сургуульд элсэн суралцах болзол хангасан залуучуудын тоо (2018-2021 он байдлаар);</p>
	<p>9.2.Энэ хуулийн 9.1.1, 9.1.2, 9.1.3-т заасан хөтөлбөрийг залуучуудын болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлнэ.</p>	<p>-ХНХЯ, БШУЯ-ны хамтран хэрэгжүүлсэн ажлын тоо</p>	<p>ХНХЯ, БШУЯ-ны хамтран хэрэгжүүлсэн ажлын тайлан</p>
	<p>9.3.Энэ хуулийн 9.1.4-т заасан багц цаг нөхөн тооцох журмыг боловсролын болон батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.</p>	<p>-БШУЯ болон БХЯ журмыг баталсан эсэх</p>	<p>БШУЯ болон БХЯ-ны хамтран баталсан журам</p>
	<p>9.4.Залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, нас, сэтгэхүй, бие бялдар, түүх соёлын хөгжлийг судлахад чиглэсэн залуучууд судлалыг хөгжүүлнэ. 9.5.энэ хуулийн 9.4-т заасан арга хэмжээг Шинжлэх ухааны академи хэрэгжүүлж, Засгийн газарт тайлагнана.</p>	<p>-Залуучууд судлалын чиглэлээр хийсэн ажил, зохион байгуулсан арга хэмжээний жагсаалт, тоо, гарсан үр дүн -ЗГ-т тайлагнасан байдал</p>	<p>Шинжлэх Ухааны Академийн залуучууд судлалын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, ЗГ-т тайлагнасан мэдээ, мэдээлэл</p>
<p>9.6.Залуучуудыг соёл, урлаг, шинжлэх ухааны шинэ бүтээл туурвихыг дэмжинэ.</p>	<p>Дэмжсэн шинэ бүтээлийн тоо</p>	<p>ХНХЯ-ны хэрэгжүүлсэн ажлын тайлан;</p>	



	9.7.Шинжлэх ухаан, өндөр технологи, инновац, шинжилгээ, судалгааны чиглэлээр үндэсний тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Хэрэгжүүлсэн үндэсний тэтгэлэгт хөтөлбөрийн тоо, үр дүн	ХНХЯ-ны хэрэгжүүлсэн ажлын тайлан;
	9.8.Энэ хуулийн 9.6, 9.7-д заасан үйл ажиллагааг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж, Залуучуудын хөгжлийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.	Санхүүжилтийн хэмжээ	ХНХЯ-ны хэрэгжүүлсэн ажлын тайлан;



Зүйл	Заалт	Шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх үүсвэр
<p>10-р зүйл. Залуучуудын эрүүл мэндийг хамгаалах</p>	<p>10.1.Хорт зуршил, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл дадал, хэвшилтэй иргэн болж төлөвшүүлэх зорилгоор залуучуудын эрүүл мэндийг дараахь чиглэлээр дэмжинэ:</p> <p>10.1.1.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагын суралцагчийг харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах ажлыг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран зохион байгуулах;</p>	<p>-Энэ чиглэлээр ЭМЯ, БШУЯ, ХНХЯ-ны хамтран зохион байгуулсан ажлын тоо</p>	<p>ЭМЯ, БШУЯ, ХНХЯ Суралцагчийг харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан он оны тайлан;</p>
	<p>10.1.2.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь оюутан, суралцагчийг эрүүл мэндийн даатгалд хамруулах;</p>	<p>-ЭМД-д хамрагдсан болон хамрагдаагүй оюутан, суралцагчийн тоо</p>	<p>ЭМЯ, БШУЯ-ны оюутнуудын ЭМД-д хамрагдалтын судалгаа, тайлан;</p>
	<p>10.1.3.өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, цахим эрүүл мэндийн үйлчилгээг нэвтрүүлэх;</p>	<p>-Цахим эрүүл мэндийн үйлчилгээг нэвтрүүлсэн байдал</p>	<p>ЭМЯ-ны тус хуулийн 10.1.3-д заасан арга хэмжээг хэрэгжүүлсэн он оны тайлан;</p>
	<p>10.1.4.залуучуудад гэр бүл төлөвлөлт, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг боловсрол, эрүүл мэнд болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран зохион байгуулах;</p>	<p>-Энэ чиглэлээр ЭМЯ, БШУЯ, ХНХЯ-ны хамтран зохион байгуулсан ажлын тоо</p>	<p>ЭМЯ, БШУЯ, ХНХЯ Тус хуулийн 10.1.4-т заасан залуучуудад гэр бүл төлөвлөлт, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан он оны тайлан;</p>
	<p>10.1.5.зорилтот бүлгийн залуучуудад чиглэсэн биеийн тамир, спорт, сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх;</p>	<p>-Үйлчилгээ тус бүрд хамрагдсан зорилтот бүлгийн залуучуудын тоо</p>	<p>ЭМЯ-ны тус хуулийн 10.1.5-д заасан арга хэмжээг хэрэгжүүлсэн он оны тайлан;</p>
	<p>10.1.6.олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт залуучуудад архи, тамхи, мансууруулах бодисын хор уршгийг ойлгуулах, эрүүл, зөв амьдралын хэвшлийг төлөвшүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ тусгах, хэрэгжилтийг зохион байгуулах.</p>	<p>-Тусгасан болон зохион байгуулсан арга хэмжээ, үйл ажиллагааны тоо, хамрагдсан залуучуудын тоо, зарцуулсан санхүүжилтийн хэмжээ</p>	<p>ЭМЯ-ны тус хуулийн 10.1.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлсэн он оны тайлан;</p>
	<p>10.2.Энэ хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3, 10.1.5, 10.1.6-д заасан арга хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.</p>	<p>-Хэрэгжүүлсэн байдал</p>	<p>ЭМЯ-ны тус хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3, 10.1.5, 10.1.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлсэн он оны тайлан;</p>



Зүйл	Заалт	Шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх үүсвэр
<p>11-р зүйл. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих</p>	<p>11.1.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дараах чиглэлээр дэмжинэ:</p> <p>11.1.1.оюутан, залуучуудыг ажилд зуучилсан хөдөлмөрийн биржийг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх асуудлыг хөдөлмөрийн болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран хэрэгжүүлэх;</p>	<p>-Дэмжсэн хөдөлмөрийн биржийн тоо -Ажилд зуучилсан оюутан залуучуудын тоо</p>	<p>-ХХҮЕГ-ын тус хуулийн 11.1.1-д заасан үйл ажиллагааг зохион байгуулсан он оны тайлан;</p>
	<p>11.1.2.залуучуудыг хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэхийг дэмжих;</p>	<p>-Хэлбэр тус бүрээр дэмжсэн арга хэмжээний тоо, цар хүрээ, үр дүн -Хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхэлж буй залуучуудын тоо</p>	<p>-ХНХЯ-ны тус хуулийн 11.1.2-д заасан үйл ажиллагааг зохион байгуулсан он оны тайлан;</p>
	<p>11.1.3.гадаад улсын тэргүүн туршлага, өндөр технологи, шинэ санааг үндэсний технологи болгон нутагшуулах, гарааны компани эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх;</p>	<p>-Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо</p>	<p>-ХНХЯ-ны тус хуулийн 11.1.3-д заасан үйл ажиллагааг зохион байгуулсан он оны тайлан;</p>
	<p>11.1.4.хөдөлмөрийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран малчин залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;</p>	<p>-Малчин залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагаануудын тоо</p>	<p>-ХНХЯ болон ХХААХҮЯ-ны тус хуулийн 11.1.4-д заасан үйл ажиллагааг зохион байгуулсан он оны тайлан;</p>
	<p>11.1.5.гадаад улсад өндөр технологи, нарийн мэргэжил, ур чадвар эзэмшсэн залуучуудыг эх орондоо ажиллахыг дэмжих хөтөлбөрийг гадаад харилцааны болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлэх;</p>	<p>-Гадаад улсад өндөр технологи, нарийн мэргэжил, ур чадвар эзэмшсэн залуучуудыг эх орондоо ажиллахыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлсэн эсэх, хөтөлбөрт хамрагдсан залуучуудын тоо</p>	<p>-ГХЯ-ны тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5-д заасны дагуу гадаад улсад өндөр технологи, нарийн мэргэжил, ур чадвар эзэмшсэн залуучуудыг эх орондоо ажиллахыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлсэн тайлан;</p>
	<p>11.1.6.мэргэжлийн ур чадвараа сайжруулах, шинэ мэргэжил эзэмших сургалтад ажилгүй залуучуудыг хамруулах;</p>	<p>-Шинэ мэргэжил эзэмших сургалтад ажилгүй залуучуудыг хамруулсан байдал, тоо, үр дүн, зарцуулсан санхүүжилтийн хэмжээ</p>	<p>-ХНХЯ-ны тус хуулийн 11.1.6-д заасан үйл ажиллагааг зохион байгуулсан он оны тайлан;</p>
	<p>11.1.7.орон нутгийн захиалгат ажлын байранд ажиллахаар очсон залуучуудыг дэмжих;</p>	<p>-Орон нутгийн захиалгат ажлын байранд ажиллахаар очсон залуучуудын тоо -Дэмжлэгийн хэмжээ, дэмжлэгт хамрагдсан залуучуудын тоо</p>	<p>-ХНХЯ-ны тус хуулийн 11.1.7-д заасан үйл ажиллагааг зохион байгуулсан он оны тайлан;</p>



	11.1.8.ажил олоход хүндрэлтэй болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгссөн төгсөгчдийг дадлагажуулан байнгын ажлын байраар хангасан ажил олгогчийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжих;	-ХЭДС-ийн дэмжлэгийн хэмжээ, санхүүжилт	-ХНХЯ-ны тус хуулийн 11.1.8-д заасан үйл ажиллагааг зохион байгуулсан он оны тайлан;
	11.1.9.хувийн хэвшлийн байгууллага /100 ба түүнээс дээш ажилтантай/ нийт ажилтнуудын 5 хувьтай тэнцэхүйц оюутны цагийн ажлын орон тоо гаргах;	-Хувийн хэвшлийн байгууллагад цагийн ажил хийж буй оюутнуудын тоо -Нийт ажилтнуудын 5 хувьтай тэнцэхүйц оюутны цагийн ажлын орон тоо гаргасан хувийн хэвшлийн тоо	-ХНХЯ-ны энэ хуулийн 11.1.9-т заасан цагаар хөдөлмөр эрхлэх Засгийн газрын журам түүний биелэлтийн тайлан
	11.1.10.энэ хуулийн 6.1.3, 6.1.4, 8.1.3 дахь заалт, 8.3 дахь хэсэгт заасан үйл ажиллагаанд хамрагдаж, төрийн албанд орох сонгон шалгаруулалтад тэнцсэн залуучуудыг төрийн албанд ажиллахад давуу тал болгон тооцох.	-Төрийн албанд ажилд орсон залуучуудын тоо, заалт бүрээр	-ХНХЯ-ны энэ хуулийн 11.1.10-д заасан үйл ажиллагааг зохион байгуулсан он оны тайлан;
	11.2.Энэ хуулийн 11.1.2, 11.1.3, 11.1.6, 11.1.7, 11.1.8, 11.1.9-г заасан арга хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.	-Хэрэгжүүлсэн байдал	-ХНХЯ
	11.3.Энэ хуулийн 11.1.9-г заасан цагаар хөдөлмөр эрхлэх журмыг Засгийн газар батална.	-Баталсан эсэх	-ЗГ
Зүйл	Заалт	Шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх үүсвэр
12-р зүйл. Аюулгүй амьдрах, хөгжих орчныг бүрдүүлэх	12.1.Залуучуудын аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг дараах чиглэлээр дэмжинэ: 12.1.1.орлоготой нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлөөр орон сууц худалдаж авах, түрээслэх, зорилтот бүлгийн залуучууд, залуу гэр бүлийг орон сууцжуулах хөтөлбөрийг залуучуудын болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлэх;	-Орлоготой нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлөөр орон сууц худалдаж авах, түрээслэх, зорилтот бүлгийн залуучууд, залуу гэр бүлийг орон сууцжуулах хөтөлбөрт хамрагдсан зорилтот бүлгийн залуучуудын тоо, зарцуулсан санхүүжилтийн хэмжээ	ХНХЯ, БХБЯ-ны тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-г заасан орлоготой нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлөөр орон сууц худалдаж авах, түрээслэх, зорилтот бүлгийн залуучууд, залуу гэр бүлийг орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлсэн он оны тайлан;
	12.1.2.залуучуудыг гэмт хэрэгт татагдан орохоос урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгмийн оролцоотой зохион байгуулах;	-Хэвлэлийн мэдээллийн байгууллагатай хамтран зохион байгуулсан ажлын тоо -Иргэний нийгмийн оролцоотой зохион байгуулсан ажлын тоо	ХНХЯ, ХЗДХЯ, бүх шатны ЗДТГ, иргэний нийгмийн байгууллагын хэрэгжүүлсэн байдлын тайлан



	<p>12.1.3. хорих болон засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож байгаа залуучуудад зориулсан сэтгэл заслын үйлчилгээ, соёл, спорт, хүмүүжлийн арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотой зохион байгуулах;</p>	<p>-Хорих болон засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож байгаа залуучуудад зориулсан сэтгэл заслын үйлчилгээ, соёл, спорт, хүмүүжлийн арга хэмжээний хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлуудын тоо, хамрагдсан залуучуудын тоо, зарцуулсан санхүүжилтийн хэмжээ</p>	<p>ХНХЯ, ХЗДХЯ, бүх шатны ЗДТГ, иргэний нийгмийн байгууллагын хэрэгжүүлсэн байдлын тайлан</p>
	<p>12.1.4.гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлсэн залуучуудад боловсрол, мэргэжил олгох, хорих ангиас суллагдах үед ажлын байраар хангах талаар төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн гаргасан санаачилгыг дэмжих;</p>	<p>-Гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлж буй залуучуудад боловсрол, мэргэжил олгосон байдал -Хорих ангиас суллагдаад ажлын байраар хангагдсан залуучуудын тоо</p>	<p>ХНХЯ, ХЗДХЯ, бүх шатны ЗДТГ, иргэний нийгмийн байгууллагын хэрэгжүүлсэн байдлын тайлан</p>
	<p>12.1.5.хөдөө, орон нутгийн бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулж, үр бүтээлтэй ажиллаж, амьдарч байгаа залуучуудыг дэмжих, алдаршуулах.</p>	<p>-Дэмжсэн залуучуудын тоо -Алдаршуулсан залуучуудын тоо</p>	<p>ХНХЯ, ХЗДХЯ, бүх шатны ЗДТГ, иргэний нийгмийн байгууллагын хэрэгжүүлсэн байдлын тайлан</p>
	<p>12.2.Энэ хуулийн 12.1.2, 12.1.3, 12.1.4, 12.1.5-д заасан үйл ажиллагааг залуучуудын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ.</p>	<p>-</p>	<p>-</p>
	<p>12.3.Залуучуудын өөрийгөө хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг дараах чиглэлээр дэмжинэ: 12.3.1.залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн, соёл, урлаг, биеийн тамир, спортын цогцолбор, хөгжлийн төв, цэцэрлэгт хүрээлэн, дэд бүтцийг шинээр барьж байгуулах, өргөтгөх төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх;</p>	<p>-Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн шинээр барьж байгуулсан соёл, урлаг, биеийн тамир, спортын цогцолбор, хөгжлийн төв, цэцэрлэгт хүрээлэнгүүдийн жагсаалт, залуучуудын сэтгэл ханамжийн үнэлгээ</p>	<p>-Залуучуудын хөгжлийн төвүүдийн тайлан, жил бүрээр, нэгдсэн тайлан -Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2020 оны жилийн эцсийн биелэлтийн тайлан</p>



	<p>12.3.2.залуучуудын авьяас чадвар, бие бялдар, сэтгэхүйг хөгжүүлэхэд шашин болон улс төрөөс ангид урлаг, соёл, спортын арга хэмжээнд залуучууд оролцох, эдгээр арга хэмжээг зохион байгуулсан хуулийн этгээдийг дэмжих;</p>	<p>-Урлаг, соёл, спортын арга хэмжээнд оролцсон залуучуудын тоо -Урлаг, соёл, спортын арга хэмжээ зохион байгуулж дэмжлэг авсан хуулийн этгээдийн тоо</p>	<p>-Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 2021 оны биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга -Энэ хуулийн 12.3.1, 12.3.2, 12.3.3, 12.3.4, 12.3.5-д заасан үйл ажиллагааг бүх шатны Засаг дарга нар хэрэгжүүлсэн байдлын тайлан</p>
	<p>12.3.3.түүх, соёлын өвийг хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ардын урлаг, ёс заншил, уламжлалт зан үйлийг хөгжүүлэхэд залуучуудын оролцоог хангах;</p>	<p>-Уламжлалт зан үйлийг хөгжүүлэхэд оролцсон залуучуудын тоо -Залуучуудын оролцоог хангасан байдал</p>	
	<p>12.3.4.залуучуудын дунд гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэх, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөглөх, сурталчлах үйл ажиллагааг дэмжих;</p>	<p>-Энэ чиглэлийн үйл ажиллагаанд хамрагдсан залуучуудын тоо -Энэ чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, дэмжлэгийн тоо</p>	
	<p>12.3.5.байгаль орчныг хамгаалах, ардын зан үйлийг сурталчлах, төлөвшүүлэх санаачилгыг дэмжих.</p>	<p>-Энэ чиглэлээр хэрэгжүүлсэн санаачилга, дэмжлэгийн тоо</p>	
	<p>12.4.Энэ хуулийн 12.3.1, 12.3.2, 12.3.3, 12.3.4, 12.3.5-д заасан үйл ажиллагааг бүх шатны Засаг дарга нар хэрэгжүүлнэ.</p>	<p>-Хэрэгжүүлсэн эсэх</p>	



Зүйл	Заалт	Шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх үүсвэр
ГУРАВДУГААР БҮЛЭГ ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦООГ ДЭМЖИХ			
13-р зүйл. Нийгмийн хөгжилд залуучуудын оролцоог дэмжих	13.1.Төрөөс залуучуудын оролцоог дараах чиглэлээр дэмжинэ: 13.1.1.залуучууд өөрсдийн эрх ашигт нөлөөлөх аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох, хэрэгжилтийг хамтран зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;	-Залуучуудын шийдвэр гаргах үйл явцад оролцож буй байдал, оролцуулах сонирхол, хүсэл эрмэлзэл	-ҮСХ-ний тайлан -Иргэний нийгмийн байгууллагуудын холбогдох тайлан мэдээлэл
	13.1.2.залуучуудын иргэний нийгмийн байгууллагын нийтэд тустай үйл ажиллагааг дэмжих;	-Залуучуудын иргэний нийгмийн байгууллагын тоо -Дэмжлэг авсан байдал	
	13.1.3.залуучуудын хүмүүнлэгийн болон сайн дурын ажилд оролцох оролцоог дэмжих.	-Залуучуудын хүмүүнлэгийн болон сайн дурын ажилд оролцох оролцоо -Дэмжлэгийн хэмжээ	
14-р зүйл. Залуучууд шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөл үзүүлэх	14.1.Залуучуудыг шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцуулах талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ: 14.1.1.шийдвэр гаргах, нөлөөлөл үзүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд шууд болон өөрийн төлөөллийн байгууллага, хуулийн этгээдээр дамжуулан оролцох боломжийг бүрдүүлэх;	-Аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ-д сонгогдон ажиллаж буй 34 хүртэлх насны залуучуудын тоо -УИХ-д сонгогдон ажиллаж буй 34 хүртэлх насны залуучуудын тоо -Авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд оролцож буй залуучуудын эзлэх хувь	-ХНХЯ -Иргэний нийгмийн байгууллагуудын холбогдох тайлан мэдээлэл -АТГ-ийн холбогдох тайлан мэдээлэл
	14.1.2.сайн засаглалыг хөгжүүлэх, авлигатай тэмцэх, түүнийг бууруулах үйл ажиллагаанд залуучуудын оролцоог дэмжих.		
15-р зүйл. Сайн дурын ажилд оролцоог дэмжих	15.1.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага залуучуудын иргэний нийгмийн байгууллага, нийтэд тустай үйл ажиллагаа, хөдөлгөөнийг дараах чиглэлээр дэмжинэ: 15.1.1.залуучуудыг бие даан амьдрах, нийгэм, эдийн засгийн эрсдэлээс хамгаалахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр зохион байгуулах;	Залуучуудыг бие даан амьдрах, нийгэм, эдийн засгийн эрсдэлээс хамгаалахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн зохион байгуулсан арга хэмжээний тоо	ХНХЯ -Залуучуудын хөгжлийн төвүүдийн тайлан, жил бүрээр, нэгдсэн тайлан -Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2020 оны жилийн эцсийн биелэлтийн тайлан
	15.1.2.залуучуудын соёл, боловсрол, иргэний үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;	-Зохион байгуулсан ажлын тоо	



	15.1.3. зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагааг сайн дурынхны оролцоотойгоор зохион байгуулах;	-Зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын тоо	-Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 2021 оны биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга
	15.1.4. хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамж, халамжийн үйл ажиллагаанд сайн дурынхан, аж ахуйн нэгж, байгууллага хамтран ажиллахыг дэмжих.	-Дэмжлэгийн хамтын ажиллагааны тоо	
	15.2. Энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т заасан сайн дурын ажилд оролцсон цагийг бүртгэж, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.	-Баталсан эсэх -Хэрэгжүүлсэн эсэх	
16-р зүйл. Хүмүүнлэгийн ажилд оролцох оролцоог дэмжих	16.1. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т заасан сайн дурын болон хүмүүнлэгийн ажилд оролцсон залуучууд болон залуучуудын иргэний нийгмийн байгууллагын сайн туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан алдаршуулж, олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ.	-Сайн туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан алдаршуулж, олон нийтэд түгээн дэлгэрүүлсэн контентын тоо, жагсаалт	-Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны болон хэрэгжилтийн тайлан, мэдээлэл



Зүйл	Заалт	Шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх үүсвэр
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТАЛААРХИ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ БҮРЭН ЭРХ, ЧИГ ҮҮРЭГ			
<p>17-р зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх</p>	<p>17.1.Улсын Их Хурал залуучуудын хөгжлийг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>17.1.1.залуучуудын хөгжлийг хангах төрийн бодлогыг тодорхойлох;</p> <p>17.1.2.залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлах;</p> <p>17.1.3.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>17.1.4.хууль тогтоомжид заасан бусад.</p>	<p>-Улсын Их Хурал залуучуудын хөгжлийг дэмжих талаар гаргасан шийдвэрүүдийн жагсаалт, тоо</p> <p>-Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай батлагдсан төсвийн хэмжээ, зарцуулагдсан төсвийн хэмжээ</p>	<p>УИХ</p> <p>- УИХ-аас гарсан холбогдох шийдвэрүүдийн мэдээлэл</p> <p>-2018-2023 оны төсвийн мэдээлэл</p> <p>-Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан</p>
<p>18-р зүйл. Засгийн газрын бүрэн эрх</p>	<p>18.1.Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>18.1.1.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;</p> <p>18.1.3.залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагаа болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, өргөн мэдүүлэх;</p> <p>18.1.4.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>18.1.5.хууль тогтоомжид заасан бусад.</p>	<p>-Засгийн газраас хэрэгжүүлж буй хууль тогтоомжийн хүрээний гаргасан шийдвэрүүдийн жагсаалт</p> <p>-Залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагаа болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж батлуулсан төсвийн хэмжээ</p>	<p>ХНХЯ</p> <p>- Засгийн газраас гарсан холбогдох шийдвэрүүдийн мэдээлэл</p> <p>-2018-2023 оны улсын болон орон нутгийн төсвийн мэдээлэл</p> <p>-Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан</p>



<p>19-р зүйл. Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг</p>	<p>19.1.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр дараах чиг үүрэгтэй:</p> <p>19.1.1.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тайлагнах;</p> <p>19.1.2.залуучуудын асуудал хариуцсан бүх шатны байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;</p> <p>19.1.3.залуучуудын хөгжил, оролцооны чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;</p> <p>19.1.4.залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, үнэлэмжийг нэмэгдүүлэх, тухайн салбарт ажилласан байдлыг ажлын туршлагад тооцох тогтолцоог бий болгох;</p> <p>19.1.5.оюутан, суралцагчид цагийн ажил хийх тогтолцоог бий болгож, хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>19.1.6.хууль тогтоомжид заасан бусад.</p> <p>19.2.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цэргийн насны залуучуудын цэргийн алба хаах хүсэл, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.</p>	<p>-Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр хийсэн ажлууд, гаргасан шийдвэрүүдийн жагсаалт</p> <p>-Залуучуудын хөгжил, оролцооны чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажилласан ажлуудын жагсаалт, гарсан үр дүн</p> <p>-Оюутан, суралцагчид цагийн ажил болон сайн дурын ажил хийх тогтолцоог бий болгох, хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр зохион байгуулсан ажлуудын жагсаалт</p> <p>-Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цэргийн насны залуучуудын цэргийн алба хаах хүсэл, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээний тоо</p>	<p>ХНХЯ</p> <p>Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр хийсэн ажлын төлөвлөгөө түүний биелэлтийн тайлан 2018-2022 он.</p> <p>-Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2020 оны жилийн эцсийн биелэлтийн тайлан</p> <p>-Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 2021 оны биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга</p> <p>-Залуучуудын хөгжлийн төвийн түүвэр судалгааны үр дүн</p> <p>-Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн холбогдох чиглэлийн арга хэмжээний тайлан мэдээлэл</p>
---	--	--	---



<p><i>20-р зүйл. Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг</i></p>	<p>20.1.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр дараах чиг үүрэгтэй:</p> <p>20.1.1.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>20.1.2.орон нутгийн салбар, нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, ажлын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авах, ажлын гүйцэтгэлийн тайланг үнэлэх;</p> <p>20.1.3.залуучуудын асуудал эрхэлсэн бүх шатны байгууллагад ажиллаж байгаа ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>20.1.4.залуучуудын талаар мэдээллийн сан бүрдүүлж, хөтлөх;</p> <p>20.1.5.залуучуудын хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан хуулийн этгээдийг алдаршуулах, шагнаж, урамшуулах;</p> <p>20.1.6.залуучуудын үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих;</p> <p>20.1.7.залуучуудын хөгжлийн чиглэлээр хууль тогтоомжийн хүрээнд гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;</p> <p>20.1.8.энэ хуулийн 8.1.2, 8.1.5 дахь заалт, 9.4 дэх хэсэг, 10.1.4 дэх заалтад заасан чиг үүрэг, арга хэмжээг гэрээний үндсэн дээр төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;</p> <p>20.1.9.хууль тогтоомжид заасан бусад.</p> <p>20.2.Энэ хуулийн 20.1.4-г заасан мэдээллийн санг бүрдүүлэх журмыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Үндэсний статистикийн хороо, улсын бүртгэлийн</p>	<p>-Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын тоо</p> <p>-Аймаг дүүрэг дэх залуучуудын хөгжлийн төвүүдийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнүүд, жилээр харьцуулснаар</p> <p>-Аймаг дүүрэг дэх залуучуудын хөгжлийн төвүүдийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр хийсэн сургалтуудын тоо, хамрагдсан ажилтнуудын тоо, жилээр харьцуулснаар</p> <p>-Залуучуудын мэдээллийн сан үүсгэсэн байдал</p> <p>-Залуучуудын хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан байдлаар нь шагнаж, урамшуулсан хуулийн этгээдийн тоо</p> <p>-Залуучуудын үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжсэн байдал, дэмжүүлсэн ТББ-уудын жагсаалт</p>	<p>ХНХЯ</p> <p>Үндэсний статистикийн хороо</p> <p>Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Үндэсний статистикийн хороо, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллагын хамтран баталсан Залуучуудын мэдээллийн сан бүрдүүлэх журам</p> <p>-Залуучуудын хөгжлийн төвүүдийн тайлан, жил бүрээр, нэгдсэн тайлан</p> <p>-Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2020 оны жилийн эцсийн биелэлтийн тайлан</p> <p>-Тус хуулийн 20 дугаар 20.1.4, 20.2-г заасан мэдээллийн сан бүрдүүлэх журам, түүнийг баталсан тушаал; түүий биелэлтийн тайлан</p> <p>-Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 2021 оны биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга</p> <p>-Залуучуудын хөгжлийн төвүүдийн тайлан, жил бүрээр, нэгдсэн тайлан</p> <p>-Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2020 оны жилийн эцсийн биелэлтийн тайлан</p> <p>-Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 2021 оны биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга</p>
--	--	---	--



	<p>асуудал эрхэлсэн байгууллага хамтран батална.</p> <p>20.3.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь орон нутагт залуучуудад зориулсан нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх залуучуудын хөгжлийн төвтэй байна.</p> <p>20.4.Энэ хуулийн 20.3-т заасан залуучуудын хөгжлийн төвийн дүрмийг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.</p> <p>20.5.Залуучуудын хөгжлийн төв нь дараах чиг үүрэгтэй:</p> <p>20.5.1.залуучуудад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт явуулах;</p> <p>20.5.2.залуучуудын эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд бүх түвшинд оролцож, саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллээр хангах;</p> <p>20.5.3.залуучуудын хүсэл, сонирхол, эрэлт, хэрэгцээнд тулгуурласан сонирхлын клуб, зөвлөл, бүлгийн үйл ажиллагааг дэмжих;</p> <p>20.5.4.залуучуудыг хууль зүйн туслалцаа болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд холбон зуучлах;</p> <p>20.5.5.залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, залуу гэр бүл тулгамдсан бэрхшээлээ хамтран даван туулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлгийн уулзалт, чөлөөт ярилцлага зохион байгуулах санал, санаачилгыг дэмжих;</p>	<p>-Залуучуудын хөгжлийн чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажилласан, хамтран зохион байгуулсан арга хэмжээний жагсаалт, тоо</p> <p>- Төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн арга хэмжээний байгуулсан гэрээний тоо, жагсаалт, жилээр харьцуулснаар</p> <p>-Залуучуудын хөгжлийн төвийн чиг үүрэг дэх 20.5-д заасан үйл ажиллагаануудын тоог аймаг, дүүргээр , жилээр, зорилгот бүлгийн иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээгээр</p> <p>-Залуучуудын хөгжлийн төвийн улсын болон орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтийн хэмжээг аймаг, дүүргээр , жилээр</p> <p>-Залуучуудын хөгжлийн төвийн ажилтнуудын сэтгэл ханамжийн үнэлгээгээр</p>	<p>-Залуучуудын хөгжлийг дэмжих нийтлэг үйлчилгээний стандартыг НҮБХАС, ШУТИС-тай хамтран хийсэн судалгааны тайлан - 2020 он</p> <p>-Залуучуудын хөгжлийн төвийн болон зорилгот бүлгийн иргэдийн түүвэр судалгааны үр дүн</p>
--	--	---	---



	<p>20.5.6.зорилтот бүлгийн залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, мэдээллээр хангаж, ажилд зуучлах;</p> <p>20.5.7.залуучуудын гарааны компани эрхлэхийг дэмжих чиглэлээр орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай хамтран ажиллах.</p> <p>20.6.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь орон нутаг дахь залуучуудын хөгжлийн төвийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.</p> <p>20.7.Залуучуудын хөгжлийн төв нь залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн ажлын алба байна.</p> <p>20.8.Залуучуудын хөгжлийн төв нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжнэ.</p>		
<p>21-р зүйл. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын чиг үүрэг</p>	<p>21.1.Бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ залуучуудын хөгжлийг дэмжих талаар дараах чиг үүрэгтэй:</p> <p>21.1.1.харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа залуучуудын салбар зөвлөлийг тэргүүлэх;</p> <p>21.1.2.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</p> <p>21.1.3.залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>21.1.4.энэ хуулийн 11.1.7 дахь заалт, 13, 14, 15 дугаар зүйлд заасан арга хэмжээг залуучуудын оролцоог дэмжих тусгай хөтөлбөрийн дагуу харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</p> <p>21.1.5.энэ хуулийн 9.5 дахь хэсэг, 11.1.7 дахь заалт, 20.8 дахь хэсэгт заасан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгах;</p> <p>21.1.6.хууль тогтоомжид заасан бусад.</p>	<p>-Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ залуучуудын хөгжлийн чиглэлээр хийсэн ажлын жагсаалт, тоо</p> <p>-Залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны -Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулсан төсвийн хэмжээ, аймаг дүүрэг бүрээр мөн жилээр харьцуулсан байдлаар</p>	<p>Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга Тус хуулийг хэрэгжүүлсэн бүх шатны Засаг дарга нарын он оны тайлан; -Залуучуудын хөгжлийн төвүүдийн тайлан, жил бүрээр, нэгдсэн тайлан</p> <p>Засаг даргын болон ИТХ-ийн ажлын тайланд холбогдох чиглэлээр тусгагдсан мэдээлэл</p> <p>-Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2020 оны жилийн эцсийн биелэлтийн тайлан</p> <p>-Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 2021 оны биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга</p>



<p>22-р зүйл. Залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөл</p>	<p>22.1.Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд, орон нутагт залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга тус тус тэргүүлнэ.</p> <p>/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</p> <p>22.2.Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг төрийн байгууллага, залуучуудын иргэний нийгмийн байгууллага, залуучуудын төлөөллийг оролцуулан Зөвлөлийн тэргүүн батална.</p> <p>22.3.Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална.</p> <p>22.4.Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөл нь дараах чиг үүрэгтэй:</p> <p>22.4.1.залуучуудын хөгжлийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газарт болон холбогдох бусад байгууллагад зөвлөх, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шаардлагатай арга хэмжээ авах;</p> <p>22.4.2.залуучуудын хөгжлийг дэмжих, эрх ашгийг хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд залуучууд, залуучуудын иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах, гаргасан санаачилгыг дэмжих;</p> <p>22.4.3.залуучуудын хөгжлийг дэмжих асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;</p> <p>22.4.4.залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн дүрэмд заасан бусад.</p>	<p>-Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн бүтэц, үйл ажиллагаа</p> <p>-Засгийн газар баталсан залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн дүрмийн хэрэгжилт</p> <p>-Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн хэрэгжүүлсэн чиг үүргийн хэрэгжилт.</p> <p>-Зорилгод хүрсэн түвшин</p> <p>-Хүлээн зөвшөөрөгдсөн байдал</p>	<p>Засгийн газар Засгийн газар жил бүрийн 3, 9 дүгээр сард танилцуулдаг Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн биелэлт;</p> <p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газар</p> <p>Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлттэй холбогдуулан:</p> <p>1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам;</p> <p>2.Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;</p> <p>3.Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөл; аймаг, нийслэлийн засаг даргын дэргэдэх салбар зөвлөлийн зүгээс Засгийн газрын хэрэг эрхлэх газарт ирүүлсэн Залуучуудын хөгжлийн дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн 2017 оноос хойших тайлангуудыг хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн</p> <p>-Залуучуудын хөгжлийн төвүүдийн тайлан, жил бүрээр, нэгдсэн тайлан</p> <p>-Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2020 оны жилийн эцсийн биелэлтийн тайлан</p> <p>-Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 2021 оны биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга</p> <p>- Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 2018-2022 оны тайлан мэдээлэл Залуучуудын хөгжлийг хангахаар тодорхойлсон төрийн бодлого, шийдвэр;</p> <p>УИХ</p>
---	--	--	---



			Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг баталсан шийдвэр, тусгасан хувь хэмжээ; Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьсан тайлан;
--	--	--	---

ТАВДУГААР БҮЛЭГ ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН			
23-р зүйл. Залуучуудын хөгжлийг дэмжих сан	<p>23.1.Залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дэргэдээ Залуучуудын хөгжлийг дэмжих сан /цаашид "сан" гэх/ -тай байна.</p> <p>23.2.Сангийн үйл ажиллагааны дүрмийг Засгийн газар батална.</p> <p>23.3.Сангийн хөрөнгийн удирдлагыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.</p>	<p>-Засгийн газар баталсан залуучуудын хөгжлийг дэмжих сангийн үйл ажиллагааны дүрэм хэрэгжсэн байдал</p> <p>-Практикт нийцэж байгаа байдал</p>	<p>Засгийн газар СЯ</p> <p>-Сангийн яамны мэдээлэл</p> <p>-Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 2018-2022 оны мэдээлэл</p> <p>-Сангийн яамны мэдээлэл</p>

1.1.4 Харьцуулах хэлбэрийг сонгох:

Аргачлалын 3.5.1-д заасны дагуу Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдээс тохирохыг сонгож хэрэглэсэн.

Ингэхдээ хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгов. Хуулийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт тус бүрийн тоон болон чанарын үзүүлэлтүүдийг харьцуулагдахуйц буюу онооны хэлбэрт хувиргахдаа дараах аргаас сонгож хэрэглэсэн.

- Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль тогтоомж хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах нөхцөл байдал буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад гарч байгаа үр дагавартай харьцуулан дүн шинжилгээ хийсэн.
- Хүлээн зөвшөөрөгдсөн байдал шалгуур үзүүлэлтийг хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтоосон.
- Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийг хууль тогтоомж хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтоосон.



- Үзүүлэлтийн бодит утга болон үзүүлэлтийн бага утга (эсвэл байж болох доод хязгаар)-ын ялгаврыг үзүүлэлтийн их утга (эсвэл хүрэх түвшин) болон үзүүлэлтийн бага утга (эсвэл байж болох доод хязгаар)-ын ялгаварт харьцуулж харьцангуй үзүүлэлтийг тооцсон.
- Цаг хугацааны хувьд суурь үеийг тайлант үеийн гүйцэтгэлд харьцуулах замаар цаг хугацааны хугацааны өөрчлөлтийг олж хувиар илэрхийлсэн.
- Чанарын үзүүлэлт тус бүрийг үнэлж оноо өгөх замаар тоон үзүүлэлтэд шилжүүлсэн.

Түүнчлэн олон улсын түвшинд тооцогддог индексүүд болон бусад улс оронд хийгдсэн бусад ижил төстэй хуулийн үр дагаврын үнэлгээтэй харьцуулж авч үзсэн болно.





1.1.5 Шалгуур үзүүлэлтийг томъёолох:

Өмнөх 1.1.3 дахь хэсэгт тодорхойлсон үзүүлэлтийн бүлэг, шалгуур үзүүлэлт тус бүрийг хэрхэн тооцох аргачлалыг энэ хэсэгт томъёолж өгсөн. Шалгуур үзүүлэлтүүдийн хувьд өсөж байгаа утга нь хуулийн хэрэгжилт сайн байгааг илэрхийлэх үзүүлэлт эсвэл буурч байгаа утга нь хуулийн хэрэгжилт муу байгааг илэрхийлэх үзүүлэлт гэх зэргээр тодорхойлсон.

1.1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох:

Өмнөх 1.1.3 дахь хэсэгт тодорхойлсон шалгуур үзүүлэлт тус бүрийн мэдээллийн эх үүсвэрийг нэгтгэж багцлан дараах гурван аргыг хослуулан үнэлгээний мэдээллийг цуглуулан триангуляц хийж үнэлгээг хийсэн.

Зураг 7. ЗХДТХ-ийн хэрэгжилтийн үнэлгээний мэдээлэл цуглуулалт

Хамрах хүрээ	Түүхэр	CAWI – Төөн судалгаа	КП – Экспертийн арилцлага	FGD – Фокус бүлгийн арилцлага	CA – Контент анализ
 <p>Монгол Улс 3 аймаг 5 дүүрэг</p>	 <p>Увс аймаг Архангай аймаг Сүхбаатар аймаг Баянзүрх дүүрэг Баянгол дүүрэг Сонгинохайрхан дүүрэг Чингэлтэй дүүрэг Налайх дүүрэг Залуучуудын ИНБ-үүд Төрийн байгууллагууд</p>	 <p>62 54 46 74 48 152 89 30 - -</p>	 <p>1 1 1 1 1 1 1 1 3 3</p>	 <p>1 1 1 1 - - - - - -</p>	 <p>1. Хэрэгжилтийн тайлан 2. Залуучуудын чиглэлээр хийгдсэн судалгаанууд 3. ЗХТ-ийн тайлан 4. Бусад баримт бичгүүд</p>
НИИТ		555	14	4	Багц материал



1.2 ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлын хэрэгжүүлэх үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн:

1. Мэдээлэл цуглуулалтын ажлыг төлөвлөх;
2. Мэдээлэл цуглуулах;
3. Мэдээллийн сан үүсгэх.

1.2.1 Мэдээлэл цуглуулалтын ажлыг төлөвлөх:

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ мэдээлэл цуглуулалтын дараах гурван аргыг хослуулан триангуляцийн аргыг ашиглан үнэлгээг хийсэн. Үүнд:

1. **Баримтын шинжилгээ:** бэлэн байгаа судалгаа, тайлан, статистик тоо мэдээллийг цуглуулж шинжилгээ хийх. Баримтын шинжилгээний үр дүнгээр үнэлгээг хийх шалтгаан, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлт, харьцуулалтын хэлбэр, мэдээлэл цуглуулалтын аргыг нарийвчлан тодорхойлох, судалгааны хэрэглэгдэхүүн буюу судалгааны асуулга, ярилцлагын удирдамжийг боловсруулсан. Түүнчлэн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл, тэдгээрийн тоон болон чанарын дүнг шууд тайлбарлахад баримтын шинжилгээний үр дүнг ашигласан болно. Энэ хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.
 - a. ХНХЯамаас авч болох тайлан мэдээллийн жагсаалтыг гаргаж, хүлээн авах: үнэлгээний арга зүйг нарийвчлан тодорхойлох, үнэлгээний тайланг бэлтгэх мэдээллийн эх үүсвэр болгон ашиглах (ЗХДтХ-ийн хүрээнд 2018 оноос хойш хийгдсэн судалгаа шинжилгээний тайлан, баримт бичгийн жагсаалт, хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ)
 - b. Бусад төрийн байгууллага болон холбогдох бусад байгууллагаас гаргуулан авах мэдээллийн жагсаалт, албан бичгийн төслийг бэлтгэх: Үнэлгээнд шаардлагатай мэдээлэл, тайланг албан ёсоор гаргуулан авах.
 - c. Бусад төрийн байгууллага болон холбогдох бусад байгууллагаас албан бичгийн дагуу мэдээллийг гаргуулан авах: Үнэлгээнд шаардлагатай хоёрдогч мэдээлэл (тайлан, мэдээ, статистик мэдээлэл) бэлэн болно.
 - d. Баримт бичгийн судалгаанд шаардлагатай бусад мэдээллийг цуглуулах: Үнэлгээнд шаардлагатай хоёрдогч мэдээлэл (хууль, бодлого, судалгаа, үнэлгээ, дүн шинжилгээ, нэг сэдэвт бүтээл, тайлан мэдээ, статистик мэдээлэл, олон улсын туршлага) бэлэн болно.
2. **Чанарын судалгаа:** Чанарын судалгааны хүрээнд сонгогдсон байршлуудад зорилтот бүлэг буюу 15-34 насны залуучуудын төлөөллийн дунд фокус бүлгийн ярилцлага (ФБЯ); аймаг дүүргийн Залуучуудын хөгжлийн төвийн ажилтнууд, дарга, иргэний нийгмийн байгууллага, төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан, шинжээч, мэргэжилтнүүд гэх мэт гол мэдээлэгчид буюу гол оролцогч талууд, бодлого боловсруулагчидтай ганцаарчилсан – гүнзгийрүүлсэн ярилцлагыг (ГЯ) хийсэн. Эдгээр ярилцлагаар хуулийн чанар үйлчлэлийн талаарх байгууллага,



иргэдийн ойлголт, нийгмийн хүлээн зөвшөөрөлт, иргэдийн эрх зүйн нийцлийн түвшин зэргийг тодорхойлж, үнэлгээний шалгуур үзүүлэлт, тэдгээрийн чанарын тайлбар, үнэлгээг тодорхойлсон. Чанарын судалгааны мэдээлэл цуглуулалтыг зөвлөх багийн голлох мэргэжилтнүүд буюу багийн ахлагч, холбогдох харилцааг хариуцсан мэргэжилтнүүд гардан гүйцэтгэсэн.

- 3. Тоон судалгаа:** Тоон судалгааны хүрээнд сонгогдсон байршлуудад зорилтот бүлэг буюу 15-34 насны залуучуудыг хамруулан анкетын аргаар түүвэр судалгааг хийсэн. Эдгээр ярилцлагаар хуулийн чанар үйлчлэлийн талаарх залуучуудын ойлголт, нийгмийн хүлээн зөвшөөрөлт, иргэдийн эрх зүйн нийцлийн түвшин зэргийг тодорхойлсон. Газар зүйн байршлын хувьд Улаанбаатар хотын 5 дүүрэг болон болон бүс тус бүрийг төлөөлсөн нэг аймаг, нийт 3 аймгийг хамруулсан.

1.2.2 Мэдээлэл цуглуулалт:

Тоон судалгааны хүрээнд 15-34 насны 555 залуугаас онлайн ярилцлагын хэлбэрээр (CAWI) судалгааг авсан. Судалгааны түүврийн хэмжээ буюу судалгаанд хамрагдах залуучуудын тоог Нейманы тэнцүү хуваарилалтын аргаар (пропорциональ хуваарилалт болон тэнцүү хуваарилалтын арифметик дунджаар) сонгогдсон аймаг, дүүрэгт хуваарилж өгсөн. Мэдээллийн итгэх магадлал 95%, итгэх түвшин 4.2%-тай байхаар тооцож түүврийн тохиромжит хэмжээг тооцоолсон.


Зураг 8. Үнэлгээнд хамрагдах түүврийг тооцсон байдал

CONFIDENCE INTERVAL

$$n = \left(\frac{Z \left(1 - \frac{\alpha}{2}\right) \cdot S}{e} \right)^2$$

Энд: n - түүврийн зайлшгүй хэрэгцээт тоо
Z - хүсч буй итгэлтэй түвшин дэх Z утга
S - эх олонлогийн дунджийн стандарт хазайлт
e - боломжит нарийвчлалын түвшин

CONFIDENCE LEVEL



Судалгааны мэдээллийн итгэх түвшин 95%-тай байгааг дараах зурагт харуулав.

Үзүүлэлт	Утга	Тайлбар
Түүврийн нэгж	15-34 нас	1 залуугаас 1 санал асуулга авна.
Түүврийн хэмжээ	555	Нийт 555 залууг хамруулна.
Итгэх түвшин	95.0%	Судалгааны үр дүнд 95.0% итгэж болно.
Итгэх интервал	+/-4.2%	Судалгааны тоон үзүүлэлтүүд 4.5 хувийн хэлбэлзэлтэй байж болно.

Жич: Түүврийн тоог нэмэгдүүлэн 555 болгов.

Улсын хэмжээнд 2022 оны байдлаар 15-34 насны 967,711 залуучууд байгаа бөгөөд зорилтот УБ хот, 3 аймагт энэ насны 513,433 залуу байна. Харин сонгогдсон 5 дүүрэг болон аймгуудын хэмжээнд энэ насны 405,922 залуу байгаа нь судалгааны үндсэн эх олонлог болно. Судалгаанд оролцох 1 залуу 720 15-34 насны залууг төлөөлөхөөр байна.



Зураг 9. Үнэлгээний түүвэр

№	Аймаг, дүүрэг	Аймаг, дүүргийн код	15-34 насны залуучуудын тоо	Түүврийн хэмжээ (%)	Түүврийн хэмжээ (тэгш)	Түүврийн хэмжээ (Нейманы)	Түүврийн жин
1	Увс аймаг	18501	27288	37.3	69.4	62	440
2	Архангай аймаг	26501	29255	39.9	69.4	54	542
3	Сүхбаатар аймаг	42201	19168	26.2	69.4	46	417
4	Баянзүрх дүүрэг	51110	110944	151.6	69.4	74	1499
5	Баянгол дүүрэг	51107	64786	88.5	69.4	48	1350
6	Сонгинохайрхан дүүрэг	51116	100760	137.7	69.4	152	663
7	Чингэлтэй дүүрэг	51125	42446	58.0	69.4	89	477
8	Налайх дүүрэг	51113	11275	15.4	69.4	30	376
Нийт			405,922	555	555	555	720

Фокус бүлгийн ярилцлагад нийт залуучуудын 4 бүлгийг хамруулсан. Судалгааны түүврийн хүрээ нь Залуучуудын хөгжлийг дэмжих хуулийн хэрэгжилт сайн, дунд зэрэг болон муу байгаа аймаг, дүүрэг тус бүрээс сонгон авсан. (3 аймаг + УБ хотын 1 байршил (төвийн дүүрэг), нийт 4 байршилд)

Ганцаарчилсан – гүнзгийрүүлсэн ярилцлага (ГЯ)-д нийт 14 оролцогчийг хамруулсан. Мэдээлэл цуглуулалтыг эхлүүлэхийн өмнө ГЯ-д хамруулах оролцогчдын жагсаалтыг гарган, захиалагчийн саналыг авч тусгасан.

Судалгааны хэрэглэгдэхүүн (Survey Instruments)-ийг боловсруулах.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тоон болон чанарын судалгааны хүрээнд дараах 4 төрлийн судалгааны хэрэглэгдэхүүнийг боловсруулсан. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийн хуудас (Indicator page)
2. Залуучуудаас авах тоон судалгааны асуулга (questionnaire);
3. ФБЯ-ын удирдамж (Focus group discussion guide);
4. ГЯ-ын удирдамж (Key informant’s interview guide).

1.2.3 Мэдээллийн сан үүсгэх:

Тоон судалгааны мэдээллийг программд оруулах

АНУ-ын тооллогын товчооноос боловсруулсан судалгааны мэдээллийг оруулах хамгийн дэвшилтэт программ болох CPro (Census and Survey Program) программыг ашигласан.

Тоон судалгааны мэдээллийг боловсруулах, шинжилгээ хийх

1. Чанарын судалгааны мэдээллийг кодлох, компьютерт шивж оруулах, ярилцлагын протоколыг баримтжуулсан.
2. Тоон судалгааны мэдээллийг SPSS болон STATA программ ашиглан боловсруулсан.

Бэлэн болсон мэдээллийн үр дүнг нэгтгэн боловсруулахдаа IBM SPSS Statistics 20 программыг ашиглан холбогдох статистикийн шинжилгээг хийн, хүснэгт графикуудыг боловсруулсан.



1.3 ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн:

- 3.1. цуглуулсан мэдээллийг үнэлэх;
- 3.2. тогтоосон шалгуур үзүүлэлт болон харьцуулах хэлбэрийг ашиглан хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийх;
- 3.3. үнэлгээний үр дүн, тайлан, санал зөвлөмжийг бэлтгэх;
- 3.4. үнэлгээний үр дүнг хэлэлцүүлэх;
- 3.5. үнэлгээний үр дүн, тайлан, санал зөвлөмжийг захиалагчид хүргүүлэх.

1.3.1. Цуглуулсан мэдээллийг үнэлэх:

Тоон болон чанарын судалгааны мэдээллийн хувьд мэдээлэл цуглуулалтын чанарын хяналтын тайланг бэлтгэж, мэдээлэл цуглуулалтын явцад гарсан хүндрэл бэрхшээл, түүнээс шалтгаалан судалгааны мэдээлэлд үзүүлэх нөлөө зэргийг тодорхойлж, цаашид үнэлгээ, дүн шинжилгээ хийхэд анхаарах асуудлыг тодруулсан.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ хуулийн заалт тус бүрийн хэрэгжилтийн үр нөлөөг тодорхойлох үзүүлэлтийн системийг дараах зарчмыг баримтлан боловсруулж ашиглалаа.

- Хуулийн зүйл заалт тус бүрийн зорилго, зорилгод нийцтэй, уялдаатай байдлаар, тухайн зорилго зорилтын үр дагаврыг илэрхийлж чадах үзүүлэлтийг сонгох.
- Сонгон авсан үзүүлэлтийн мэдээллийн эх үүсвэр нь тогтмол байнгын захиргааны болон албан ёсны статистик мэдээлэл болон судалгаа байх.

Аргачлал арга зүй үндэсний болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, олон улсын түвшинд болон цаг хугацааны хувьд харьцуулалт хийх боломжтой зэрэг юм.



ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний гол зорилго нь Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход оршино.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль 2018 оны 1 дүгээр 01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээр Залуучууд хөгжлийн төв (ЗХТ)-өөр дамжуулан төрийн үйлчилгээг залуучуудад хүргэх тогтолцоог бий болсон байна. Ингэснээр өмнө олон нийт, төрийн бус байгууллагаар хүргэдэг байсан ажил үйлчилгээг төр хариуцах болжээ.

Эхэн үедээ ЗХТ-үүд нь олон нийт, залуучуудад үйл ажиллагаагаа таниулан ойлгуулах, танилцуулах үйл ажиллагааг голчлон явуулж байсан бол эдүгээ нийгмийн тодорхой бүлгийн гишүүдийг амьдрах ухааны сургалт, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд холбон зуучлах ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэж байна.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх, үүрэг хүлээгчдийн үйл ажиллагааны үр дүнгээр хуулийн үнэлгээг хийснээр хуулийг сайжруулах, хэрэгжилт муу байгаа заалтуудын учир шалтгааныг оношлох, ЗХТ-ийн үйлчилгээний арга зүй, аргачлалыг боловсронгуй болгоход ач холбогдолтой юм. Түүнчлэн хөгжлийн үйлчилгээг төрөлжүүлж, зардлыг нарийвчлах, төрийн үйлчилгээг залуучуудад хүргэхдээ ТББ, олон нийтийн оролцоог хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Нийгмийн сэтгэл зүй, зан төлөв, хүмүүсийн амьдралын хэв маяг ихээхэн өөрчлөгдөж буй цаг үед бид амьдарч байна. Манай улсын хувьд нийгмийн нэг тогтолцоо нөгөөгөөр солигдож өөрчлөгдсөн шилжилтийн он жилүүдийн үед хүмүүсийн сэтгэлгээний өөрчлөлт, дасан зохицох байдал удаашралтай байв. Нийгэмд хүмүүсийн үнэт зүйлс, итгэл үнэмшил өөрчлөгдөх нь бэрхшээлтэй юм. Нийгмийн хөгжлийг шинжлэх ухаан, техник, технологийн ололт амжилт, мэдлэгт суурилсан эдийн засгийн өсөлтөөр хэмжихээс гадна орчин цагт хүний манлайлал, төлөвшил хөгжил, хүний хүчин зүйл, хүчин чадамжаар тодорхойлдог хандлага 'давамгайлах боллоо. Нийгмийн хөдөлгүүр нь хүн, хүний хөдөлгүүр нь эрүүл мэнд, зөв хүмүүжил төлөвшил, эрдэм боловсрол, чадвар, манлайлал юм.

Өнөө цагт залуус, дунд үеийнхэн, ахмадуудын цаг үеийнх нь суурь хүмүүжил, төлөвшил, үнэт зүйл, итгэл үнэмшил, нийгмийн хариуцлага, ухамсар, хандлага нь өөр байгаагаас үзэл бодлын зөрүүтэй байдал ажиглагдаж байна. Энэ бүхнийг нэг чигт хандуулах чухал хүчин зүйл бол эрх зүйн зохицуулалт, хөгжлийн бодлого хөтөлбөр юм. Тиймээс орчин үеийн залуучуудын хөгжлийг дэмжих бодлого, эрх зүйн зохицуулалт нь ирээдүйн дунд, ахмад үеийг бүтээх үндэс суурь билээ.



Дэлхий даяар хүн амын тоо буурч байгаа энэ үед манай орон хүн ам зүйн ачаалал бага, “Хүн ам зүйн цонх” хаагдах болоогүй таатай нөхцөл байна. Иймээс Монгол Улсын тусгаар тогтнол, нүүдлийн соёл иргэншлийн онцлог, амьдралын өөрийн давтагдашгүй шинж, өвөрмөц хэв маяг, уналт, босолт, сорилт, бэрхшээл, сургамжийн буурал түүхийг цаашид залгамжлан үргэлжлүүлэх үүрэг бүхий залуу үеийнхний талаар баримтлах бодлого нэн чухал юм.



2.1 ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТӨРӨӨС ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хоёрдугаар бүлэг буюу төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилт дундаж түвшинд байна.



8-р зүйл. Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих:

- 8.1.Залуучуудын хувь хүний хөгжлийг дараах чиглэлээр дэмжинэ:
 - 8.1.1.ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн боловсролын төв, багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хичээлийн агуулгыг тусгах;

Шалгуур үзүүлэлт. Ерөнхий боловсролын болон ИДС, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн боловсролын төв, багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хичээлийн агуулгыг тусгагдсан байдал

ЕБС-ийн сурагчид бага ангидаа хүн ба орчин, хүн ба нийгэм, дунд, ахлах ангидаа эрүүл мэнд, нийгэм судлал хичээлээр амьдрах ухааны чадвар, бэлгийн боловсрол, гэр бүл төлөвлөлт, жендэрийн тэгш байдлын цогц агуулгыг тус тус судалж байна. Эдгээр сургалтын хөтөлбөрүүдийн агуулгыг БСШУССайдын 2019 оны А/192 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар батлуулж, 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн ЕБС-ийн нийт сурагчид судалж байна. Насан туршийн боловсролын үндэсний төвийн сургалтын албан ёсны таван чиглэлийн нэг нь амьдрах ухаан, санхүүгийн боловсрол бөгөөд насан туршийн боловсролын салбар төвүүдээр дамжин сургалт явагдаж байна.

... Гэр бүлийн боловсрол, харилцаа хандлага, амьдрах ухааны сургалт, чадамжийг 10-н жилийн сургуулиас нь эхэлж илүү үр дүнтэй заамаар байдаг. Хорих ял хойшлуулсан хүүхдүүд болон МСҮТ-ийн хүүхдүүдэд хичээл зааж байх үед ингэж хамгийн их бодогддог.

Чанарын судалгааны явцад ЗХТ-ийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас...

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.14-г “Ерөнхий боловсролын сургуульд сурагчдын амьдрах ур ухааныг хөгжүүлэх, аюулгүй байдлын сургалтыг нэвтрүүлж, хүүхдийг эрсдэлгүй, осол эндэлгүй, эрүүл, аюулгүй амьдрах чадварт сургана” гэж тусгасан байна. Үүний дагуу онцгой байдлын ерөнхий газар, Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага болох ЖАЙКА-тай хамтран “Монгол



Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлж эхэлжээ. Төсөл нь, газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх замаар төрийн захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлэх зорилготой ажээ.

Дээрх ажлын хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Боловсролын хүрээлэн, Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институт, ОБЕГ-ын төлөөлөл бүхий ажлын хэсэг “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг боловсруулсан байна. Сургалтын хөтөлбөр нь БСШУС-ын сайдын 2018 оны А/181 дүгээр тушаалаар баталгаажиж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хэрэгжихээр эхлээд байна. Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институт, Боловсролын Хүрээлэн, аймаг, нийслэл, дүүргийн Боловсрол соёл урлагийн газрын мэргэжилтнүүдэд зориулсан арга зүйн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсаар байна.

Өнөөгийн залуу үеийнхний онцлог нь нээлттэй, технологийн дэвшилтэй хөл нийлүүлж алхсан, нийгмийн сүлжээгээр нягт холбогдсон, нийгмийн болон байгаль орчноо хамгаалах ухамсар өндөр байдаг зэрэгт оршиж байна. Нөгөөтээгүүр тэд бие дааж, амьдралд хөлөө олох явцад нь томоохон асуудал бэрхшээл тулгарсаар байгааг дурдвал хөдөлмөр эрхлэх боломж, мэдлэг, чадвар дутмаг, бэлгийн замаар дамжих халдвар болон жендэрт суурилсан хүчирхийллийн тархалт өндөр байгаа явдал юм. Энэ асуудлуудаас урьдчилан сэргийлэх боломж, шийдвэрлэх аргын нэг нь “Амьдрах ухааны боловсрол, бэлгийн цогц боловсрол” олгох үйл ажиллагаа гэж дүгнэж байна. Хүүхэд залуучуудад ажил амьдралынхаа туршид аливаа асуудал бэрхшээлээс сэргийлэх, даван туулахад хэрэгтэй мэдлэг, хандлага, үнэт зүйлс, ур чадварыг эзэмшүүлдгээрээ энэхүү боловсролын агуулгын онцлог оршиж байна.

Насан туршийн боловсролын төвөөр дамжуулан дүйцсэн хөтөлбөрийн сургалтад суралцах, номтой харилцах, гоо сайхны хичээлд суралцах гэх мэт өөрт нь хэрэгтэй, амьдралд бодитой хэрэг болох зүйлүүдээр суралцахаас гадна яаж сайхан амьдрах вэ, амьдралаа яаж зөв авч явах вэ?, хүнтэй яаж зөв харилцаж сурах вэ? гэх зэрэг сайхан амьдралын нууцад нэвтрэхэд Амьдрах ухааны сургалтууд ач холбогдолтой байна. Энэхүү сургалтын агуулгыг шинэчлэх, хамрах хүрээг илүү нэмэгдүүлэх шаардлагатай байна. Амьдрах ухааны боловсрол нь ЗХДТХ-ийн хэрэгжиж байгаа заалтуудын онцлох хэсэг боловч боловсролын бүх шатны агуулгад тусгагдаагүй байна. Тухайлбал МСҮТ, коллеж, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт дээрх агуулгыг тусгасан хөтөлбөр, тушаал хараахан батлагдаагүй байна.

... Амьдрах ухааны сургалтыг их, дээд, сургууль мэргэжлийн боловсролын агуулгад тусгана гэж заасан заалт нь их сонин санагддаг. Энэ угаасаа хэрэгжээгүй. Миний бодлоор насан туршийн сургалтаар, зорилгот бүлгийн залуучууддаа энэ сургалт нь ороод явах нь зүйтэй. Их, дээд сургуульд орох боломж байгаа ч юмуу. Угаасаа мэргэжлээ эзэмшээд чадваржаад явж байгаа хүмүүст...

Чанарын судалгааны явцад ЗХТ-ийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас...



<p>8.1.Залуучуудын хувь хүний хөгжлийг дараах чиглэлээр дэмжинэ: 8.1.1.ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн боловсролын төв, багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хичээлийн агуулгыг тусгах;</p>	<p>Хэрэгжилт 50%</p>
---	---------------------------------

- 8.1.2.залуучуудад зориулан хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих;
- 8.1.3.түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие дааж амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд чиглэсэн амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хөтөлбөрийн дагуу цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны залуучуудыг хамруулах;

Шалгуур үзүүлэлт. Дэмжсэн сургалтын тоо, цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан 18-27 насны залуучуудын тоо

Хуулийн 8.1.2 заалтыг хэрэгжүүлэх хүрээнд сургалтыг ЭМЯ-ны харьяа газрууд, БШУЯ-ны насан туршийн боловсролын төвүүд, ЗХДТ-үүд хийж байна. Залуучуудын хөгжлийн төвүүд нь “Амьдрах ухааны 12 модуль” сургалтыг тогтмол зохион байгуулж байгаа бөгөөд төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн нэг болж байна. Сүхбаатар, Увс, Архангай зэрэг аймгууд, Сонгинохайрхан, Баянгол дүүрэг, Баянзүрх, Налайх дүүргүүдийн Залуучуудын хөгжлийн төвүүдийн тайлан мэдээнээс үзвэл жилд дунджаар нэг төв 4000-10 000 залууст сургалт, мэдээлэл хүргэж ажиллаж байна.²

Чанарын судалгаагаар ЗХТ-ийн гол үйл ажиллагаагаар хуулийн 8.1.2-т заагдсан ажлыг хамгийн гол ажлаар нэрлэсэн байна.

...Оны эхнээс аймгийнхаа байгууллагууд руу сургалтын мэдээллээ явуулдаг. Амьдрах ухааны сургалт, Тэгш боломж, Залуучуудын манлайлал, Жендерийн тухай сургалт, Цахим орчны соёлтой хэрэглээ, Эрүүл мэндийн сургалт хийдэг.

Чанарын судалгааны явцад ЗХТ-ийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас...

...Хүмүүжлийн чанартай албадагын арга хэмжээ авагдсан хүүхдүүд, асрамжийн төвийн хүүхдүүдэд чиглэсэн ажил, амьдрах ухааны сургалт, мэргэжил сонголт, хорт зуршлаас сэргийлэх, сэтгэл зүйн зөвлөгөө, хууль зүйн зөвлөгөөнд холбон зуучлах ажлуудыг хийдэг.

Чанарын судалгааны явцад ЗХТ-ийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас...

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан цэргийн мэргэжил олгох сургалтын журмын тушаал нь хууль батлагдахаас өмнө гарсан. 2017 оны 1 сарын 25-ны өдөр МУ-ын Засгийн газрын тогтоолоор 1 дугаар 32\ цэргийн албаны тухай хуулийн 7.9-д заасныг үндэслэн “Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын журмыг баталсан байна. Журмын

² Залуучуудын хөгжлийн төвүүдийн тайлан мэдээ.
2021 онд ЗХДТХ-ийн хэрэгжилтэд хийсэн түргэвчилсэн үнэлгээний тайлан



1.2-т “Оюутан цэрэг” сургалтад Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежийн 1 дүгээр дамжааны оюутан, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагч сайн дурын үндсэн дээр хамрагдана.

1.3-т “Оюутан цэрэг” сургалтад хамрагдсан цэргийн ерөнхий бэлтгэл, цэргийн мэргэжлийн бэлтгэл сургалтын хөтөлбөрийг бүрэн хангасан оюутан, суралцагчийг цэргийн жинхэнэ алба хаасанд тооцож цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэнэ гэжээ. Тус журмын дагуу оюутан цэрэг хөтөлбөр хэрэгжиж буй ч Батлан хамгаалах яамны зүгээс нууц гэж үздэг тул хөтөлбөрийн агуулга, нийт сургалтад хамрагдсан залуусын тоо мэдээллийг өгөх боломжгүй байна. Тус журам хэрэгжиж байгаа ч практикаас харахад хамрагдах оюутны тоо хязгаартайн улмаас хүссэн залуус бүр хамрагдах боломжгүй байх магадлалтай байна.

МУ-ын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор “Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. БШУСЯ, БХЯ, ХНХЯ сайд нарын хамтарсан 2019 оны А\567, А\1227, А\268 дугаар тушаалаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2019 оны А477 дугаар тушаалаар “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг түүх, соёлын дурсгалт газруудтай танилцуулах журам”-ыг шинэчлэн батлуулснаар гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдад эх оронч хүмүүжил олгох чухал ач холбогдолтой шийдвэр болсон байна.

Үнэлгээ.

8.1.2.залуучуудад зориулан хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих;	Хэрэгжилт дундаж. 50%
8.1.3.түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие дааж амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд чиглэсэн амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хөтөлбөрийн дагуу цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны залуучуудыг хамруулах;	Хэрэгжилт хангалттай. 100%

- 8.1.4.залуучуудын гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа, уламжлал, зан заншлын тухай утга зохиол, уран сайхны бүтээлийг дэмжих;
- 8.1.5.залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт тусгах;
- 8.1.6.энэ хуулийн 8.1.5-д заасан агуулга, хөтөлбөрийг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

Шалгуур үзүүлэлт. Дэмжсэн утга зохиол, уран сайхны бүтээлийн тоо. Залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөр хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт туссан байдал



ХНХЯ-ны Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан бичсэн 2018-2022 оны нийгмийн хамгааллын салбарт хамаарах хуулийн хэрэгжилтийн тайлангаас үзвэл 8.1.4 -т заасан бүтээлийг сонгон шалгаруулах “Утга зохиол, уран сайхны бүтээл шалгаруулах журам”-ыг ХНХСайдын 2019 оны 3 дугаар сарын 28 өдрийн А\129 дүгээр тогтоолоор баталсан ч “Залуучуудын хөгжлийг дэмжих сан” байгуулагдаагүйн улмаас хэрэгжээгүй байна. Мөн дээрх тайланд дурдсанаар 8.1.5, 8.1.6 заалтыг журамд тусгах боломжгүй, үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөмж хэлбэрээр хүргэж хамтран ажиллах байр суурийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос ирүүлсэн тухай дурджээ.

Үнэлгээ.

8.1.4.залуучуудын гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа, уламжлал, зан заншлын тухай утга зохиол, уран сайхны бүтээлийг дэмжих;	Хэрэгжилт хангалтгүй. 0%
8.1.5.залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт тусгах; 8.1.6.энэ хуулийн 8.1.5-д заасан агуулга, хөтөлбөрийг зохицуулсан журмыг Засгийн газар батална.	Хэрэгжилт хангалтгүй. 0%
8.2.Энэ хуулийн 8.1.1-д заасан хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Хэрэгжилт дундаж. 50%.
8.3.Энэ хуулийн 8.1.3-т заасан цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны эмэгтэйчүүд сайн дурын үндсэн дээр хамрагдаж болно. 8.4.Энэ хуулийн 8.1.3 дахь заалт, 8.3 дахь хэсэгт заасан залуучуудад цэргийн мэргэжил олгох журмыг Засгийн газар батална.	Журам батлагдсан. Хэрэгжилт 100%.
8.5.Энэ хуулийн 8.1.4-т заасан бүтээлийг сонгон шалгаруулах журмыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Хэрэгжилт хангалтгүй. 0%
8.6.Энэ хуулийн 8.5-т заасан журмын дагуу шалгаруулсан бүтээлийг Залуучуудын хөгжлийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.	Хэрэгжилт хангалтгүй. 0%



9-р зүйл. Залуучуудын боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих

- 9.1.Залуучуудын хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй, чанартай боловсрол эзэмшүүлэхийг дараах чиглэлээр дэмжинэ:
 - 9.1.1.үндэстний цөөнх, шилжин суурьшигч, зорилтот бүлгийн залуучуудын боловсролын хэрэгцээнд суурилсан сургалтыг насан туршийн боловсролын хөтөлбөрийн дагуу эзэмшүүлэх;
 - 9.1.2.залуучуудыг эх орондоо болон гадаад улсад мэргэжил эзэмших, мэргэших боломжийг бүрдүүлэх;
 - 9.1.3.номын сангийн үйлчилгээг залуучуудад хүртээмжтэй болгох арга хэмжээ авч, цахим номын сан хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
 - 9.1.4.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь хугацаат цэргийн алба хаасан, цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан суралцагчийн амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийн багц цагийг нөхөн тооцох;
 - 9.1.5.энэ хуулийн 8.1.3 дахь заалт, 8.3 дахь хэсэгт заасан цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан, их, дээд сургуульд элсэн суралцах болзол хангасан залуучуудыг Боловсролын зээлийн сангаас олгох оюутны хөгжлийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулах.
- 9.2.Энэ хуулийн 9.1.1, 9.1.2, 9.1.3-т заасан хөтөлбөрийг залуучуудын болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлнэ.
- 9.3.Энэ хуулийн 9.1.4-т заасан багц цаг нөхөн тооцох журмыг боловсролын болон батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.
- 9.4.Залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, нас, сэтгэхүй, бие бялдар, түүх соёлын хөгжлийг судлахад чиглэсэн залуучууд судлалыг хөгжүүлнэ.
- 9.5.энэ хуулийн 9.4-т заасан арга хэмжээг Шинжлэх ухааны академи хэрэгжүүлж, Засгийн газарт тайлагнана.
- 9.6.Залуучуудыг соёл, урлаг, шинжлэх ухааны шинэ бүтээл туурвихыг дэмжинэ.
- 9.7.Шинжлэх ухаан, өндөр технологи, инновац, шинжилгээ, судалгааны чиглэлээр үндэсний тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 9.8.Энэ хуулийн 9.6, 9.7-д заасан үйл ажиллагааг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж, Залуучуудын хөгжлийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

Шалгуур үзүүлэлт. Залуучуудын боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, хамрагдсан залуучуудын тоо

Хуулийн 9.1 заалтыг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан ажлын нэгдсэн дүн мэдээ. 2022 оны байдлаар БШУЯ.

9.1.1. заалтын хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх, ач холбогдлыг ойлгуулах, хувь хүний ур чадваруудаас суралцах “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох цуврал ярилцлага” цуврал дугаар, “Ажлын байрны өдөрлөг”, “Мэргэжил сонголтод хувь хүний онцлог чухал болох нь” сургалтыг



амжилттай зохион байгуулах, “АМЧБО зөвлөл” байгуулах “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох” гарын авлага боршуур бэлтгэн эцэг, эх, ахлах ангийн сурагчдад зөвлөмж өгч ажилласан. Үндэсний хэмжээнд 332 удаагийн сургалтаар 13016 иргэн, 74 удаагийн нөлөөллийн арга хэмжээнд 2751 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулжээ.

9.1.2 заалтын хүрээнд бичиг үсэггүй 120 иргэн хамрагдсанаас анхан шат 41, дунд шат 20% гүнзгий шат 20, бичиг үсгийн дараах сургалтад 39 казак иргэд хамрагдав. Мөн 2022-2023 оны хичээлийн жилд 299 суралцагч боловсрол нөхөн эзэмших сургалтад хамрагдаж, 4 иргэн, 40 иргэн суурь, 65 иргэн бүрэн дунд боловсрол эзэмшив. Тэдгээрийн 21 иргэн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байв. ЗГ-ын 1000 инженер хөтөлбөр, ерөнхийлөгчийн тэтгэлэг гэх мэт тодорхой хөтөлбөрүүдээр дамжин гадаадад сургаж байна.

9.1.3 Соёлын яамнаас заалтын хүрээнд номын сангийн үйл ажиллагааны танилцуулга шторк бэлтгэн байгууллагын цахим хаягт байршуулах, дүүргүүдийн нийт иргэдэд мэдээлэл хүргэх, номын сангаар олон давтамжтай үйлчлүүлсэн, номын санд үр бүтээлтэй суусан хүүхэд, залуучуудыг “Номын нөхөр” тэмдэг, батламж өгч урамшуулахаар 45 хоногийн аян зохион байгуулах зэрэг үйлчилгээг зохион байгуулах чиглэл өгч ажиллаж байна. ХУД номын сангийн үйлчилгээг иргэд, олон нийтэд хүртээмжтэй болгох, үйл ажиллагааг тэлэх зорилгоор 4 төрлийн үйлчилгээг нэвтрүүлж танхимын үйлчилгээг 301, зөөврийн номын сангаар 278, олон нийтэд чиглэсэн үйлчилгээг танхимаар 165, цахимаар 283 иргэд хүргэжээ. Их дээд сургуулиудыг цахим номын сантай болох шаардлага тавьж байгаа бөгөөд дээд боловсролын байгууллага болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагад оруулсан.

9.1.5 Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчдад олгох “Оюутны хөгжлийн зээл”-ийн журмыг Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, хэрэгжүүлж байна. 2.8-аас дээш сургалтын голч оноотой, санхүүгийн бололцоогүй, амжилттай суралцаж буй залуучуудыг дэмжсэн, хүүгүй, барьцаагүй, ажлын байранд эргэн төлөгдөх нөхцөлтэй байна.

ЗХДТХ-д тусгаснаар ЗХТ-өөр дамжуулан 1/амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт явуулах, 2/залуучуудын оролцоог хангах, мэдээллээр хангах, 3/залуучуудын хүсэл сонирхолд нийцсэн клуб зөвлөлийг ажиллуулах, бүлгийн үйл ажиллагааг дэмжих, 4/хууль зүйн туслалцаа болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд холбон зуучлах, 5/гэр бүлийн боловсрол олгох, тулгамдсан бэрхшээлээ хамтран даван туулахад сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх бүлгийн уулзалт, ярилцлага зохион байгуулах, 6/зорилтот бүлгийн залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ мэдээллээр хангах, ажилд зуучлах, 7/залуучуудын гарааны компани эрхлэхийг дэмжих чиглэлээр орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай хамтран ажиллах зэрэг долоон чиг үүргийн хүрээнд төрийн үйлчилгээг залууст хүргэхээр заасан. Хуулийг хэрэгжүүлж эхэлсэн эхний жилд залуучууд, олон нийтэд үйл ажиллагааны талаар таниулах, мэдээлэх үйл ажиллагааг голчлон явуулжээ. Харин 2019 оноос ЗХТ-үүд байгуулагдаж нийгмийн тодорхой бүлгийн гишүүдийг амьдрах ухааны сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд холбон зуучлах болон өдөрлөг аяныг зохион байгуулж залуучуудыг өргөн хүрээнд хамруулахыг зорьж тодорхой үр дүнд



хүрсэн байна. ЗХТ-ийн үйл ажиллагаа харьцангуй залууст танигдаж эхэлсэн ч үйл ажиллагааны санхүүжилт багатай, мэргэжилтнүүдийн цалин бага, тогтвор муутай, зарим үйлчилгээ давхардалтай, институт хоорондын уялдаагүй байдал үйл ажиллагаа болон нэр хүндэд нь таагүй нөлөө үзүүлж байна.

... ЗХДТХ-д спортоор хичээллэх боломж, номын сан, шинжлэх ухааныг дэмжинэ гэсэн боловч яг үнэндээ бодит байдал дээр хүртээмж муу. Захын хороололд амьдардаг залуус гэрээсээ гараад номын сан орох, заал орох ямарч боломжгүй...

... Гаргасан шийдвэрүүд нь хөрсөн дээрээ буугаагүй юм шиг санагддаг...

Чанарын судалгааны явцад хийсэн фокус бүлгийн ярилцлагаас...


... Спортын уралдаан тэмцээн, залуучуудын чуулга уулзалт гэсэн арга хэмжээнүүдэд залуучуудын оролцоо сайн байдаг. Сургалт гэхээр их хойрго хандана, цай кофе уучихаад яваад өгөх тохиолдол ч бий...

...Томоохон ажлуудыг тогтмол хийх гэхээр санхүүгийн боломж байдаггүй тул аян маягаар, тэмцээн, уралдаан гээд л зохион байгуулдаг даа...

Чанарын судалгааны явцад ЗХТ-ийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас...

Асуумжийн судалгаанаас үзвэл залуусын 59% нь өөрийн амьдарч буй газар, орон нутгийн ЗХТ-ийн үйл ажиллагааг мэдэж байгаа бол 41% нь мэдэхгүй байна. Энэ нь ЗХТ-ийн үйл ажиллагаа бүхий залуучуудад хүрэх боломжгүй, магадгүй хүрэх шаардлагагүй байгааг ч илтгэж байж болох юм.

График 1. Залуучуудын Залуучуудын хөгжлийн төвийн талаарх мэдлэг



Эх сурвалж: Залуучуудаас авсан түүвэр судалгаа, Түүврийн хэмжээ N=555, Q3

Залуучуудын хэрэгцээнд нийцсэн хүртээмжтэй боловсрол эзэмшүүлэх гэсэн заалтын хүрээнд залуучуудын насны бүлэгт тохирсон хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн нийтлэг үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай байна. Мэдээлэл, технологийн хурдацтай



хөгжил бүхий, хүнлэг хүмүүнлэг, эрх зүйн харилцааг чухалчилдаг 21-р зууны иргэнийг төлөвшүүлэхэд залуучууд руу чиглэсэн хөгжлийн үйлчилгээ анхаарах ёстой. Үүний зэрэгцээ орчин үеийн залуусын хүсээд байгаа соёл, боловсрол, спортын үйлчилгээг хөгжүүлэх, ялангуяа хотын зах, хөдөө орон нутагт залууст зориулсан үйлчилгээний байгууламжуудыг цогцоор нь байгуулах нь зүйтэй байна. Өөрөөр хэлбэл залуучуудад хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэхэд онцгой анхаарах нь чухал байна. Ингэснээр залуучууд чөлөөт цагаа спортоор хичээллэж өнгөрүүлэх, хорт зуршлаас ангид байх, бие биеэсээ суралцах гэх мэт эерэг үр дүнгүүд гарах юм.

Инновацийн соёлыг бий болгох, түгээх “Инновацийн 7 хоног” арга хэмжээг 2021 онд БШУЯ-наас цахимаар зохион байгуулж, “Инновац ба тогтвортой хөгжлийн зорилтууд” олон улсын үзэсгэлэнг зохион байгуулж, 250 гаруй байгууллагад урилга, мэдээлэл хүргүүлж, нийт 10 орны 29 гарааны бизнес эрхлэгч, дотоодын 92 их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, төр, хувийн хэвшлийн нийт 200 гаруй инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулсан. Үзэсгэлэнд 201492 хүн оролцож, шууд дамжуулалтаар 649339 хүн хамрагдсан.

Аж үйлдвэрийн IV хувьсгалын талаар орчин үеийн чиг хандлагыг сурталчлан таниулах, технологи хөгжүүлж буй залуу мэргэжилтнүүдэд туршлага олгох зорилгоор “Tech ignite talk” буюу “Технологийн яриа” арга хэмжээг цахимаар зохион байгуулсан. Арга хэмжээнд МУИС-ийн эрдэмтэн, профессорууд, Датаком, Эмпасофт, Мазаалай, Энд системс тех зэрэг мэдээлэл, технологийн компаниудаас нийт 12 илтгэгч интернэт, нано биотехнологи, их өгөгдөл, блокчейн, гурван хэмжээст хэвлэл, цахим хийсвэр орчин, хиймэл оюун ухаан, сансрын өрсөлдөөн зэрэг сэдвүүдээр илтгэл танилцуулж, 26000 хүнд шууд дамжуулан хүргэсэн байна. Инновацийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, шинэ мэдлэг патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах, төр хувийн хэвшлийн түншлэл, эрдэм шинжилгээ судалгааны байгууллага, хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, түүн дэх залуучуудын оролцоог дэмжих талаар бодлого, эрх зүйн орчин дугмаг байна. Инноваци, шинэ мэдлэг, патент бүтээж байгаа залуу эрдэмтэн судлаачид гарааны компани байгуулж, түүгээрээ дамжуулж бизнес, эдийн засгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байгаа залуусыг урамшуулж, дэмжих бодлого хэрэгцээтэй байна.

... ЗХДТХ хуулийн хэрэгжилт хангалтгүй байна гэж үзвэл шалтгаан нь юу вэ?

...Залуучуудын санал санаачилгад дэмжлэг сул, бид үйл ажиллагаагаа ядаж 1000 залууст хүргэе гэхэд төсөвлөсөн санхүү нь хүрдэггүй. Тэгэхлээр үйл ажиллагаанд зориулсан санхүүжилт бага байдагтай холбоотой гэж хэлнэ...

ЗХТ-ийн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас...

... ЗХДТХ хуулийн хэрэгжилт хангалтгүй байна гэж үзвэл шалтгаан нь юу вэ?

...Залуучуудын санал санаачилгад дэмжлэг сул, бид үйл ажиллагаагаа ядаж 1000 залууст хүргэе гэхэд төсөвлөсөн санхүү нь хүрдэггүй. Тэгэхлээр үйл ажиллагаанд зориулсан санхүүжилт бага байдагтай холбоотой гэж хэлнэ...

ЗХТ-ийн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас...

Үнэлгээ.



9.1.Залуучуудын хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй, чанартай боловсрол эзэмшүүлэхийг дараах чиглэлээр дэмжинэ: 9.1.1.үндэстний цөөнх, шилжин суурьшигч, зорилтот бүлгийн залуучуудын боловсролын хэрэгцээнд суурилсан сургалтыг насан туршийн боловсролын хөтөлбөрийн дагуу эзэмшүүлэх;	Хэрэгжилт хангалттай. 100%
9.1.2.залуучуудыг эх орондоо болон гадаад улсад мэргэжил эзэмших, мэргэших боломжийг бүрдүүлэх;	Хэрэгжилт хангалттай. 100%
9.1.3.номын сангийн үйлчилгээг залуучуудад хүртээмжтэй болгох арга хэмжээ авч, цахим номын сан хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	Хэрэгжилт хангалттай. 100%
9.1.4.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь хугацаат цэргийн алба хаасан, цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан суралцагчийн амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийн багц цагийг нөхөн тооцох;	Хэрэгжилт хангалтгүй. 0%
9.1.5.энэ хуулийн 8.1.3 дахь заалт, 8.3 дахь хэсэгт заасан цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан, их, дээд сургуульд элсэн суралцах болзол хангасан залуучуудыг Боловсролын зээлийн сангаас олгох оюутны хөгжлийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулах.	Хэрэгжилт хангалтгүй. 0%
9.2.Энэ хуулийн 9.1.1, 9.1.2, 9.1.3-т заасан хөтөлбөрийг залуучуудын болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлнэ.	Хэрэгжилт хангалттай. 100%
9.3.Энэ хуулийн 9.1.4-т заасан багц цаг нөхөн тооцох журмыг боловсролын болон батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.	-БШУЯ болон БХЯ хамтарсан журам гараагүй. Хэрэгжилт 0%
9.4.Залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, нас, сэтгэхүй, бие бялдар, түүх соёлын хөгжлийг судлахад чиглэсэн залуучууд судлалыг хөгжүүлнэ. 9.5.энэ хуулийн 9.4-т заасан арга хэмжээг Шинжлэх ухааны академи хэрэгжүүлж, Засгийн газарт тайлагнана.	Хэрэгжилт дундаж. 50%
9.6.Залуучуудыг соёл, урлаг, шинжлэх ухааны шинэ бүтээл туурвихыг дэмжинэ.	Хангалтгүй. Хэрэгжилт 30%
9.7.Шинжлэх ухаан, өндөр технологи, инновац, шинжилгээ, судалгааны чиглэлээр үндэсний тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Хэрэгжилт дундаж. 50%
9.8.Энэ хуулийн 9.6, 9.7-д заасан үйл ажиллагааг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж, Залуучуудын хөгжлийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.	Хангалтгүй. Хэрэгжилт 0%.



10-р зүйл. Залуучуудын эрүүл мэндийг хамгаалах

- 10.1.Хорт зуршил, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл дадал, хэвшилтэй иргэн болж төлөвшүүлэх зорилгоор залуучуудын эрүүл мэндийг дараахь чиглэлээр дэмжинэ:
 - 10.1.1.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагын суралцагчийг харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах ажлыг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран зохион байгуулах;
 - 10.1.2.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь оюутан, суралцагчийг эрүүл мэндийн даатгалд хамруулах;
 - 10.1.3.өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, цахим эрүүл мэндийн үйлчилгээг нэвтрүүлэх;
 - 10.1.4.залуучуудад гэр бүл төлөвлөлт, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг боловсрол, эрүүл мэнд болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран зохион байгуулах;
 - 10.1.5.зорилтот бүлгийн залуучуудад чиглэсэн биеийн тамир, спорт, сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх;
 - 10.1.6.олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт залуучуудад архи, тамхи, мансууруулах бодисын хор уршгийг ойлгуулах, эрүүл, зөв амьдралын хэвшлийг төлөвшүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ тусгах, хэрэгжилтийг зохион байгуулах.

Шалгуур үзүүлэлт. Энэ чиглэлээр ЭМЯ, БШУЯ, ХНХЯ-ны хамтран хэрэгжүүлсэн ажил, үр дүн.

2018 оноос хойш Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын хамтарсан "Оюутны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг зохион байгуулах тухай" тушаалын дагуу жил бүр оюутны эрүүл мэндийг дэмжих ажлыг тогтмол зохион байгуулж байна.

ЭМЯ-аас БШУЯ, ХНХЯ, НЭМГ, НЭМТ, ГБХЗХГ, СЭМҮТ-тай хамтран “Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аян”-ыг жил бүр тогтмол зохион байгуулж байна. Энэ аяны хүрээнд дараах ажлууд тогтмолжсон байна.

- Оюутан залууст зориулан “Нөхөн үржихүй-Гэр бүл төлөвлөлт”, БЗДХ-Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ”, “Архи, тамхины хор уршиг”, Эрүүл зөв хооллолт”: “Залуусын сэтгэлзүйн эрүүл мэнд” сэдвүүдээр 5 төрлийн инфографик бэлтгэн цахим хэлбэрээр түгээх
- Эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах ажлын хүрээнд аймаг, дүүргийн нөхөн үржихүй, өсвөр үе залуучуудын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн, ЭМБ-уудын их эмч, эх баригч, өсвөр үеийн кабинетын их эмч, бага эмч, ЕБС, МСҮТ-ийн нийгмийн ажилтан, Эрүүл мэндийн хичээл ордог багш нартай хамтран “Өсвөр үеийн эрүүл мэнд”, “Өсвөр насны хүүхдийн сэтгэлзүй”, “Эрүүл зөв хооллолт”, “Архи, согтууруулах ундаа болон тамхины хор уршиг”, “БЗДХ болон ХДХВ, ДОХ-ын



талаар ойлголт”, “Нөхөн үржихүй-гэр бүл төлөвлөлт” зэрэг сургалтыг зохион байгуулдаг.

- Мэдээлэл сургалт сурталчилгааны гарын авлага боловсруулан, түгээх ажлын хүрээнд оюутан сурагчдад мэдээлэл зөвлөгөө өгөх гарын авлагыг тарааж мэдээллээр хангаж ажилладаг.
- Мэдээлэл, сурталчилгааны материалыг олон нийтийн сүлжээнд идэвхжүүлэлт хийх ажлын хүрээнд “Нөхөн үржихүй-Гэр бүл төлөвлөлт”, БЗДХ-Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ”, “Архи, тамхины хор уршиг”, Эрүүл зөв хооллолт”: “Залуусын сэтгэлзүйн эрүүл мэнд” сэдвүүдээр мэдээлэл сурталчилгааны материал монгол хүний онцлогт тохируулан боловсруулж НЭМҮТ-ийн цахим хуудсаар оюутан сурагчдад зориулан түгээдэг.
- Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад 21 аймаг, нийслэлийн хэмжээнд жилд дунджаар 4,556 оюутан залуус амжилттай суралцдаг бол цахим контентууд 68000-100 000 хүнд хүрдэг байна.³

2022 онд “Эерэг хандлага–Эрүүл оюутан” уриатайгаар оюутны эрүүл мэндийг дэмжих сарын үйл ажиллагааг НҮБ-ын Хүн амын сангийн санхүү, техникийн дэмжлэг туслалцаатайгаар оюутан, суралцагчдад эрүүл мэндийн мэдлэг, боловсрол олгох сургалт, сурталчилгааг орон даяар зохион байгуулсан байна. .

Үүний зэрэгцээ оюутан суралцагчдыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулж, оюутан, суралцагчдын дунд зонхилон тохиолдож буй өвчлөлийн шалтгааныг тодруулан, дүн шинжилгээ хийжээ. Энэхүү арга хэмжээнд давхардсан тоогоор 40 000 оюутан хамрагдсан байна.

Хуулийн 10.1.2 заалтын хувьд ҮСХ 2022 оны мэдээгээр 19-с дээш насны 95,9 мянган оюутан, суралцагч байгаагаас эрүүл мэндийн даатгалд 14,3 мянган оюутан суралцагч л хамрагдаж шимтгэл төлсөн байна.

Манай төв нь залуучуудын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр сургалт зарлаад явуулдаг. БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх, хорт зуршлаас сэргийлэх чиглэлээр түлхүү заадаг. Гэвч эрүүл мэндийн газраас наадах чинь манай ажил, эсхүл та нар эмч, эмнэлэгийн мэргэжилтэн биш байж яагаад эдгээр сэдвээр хамаагүй яриад байгаа юм бэ? үнэн зөв мэдээлэл өгч байгаа юмуу гэдэг. Бид НҮБ-ын дэмжлэгээр сургалтад суугаад сургагч багш болсон гэж хэлсэн ч нарийн мэргэжлийн хүн заах ёстой гээд байдаг нь хэцүү байдаг. Гэтэл манай төвийн чиг үүрэгт байгаа болохоор бид бас ажил хийхгүй бол болохгүй.

Чанарын судалгааны явцад ЗХТ-ийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас...

ЗХТ-ийн чиг үүрэгт төрийн байгууллага хоорондын үйл ажиллагааны давхцал байгааг анхаарч үзэх, үйлчилгээ арга зүйг илүү нарийвчлан тогтоож өгөх нь зүйтэй байна.

Үнэлгээ.

³ “Эрүүл оюутан – эерэг хандлага” уриан дор оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аян зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан. 2021. ЭМЯ. 2022



<p>10.1.Хорт зуршил, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл дадал, хэвшилтэй иргэн болж төлөвшүүлэх зорилгоор залуучуудын эрүүл мэндийг дараахь чиглэлээр дэмжинэ: 10.1.1.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагын суралцагчийг харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах ажлыг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран зохион байгуулах;</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 100%</p>
<p>10.1.2.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь оюутан, суралцагчийг эрүүл мэндийн даатгалд хамруулах;</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 100%</p>
<p>10.1.3.өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, цахим эрүүл мэндийн үйлчилгээг нэвтрүүлэх;</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 100%</p>
<p>10.1.4.залуучуудад гэр бүл төлөвлөлт, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг боловсрол, эрүүл мэнд болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран зохион байгуулах;</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 100%</p>
<p>10.1.5.зорилтот бүлгийн залуучуудад чиглэсэн биеийн тамир, спорт, сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх;</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 100%</p>
<p>10.1.6.олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт залуучуудад архи, тамхи, мансууруулах бодисын хор уршгийг ойлгуулах, эрүүл, зөв амьдралын хэвшлийг төлөвшүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ тусгах, хэрэгжилтийг зохион байгуулах.</p>	<p>Хэрэгжилт дундаж. 50%</p>



11-р зүйл. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

11.1. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дараах чиглэлээр дэмжинэ:

- 11.1.1. оюутан, залуучуудыг ажилд зуучилсан хөдөлмөрийн биржийг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх асуудлыг хөдөлмөрийн болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран хэрэгжүүлэх;
- 11.1.2. залуучуудыг хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэхийг дэмжих;
- 11.1.3. гадаад улсын тэргүүн туршлага, өндөр технологи, шинэ санааг үндэсний технологи болгон нутагшуулах, гарааны компани эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
- 11.1.4. хөдөлмөрийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран малчин залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;
- 11.1.5. гадаад улсад өндөр технологи, нарийн мэргэжил, ур чадвар эзэмшсэн залуучуудыг эх орондоо ажиллахыг дэмжих хөтөлбөрийг гадаад харилцааны болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлэх;
- 11.1.6. мэргэжлийн ур чадвараа сайжруулах, шинэ мэргэжил эзэмших сургалтад ажилгүй залуучуудыг хамруулах;
- 11.1.7. орон нутгийн захиалгат ажлын байранд ажиллахаар очсон залуучуудыг дэмжих;
- 11.1.8. ажил олоход хүндрэлтэй болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгссөн төгсөгчдийг дадлагажуулан байнгын ажлын байраар хангасан ажил олгогчийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжих;
- 11.1.9. хувийн хэвшлийн байгууллага /100 ба түүнээс дээш ажилтантай/ нийт ажилтнуудын 5 хувьтай тэнцэхүйц оюутны цагийн ажлын орон тоо гаргах;

Шалгуур үзүүлэлт. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, үр шимийг хүртсэн залуучуудын тоо

ЗХДТХ-ийн 11.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 6 дугаар сарын 19-ий өдөр “Оюутан цагаар хөдөлмөр эрхлэх журмыг” баталсан байна. Их дээд сургуулиудад Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвүүд байгуулагдаж аймаг нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь ажлын байрны зар мэдээллийг уг төвүүдэд хүргэх болсон байна. Уг журмын 2.6-д хуулийн 11.1.9 заалтыг тусгаж өгчээ.

Хөдөлмөр эрхлэлтийн болон залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран ажиллахаар журамд зааж өгчээ. Журмыг зөрчсөн аж ахуйн нэгжид хариуцлага хүлээлгэх, цагийн ажлаар залуусыг дэмжсэн байгууллагад дэмжлэг үзүүлэх хуулийн орчин бүрдээгүй байна.

ҮСТ газрын 2022 оны тайлан мэдээгээр бүртгэлтэй ажилгүй иргэдийн 13,3 хувь буюу 2164 нь 15-24 насны, 36,5 хувь буюу 59650 нь 25-34 насны залуус байна. Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төсөлд жилд 200 гаруй залуус хамрагдаж хөдөлмөр



эрхлэх, байнгын ажлын байртай болох, үе тэнгийн залуучуудтайгаа танилцаж, нөхөрлөж, хувь хүний ур чадвараа улам хөгжүүлж, улмаар ирээдүйдээ итгэлтэй алхаж, цаашид ажил хөдөлмөрийн гараагаа амжилттай эхлүүлэх ур чадварыг олж авч байна.

ХНХЯ-ы 2021,2022 оны тайлан мэдээгээр:⁴ “Залуучуудад зориулсан хөдөлмөр эрхлэлтийн шинэлэг үйлчилгээ”, “Бизнес төсөл боловсруулах гарын авлага”, “Гарааны бизнесийн арга хэмжээг зохион байгуулах гарын авлага”-ыг олон нийтэд зориулж, “Би өөрийн санаагаа хэрхэн бизнес болгохоо мэднэ” гарын авлагыг сургагч багш нарт зориулан боловсруулж, Залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн албан ёсны веб сайтад олон нийтэд зориулан байршуулан тархаасан.

Байгууллагын соёл, хувь хүний харилцаа хандлагын талаар сургалтыг Удирдлагын академид Дундговь аймагт зохион байгуулсан. Мөн ГБХЗХГ-аас “Хувь хүний харилцаа хандлага”, “Байгууллагын соёл” сэдвүүдээр сургалт зохион байгуулж 100 гаруй албан хаагчдад зохион байгуулсан. “Шинэ мянганы ёс зүй” цахим сургалтыг ГБХЗХГ, Сан их сургууль хамтран Өмнөговь аймагт зохион байгуулж төрийн албан хаагчдыг хамруулсан.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны санаачилгаар төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудтай хамтран “Халамжаас хөдөлмөрт” цахим ажил олгогчийн өдөрлөгийг зохион байгуулж, ажил хайгч, ажил олгогчийг цахимаар уулзуулж, цахим зөвлөгөө, ажил зуучлал, өдөрлөг зохион байгуулж, хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодлого, үйлчилгээ, арга хэмжээг сурталчлан ажиллажээ. Тус цахим өдөрлөгт/www.expromongolia.org/career экспроплатформ/ нийт 14845 хандаж, үзэж танилцсан бөгөөд цахим хурлын платформ болон “Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар” фейсбүүк хуудсаар 24141 хүн, нийтдээ давхардсан тоогоор 38986 хүн үзэж сонирхсон байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Боловсрол шинжлэх ухааны яамны хамтран зохион байгуулсан “Цахим төгсөлт-Цахим ажлын байр” өдөрлөгт шинээр төгсөгч оюутан, залуучуудад зориулан Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг танилцуулан иргэд, олон нийтэд цахимаар мэдээлэл хүргэж, сурталчилж ажилласан.

Малчин залуучуудад аж ахуй эрхлэх, мал маллах уламжлалт арга барил эзэмшүүлэх, амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн мэдлэг, чадвар, чадамжийг хөгжүүлэх, насан туршийн боловсролын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр:⁵

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуй эрхлэгчдэд үйл ажиллагаагаа сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах санаачилгыг дэмжих, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийн хүрээнд Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 363 өрхийн 672 иргэн хамрагдаж, 704 ажлын байр бий болж, 1,686,000.0 мянган төгрөгийг; Мал маллах арга

⁴ ХНХЯ-ы 2021, 2022 оны тайлан мэдээ

⁵ ХНХЯ-ы 2020,2021 оны тайлан мэдээ



ухааны сургалт зохион байгуулах арга хэмжээнд 1,001 иргэн хамрагдаж, 96,835.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

“Орон нутгийн хөгжилд-залуучуудын оролцоо” аймгийн залуучуудын чуулган, “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аян, “Мэдлэгээ дээшлүүлж, мэдээллээ нэмэгдүүлье” өдөрлөг, “Career expo” хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг, Залуучуудыг гарааны бизнес эрхлэх мэдээллээр хангах “Нээлттэй хаалганы өдөрлөг” зэрэг арга хэмжээнд нийт 2600 орчим залуучуудыг хамруулсан.

“Халамжаас-Хөдөлмөрт” өдөрлөгийг 2021 онд зохион байгуулж, 1475 иргэн ажил хайгчаар бүртгүүлж, 1821 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 577 иргэнд төсөл, хөтөлбөрийн талаар мэдээлэл, танилцуулга хийж, 177 иргэн ажилд зуучлагдсан.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Боловсрол шинжлэх ухааны яамны хамтран зохион байгуулсан “Цахим төгсөлт-Цахим ажлын байр” өдөрлөгт шинээр төгсөгч оюутан, залуучуудад зориулан Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг танилцуулан иргэд, олон нийтэд цахимаар мэдээлэл хүргэж, сурталчилж ажилласан.

Гадаадад төгсөгчдийн нэгдсэн холбоо”, МҮХАҮТ-тай хамтран “Career expo” хөдөлмөрийн үзэсгэлэн яармагийг зохион байгуулж, 51 аж ахуйн нэгж, байгууллага оролцож, 3853 нээлттэй ажлын байрыг танилцуулсан. Тус арга хэмжээнд 750 гаруй залуучууд оролцож, давхардсан тоогоор 1724 ажилд орох анкет бөглөсөн. Мөн байгууллагын цахим хаягаар фейсбүүк орчинд 4 цагийн шууд дамжуулалт хийж олон нийтэд хүргэсэн. Залуучуудыг гарааны бизнес эрхлэх мэдээллээр хангах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулсан. Тус өдөрлөгт томоохон ажил олгогч компани болох “СҮҮ” ХХК, “ТЭСО” ХХК, “МОБИКОМ” ХХК-иуд оролцож, 6 залууг ажилд холбон зуучилж, 79 залууд зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2021-2022 оны хөтөлбөрийг батлах тухай” 01 дүгээр тогтоолын хүрээнд “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” батлагдаж хэрэгжсэн.

ХЭДС-аас Залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх, ажилд дадлагажуулан зуучлах цогц үйлчилгээг туршин нэвтрүүлэх болон аж ахуй эрхлэх бүтээлч, шинэлэг санал, санаачилгыг дэмжихэд зорилготой Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. 2021 онд өссөн дүнгээр нийт 9,339 иргэнийг хамруулж, 772,913:080 мянган төгрөгийг зарцуулж 6,660 иргэнийг ажлын байраар хангасан. Үүнийг арга хэмжээ тус бүрээр авч үзвэл:

- Ажлын дадал, туршлага үзүүлэх үйлчилгээнд 124 иргэн хамрагдаж, 78 иргэн байнгын ажлын байранд зуучлагдаж 44,312.8 мянган төгрөгийг;
- Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээнд 479 багийн 1,718 иргэн хамрагдаж, 117 иргэн байнгын ажлын байртай болж 683,620.9 мянган төгрөгийг;
- Цагийн ажилд зуучлах арга хэмжээнд 7,497 иргэн хамрагдаж, 6,465 иргэн ажлын байранд зуучлагдаж, 44,979.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчдад олгох “Оюутны хөгжлийн зээл”-ийн журмыг Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоолоор шинэчлэн



баталж, хэрэгжүүлж байна. 2.8-аас дээш сургалтын голч оноотой, санхүүгийн бололцоогүй, амжилттай суралцаж буй залуучуудыг дэмжсэн, хүүгүй, барьцаагүй, ажлын байранд эргэн төлөгдөх нөхцөлтэй Оюутны хөгжлийн 13 тэрбум төгрөгийн зээлийг 2018-2019 оны хичээлийн жилд нийт 9200 гаруй оюутан, суралцагчдад олгосон.

... Цагийн ажил хомс. Ажлын байр хомс. Цалин хөлс бага. 20-с дээш насныханд тогтмол ажлын байр олддоггүй...Шинэ гэр бүлийн орон байрны асуудлыг уяан хатан шийдэх байдал дутмаг....

Чанарын судалгааны явцад орон нутагт хийсэн фокус бүлгийн ярилцлагаас...

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа бодлого хөтөлбөрүүд нь тодорхой үр дүнгээ өгч байгаа ч алслагдмал хөдөө орон нутгийн залууст үр өгөөж сайн биш байгаа нь чанарын судалгаанаас харагдаж байна. Орон нутагт залууст ажлын байр олдохгүй байгаа энэхүү нөхцөл байдал нь төвлөрлийг нэмэгдүүлэх үндсэн шалтгаан болоод буй юм.

ХНХС-ын 2022 оны 3 сарын 27-ны А/54 тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ арга хэмжээг 2022-2023 онд зохион байгуулах нэгдсэн удирдамж батлах тухай тушаалд 7 хөтөлбөр 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

... Ажлын байрны нээлттэй өдөрлөг хийх, ажилд зуучлах зэрэг дээр ХХҮХ манай хэлтэс хоёрын чиг үүрэг давхцаад байдаг тул заримдаа хамтарна. Заримдаа манайх тайлан хэрэгтэй болдог тул нээлттэй өдөрлөг их дээд сургуулиудаар хийдэг. Манайхаас өмнө ХХҮХ хийгээд ирсэн ажил л даа. Заримдаа бид ийм нэг залуу байна ажил байна уу гэх зэргээр хамтардаг....

Чанарын судалгааны явцад ЗХТ-ийн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас...

ЗХДТХ-ийн Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гэсэн 11-р зүйл нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн заалтуудтай давхцаж буй тул ХХҮХ-үүд Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаанууд давхцадаг байна.

Үнэлгээ.



11.1.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дараах чиглэлээр дэмжинэ: 11.1.1.оюутан, залуучуудыг ажилд зуучилсан хөдөлмөрийн биржийг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх асуудлыг хөдөлмөрийн болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран хэрэгжүүлэх;	Хэрэгжилт дундаж. 60%
11.1.2.залуучуудыг хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэхийг дэмжих;	Хэрэгжилт хангалттай. 70%
11.1.3.гадаад улсын тэргүүн туршлага, өндөр технологи, шинэ санааг үндэсний технологи болгон нугагшуулах, гарааны компани эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх;	Хэрэгжилт дундаж 50%
11.1.4.хөдөлмөрийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран малчин залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;	Хэрэгжилт хангалтгүй. 30%
11.1.5.гадаад улсад өндөр технологи, нарийн мэргэжил, ур чадвар эзэмшсэн залуучуудыг эх орондоо ажиллахыг дэмжих хөтөлбөрийг гадаад харилцааны болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлэх;	Хэрэгжилт дундаж. 50%
11.1.6.мэргэжлийн ур чадвараа сайжруулах, шинэ мэргэжил эзэмших сургалтад ажилгүй залуучуудыг хамруулах;	Хэрэгжилт хангалттай. 100%
11.1.7.орон нутгийн захиалгат ажлын байранд ажиллахаар очсон залуучуудыг дэмжих;	Хэрэгжилт хангалттай. 80%
11.1.8.ажил олоход хүндрэлтэй болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгссөн төгсөгчдийг дадлагажуулан байнгын ажлын байраар хангасан ажил олгогчийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжих;	Хэрэгжилт хангалттай. 60%
11.1.9.хувийн хэвшлийн байгууллага /100 ба түүнээс дээш ажилтантай/ нийт ажилтнуудын 5 хувьтай тэнцэхүйц оюутны цагийн ажлын орон тоо гаргах;	Хэрэгжилт хангалттай. 80%



12-р зүйл. Аюулгүй амьдрах, хөгжих орчныг бүрдүүлэх

- 12.1.Залуучуудын аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг дараах чиглэлээр дэмжинэ:
- 12.1.1.орлоготой нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлөөр орон сууц худалдаж авах, түрээслэх, зорилтот бүлгийн залуучууд, залуу гэр бүлийг орон сууцжуулах хөтөлбөрийг залуучуудын болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлэх;

Шалгуур үзүүлэлт. Орлоготой нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлөөр орон сууц худалдаж авах, түрээслэх, зорилтот бүлгийн залуучууд, залуу гэр бүлийг орон сууцжуулах хөтөлбөрт хамрагдсан зорилтот бүлгийн залуучуудын тоо, зарцуулсан санхүүжилтийн хэмжээ

БХБЯ-ы тайлан мэдээгээр⁶ ипотекийн зээл авсан зээлдэгчдийн 53,2% нь буюу ойролцоогоор 23556 зээлдэгч нь 20-34 насны залуус байна. Эдгээр зээлдэгч “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам”-ын дагуу зээлдэгчид тавьсан нийтлэг шалгуур шаардлагыг хангаж зээл авсан бөгөөд залуу гэр бүлд гэсэн онцгой нөхцөл бүхий урт хугацааны хөнгөлөлттэй дэмжлэг байхгүй байна. Зээлүүдийн 77,4% нь Улаанбаатар хотод, 22,6% нь орон нутагт олгогджээ. Зээлдэгчдэд нийт 1,51 их наяд төгрөгийн зээлийг олгосон бөгөөд 61,7% нь эрэгтэй, 38,3% нь эмэгтэй зээлдэгчид байна.

Зээлдэгчдийн 91,7% нь цалин хөлстэй ажиллагч, 6,6% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байгаа бол үлдсэн 1,7% нь ажил олгогч, мал аж ахуй эрхлэгч болон бусад төрлийн ажил эрхлэлттэй байна. Зээлдэгчдийн 73,4% нь 60м.кв хүртэлх талбайтай орон сууц худалдан авсан бол үүнээс 27,2% нь 40-50м.кв байр худалдан авсан байна.

Монгол Улсын Алсын хараа 2050, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “150 мянган айл-Орон сууц” үндэсний хөтөлбөр болон Монгол Улсын Ерөнхий сайдаас 2021 онд барилгын салбарын төлөөллүүдтэй хийсэн уулзалтын үеэр өгсөн чиглэлийн дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 43 дугаар захирамжаар “Залуус” орон сууцны цогцолбор байгуулах ажлын хэсгийг байгуулсан. БХБЯ-наас төслийн концепц, техникийн шийдлийг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, ХУД-ийн 21-р хороо, Морингийн даваа орчимд “ТОСК” ТӨХХК-ийн 57 га талбайд төслийг хэрэгжүүлэхээр тогтож, БХБСайд болон НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч хамтран 2021 онд 2021/03 дугаартай ажлын даалгаврыг баталсан. Ажлын даалгаврын дагуу “Залуус-1” орон сууцны хорооллын ТЭЗ-ийн урьдчилсан судалгаа, эх загвар зураг боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгож “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулж эх зураг батлагдсан. Төслийн талбайд төрийн захиргааны байгууллага, олон нийтийн төв, мэдээлэл, технологийн кластер, эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний 5200 ажлын байр, зам, талбай, ногоон байгууламж, 5616 айлын орон сууцыг цогц байдлаар төлөвлөсөн бөгөөд төслийн эхний ээлжийг 2024 онд ашиглалтад оруулна.

Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журмын дагуу нийслэлд түрээсийн орон сууцны 20 хувь, орон нутагт 18 хувийг залуу гэр бүл /гэрлэлтээ

⁶ БХБЯ-ны 2022 оны тайлан мэдээ.



батлуулсан, 35 хүртэлх насны эхнэр, нөхөр/- олгох квот тогтоож, 2016-2021 оны нийт дүнгээр нийслэлд 59 гэр бүлийг түрээсийн орон сууцанд хамруулж квотын хэрэгжилт 90 хувь, орон нутагт 63 гэр бүлийг түрээсийн орон сууцанд хамруулж квотын хэрэгжилт 90 хувьтай байна.

... Залуу гэр бүлд зориулсан урт хугацааны хөнгөлөлттэй орон сууцны зээл хэрэгтэй байна. Залуучуудын хувьд урьдчилгаа мөнгө дээр асуудалтай байдаг ч үүнд уян хатан бодлого байхгүй байна. Ар гэрийн дэмжлэгтэй боломжтой залууст л одоогийн журам нь үйлчилдэг.

Чанарын судалгааны явцад орон нутагт хийсэн фокус бүлгийн ярилцлагаас...

Залууст хүргэх орон сууцны хүртээмж хязгаарлагдмал, тогтмол орлогогүй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг залууст боломж хязгаарлагдмал байна. Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хөдөөгийн сэргэлт” бодлогын хүрээнд залууст зориулсан хөнгөлөлттэй зээлийн хүртээмж бага байна. Залуучуудын нийгмийн томоохон асуудлын нэг бол орон сууцны асуудал бөгөөд үүнийгээ шийдвэрлэж чадахгүй байх нь эцэг, эхийн хамт нийлмэл гэр бүл үүсгэн амьдрах, цаашлаад гэр бүл тогтворгүй байх нэг үндсэн шалтгаан болж байна. Залууст чиглэсэн эрх зүйн зохицуулалт, бодлогын хөтөлбөрүүд нь тэдний өмнө тулгарч буй нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд илүү түлхүү анхаарах нь зүйтэй.

- 12.1.2.залуучуудыг гэмт хэрэгт татагдан орохоос урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгмийн оролцоотой зохион байгуулах;
- 12.1.3.хорих болон засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож байгаа залуучуудад зориулсан сэтгэл заслын үйлчилгээ, соёл, спорт, хүмүүжлийн арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотой зохион байгуулах;
- 12.1.4.гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлсэн залуучуудад боловсрол, мэргэжил олгох, хорих ангиас суллагдах үед ажлын байраар хангах талаар төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн гаргасан санаачилгыг дэмжих;
- 12.1.5.хөдөө, орон нутгийн бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулж, үр бүтээлтэй ажиллаж, амьдарч байгаа залуучуудыг дэмжих, алдаршуулах;
- 12.3.Залуучуудын өөрийгөө хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг дараах чиглэлээр дэмжинэ:
 - 12.3.1.залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн, соёл, урлаг, биеийн тамир, спортын цогцолбор, хөгжлийн төв, цэцэрлэгт хүрээлэн, дэд бүтцийг шинээр барьж байгуулах, өргөтгөх төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх;
 - 12.3.2.залуучуудын авьяас чадвар, бие бялдар, сэтгэхүйг хөгжүүлэхэд шашин болон улс төрөөс ангид урлаг, соёл, спортын арга хэмжээнд залуучууд оролцох, эдгээр арга хэмжээг зохион байгуулсан хуулийн этгээдийг дэмжих;
 - 12.3.3.түүх, соёлын өвийг хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ардын урлаг, ёс заншил, уламжлалт зан үйлийг хөгжүүлэхэд залуучуудын оролцоог хангах;
 - 12.3.4.залуучуудын дунд гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэх, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх, сурталчлах үйл ажиллагааг дэмжих;
 - 12.3.5.байгаль орчныг хамгаалах, ардын зан үйлийг сурталчлах, төлөвшүүлэх санаачилгыг дэмжих.



Шалгуур үзүүлэлт. Хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, хамрагдсан залуучуудын тоо

Аймаг, нийслэл, дүүргийн Залуучуудын хөгжлийн төвүүд, холбогдох төрийн захиргааны байгууллагууд нь иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ЗХДТХ-ийн 12 дүгээр зүйлийн заалтын хүрээнд дараах ажлуудыг хийж байна. Тухайлбал:⁷

- ЗХДТ, ГБХЗХГ-ууд нь 12-р зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал: ⁸Дорнод аймаг 2018 онд аймгийн залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 28 удаагийн сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд 4340 өсвөр үе, залуучуудыг хамруулжээ.
- 2019 онд “Бид Дорнодын залуус-2019” төслийн хүрээнд 20 000 орчим залууст хүрч нөлөөлжээ.
- 2020 онд Залуучуудын хөгжлийн төвөөс “Үндэсний бичгээ суралцъя, “Охид бидний ирээдүй”, “Хүрч очъё”, “Үлгэрч аав ээж” 4 удаагийн аяныг зохион байгуулж 4200 залууст хүрч ажиллажээ.
- 2021 онд “Нэг өдрийн цалин нэг хүний амь”, “Орон нутгийн оюутны хөгжил”, “Эх орон ч залуу”, “Иргэний андгай өргөх ёслол”, “Амьдрах ур чадварын сургалт” зэрэг 72 удаагийн сургалтаар 2150 залууст хүрч үйлчилжээ.
- 2022 онд 105 удаагийн уулзалт, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд 8500 гаруй өсвөр үе, залуучуудын оролцоонд тулгуурласан арга хэмжээг зохион байгуулжээ.
- 2023 оны хагас жилээр 102 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж 6225 өсвөр үе залууст хүрсэн байна.

Мөн хуулийн заалтын хүрээнд 2019-2021 онуудад дараах ажлууд хийгдсэн байна.⁹

Залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх чиглэлээр Монгол үндэсний хувцас” гэрэл зургийн уралдаан, “Эх дэлхийгээ хайрлах нь”, “Удам судраа мэдэж, угийн бичгээ хөтөлцгөөе” аян, “Эх орныхоо түүх, соёлыг танин мэдэх”, “Монгол ёс заншил, зан үйлд суралцах” сэдэвт 5 удаагийн нэвтрүүлэг, “Үндэсний соёл, өв уламжлалаа өвлүүлж, хөгжүүлэе” аян, эсээ бичлэгийн уралдаан зэрэг 20 орчим төрлийн арга хэмжээнд нийт 21000 гаруй залуучуудыг хамруулсан байна.

СХД-ийн “Хүүхдийн холбоо” санаачлан лаа, саван, үнэртүүлэгч үйлдвэрлэн борлуулж зорилтот бүлгийн үе тэнгийн найз нөхдөдөө туслах ажлыг зохион байгуулахад хэлтсийн зүгээс анги танхим, түүхий эд, арга зүйгээр дэмжин ажилласан. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авч буй хорихоос өөр төрлийн ялтай залуучуудыг хамруулан, “Тэр бүлийн үнэ цэнэ”, “Бодлоо удирдахуй, амжилттай явахад туслах арга”, “Харилцаа”, “Стресс”, “Зорилготой байх, зорилгоо тодорхойлохуй”, “Өөртөө амлалт авч амлалтдаа хүрэх, өөртөө итгэх итгэл”, “Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх” сэдвээр сургалт зохион байгуулсан. Хувь хүний харилцаа, хорт зуршил, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх “Амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх 12 модуль сургалт”-ыг “Манай гэр” асрамж халамжийн төвийн хүүхдүүдэд зохион байгуулсан. Мөн Говьсүмбэр аймгийн ЗХТ тогтвортой хөгжилд залуусын оролцоог нэмэгдүүлэх, өөрийгөө хөгжүүлдэг, гэр бүл, нийгмийн амьдрал, улс орны хөгжилд идэвх

⁷ Авилгатай тэмцэх газрын тайлан мэдээ.2018-2022 он

⁸ Дорнод аймгийн ЗХТ-ийн үйл ажиллагааны тайлан. 2018-2023.

⁹ Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан мэдээ.



санаачилгатай оролцдог иргэнийг төлөвшүүлэх зорилгоор нийт 12 арга ажил хэмжээ, 1 подкаст, 1 нэвтрүүлэг, 1 цахим групп шинээр үүсгэн нийт 42 удаагийн сургалтыг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулж давхардсан тоогоор нийт 2143 хүнд шууд болон шууд бусаар хүрч, нийт 80000 гаруй үзэлтийн хандалтыг цахимаар авсан.

Залуучуудыг бүх нийтийн биеийн тамирын арга хэмжээнд тогтмол хамруулах ажлын хүрээнд “Осол гэмтлийг бууруулах нь”, “Тамхины эсрэг өдөр”, “Эрүүл оюутан-эерэг хандлага” зэрэг 10 гаруй төрлийн арга хэмжээ зохион байгуулж нийт 34000 орчим залуучууд, олон нийтийг хамруулсан.

Залуучууд, зорилтот бүлгийн залуучуудад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхдээ эрхийг нь хүндэтгэх, хамгаалах талаар эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын чадавхыг сайжруулах ажлын хүрээнд:

Асрамж, халамжийн газраас 18 насанд хүрч гарч буй залуучууд, хорих ангиас суллагдан гарч буй залуучуудын нийгэмд бие даан амьдрах чадварыг дэмжих хөтөлбөрийг олон улсын туршлагыг судлан боловсруулж холбогдох талуудаар 2 удаа хэлэлцүүлсэн. Саналыг тусган эцэслэж асрамж, халамжийн холбогдолтой хөтөлбөрийг ХНХСайдын тушаалаар, хорих ангийн холбогдох хөтөлбөрийг ХНХСайд болон ХЗДХСайдын хамтарсан тушаалаар батлуулахаар ажиллаж байна.

Говь-Алтай, Дорнод, Орхон, Хэнтий, Увс, Сүхбаатар аймагт “Эрт илрүүлж-Эрт эмчлүүлцгээе” аянд 192 оюутан, АШУҮИС-ын Говь-Алтай аймаг дахь анагаах ухааны сургуулийн 2-3-р дамжааны 321 оюутан залуучуудыг, хорих ангиас суллагдахад нь нийгмийн дэмжлэг тусалцааг үзүүлэх, амьдрах ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ганцаарчилсан зөвлөгөө уулзалтад Хорих 437-р ангид хүмүүжиж байгаа зорилтот бүлгийн 10 хүмүүжигчийг, “Хөдөлмөр зуслан” арга хэмжээнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан болон бэлгийн хүчирхийллийн хохирогч 18 өсвөр үеийнхнийг, хувь хүний хөгжлийг дэмжих, эерэг зан үйлтэй болоход нөлөөлөх, хорт зуршлаас татгалзах, өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, өөртөө итгэх итгэл зэрэг сэдвээр сургалтад ЕБС-ийн ахлах ангийн 94 сурагч, захиргааны журмаар түр баривчлагдсан 12 залуу, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 2 хүүхдийг, аймгийн Эрүүл мэндийн төвд өсвөр үеийн кабинет байгуулж, хувь хүний нууцлалыг хадгалах зорилгоор тусгай хаалгаар үзүүлэх үйлчилгээнд 2400 охид, залуу эмэгтэйчүүдийг тус тус хамруулсан.

... Манай төвийн тогтмолжсон үйл ажиллагаа бол зорилтот бүлгийн залуучууд руу чиглэсэн амьдрах ухааны сургалт буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтран хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан залуучуудад явуулдаг амьдрах ухааны сургалт юм.

Чанарын судалгааны явцад ЗХТ-ийн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас...

Өсвөр үе, залуучууд, олон нийтэд чиглэсэн сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг түгээх, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр: “Цахим сэтгэл зүйн үйлчилгээ”-ний <https://bit.ly/3gfoSCx> хуудсыг Залуучуудын хөгжлийн төвүүд болон Хүүхдийн тусламжийн 108 утасны төв хамтран 24 цагаар ажиллуулж, сэтгэл зүйн үнэ төлбөргүй зөвлөгөөг 2021 онд 1335 залуучуудад хүргэсэн.



“Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийн судалгаа”-нд 183 хүүхэд, өсвөр үеийнхнийг хамруулж, сэтгэл зүйн подкаст, зөвлөгөө, мэдээлэл, үйлчилгээнд 68 мянга гаруй өсвөр үеийнхэн, залуучуудыг хамруулсан.


Залуучуудын хөгжлийн төвийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, арга зүйн зөвлөмж өгөх, уулзалтыг ОУХНайрамдал цогцолборт 2021 оны 12 дугаар сард зохион байгуулж Залуучуудын хөгжлийн төвийн 100 ажилтныг хамруулсан. Сургалтаар залуучуудын асуудлаар үүрэг хүлээгчдийн санал бодлыг сонсож, холбогдох арга зүй, зөвлөмжийг хүргэсний дотор сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх арга зүй, аргачлал багтсан. Мөн цахим сэтгэл зүйн пэйж хуудас нээж салбарын сэтгэл зүйч мэргэжилтэй албан хаагчид болон 108 төвтэй хамтран мэргэжлийн сэтгэл зүйчдээр дамжуулан 24 цагаар сэтгэл зүйн зөвлөгөө өгч байна.

“Хувь хүнийг хөгжүүлэх 12 модуль сургалт”, “Харилцаа”, “Гэр бүл төлөвлөлт”, “Стресс бухимдлаа зөв зохицуулах нь” сургалт, “CV resume, ажлын ярилцлагад амжилттай бэлтгэх нь”, “Жилийн төлөвлөлтийг хэрхэн хийх вэ?” зэрэг сэдэвт сургалт, нөлөөллийн арга хэмжээнд зорилтот бүлгийн 17363 залуучуудыг хамруулсан.

Асуулгын судалгааны үр дүнгээс үзвэл залуучуудын 22% ЗХТ-өөс зохион байгуулсан үйл ажиллагаанд бүрэн хамрагдаж байгаа нь сайшаалтай байна. Энэ үзүүлэлт нь эдгээр залуусын хэрэгцээг ЗХТ хангаж байгааг илтгэж буй юм. Харин 38% нь огт хамрагдаж байгаагүй нь мэдэхгүй, эсхүл хэрэгцээгүй, сонирхлыг татаагүй байж болох юм. 40% нь заримдаа оролцож байгаа нь шаардлага гарсан үед очдог, мэдээлэл аваагүй, эсхүл хүсдэггүй хэсгийнхэн байж болох юм. Дүгнээд үзвэл нийт залуусын 62% ямар нэг байдлаар ЗХТ-ийн үйл ажиллагаанд хамрагдаж байсан нь баримт бичгийн судалгаанд гарч буй тайлан мэдээ үр дүнд хүрч байгааг нотолж буй юм.

График 2. Залуучуудын ЗХТ-ийн үйл ажиллагаанд хамрагдалт


Та өөрийн аймаг, дүүрэг, орон нутгийн Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаанд хамрагдаж байсан уу?



Эх сурвалж: Залуучуудаас авсан түүвэр судалгаа, Түүврийн хэмжээ N=555, Q4



График 3. Залуучуудын чиглэлийн үйл ажиллагааг мэддэг байдал



Эх сурвалж: Залуучуудаас авсан түүвэр судалгаа, Түүврийн хэмжээ N=555, Q5

Мөн судалгаагаар Залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр төрийн холбогдох байгууллагаас явуулдаг үйл ажиллагаануудыг та хэр мэдэх вэ? гэсэн асуулгад 28% бараг мэдэхгүй, 16% огт мэдэхгүй гэж хариулжээ. Нийт залуусын 34% тэдний хөгжлийг дэмжих үйл ажиллагааг мэдэхгүй байгаа нь ЗХТ-өөр үйлчлүүлж байгаагүй 38% -ыг баталж буй юм. Энэ үзүүлэлт нь монголын залуучуудын 40% нь хөгжлийн үйлчилгээний гадна байгааг харуулж байна. Эдгээр залуус нь дэмжлэг авах зайлшгүй шаардлагатай ч мэдээллийн гадна үлддэг, эсхүл хэрэгцээ байхгүй хэсгийнхэн үү? гэдгийг нарийвчилж авч үзэх нь зүйтэй. Залуусын 56% залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг мэднэ гэсэн нь ЗХДТХ-ийн холбогдох заалтын хэрэгжилтийн арга хэмжээнүүд хүрч үйлчилж байгааг нотолж буй юм.

Үнэлгээ.



12.1.Залуучуудын аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг дараах чиглэлээр дэмжинэ: 12.1.1.орлоготой нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлөөр орон сууц худалдаж авах, түрээслэх, зорилтот бүлгийн залуучууд, залуу гэр бүлийг орон сууцжуулах хөтөлбөрийг залуучуудын болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлэх;	Хэрэгжилт дундаж. 50%
12.1.2.залуучуудыг гэмт хэрэгт татагдан орохоос урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгмийн оролцоотой зохион байгуулах;	Хэрэгжилт дундаж. 60%
12.1.3.хорих болон засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож байгаа залуучуудад зориулсан сэтгэл заслын үйлчилгээ, соёл, спорт, хүмүүжлийн арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотой зохион байгуулах;	Хэрэгжилт хангалттай. 70%
12.1.4.гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлсэн залуучуудад боловсрол, мэргэжил олгох, хорих ангиас суллагдах үед ажлын байраар хангах талаар төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн гаргасан санаачилгыг дэмжих;	Хэрэгжилт хангалттай. 70%
12.1.5.хөдөө, орон нутгийн бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулж, үр бүтээлтэй ажиллаж, амьдарч байгаа залуучуудыг дэмжих, алдаршуулах;	Хэрэгжилт дундаж. 60%
12.3.Залуучуудын өөрийгөө хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг дараах чиглэлээр дэмжинэ:	
12.3.1.залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн, соёл, урлаг, биеийн тамир, спортын цогцолбор, хөгжлийн төв, цэцэрлэгт хүрээлэн, дэд бүтцийг шинээр барьж байгуулах, өргөтгөх төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх;	Хэрэгжилт хангалтгүй. 30%
12.3.2.залуучуудын авьяас чадвар, бие бялдар, сэтгэхүйг хөгжүүлэхэд шашин болон улс төрөөс ангид урлаг, соёл, спортын арга хэмжээнд залуучууд оролцох, эдгээр арга хэмжээг зохион байгуулсан хуулийн этгээдийг дэмжих;	Хэрэгжилт дундаж. 70%
12.3.3.түүх, соёлын өвийг хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ардын урлаг, ёс заншил, уламжлалт зан үйлийг хөгжүүлэхэд залуучуудын оролцоог хангах;	Хэрэгжилт дундаж. 60%
12.3.4.залуучуудын дунд гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэх, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх, сурталчлах үйл ажиллагааг дэмжих;	Хэрэгжилт хангалттай. 90%
12.3.5.байгаль орчныг хамгаалах, ардын зан үйлийг сурталчлах, төлөвшүүлэх санаачилгыг дэмжих.	Хэрэгжилт дундаж. 60%



2.2 ГУРАВДУГААР БҮЛЭГ: ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦООГ ДЭМЖИХ

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн гуравдугаар бүлэг буюу залуучуудын оролцоог дэмжих бүлгийн хэрэгжилт харьцангуй хэрэгжиж байна.



13-р зүйл. Нийгмийн хөгжилд залуучуудын оролцоог дэмжих

- 13.1.Төрөөс залуучуудын оролцоог дараах чиглэлээр дэмжинэ:
 - 13.1.1.залуучууд өөрсдийн эрх ашигт нөлөөлөх аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох, хэрэгжилтийг хамтран зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;
 - 13.1.2.залуучуудын иргэний нийгмийн байгууллагын нийтэд тустай үйл ажиллагааг дэмжих;
 - 13.1.3.залуучуудын хүмүүнлэгийн болон сайн дурын ажилд оролцох оролцоог дэмжих.

Шалгуур үзүүлэлт. Нийгмийн хөгжилд залуучуудын оролцоог дэмжих чиглэлээр зохион байгуулсан ажил, хамрагдсан залуучуудын тоо

- ❖ Залуучууд эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхийг дэмжих, боломжийг бүрдүүлэх чиглэлээр.¹⁰

Хуулийн тайлант хугацаанд сум, аймаг, нийслэл залуучуудын чуулга уулзалтыг шат бүртээ жил бүр хийж ирсэн төдийгүй нам, олон нийтийн байгууллагуудын дунд залуучуудын зөвлөл, нэгдэл байгуулагдах, элсэх нь чөлөөт сонголтоор хангагдсан байна.

Залуучуудын эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангах чиглэлээр Залуучуудын үндэсний чуулганыг жил бүр зохион байгуулж ирсэн.

Үндэсний хэмжээнд 21 аймаг, 8 дүүрэг, 56 сум, 124 хороо, төрийн захиргааны байгууллагын дэргэд 78, ААНБ-ын дэргэд 133, Сонирхлын 3 нийт 436 залуучуудын зөвлөл байгуулагдаж 7000 гаруй залуучуудыг бүртгэсэн нь залуучуудын нийгмийн хөгжилд оролцох оролцоог идэвхжүүлсэн ажил болжээ.

¹⁰ ГЕХЗХГ-ын тайлан мэдээ. 2020,2021,2022 он



2022 онд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт, Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээ, арга хэмжээг сурталчлах тус бүр 5-8 минутын, нийт 6 видео болон цахим, хэвлэмэл постерийг “Медиус” ХХК-тай хамтран бэлтгэж, Залуучуудын хөгжлийн үндэсний чуулган болон бусад арга хэмжээ, ХНХЯ, ГБХЗХГ-ын цахим хуудас, аймаг, дүүргийн Залуучуудын хөгжлийн төвүүд болон тэдгээрийн цахим хуудсаар залуучууд, олон нийтэд хүргэсэн.

- ❖ Олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан залуучуудын ёс суртахууны боловсролын түвшинг дээшлүүлэх, тэдний оролцоонд тулгуурлан хүмүүнлэгийн ажлыг өрнүүлэх чиглэлээр:

Сайн дурын ажлыг сурталчлах, таниулах, сургагч багш, сайн дурын ажилтан бэлтгэх 87 удаагийн сургалтыг зохион байгуулж, 76 сургагч багш, Хүүхэд хамгааллын сайн дурын 1476 ажилтныг бэлтгэж, 5643 сайн дурын ажилтныг хамруулсан. Мөн 3 чиглэлийн хүрээнд үйл ажиллагааг санхүүжүүлэх ашгийн бус төслийн уралдаан зарлаж, 35 төслөөс 5 төслийг шалгаруулж тус бүр 2 сая төгрөгөөр дэмжсэн. “MAX COURAGE” амьдрах ухааны болон эссе бичих чадвар эзэмшүүлэх ОУ-ын хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх онлайн 4 удаагийн сургалтад 21 аймгийн ЗХТ-ийн мэргэжилтнүүд, 330 сумаас 1 хүн нийт 360 сургуулийн нийгмийн ажилтан, Зэвсэгт хүчний Жанжин штабын харьяа 45 цэргийн ангийн соёл хүмүүжил хариуцсан офицеруудыг хамруулсан.

Зөв эрчүүдийн клуб”-тэй хамтран 15-34 насны залуучуудын хандлага, зуршлыг өөрчилж, эрүүл, хариуцлагатай байхыг уриалж “Зөв эрчүүдийн орон зай” онлайн хөтөлбөрийг хэрэгжүүлж, “Хөвгүүдийн эрүүл мэнд” цуврал лайв, 30 постерыг 13990 хүнд, 10 төрлийн бичлэгийг цахимаар 6084 хүнд хүргэсэн. Эрчүүдийн эрүүл мэнд, гэр бүлийн сэдвээр 10 бичлэгийг 26569 хүнд хүргэсэн. NTV телевиз, “Оранж медиа” ХХК-тай хамтран “Нийслэл хүүхэн” 12 ангит киног бүтээж хүргэсэн. Мөн “Оролцож байж гэрэл тусна” төслийн хүрээнд богино зохиолын 6 контентыг бүтээн 8723 үзэгчдэд хүргэсэн.

Залуучуудад өөртөө итгэлтэй байх өөрийгөө зөв илэрхийлэх соёлыг сурталчлах “Нэг хүн-Нэг хариуцлага” нөлөөллийн аян, социал орчин дахь сөрөг мэдээ мэдээллийг багасгах зорилгоор социал цахим хэлэлцүүлэг, “Танайд тоглоё” хөгжөөнт нэвтрүүлэг, мансууруулах бодисын хор уршиг, архины хор уршиг, зэрэг 8 төрлийн контентыг 170000 залуучуудад хүргэсэн. “Хамтдаа урлая” клуб, “Оюунлаг найзууд” ТББ, “Хөгжлийн шийдэл” ТББ, Засаг даргын дэргэдэх залуучуудын зөвлөл, “Хариуцлагатай манлайлагч залуус”, “Open Mic Erdenet Lowc”, “Лантуун дохио” Эрдэнэт хот дахь салбар, “Хөөрхөн Зүрх” ТББ-уудтай хамтран “Танд захидал ирлээ” нөлөөллийн арга хэмжээ, “Номтой нөхөрлөө” аян, гарааны бизнес эрхлэгчдэд шаардлагатай энтерпренер сэтгэлгээ, төсөл бичих арга зүй, сошейл маркетинг сэдэвт сургалт, флаш моб арга хэмжээ, “Чихрээс үнэтэй дурсамж” аян, “Өөрийгөө хайрлахуй” сургалт, “Сургууль ба охидын үзлэг” цахим хэлэлцүүлэг зэрэг 11 төрлийн нөлөөллийн арга хэмжээнд 520 залуучуудыг хамруулсан. Залуучуудын цахим чуулганыг зохион байгуулж, 800 гаруй залуучуудыг хамруулсан.

“Мансуурал донтолт, архи дан согтуурахын эсрэг Монголын залуучуудын эв нэгдэл” ТББ, “Оюунлаг Залуусын Давлагаа” ТББ, “Залуус өөрчлөлтийн төлөө” үндэсний хөдөлгөөн, “Баян-Өндөрийн хөгжил” ТББ зэрэг залуучуудын өөрийн удирдлагын байгууллагатай туршлага, мэдээлэл солилцох 12 цуврал арга хэмжээг зохион байгуулсан.



“Зөв эрчүүдийн клуб”-тэй хамтран залуучуудыг хандлага, зуршлаа өөрчилж, эрүүл, хариуцлагатай байхад уриалах “Зөв эрчүүдийн орон зай” онлайн хөтөлбөрийг хэрэгжүүлж, 13990 залуучуудыг хамруулсан.

❖ Зорилтот бүлэгт үйлчилгээ үзүүлэх залуучуудын сайн дурын ажлыг дэмжих чиглэлээр :

2018 оноос хойш “Нэг байгууллага-Нэг залуу гэр бүл”-ийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх сайн дурын үйл ажиллагааны дэвтрийг төрийн байгууллагаар аялуулах, хөгжлийн ялгаатай залуучуудын цахим урлагийн наадмыг зохион байгуулах зэрэг арга хэмжээг орон нутагт зохион байгуулж, 3500 гаруй залуучуудыг хамруулсан байна.

... ЗХДТ-ийн сул тал нь хүртээмжгүй байдал, олон нийтийг хамруулж чадахгүй байгаа явдал юм. Хүмүүнлэгийн болон сайн дурын үйл ажиллагаанд залуус өргөнөөр оролцож өөрсдөө хөгжвөл сайхан байна....

... Сэтгэхгүй, соёл зэргийг өөрчлөх нь чухал.

...Хорт зуршил хэрэглэхгүй байна гэдгийг мэдэж авч татгалзаж байна,. Шинэ үеийн залуучууд архи тамхинаас татгалзаж гангарч байна гэх мэт мессеж, үйл ажиллагаанууд нөлөөтэй байдаг.

Чанарын судалгааны явцад ЗХТ-ийн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас...

Шилжилтийг Дэмжих Хөтөлбөрийн Монголын залуучуудад чиглэсэн ИНБ болон залуучуудын чадавхыг нэмэгдүүлэх төслийг 2020 онд орон нутгийн түнш байгууллагууд болох Монголын Залуучуудын Эвсэл (МЗЭ), болон Иргэний Боловсролын Төв (ИБТ)-тэй хамтран Каритас Чех Републик байгууллага амжилттай хэрэгжүүлдээ. Монгол Улсын залуучууд, болон иргэний нийгмийг дэмжих төслийг Бүгд Найрамдах Чех Улсын Гадаад хэргийн яамны Шилжилтийг Дэмжих Хөтөлбөрөөс хамтран санхүүжүүлж, Европын Холбооны санхүүжилттэй "Бүгд залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө" төслийн хүрээнд хэрэгжүүлсэн юм. БНЧУ-ын Гадаад хэргийн яам уг төслийн үйл ажиллагааг дэмжихэд зориулж 424,282 чех кроны санхүүжилт олгожээ. Энэхүү төсөл нь Монгол Улсын хөгжил, шийдвэр гаргах үйл явцад оролцох залуучуудыг чадавхжуулах, залуучуудын ИНБ-уудыг бэхжүүлэх, цаашлаад Монгол Улсад сайн засаглал, ардчиллыг бэхжүүлэх зорилгоор хийгдсэн болно. Чехийн Гадаад хэргийн яамны санхүүгийн дэмжлэгтэйгээр төслийн баг төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: i) Залуучууд, залуучуудын ИНБ-уудын чадавхын зөрүү болон суралцах хэрэгцээг тодорхойлох судалгаа хийх, ii) Залуучуудын ТББ-уудын чадавхи бэхжүүлэх сургалт зохион байгуулах, iii) Залуучуудын иргэний оролцоог дэмжих зорилгоор мэдээллийн хуудас нийтэлж, түгээх, болон iv) 2020 оны УИХ-ын сонгуульд залуучуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх кампанит ажил явуулсан зэрэг багтана. Төсөл хэрэгжүүлэх хугацаанд COVID-19-ийн түгшүүртэй хүнд цаг үеэс үл шалтгаалан төслийн баг түнш байгууллагуудтайгаа нягт уялдаатай ажиллаж, төслийн төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлж, бодитой үр дүнд хүрч чадсан байна.

Төслийн үйл ажиллагааны үр дүнд залуучууд, болон залуучуудын ИНБ-уудын суралцах хэрэгцээг тодорхойлж, зорилтот 5 байршлаас (Улаанбаатар хот, Хэнтий, Баянхонгор, Дорноговь, Сэлэнгэ аймаг) 180 залуус өөрсдийн оршин суугаа орон нутагтаа чадавхжуулах сургалтад хамрагдаж залуучуудын оролцоо, нөлөөллийн талаар мэдлэг, ур чадвараа дээшлүүлэв. Сургалтын дараах үнэлгээний үр дүнгээс харахад уг сургалтууд үр дүнтэй болж, оролцогчид олон хэрэгцээтэй мэдлэг, ур чадвар эзэмшсэн байна. Цаашид



энэ мэтчилэн залуусын ИНБ-ын идэвхтэй үйл ажиллагааг тогтмол дэмжих, төсөл санхүүжилтийг холбон зуучлах, тэдний оролцоотой асуудлыг нь шийдвэрлэх үйл ажиллагааг тогтмолжуулах нь зүйтэй. Тухайлбал Монгол дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор Иргэний нийгмийн зөвлөх хороог 2023 оны 8 дугаар сард үүсгэн байгуулсан байна. Иргэний нийгэм нь хариуцлагатай, ил тод байдлыг дэмжихийн зэрэгцээ иргэдийг шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг олгон Монгол Улсын хөгжилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг.

Олон улсын түвшинд 2000 онд байгуулагдсан Иргэний нийгмийн зөвлөх хороо (ИНЗХ) нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ) болон иргэний нийгмийн байгууллагуудын хоорондын зөвлөлдөх үйл явцыг системчлэх зорилготой ба НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн зөвлөх статустайгаар үйл ажиллагаагаа явуулдаг.

НҮБХХ нь 2023-2027 онд Монгол Улсад хэрэгжүүлэх хөгжлийн туслалцааны баримт бичиг боловсруулалт тэргүүтэй өргөн цар хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудтай олон жилийн турш идэвхтэйгээр хамтран ажиллаж ирсэн бөгөөд тус хороо нь НҮБХХ-ийн зүгээс Монгол Улс дахь үйл ажиллагаандаа хүртээмжтэй, оролцоотой байдлыг тууштай баримтлах төдийгүй тогтвортой хөгжлийг дэмжихэд иргэний нийгэм чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг онцолж байгаагийн нэг илрэл юм.

НҮБХХ нь ИНЗХ-гоор дамжуулан Монгол Улс Тогтвортой хөгжлийн зорилтуудад 2030 он гэхэд хүрэхэд дэмжлэг үзүүлэн хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн гол чиглэлүүдэд үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудтай нээлттэй яриа хэлэлцээг өрнүүлэн хамтран ажиллах юм. Тус хороо нь жендэрийн тэгш байдал, залуучууд, хэвлэл мэдээлэл, сэргээгдэх эрчим хүч, засаглал, малчид, байгаль орчин, дижиталчлал, тогтвортой санхүүжилт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зэрэг салбар, салбартаа далайцтай ажил хийж хэрэгжүүлж буй иргэний нийгмийн байгууллагуудын гишүүнчлэлээс бүрдэж байгаа юм. Мөн ИНЗХ нь иргэний нийгмийн байгууллагуудад тулгамдаж буй асуудлаа илэрхийлэх, нэн чухал асуудлуудад анхаарал хандуулах, нийгмийн эмзэг бүлгийн хүмүүсийн эрхийг хамгаалахад хийж хэрэгжүүлж буй ажлуудаа НҮБХХ-тэй хамтран улам эрчимжүүлэхэд чухал ач холбогдолтой механизм байх юм.

Иймд Залуучуудын ИНБ-уудыг энэхүү хөтөлбөртэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд анхаарах нь зүйтэй.

... Залуучуудын нийгмийн оролцоог хангах гэдэг нь заавал нэг эвсэл, бүлгэм клүбээр дамжуулах, гишүүнчлэлтэй болох гэхээсээ илүүтэй сурч ажиллаж байгаа салбар бүртээ л залуу хүн санаачилгатай оролцоотой байх нь чухал гэж боддог. Залуучуудын өөрсдийн эрх ашигтай холбоотой асуудлаар хаана ч байсан нэгдээд дуу хоолойгоо гаргадаг, нэгнээ дэмждэг байх нь л чухал шүү дээ. Гэтэл заавал нэг байгууллага, юмны харьяалалд байж оролцоотой байна гэдэг ойлголтыг өөрчлөх ёстой. Залуу хүн гэдэг түлхүүлж биш өөрөө идэвхтэй байх нийгмийн бүлэг шүү дээ...

... Бид залуучуудын оролцоог нэмэгдүүлэх гээд ажил хийх гэхээр олон хүнийг хамруулах шаардлага гарна, маш их мөнгө шаарддаг. Бидэнд тийм төсөв байхгүй. Аль болох мөнгө шаардахгүй ажил хийж, тайланд бичих хэрэг гардаг....

Чанарын судалгааны явцад ЗХТ-ийн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас...



Үнэлгээ:

13.1.Төрөөс залуучуудын оролцоог дараах чиглэлээр дэмжинэ: 13.1.1.залуучууд өөрсдийн эрх ашигт нөлөөлөх аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох, хэрэгжилтийг хамтран зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;	Хэрэгжилт хангалттай. 100%
13.1.2.залуучуудын иргэний нийгмийн байгууллагын нийтэд тустай үйл ажиллагааг дэмжих;	Хэрэгжилт хангалттай. 70%
13.1.3.залуучуудын хүмүүнлэгийн болон сайн дурын ажилд оролцох оролцоог дэмжих.	Хэрэгжилт хангалттай. 70%

14-р зүйл.Залуучууд шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөл үзүүлэх

- 14.1.Залуучуудыг шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцуулах талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:
 - 14.1.1.шийдвэр гаргах, нөлөөлөл үзүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд шууд болон өөрийн төлөөллийн байгууллага, хуулийн этгээдээр дамжуулан оролцох боломжийг бүрдүүлэх;
 - 14.1.2.сайн засаглалыг хөгжүүлэх, авлигатай тэмцэх, түүнийг бууруулах үйл ажиллагаанд залуучуудын оролцоог дэмжих.

Шалгуур үзүүлэлт. Шийдвэр гаргах үйл ажиллагаанд залуусын оролцоо

Үндэсний хэмжээнд 21 аймаг, 8 дүүрэг, 56 сум, 124 хороо, төрийн захиргааны байгууллагын дэргэд 78, ААНБ-ын дэргэд 133, Сонирхлын 3 нийт 436 залуучуудын зөвлөл байгуулагдаж 7000 гаруй залуучуудыг бүртгэсэн. Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрмийг баталсан.

... Сумдын залуучуудын хөгжлийн зөвлөл сумын орлогч дарга нараар ахлуулсан байдаг. Бүгд мэдээлэл, тогтмол ажилтай байдаг. Тогтмол үйл ажиллагаануудаа аваад явдаг жилд 2 удаа тайлан явуулдаг. Бүх шатанд залуучуудын оролцоо харьцангуй сайжирсан. Гэхдээ хөдөө орон нутагт намчирхах байдал илт ажиглагддаг...

Чанарын судалгааны явцад орон нутгийн ЗХТ-ийн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас...

Зорилтот бүлгийн залуучуудыг дэмжих бүлэг, оролцооны зөвлөлийг Залуучуудын хөгжлийн төвүүдэд тогтмол ажиллуулах чиглэлээр:

Аймаг, дүүрэг, зарим сумдын Залуучуудын хөгжлийн төвийн дэргэд 110 гаруй сонирхлын клуб, зөвлөл, бүлгэм байгуулагдаж, 2500 орчим залуучууд хамрагдаж байна. Залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан өсвөр үе залуучуудын оюунд хөрөнгө оруулах зорилгоор “Хөгжилд бэлэн үү? хувь хүний академик хөтөлбөр”-ийг зохион байгуулж, 6 сургагч багшийн бүрэлдэхүүнтэй 9 өөр



хичээлийн хөтөлбөртэй 5 өдрийн турш үргэлжилж нийт 100 залууг хамруулан сертификат гардуулсан.

Шийдвэр гаргах түвшинд залуучуудын дуу хоолойг хүргэх зорилгоор МУ-ын засгийн газар жил бүр Залуучуудын үндэсний чуулганыг зохион байгуулдаг.

Энэ чуулганаар шийдвэр гаргагчид, олон нийтийн анхаарлыг залуучуудын хөгжил оролцоог дэмжихэд хандуулдаг. Монголын залуучуудын өдрийг тохиолдуулан Монгол Улсын Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын залуучуудын эвсэлтэй хамтран “Хүний эрхийг дээдэлсэн нийгэм цогцлооход төр, иргэний нийгэм, залуучуудын бүтээлч хамтын оролцоог бэхжүүлэе!” уриан дор Залуучуудын 9 дүгээр чуулганыг 2023 оны 8дугаар сарын 25 өдөр амжилттай зохион байгуулсан. Чуулганд иргэний нийгмийн төлөөлөл, залуу бизнес эрхлэгч, залуучуудын хөгжлийн төвийн сайн дурын ажилтан, залуучуудын хөгжлийн зөвлөлийн төлөөлөл, залуучуудын хөгжлийн төвийн мэргэжилтнүүд оролцож өөрсдийн орон нутагт залуучуудад тулгамддаг асуудал, онцлог, залуучуудын хөгжил, оролцоог хангахад ямар асуудал тулгарч буй болоод цаашид төрөөс хэрэгжүүлэх бодлого шийдвэрт өөрсдийн байр суурь, санал санаачилгаа илэрхийллээ. Чуулган 2 үндсэн хэлэлцүүлэг буюу “Хүний эрхийг дээдэлсэн нийгэм цогцлооход төр, иргэний нийгэм, залуучуудын бүтээлч хамтын оролцоо” “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, залуучуудын хөгжлийн тулгамдсан асуудал, боломжит шийдэл” сэдвүүдээр зохион байгуулагдсан. Мөн чуулганаар панелистүүд дараах сэдвийн хүрээнд илтгэл танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Оролцогчдын саналыг нэгтгэн боловсруулж зөвлөмж гаргаж чуулганы зөвлөмжийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдад гардуулан өгсөн.

Авлигатай тэмцэх газар 2018 оноос эхлэн МЗХ, МОХ -той хамтран авлига түүнээс хол байх, түүний хор хөнөөлийн талаар “Авлига түүнээс ангид хүн” лекц сургалтыг ЕБС, Их дээд сургуулиуд, МСҮТөвүүдэд тогтмол хийж ирсэн байна. Жилд дунджаар 5000 гаруй залууст сургалт мэдээллийг өгч ажиллажээ

Шударга ёсны үзэл санааг олон нийтэд төлөвшүүлэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж 2018,2019,2020,2021, 2022 онуудад дунд сургуулийн сурагчид, их дээд сургуулийн оюутнуудын дунд цахим нөлөөллийн ажлыг зохион байгуулахын зэрэгцээ, эцэг, эх, багш сурган хүмүүжүүлэгч нарт нөлөөлөх сургалтын ажлуудыг зохион байгуулжээ. Түүнчлэн сургагч багш бэлтгэх, цахим болон цаасан гарын авлага боловсруулан түгээх, хичээл сургалтын хөтөлбөрийн агуулгад сэдэв тусгах зэрэг ажлуудыг зохион байгуулсан байна.

Үнэлгээ.



<p>14.1.Залуучуудыг шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцуулах талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ: 14.1.1.шийдвэр гаргах, нөлөөлөл үзүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд шууд болон өөрийн төлөөллийн байгууллага, хуулийн этгээдээр дамжуулан оролцох боломжийг бүрдүүлэх;</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 100%</p>
<p>14.1.2.сайн засаглалыг хөгжүүлэх, авлигатай тэмцэх, түүнийг бууруулах үйл ажиллагаанд залуучуудын оролцоог дэмжих.</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 80%</p>

15-р зүйл. Сайн дурын ажилд оролцох оролцоог дэмжих

- 15.1.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага залуучуудын иргэний нийгмийн байгууллага, нийтэд тустай үйл ажиллагаа, хөдөлгөөнийг дараахь чиглэлээр дэмжинэ:
 - 15.1.1.залуучуудыг бие даан амьдрах, нийгэм, эдийн засгийн эрсдэлээс хамгаалахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр зохион байгуулах;
 - 15.1.2.залуучуудын соёл, боловсрол, иргэний үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;
 - 15.1.3.зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагааг сайн дурынхны оролцоотойгоор зохион байгуулах;
 - 15.1.4.хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамж, халамжийн үйл ажиллагаанд сайн дурынхан, аж ахуйн нэгж, байгууллага хамтран ажиллахыг дэмжих.
- 15.2.Энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т заасан сайн дурын ажилд оролцсон цагийг бүртгэж, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

Шалгуур үзүүлэлт. Залуучуудыг бие даан амьдрах, нийгэм, эдийн засгийн эрсдэлээс хамгаалахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, сайн дурын нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 03 сарын 28-ны өдрийн А/130 тоот тушаалаар “Залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журам” батлагдсан.

Сайн дурын ажлыг сурталчлах, таниулах, сургагч багш, сайн дурын ажилтан бэлтгэх 87 удаагийн сургалтыг зохион байгуулж, 76 сургагч багш, Хүүхэд хамгааллын сайн дурын 1476 ажилтныг бэлтгэж, 5643 сайн дурын ажилтныг хамруулсан. Мөн 3 чиглэлийн хүрээнд үйл ажиллагааг санхүүжүүлэх ашгийн бус төслийн уралдаан зарлаж, 35 төслөөс 5 төслийг шалгаруулж тус бүр 2 сая төгрөгөөр дэмжсэн. “MAX COURAGE” амьдрах ухааны болон эссе бичих чадвар эзэмшүүлэх ОУ-ын хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх



онлайн 4 удаагийн сургалтад 21 аймгийн ЗХТ-ийн мэргэжилтнүүд, 330 сумаас 1 хүн нийт 360 сургуулийн нийгмийн ажилтан, Зэвсэгт хүчний Жанжин штабын харьяа 45 цэргийн ангийн соёл хүмүүжил хариуцсан офицеруудыг хамруулсан.

- ❖ Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд үе тэнгийнхэнтэйгээ сурч, боловсрол эзэмших нөхцөл боломжийг бүх шатны сургуульд бүрдүүлж, тэгш хамран сургах чиглэлээр:

БСШУС-ын сайдын 2020 оны А/249 дүгээр тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл”-ийг баталсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмшихэд тулгарч байгаа бэрхшээлийг бууруулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг ерөнхий боловсролын сургуулийн орчинд зохион байгуулахад энэхүү чиглэлийг баримтлан ажиллах юм. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг ердийн хэв шинжтэй сургуульд шилжин ирсэн үед нийгэмших, сурах орчинд нь дасгах үүрэг бүхий “Дэмжлэгийн баг” сургуулийн захирлын тушаалаар байгуулагдан хөтөлбөр төлөвлөгөөтэй ажиллаж байна. “Ковид-19” цар тахлын үед ЕБС-уудын “Дэмжлэгийн баг”-ууд анхаарал тавих шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 75 сурагчдын ар гэрээр “Гэрийн айлчлал” хөтөлбөр хэрэгжүүлж, эцэг эх, асран хамгаалагч болон хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад хорио цээрийн дэглэмийн үед баримтлах эрүүл мэндийн зөвлөгөө, теле хичээлээс сурахад нь зөвлөмж, зөвлөгөөг өгч ажилласан.

ЖАЙКА-тай хамтран хэрэгжүүлсэн СТАРТ төслийн хүрээнд Хөвсгөл аймаг, Баянгол дүүрэг эрт оролцооны төслийг 2015-2019 онд амжилттай хэрэгжүүлж, төслийн дараагийн үе шатыг 2020 онд эхлүүлсэн. 25, 55, 63, 70, 116-р ЕБС, 10, 186-р цэцэрлэгт 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 500 сая төгрөгийн тавилга, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн худалдан авсан. Тусгай 10 дугаар цэцэрлэгийн санхүүжилт шийдэгдэж Монгол Улсад анх удаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан 120 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгын ажил 4.9 тэрбум төгрөгөөр хийгдэж дууссан. 2019-2020 оны хичээлийн жилд нийслэлийн 10, 186-р тусгай цэцэрлэгүүдэд 100 сая төгрөгийн хөрөнгөөр тоног төхөөрөмжийг сайжруулж, цэцэрлэг тус бүрд 128 сая төгрөгийн автобус олгосон. СБД-ийн 186-р тусгай цэцэрлэгт НҮБХС-гийн “Дотор агаарын чанарыг дээшлүүлэх” төслийн хүрээнд 238 сая төгрөгийн өртгөөр агааржуулалтын системийг шинэчилж байна. ДБ-ны санхүүжилттэй “Бага боловсролын шинэчлэл” төслийн хүрээнд хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29, 116-р сургуульд 120 мянган долларын өртөг бүхий цахим /DAISY/ ном тоглуулагч, дэлгэц уншигч монгол программ, цахим брайл төхөөрөмж зэрэг сургалтын тусгай хэрэгсэл нийлүүлсэн. Мөн нийслэлийн 25, 29, 55, 63, 70-р сургуулиудад дээрх төслийн хүрээнд 30 мянган долларын хөрөнгө оруулалтаар тайвшруулах өрөө, өдөр өнжүүлэх анги, хөдөлмөрийн хичээлийн дадлагын танхимыг байгуулсан.



Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын сонгох, сонгогдох эрхийг хангах чиглэлээр Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Өсвөрийн Парламент” хөтөлбөрийг УИХ, Тогтвортой Хөгжлийн Зорилгын дэд хороо, Парламентын Судалгааны Хүрээлэн, НҮБХС, “People in Need” байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрт 21 аймаг, 9 дүүргээс 9-11 дүгээр ангийн 90 сурагч хамрагдсан.

ИРЭЭДҮЙН ЭЗЭД-2021” аяны хүрээнд 6 удаагийн цахим сургалтыг зохион байгуулсан. Цахим өдөрлөгөөр ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад мэргэжил сонголтод зөвлөмж мэдээлэл хүргэх, гадаадад тэтгэлгээр суралцах боломжуудыг танилцуулах, боловсролын системийн онцлог, гарч болох хүндрэл, даван туулах зөвлөмж зөвлөгөөг цогцоор нь хүргэсэн. Аянд ЕБС-ийн ахлах ангийн 600 сурагчид цахимаар хамрагдаж, цахим өдөрлөгийн шууд дамжуулалтыг олон нийтийн сүлжээгээр 14794 хүнд хүргэж, сургалтын дараах судалгаанд 821 залуучуудыг хамруулж, ахлах ангийн 4 сурагчийг гадаад хэлний төвд 1 жил үнэ төлбөргүй суралцах эрхийн бичгээр урамшуулсан.

График 4. Залуучуудын оролцоог дэмждэг байдал



Эх сурвалж: Залуучуудаас авсан түүвэр судалгаа, Түүврийн хэмжээ N=555, Q6

Асуумжийн судалгаагаар залуус сайн дурын ажил, нийгэмд тустай оролцоог 30% нь сайн дэмждэг, 34% нь дунд зэрэг дэмждэг гэж үзсэн нь нийт залуусын 60 гаруй хувь нь энэ чиглэлийн үйл ажиллагаандаа тодорхой дэмжлэг авдаг болохыг илтгэж байна.

... Залуусын сайн дурын үйл ажиллагаанууд төв суурин газруудад л идэвхтэй байдаг. Суманд ч гэсэн идэвхжүүлмээр байгаа...

... Орон нутагт намчирхах, залуу хүн байж гэж гадуурхах байдал түгээмэл байдаг...

Чанарын судалгааны явцад хийсэн фокус бүлгийн ярилцлагаас...

Үнэлгээ:



<p>15.1.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага залуучуудын иргэний нийгмийн байгууллага, нийтэд тустай үйл ажиллагаа, хөдөлгөөнийг дараахь чиглэлээр дэмжинэ: 15.1.1.залуучуудыг бие даан амьдрах, нийгэм, эдийн засгийн эрсдэлээс хамгаалахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр зохион байгуулах;</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 80%</p>
<p>15.1.2.залуучуудын соёл, боловсрол, иргэний үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 90%</p>
<p>15.1.3.зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагааг сайн дурынхны оролцоотойгоор зохион байгуулах;</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 90%</p>
<p>15.1.4.хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамж, халамжийн үйл ажиллагаанд сайн дурынхан, аж ахуйн нэгж, байгууллага хамтран ажиллахыг дэмжих.</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 70%</p>
<p>15.2.Энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т заасан сайн дурын ажилд оролцсон цагийг бүртгэж, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 80%</p>



16-р зүйл. Хүмүүнлэгийн ажилд оролцох оролцоог дэмжих

- 16.1. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т заасан сайн дурын болон хүмүүнлэгийн ажилд оролцсон залуучууд болон залуучуудын иргэний нийгмийн байгууллагын сайн туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан алдаршуулж, олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ.

Шалгуур үзүүлэлт. Сайн туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан алдаршуулж, олон нийтэд түгээн дэлгэрүүлсэн байдал

Аймаг, сум, нийслэл, дүүргүүд жил бүр шилдэг залуусаа шалгаруулж байна. Тухайлбал “Шилдэг авьяаслаг залуу”, “Шилдэг спортлог залуу”, “Шилдэг хөдөлмөрч залуу”, “Шилдэг малчин залуу”, “Шилдэг бизнесмен залуу”, “Шилдэг оюунлаг залуу” гэсэн төрлүүдээр шалгаруулдаг нь хэвшил болон тогтсон байна.

УБ хотын хувьд “Нийслэлийн шилдэг залуу”, “Залуучуудад ээлтэй байгууллага” шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж, Шилдэг залуу” шагналд 63, “Ээлтэй байгууллага” шагналд 20 оролцогч өрсөлдөж, “Шилдэг 10 залуу”, “Ээлтэй 5 байгууллага”-ыг сонгон шалгаруулж олон нийтэд сайн туршлагыг түгээн сурталчлах ажил тогтмолжсон. “Ээлтэй байгууллага” шалгаруулах шалгуур үзүүлэлтэд шинээр төгсөж байгаа залуучуудыг ажлын байраар хангасан эсэх, залуучуудад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулсан эсэх, байгууллагын залуусын үзэл бодол, саналыг сонсдог эсэх, залуучуудыг сурч боловсрох орчин нөхцөлөөр хангадаг, дэмждэг эсэх, байгууллагын залуусыг эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг эсэх зэрэг шалгаруулалтыг тусгасан.

Сайн дурын болон хүмүүнлэгийн ажилд оролцсон залуучууд болон залуучуудын иргэний нийгмийн байгууллагын сайн туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан алдаршуулах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг орон нутаг, тухайн байгууллагууд өөрсдийн боломжийн хүрээнд хэрэгжүүлж байна. Хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг, оролцоог тодорхой журамд тусгаж өгөөгүйгээс арилжааны байдлаар ханддаг нь мэдээллийг хангалттай түгээх боломжгүй нөхцөл үүсгэдэг байх магадлалтай байна.

Залуучуудын хөгжил, оролцоог дэмжих бодлогын баримт бичгүүдийг авч үзэхэд урт, дунд, богино хугацаанд дараах голлох бодлого, хөтөлбөрүүд байна. Үүнд:

- Урт хугацаанд баримтлах “Алсын хараа 2050”;
- Дунд хугацаанд баримтлах “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”;
- Дунд хугацаанд баримтлах “Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, мөн “Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл” зэрэг баримт бичгүүд байна.

Үнэлгээ:




<p>16.1. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т заасан сайн дурын болон хүмүүнлэгийн ажилд оролцсон залуучууд болон залуучуудын иргэний нийгмийн байгууллагын сайн туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан алдаршуулж, олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ.</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 100%</p>
---	--



2.3 ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТАЛААРХИ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ БҮРЭН ЭРХ, ЧИГ ҮҮРЭГ

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 4 дүгээр бүлэгт Залуучуудын хөгжлийг дэмжих талаарх төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх, чиг үүргийг тодорхойлж өгсөн байдаг бөгөөд 17-20 дугаар зүйлийн чиг үүргийн хэрэгжилт дунджаас дээгүүр буюу хангалттай байгаа бол бусад оролцогчдын чиг үүргийн хэрэгжилт дунджаас доогуур буюу хангалтгүй байна.



17-р зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

- 17.1. Улсын Их Хурал залуучуудын хөгжлийг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 17.1.1. залуучуудын хөгжлийг хангах төрийн бодлогыг тодорхойлох;
 - 17.1.2. залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлах;
 - 17.1.3. залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
 - 17.1.4. хууль тогтоомжид заасан бусад.

Шалгуур үзүүлэлт: Залуучуудын хөгжлийг дэмжих хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх

Төр, засгийн зүгээс залуучуудын хөгжлийг дэмжих, залуучуудын эдийн засаг, нийгэмд үзүүлэх хувь нэмэр, оролцоог идэвхжүүлэх тал дээр сүүлийн жилүүдэд ихээхэн анхаарч хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, институцийн чадавхыг тодорхой түвшинд бэхжүүлж ирсэн байна. Тухайлбал, УИХ-аас Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг 2017 онд баталж 2018 оноос мөрдөж эхэлсэн.

2021 онд УИХ-д Залуучуудын хөгжлийг дэмжих лобби бүлэг байгуулагдсан бөгөөд гишүүнээр Н.Учрал, Э.Бат-Амгалан, Х.Булгантуяа, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Г.Тэмүүлэн, Ч.Ундрам нар ажилладаг байна. Улс орнууд нийгмийн хөгжлийг шинжлэх ухаан, технологийн ололт амжилт, эдийн засгийн өсөлтөөр хэмжихээс гадна тухайн улс



орны хүний хөгжил, чадамжаар тодорхойлдог хандлага давамгайлж, тэр тусмаа залуучуудыг хүн амын бүлгийн хувьд нийгэм-эдийн засгийн томоохон хөрөнгө оруулагч, хөгжлийг түүчээлэгч гэж үзэж байна.

2020 оны 05 сарын 13 өдөр Монгол улсын их хурлаас “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого баталсан. Уг бодлогын зорилт 2.3. Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ гэсэн бол хэрэгжилтийн I үе шат (2021-2030): Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ гэжээ. Энэхүү заалтын 3-т залуу гэр бүлийг дэмжсэн орчин, нөхцөл бүрдэж, цогц үйл ажиллагааны чанарыг дээшлүүлнэ гэж заажээ. Энэ нь залуучуудын нийгмийн асуудлыг анхаарч чухал заалт бөгөөд хэрэгжилтийг бодитой, үр өгөөжтэй байлгах тал дээр олон талт хамтын ажиллагааг хангаж, тодорхой болгох шаардлагатай.

... УИХ тодорхой хууль, асуудлаар шийдвэр гаргах гэж байгаа бол эрх ашгийг нь хөндөж байгаа бүлгийнхээ санаа бодлыг тусгадаг, эрх ашиг хэрэгцээг нь судалж, сонсож хуульд өөрчлөлт оруулдаг байх хэрэгтэй...

Чанарын судалгааны явцад иргэний нийгмийн байгууллагатай хийсэн ярилцлагаас...

... Нэгдсэн Үндэстний Байгууллагад залуучуудыг төлөөлөн ажилладаг байгууллагын хувьд залуучуудын хөгжлийн тухай хуулийн хэд хэдэн зүйл, заалтыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг. Жишээлбэл, бид бүхэн НҮБ-ын төсөл хөтөлбөрүүдэд залуучуудын дуу хоолойг тусгах, оролцоог ханган, төлөөлөх зорилготойгоор үйл ажиллагаа явуулдаг тул тус хуулийн 14 дүгээр зүйл буюу залуучууд шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөл үзүүлэх мөн тус хуулийн 13.1.1 залуучууд өөрсдийн эрх ашигт нөлөөлөх аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох, хэрэгжилтийг хамтран зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих зэрэг зүйл заалтын хэрэгжилттэй шууд холбогддог...

Чанарын судалгааны явцад иргэний нийгмийн байгууллагатай хийсэн ярилцлагаас...

Залуучуудын бүлэг нийт хүн амын 33.7 хувийг, хөдөлмөрийн насны хүн амын 46.5 хувийг бүрдүүлж, хөдөлмөрийн насны хүн амын нийгэм, эдийн засагт үзүүлэх хамгийн таатай үе тохиож байгаа бөгөөд энэ нь 2030-аад он хүртэл үргэлжилж, үүнээс цааших хугацаанд хүн ам идэршиж, улмаар насжилтын үе эхэлнэ. Хүн ам зүйн энэ зурвас үед залуучуудаа боловсрол, мэдлэгтэй, мэргэжилтэй, эрүүл саруул оюун ухаан, эрүүл чийрэг бие бялдартай, эх оронч, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлж, ажил орлоготой болгох талаар Улсын Их Хурлаас тогтвортой, тодорхой зорилго чиглэл бүхий арга хэмжээг хэрэгжүүлэх, цаашид залуучуудын хөгжлийн бодлогыг зөв тодорхойлж төрийн дэмжлэг, оролцоог оновчтой болгох шаардлагатай хэмээн үзэж байгаа нь сайшаалтай байна.



17.1.Улсын Их Хурал залуучуудын хөгжлийг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 17.1.1.залуучуудын хөгжлийг хангах төрийн бодлогыг тодорхойлох; 17.1.2.залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлах; 17.1.3.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих; 17.1.4.хууль тогтоомжид заасан бусад.	Хэрэгжилт хангалттай. 100%
--	-------------------------------

18-р зүйл. Засгийн газрын бүрэн эрх

- 18.1.Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 18.1.1.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;
- 18.1.3.залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагаа болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, өргөн мэдүүлэх;
- 18.1.4.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- 18.1.5.хууль тогтоомжид заасан бусад.

Шалгуур үзүүлэлт: Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлого, шийдвэр

Монгол Улсын Засгийн газраас залуучуудаа дэмжих бодлого, зорилтуудыг дэвшүүлж Монгол Улсын Их хурлаас 2017 онд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг анх удаа баталж, 2018 оноос хуулийн дагуу залуучуудад нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх Залуучуудын хөгжлийн төвүүдийг байгуулж, үндэсний хэмжээнд залуучуудын асуудал хариуцсан бүтэц, тогтолцоо, хүний нөөцийг бүрдүүлжээ.

2019 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын засгийн газрын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” тогтоолоор Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн байна.

Хөтөлбөрийн зорилгыг залуучуудын нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралд идэвхтэй оролцож, хөгжилд бодитой хувь нэмэр оруулах таатай орчныг бүрдүүлэх замаар эх оронч үзэлтэй, тусгаар тогтнол, түүх, хэл, өв соёлоороо бахархдаг, байгаль орчноо хайрлан хамгаалдаг, өөрийн, гэр бүлийн болон нийгмийн өмнө хүлээх хариуцлага, хуулиар олгогдсон эрх, үүргээ ухамсарладаг өрсөлдөх чадвартай иргэн болоход нь дэмжлэг үзүүлэхэд оршино хэмээн тодорхойлжээ. Энэ нь залуучуудын талаар баримтлах засгийн газрын бодлогыг бүрэн илэрхийлж буй юм.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 08 сарын 28-ны өдрийн “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” тогтоол 2.5.8.Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ гэжээ. Мөн Монгол Улсын Засгийн газрын “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг хэрэгжүүлж байна. Уг төсөл нь залуучуудад эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, эх



оронч үзлийг төлөвшүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэж, хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхлыг бий болгож, ажилтай, орлоготой болгох зорилготой байна. Энэхүү төсөлд 18-34 насны, сүүлийн 3 сар ажил, хөдөлмөр эрхлээгүй, их дээд сургууль болон мэргэжлийн боловсролын байгууллагад суралцдаггүй ажилтай, орлоготой болж ирээдүйгээ өөрчлөх хүсэлтэй залуусыг хамруулдаг бөгөөд жилд дунджаар 1000 орчим залуусыг хамруулж байгаа бөгөөд нийтдээ 5000 залуусыг хамруулахаар төлөвлөжээ.

Монгол Улсын Засгийн газраас оюутан залуусын боловсрол эзэмших үйл ажиллагааг дэмжиж “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын хүрээнд Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагын диплом, бакалавр, магистр, докторын боловсрол эзэмших өдрийн ангид суралцаж байгаа Монгол улсын иргэнд сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийг Боловсролын зээлийн сангаар дамжуулан олгож байна. Мөн Монгол улсад шаардлагатай тэргүүлэх болон эрэлтгүй мэргэжлээр дотоодын сургалтын байгууллагад бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрт суралцагч залууст оюутны хөгжлийн зээлийг олгож байна. Дэлхийн шилдэг их, дээд сургуулиудын тухайн жилийн эхний 100-д багтсан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцуулах тэтгэлэг буюу Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлгийг мөн олгож байна.

... Төрийн залуучуудын байгууллага нь шийдвэр гаргах үйл явцад залуучуудыг идэвхтэй оролцуулж, янз бүрийн оролцогч талуудтай хамтран ажилладаг бүтцийг хөгжүүлэх шаардлагатай санагддаг. Ингэснээр залуучуудын хэрэгцээ шаардлага, хүсэл эрмэлзлийг илүү сайн сонсож, шийдвэрлэх боломж бүрдэнэ. Мөн төрийн залуучуудын байгууллагыг бүх залуучуудыг хамарсан болгохын тулд төлөөлөх чадварыг сайжруулж, үйл ажиллагааны ил тод байдлыг хөгжүүлбэл зохистой...

Чанарын судалгааны явцад иргэний нийгмийн байгууллагатай хийсэн ярилцлагаас...

Чанарын судалгааны явцад хамгийн ихээр яригдаж байсан асуудал бол засгийн газраас залуучуудын талаар хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагаа нь тэгш хүртээмжтэй биш байгааг онцолж байлаа. Монгол улсын хувьд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орон, нүүдлийн ахуй, соёл иргэншлээ хадгалж үлдэхийн тулд бүсчилсэн хөгжлийн бодлого, хөдөөгийн залуусын хөгжлийг дэмжих тал дээр онцгой анхаарах шаардлагатай. Засгийн газраас залуучуудын талаар баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь хэт ерөнхий байгаа бөгөөд нийгмийн бүлгүүдийн онцлог хийгээд хөгжлийн хэрэгцээг тусгаж чадахгүй байна.

... Хөдөөгийн залуучууд бол бодлогын гадна орхигдсон. Малчин залуусын эрүүл мэнд, хөгжлийн төлөө хэн ч дуугардаггүй. Хөдөө суманд залуучуудад зориулсан юу ч байхгүй. Залуу хүн л юм чинь хөгжил, гоё сайхан орчин хүснэ. Хөдөө мал маллах хүнгүй болж байгаа. Ялангуяа охид бүсгүйчүүд байхгүй...

... Бид жилдээ 1 удаа сумдаа тойрч сургалт хийдэг. Хөдөөгийн залуус өрөвдмөөр л байдаг даа...

... Малчин залуусыг онцгой анхаарах хэрэгтэй. Байгаль цаг уур өөрчлөгдөж, малын түүхий эд үнэгүй байгаа үед хэн мал маллахыг хүсэх вэ? Залуу хүн юм чинь сар бүр цалин авахыг хүснэ шүү дээ...

Чанарын судалгааны явцад ЗХТ-ийн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас...



<p>18.1.Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 18.1.1.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах; 18.1.3.залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагаа болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, өргөн мэдүүлэх; 18.1.4.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих; 18.1.5.хууль тогтоомжид заасан бусад.</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 100%</p>
---	---------------------------------------

19-р зүйл. Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

- 19.1.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр дараах чиг үүрэгтэй:
- 19.1.1.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тайлагнах;
- 19.1.2.залуучуудын асуудал хариуцсан бүх шатны байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 19.1.3.залуучуудын хөгжил, оролцооны чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;
- 19.1.4.залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, үнэлэмжийг нэмэгдүүлэх, тухайн салбарт ажилласан байдлыг ажлын туршлагад тооцох тогтолцоог бий болгох;
- 19.1.5.оюутан, суралцагчид цагийн ажил хийх тогтолцоог бий болгож, хэрэгжилтийг зохион байгуулах;
- 19.1.6.хууль тогтоомжид заасан бусад.
- 19.2.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цэргийн насны залуучуудын цэргийн алба хаах хүсэл, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

Залуучуудын оролцоог дэмжих чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагааны талаар тайлангийн гуравдугаар бүлгээс үзнэ үү.

Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр гадаад, дотоодын ИНБ-уудтай хамтран ажиллаж байна. Эдгээрээс Монгол Улс дахь НҮБ-ын Залуучуудын зөвлөх хороо буюу НҮБ-ын үйл ажиллагааг дэмжин ажилладаг залуусын гол байгууллагатай илүү үр дүнтэй хамтран ажиллаж байна. НҮБ нь Монголын бүх залуучуудтай хүчээ нэгтгэн, хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг хангахад хамтран ажиллаж, хөгжлийн үр шимээс хэнийг ч үлдээлгүйгээр дэвжих үйлст залуусыг татан оролцуулах, дэмжихэд бэлэн гэсэн үзэл санаатай. НҮБ-ын Залуучуудын стратеги-2030 болон Монгол Улсын Засгийн газраас 2018 онд баталсан Залуучуудын хөгжлийн хөтөлбөр зэрэг баримт бичигт тусгагдсаны дагуу Монгол Улс дахь НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд өөр, өөрсдийн чиг үүргийн дагуу залуусыг өөрсдийн нөөц боломжоо бүрэн дайчилж, утга төгөлдөр амьдрахыг



дэмжиж, эх орныхоо хөгжилд тэгш оролцохын сацуу, тэд хүсэл санаа, тэмүүлэл, үзэл бодлоо илэрхийлэх хийгээд бусад олон язгуур эрхээ эдлэх, хамгаалах боломжийг бүрдүүлэхэд зорин ажилладаг.

Монгол улс залуучуудын нийгэм дэх бүх талын оролцоог дэмжих нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч байгаа нь тайлангийн гуравдугаар бүлэгт дурдсан арга хэмжээ, шийдвэрүүдээс харагдаж байна.

Чанарын судалгаанд оролцогчид Сайн дурын ажилд оролцох оролцоог дэмжих" хэмээх зүйл, заалтын хэрэгжилт харьцангуй ахицтай байгаа хэмээн үнэлж байв. Учир нь сүүлийн үед олон байгууллагууд залуучуудыг сайн дурын үйл ажиллагаанд оролцуулах нөхцөл боломжийг бүрдүүлж, залуучууд ч сайн дурын үйл ажиллагааны ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, оролцох хандлагатай байгаа. Сайн дурын гишүүд элсүүлэх сонгон шалгаруулалт зарлахад 200-300 өргөдөл ирдэг нь үүнийг нотолж байна хэмээн үзэж байв. Гэсэн хэдий ч залуучуудын хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийг дэмжих, ур чадварыг хөгжүүлэхтэй холбоотой заалтууд нь холбогдох төрийн байгууллагуудын нөөц бололцоо, зохицуулалтын асуудлаас шалтгаалан бэрхшээлтэй тулгарч байна гэж үзэж байгааг анхаарах шаардлагатай.

...Олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахад сайн дурын ажилтнуудтай тогтмол хамтарч ажилладаг тул тэднийг бүртгэх баталгаажуулах журмын төслийг боловсруулан ажиллаж байна. Мөн WWW.IVOLUNTEER.MN сайтыг хөгжүүлэн СДА-аар ажиллах сонирхолтой залуусыг бүртгэх, СДА хайгч болон ажил олгогч нарын хооронд холбох гүүр болсон цахим талбарыг хөгжүүлэн ажилладаг. Төрийн зүгээс СДА-ыг бүртгэх баталгаажуулах журмыг хэлэлцэн батлуулах дэмжлэг хэрэгтэй байгаатай холбогдуулан 10 орчим хэлэлцүүлгийг зохион байгуулаад байна.

Чанарын судалгааны явцад иргэний нийгмийн байгууллагатай хийсэн ярилцлагаас...

.... Манай байгууллага залуучуудын сайн дурын үйл ажиллагааг төрөл бүрийн санаачилга өрнүүлэн идэвхтэй дэмждэг. Тухайлбал, манайхаас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрт хамрагдсан залуусыг НҮБ-ын агентлагуудад сайн дурын ажилтнаар ажиллах боломж олгож, зуучилж өгдөг. НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд ч бид бүхнээс ямар нэгэн өдөрлөг, арга хэмжээний үеэр ажиллах сайн дурын ажилтан шалгаруулж өгөх хүсэлт ихээр тавьдаг. Мөн бид бүхэн сайн дурын үйл ажиллагаанд оролцсон залууст батламж, урамшуулал олгох замаар сайн дурын үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлэхийн хичээдэг.

Чанарын судалгааны явцад иргэний нийгмийн байгууллагатай хийсэн ярилцлагаас...



19.1.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр дараах чиг үүрэгтэй:	Хэрэгжилт дундаж
19.1.1.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тайлагнах;	Хэрэгжилт дундаж. 60%
19.1.2.залуучуудын асуудал хариуцсан бүх шатны байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;	Хэрэгжилт дундаж. 60%
19.1.3.залуучуудын хөгжил, оролцооны чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;	Хэрэгжилт дундаж. 50%
19.1.4.залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, үнэлэмжийг нэмэгдүүлэх, тухайн салбарт ажилласан байдлыг ажлын туршлагад тооцох тогтолцоог бий болгох;	Хэрэгжилт хангалтгүй. 30%
19.1.5.оюутан, суралцагчид цагийн ажил хийх тогтолцоог бий болгож, хэрэгжилтийг зохион байгуулах;	Хэрэгжилт хангалттай. 100%
19.1.6.хууль тогтоомжид заасан бусад.	
19.2.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цэргийн насны залуучуудын цэргийн алба хаах хүсэл, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.	Хэрэгжилт дундаж. 50%

20-р зүйл. Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг



- 20.1.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр дараах чиг үүрэгтэй:
- 20.1.1.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 20.1.2.орон нутгийн салбар, нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, ажлын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авах, ажлын гүйцэтгэлийн тайланг үнэлэх;
- 20.1.3.залуучуудын асуудал эрхэлсэн бүх шатны байгууллагад ажиллаж байгаа ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;
- 20.1.4.залуучуудын талаар мэдээллийн сан бүрдүүлж, хөтлөх;
- 20.1.5.залуучуудын хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан хуулийн этгээдийг алдаршуулах, шагнаж, урамшуулах;
- 20.1.6.залуучуудын үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих;
- 20.1.7.залуучуудын хөгжлийн чиглэлээр хууль тогтоомжийн хүрээнд гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;
- 20.1.8.энэ хуулийн 8.1.2, 8.1.5 дахь заалт, 9.4 дэх хэсэг, 10.1.4 дэх заалтад заасан чиг үүрэг, арга хэмжээг гэрээний үндсэн дээр төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;
- 20.1.9.хууль тогтоомжид заасан бусад.
- 20.2.Энэ хуулийн 20.1.4-т заасан мэдээллийн санг бүрдүүлэх журмыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Үндэсний статистикийн хороо, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллага хамтран батална.
- 20.3.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь орон нутагт залуучуудад зориулсан нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх залуучуудын хөгжлийн төвтэй байна.
- 20.4.Энэ хуулийн 20.3-т заасан залуучуудын хөгжлийн төвийн дүрмийг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.
- 20.5.Залуучуудын хөгжлийн төв нь дараах чиг үүрэгтэй:
- 20.5.1.залуучуудад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт явуулах;
- 20.5.2.залуучуудын эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргах, үйл ажиллагаанд бүх түвшинд оролцож, саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллээр хангах;
- 20.5.3.залуучуудын хүсэл, сонирхол, эрэлт, хэрэгцээнд тулгуурласан сонирхлын клуб, зөвлөл, бүлгийн үйл ажиллагааг дэмжих;
- 20.5.4.залуучуудыг хууль зүйн туслалцаа болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд холбон зуучлах;
- 20.5.5.залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, залуу гэр бүл тулгамдсан бэрхшээлээ хамтран даван туулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлгийн уулзалт, чөлөөт ярилцлага зохион байгуулах санал, санаачилгыг дэмжих;
- 20.5.6.зорилтот бүлгийн залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, мэдээллээр хангаж, ажилд зуучлах;



- 20.5.7.залуучуудын гарааны компани эрхлэхийг дэмжих чиглэлээр орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай хамтран ажиллах.
- 20.6.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь орон нутаг дахь залуучуудын хөгжлийн төвийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.
- 20.7.Залуучуудын хөгжлийн төв нь залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн ажлын алба байна.
- 20.8.Залуучуудын хөгжлийн төв нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжнэ.

Шалгуур үзүүлэлт: Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /ГБХЗХГ/ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяанд байгуулагдсан бөгөөд залуучуудын хөгжилтэй холбоотой засгийн газрын тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлж, үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй бөгөөд залуучуудын талаар эрх зүй, бодлогын орчныг сайжруулж, салбар хоорондын зохицуулалтыг хангах үйл ажиллагааг явуулж байна. Үндсэн чиг үүрэг:

- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Орон нутгийн салбар, нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, ажлын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авах, ажлын гүйцэтгэлийн тайланг үнэлэх;
- Залуучуудын асуудал эрхэлсэн бүх шатны байгууллагад ажиллаж байгаа ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;
- Залуучуудын талаар мэдээллийн сан бүрдүүлж, хөтлөх;
- Залуучуудын хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан хуулийн этгээдийг алдаршуулах, шагнаж, урамшуулах;
- Залуучуудын үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих;
- Залуучуудын хөгжлийн чиглэлээр хууль тогтоомжийн хүрээнд гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;
- Энэ хуулийн залуучуудад зориулан хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт, залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт тусгах, залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, нас, сэтгэхүй, бие бялдар, түүх соёлын хөгжлийг судлахад чиглэсэн залуучууд судлалыг хөгжүүлэх, залуучуудад гэр бүл төлөвлөлт, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион



байгуулах, гэрээний үндсэн дээр төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

Энэхүү чиг үүрэг болон хуулийн хэрэгжилтийн хүрээнд Залуучуудын хөгжлийн төвүүд байгуулагдсан бөгөөд дангаараа болон бусад төрийн байгууллагатай хамтарсан байдлаар дараах долоон төрлийн үйлчилгээг үзүүлэхээр холбогдох хуульд тусгасан.

ЗХТ-ийн чиг үүрэг:

1. Амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх 20.5.1.залуучуудад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт явуулах;
2. Залуучуудын оролцоог хангах 20.5.2. залуучуудын эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд бүх түвшинд оролцож, саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллээр хангах;
3. 3 Залуусын хүсэл сонирхолд нийцсэн клуб, зөвлөл, дэмжих бүлэг ажиллуулах 20.5.3.залуучуудын хүсэл, сонирхол, эрэлт, хэрэгцээнд тулгуурласан сонирхлын клуб, зөвлөл, бүлгийн үйл ажиллагааг дэмжих;
4. 4 Эрүүл мэндийн болон хууль зүйн тусламж үйлчилгээнд холбон зуучлах 20.5.4.залуучуудыг хууль зүйн туслалцаа болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд холбон зуучлах;
5. Сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, уулзалт, чөлөөт ярилцлага зохион байгуулах 20.5.5.залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, залуу гэр бүл тулгамдсан бэрхшээлээ хамтран даван туулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлгийн уулзалт, чөлөөт ярилцлага зохион байгуулах санал, санаачилгыг дэмжих;
6. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, мэдээллээр хангах 20.5.6.зорилтот бүлгийн залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, мэдээллээр хангаж, ажилд зуучлах;
7. Гарааны бизнес эрхлэх, залуучуудад дэмжлэг үзүүлэх, холбон зуучлах 20.5.7.залуучуудын гарааны компани эрхлэхийг дэмжих чиглэлээр орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай хамтран ажиллах.

Хэдийгээр хууль, эрхзүй, бодлогын хүрээнд ахиц дэвшил гарч байгаа ч залуучуудын хөгжилд чиглэсэн институцүүдийн эрх, үүргийн давхцал их, санхүүжилт, төсвийн хүрэлцээ сул хэвээр байна. Өөрөөр хэлбэл, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль нь хэт ерөнхий, залуучуудын хөгжилд чиглэсэн тодорхой бодлого, арга хэмжээнүүдийг хариуцаж буй институц тус бүрийн үүргийг нарийн зааглаагүйн улмаас Залуучуудын хөгжлийн төвүүдийн үйл ажиллагаа нь бусад байгууллагууд тухайлбал Хөдөлмөр, халамж үйлчилгээний төвийн чиг үүрэгтэй давхцах, улмаар институц хооронд үл ойлголцол үүсэж төлөвлөгөөт ажлууд орхигдох, ЗХТ-үүдийн үйл ажиллагаа удаашрах эрсдэл ажиглагдаж байна.¹¹

¹¹ ЗАЛУУЧУУДАД ЧИГЛЭСЭН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ. 2021



... Залуучуудын асуудлыг хариуцсан төрийн байгууллага, төр өөрөө эрүүл мэнд, боловсрол, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх гэх мэт хуульд заасан үүргээ биелүүлэх, яг амьдрал дээр хэрэгжүүлэх төрийн бүтцээ байхгүй болгож байгаа нь энэ маш том ухралт болсон.

Хуулийг хэрэгжүүлэх амин сүнс болох төсөв буюу хөгжлийн сангаа огт байгуулаагүй одоо түүнээсээ ухраад бүр авч хаясан байна. Яам бол энэ 9 дүүрэг, 21 аймагтаа хүрч ажиллаж чадахгүй, бодлого дээрээ л зангидаж ажиллана.

Хуулийг дагаад тухайн төрийн байгууллага, ажлын хөтөлбөр гаргана гэдэг юм уу үйл ажиллагааны чиглэл боловсруулна гэсэн хэсгийг нэмэлт өөрчлөлтөд оруулж өгөх хэрэгтэй.

Залуучуудын оролцоог дэмжинэ, төрийн бус байгууллага хамтарна, бусад яам агентлаг хамтарна гэдэг дээр яаж хамтарч ажиллах талаар маш ерөнхий байгаа тиймээс хуулийг хэрэгжүүлэх, уялдаа холбоог хангасан хөтөлбөр гаргах хэрэгтэй. Энэ нь хуулийг ерөнхий уриа маягтай болгож байна.

Чанарын судалгааны явцад иргэний нийгмийн байгууллагатай хийсэн ярилцлагаас...

Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг тогтворжуулахад арга зүйн туслалцаанаас гадна хангалттай санхүүжилт шаардлагатай байдаг бол залуучуудын оролцоог нэмэгдүүлэхийн тулд ялгаатай нийгмийн бүлэг тус бүрийн оролцоог бүх шатанд хангах, татан оролцуулах, оролцож дадтал дэмжих, чадавхжуулах шаардлагатай байна. Мөн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахын тулд бодлогын түвшинд дүрэм, журам боловсруулах, батлахын зэрэгцээ хангалттай төсөв чухал байгааг үнэлгээнд оролцогчдын зүгээс онцолж байлаа. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага, төрийн байгууллагуудын нөхцөл байдал, үүрэг амлалтаас хамааран харилцан адилгүй байна. Тухайлбал, хуулийн талаарх мэдлэг дутмаг, санхүүжилт хангалтгүй, оролцогч талуудын уялдаа холбоо сул байгаа зэрэг бэрхшээлүүд байна.

Залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, ЗХТ-үүд нь одоогийн материаллаг орчин болон санхүү, боловсон хүчний нөөцөөр ЗХДТХ-ийн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй байна.

ЗХТ-ийн хүчин чадал, орчны болон үйлчилгээний стандарт байхгүйгээс 2 ширээ, 2 компьютер тавиад төв гэж нэрлэх тохиолдол ч байна. Хэрэв төв гэсэн статустай бол санхүүжилт, үйлчилгээ, мэргэжлийн боловсон хүчин хангалттай байж үйл ажиллагаа үр дүнд хүрэх юм. Одоогийн нөөц боломжоор хийж байгаа ажлууд нь тогтвортой, хүртээмжтэй бус байгаа нь үүнтэй холбоотой байна.



20.1.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр дараах чиг үүрэгтэй: 20.1.1.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Хэрэгжилт дундаж. 50%
20.1.2.орон нутгийн салбар, нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, ажлын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авах, ажлын гүйцэтгэлийн тайланг үнэлэх;	Хэрэгжилт дундаж. 50%
20.1.3.залуучуудын асуудал эрхэлсэн бүх шатны байгууллагад ажиллаж байгаа ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;	Хэрэгжилт хангалттай. 70%
20.1.4.залуучуудын талаар мэдээллийн сан бүрдүүлж, хөтлөх;	Хэрэгжилт дундаж. 60%
20.1.5.залуучуудын хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан хуулийн этгээдийг алдаршуулах, шагнаж, урамшуулах;	Хэрэгжилт хангалтгүй. 0%
20.1.6.залуучуудын үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих;	Хэрэгжилт дундаж. 50%
20.1.7.залуучуудын хөгжлийн чиглэлээр хууль тогтоомжийн хүрээнд гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;	Хэрэгжилт дундаж. 50%
20.1.8.энэ хуулийн 8.1.2, 8.1.5 дахь заалт, 9.4 дэх хэсэг, 10.1.4 дэх заалтад заасан чиг үүрэг, арга хэмжээг гэрээний үндсэн дээр төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;	Хэрэгжилт дундаж. 50%
20.1.9.хууль тогтоомжид заасан бусад.	
20.2.Энэ хуулийн 20.1.4-т заасан мэдээллийн санг бүрдүүлэх журмыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Үндэсний статистикийн хороо, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллага хамтран батална.	Хэрэгжилт дундаж. 60%
20.3.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь орон нутагт залуучуудад зориулсан нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх залуучуудын хөгжлийн төвтэй байна.	Хэрэгжилт хангалттай. 70%
20.4.Энэ хуулийн 20.3-т заасан залуучуудын хөгжлийн төвийн дүрмийг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.	Хэрэгжилт дундаж. 50%
20.5.Залуучуудын хөгжлийн төв нь дараах чиг үүрэгтэй: 20.5.1.залуучуудад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт явуулах;	Хэрэгжилт дундаж. 70%
20.5.2.залуучуудын эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд бүх түвшинд оролцож, саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллээр хангах;	Хэрэгжилт хангалттай. 70%
20.5.3.залуучуудын хүсэл, сонирхол, эрэлт, хэрэгцээнд тулгуурласан сонирхлын клуб, зөвлөл, бүлгийн үйл ажиллагааг дэмжих;	Хэрэгжилт хангалттай. 70%
20.5.4.залуучуудыг хууль зүйн туслалцаа болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд холбон зуучлах;	Хэрэгжилт хангалттай. 80%
20.5.5.залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, залуу гэр бүл тулгамдсан бэрхшээлээ хамтран даван туулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлгийн уулзалт, чөлөөт ярилцлага зохион байгуулах санал, санаачилгыг дэмжих;	Хэрэгжилт дундаж. 50%



20.5.6. зорилтот бүлгийн залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, мэдээллээр хангаж, ажилд зуучлах;	Хэрэгжилт хангалттай. 60%
20.5.7. залуучуудын гарааны компани эрхлэхийг дэмжих чиглэлээр орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай хамтран ажиллах.	Хэрэгжилт дундаж. 50%
20.6. Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь орон нутаг дахь залуучуудын хөгжлийн төвийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.	Хэрэгжилт дундаж. 50%
20.7. Залуучуудын хөгжлийн төв нь залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн ажлын алба байна.	Хэрэгжилт хангалттай. 80%
20.8. Залуучуудын хөгжлийн төв нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжнэ.	Хэрэгжилт дундаж. 50%

21-р зүйл. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын чиг үүрэг

- 21.1. Бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ залуучуудын хөгжлийг дэмжих талаар дараах чиг үүрэгтэй:
 - 21.1.1. харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа залуучуудын салбар зөвлөлийг тэргүүлэх;
 - 21.1.2. залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;
 - 21.1.3. залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;
 - 21.1.4. энэ хуулийн 11.1.7 дахь заалт, 13, 14, 15 дугаар зүйлд заасан арга хэмжээг залуучуудын оролцоог дэмжих тусгай хөтөлбөрийн дагуу харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;
 - 21.1.5. энэ хуулийн 9.5 дахь хэсэг, 11.1.7 дахь заалт, 20.8 дахь хэсэгт заасан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгах;
 - 21.1.6. хууль тогтоомжид заасан бусад.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрэм болон Орон нутгийн салбар зөвлөлийн дүрмийг баталсан. Уг дүрэмд зааснаар залуучуудын салбар зөвлөлийг аймаг, сум, дүүргийн засаг дарга удирдахаар заасан.

Энэ чиг үүргийн хүрээнд аймаг, дүүргийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт залуучуудын хөгжлийг дэмжих ажил тодорхой хэмжээнд тусч байна. Тухайлбал зарим дүүргийг жишээлэн авч үзвэл Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3/03 дугаар тогтоолоор, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Баянгол дүүргийн Засаг даргын 2021 оны А/262 дугаар захирамжаар тус тус баталсан байна. Дээрх хөтөлбөр, төлөвлөгөөнд 1 зорилт дэвшүүлж, түүний хүрээнд 6 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Баянгол дүүргийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт тусгасан залуучуудад чиглэсэн арга хэмжээ



- Залуу гэр бүл, залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн “Баянгол-Залуучуудын хөгжил” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. Баянгол-Залуучуудын хөгжил дэд хөтөлбөр баталж жил бүр хэрэгжүүлнэ. \287.000 000\
- Залуучуудын өдрийг тохиолдуулан “Залуучуудын чуулга уулзалт”-ыг жил бүр уламжлал болгон зохион байгуулна. \32.000 000\
- Зорилтот бүлгийн залуучуудыг сэтгэл зүй, хууль эрх зүй, эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучлах, нийгэмшүүлэх, хөгжлийг дэмжих ажлыг эрчимжүүлж хэрэгжилтийг ханган ажиллана. \37.5 000 000\
- Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна. \12.000 000\
- Залуучууд, өсвөр үеийнхэнд зориулсан мэргэжил сонгох цуврал лекц, семинар, сургалт тогтмол зохион байгуулна. \10.000 000\
- Хүмүүнлэгийн болон сайн дурын ажилд залуучуудыг татан оролцуулах, нийгмийн сайн сайхны төлөө ажилд идэвхжүүлэхэд хамтран ажиллана. \20.000 000\

Дээрх төлөвлөгөөний хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлжээ. Үүнд: “Баянгол – Залуучуудын хөгжил” дэд хөтөлбөрийг дүүргийн Засаг даргын 2021 оны А/266 дугаартай захирамжаар баталсан байна. Уг дэд хөтөлбөрт 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг тусгасан байна.

“Нийслэлийн Баянгол, Баянзүрх дүүргийн засаг дарга нарын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн залуучуудад чиглэсэн зорилт, түүний хэрэгжилтэд хийсэн мониторингийн тайлан”-д дурдсанаар хэрэгжилт тодорхойгүй гэж үнэлжээ.

Баянзүрх дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхээр тусгасан байна.

- Өсвөр үе, залуучуудад бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, сайн дурын ажилтан бэлтгэнэ.
- Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ.¹² Мөн тайланд дурдсанаар гүйцэтгэлийн тайлан олдоогүй тул үнэлэх боломжгүй гэж үзжээ.

... Салбар зөвлөлийн асуудлууд тодорхой байх ёстой, хуралдаж хуулийн дагуу, үйл ажиллагааг нь явуулдаг байхаар тодорхой болгох хэрэгтэй, хариуцлага тооцдог болгох, уялдаа холбооны асуудал хүндрэлтэй байдгийг илүү оновчтой үр дүнтэй ажиллахаар яам өөрөө шийдвэрлэх хэрэгтэй.

Чанарын судалгааны явцад иргэний нийгмийн байгууллагатай хийсэн ярилцлагаас...

Энэхүү 2 дүүргээс авч үзвэл дүүргийн засаг дарга нар хуулийн хэрэгжилтийн хүрээнд залууст чиглэсэн ажлуудыг төлөвлөж байгаа нь сайшаалтай ч үр дүнгийн тайлан үнэлгээгээ илүү нээлттэй гаргаж байх нь чухал байна.

¹² Нийслэлийн Баянгол, Баянзүрх дүүргийн засаг дарга нарын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн залуучуудад чиглэсэн зорилт, түүний хэрэгжилтэд хийсэн мониторингийн тайлан



Өнөөгийн Монголын залуучуудын хамгийн тулгамдсан асуудал бол тэдний ажил эрхлэлт бөгөөд тэр нь хүн ам зүй, эдийн засаг, нийгэм, үнэт зүйлсийн тогтолцооны эмзэг асуудал юм. Монголын залуучуудын зарим нь улс төр, бизнес, урлаг, спорт зэрэгт од болон гялалзаж байхад зарим нь ажилгүйдэл, ядуурал, гэмт хэрэгт өртөн, ад үзэгдэж байна. Иймд төрийн байгууллагуудаас залууст чиглэсэн бодлого, үйлчилгээг хүргэхдээ тэгш хүртээмжтэй байх, ялгаатай байдлыг арилгахад чиглэх шаардлагатай байна.

Чанарын судалгааны ярилцлагуудаас үзвэл залуус төрөөс явуулж буй бодлого үйлчилгээнд сэтгэл хангалуун биш байгаа нь ажиглагдаж байлаа. Энэ нь тэдэнд зориулсан үйл ажиллагааны санхүүжилт дутмаг, тэгш хүртээмжтэй байж чаддаггүйтэй холбоотой байна.


... Залуучуудын хөгжлийг дэмжих хуулийн хэрэгжүүлэхэд, энэ хууль дээр байгаа залуучуудын санаа бодлыг шийдвэр гаргах түвшинд тусгах гэдэг заалт бараг хэрэгжихгүй байгаа заалтын нэг.

Төр залуучуудыг халамж хүртэгч, нэг бол хэрэгцээтэй үедээ ашигладаг, улс төрд саналыг нь авах гэж тархи толгойг нь угаах гэдэг байдлаар л ашиглаж байгаа болохоос яг хамтрагч гэж харж ажиллахгүй байна. Харин энэ чиглэлээр төртэй хамтрах гэж оролддог, өөрсдөө бие дааж ажиллах чиглэлээр идэвх гаргаж ажиллах гэдэг цөөн тооны ТББ-ууд бий.

Чанарын судалгааны явцад иргэний нийгмийн байгууллагатай хийсэн ярилцлагаас...

График 5. Залуучуудын байгууллагын үйл ажиллагааг мэддэг байдал


Залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр төрийн холбогдох байгууллагаас явуулдаг үйл ажиллагаануудыг та хэр мэдэх вэ?



Эх сурвалж: Залуучуудаас авсан түүвэр судалгаа, Түүврийн хэмжээ N=555, Q6



График 6. Хуулийн хүрээнд төрөөс авч буй дэмжлэг



Эх сурвалж: Залуучуудаас авсан түүвэр судалгаа, Түүврийн хэмжээ N=555, Q7

Асуумжийн судалгаагаар залуусын 19% нь залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр төрийн холбогдох байгууллагаас явуулдаг үйл ажиллагаануудыг сайн мэднэ гэсэн бол 37% нь заримыг нь мэднэ гэжээ. Нийт залуусын 56% өөрсдөд нь чиглэсэн төрийн байгууллагын үйл ажиллагааг мэдэж байна. Харин 44% төрийн байгууллагын үйлчилгээний талаар хангалттай мэдээлэлгүй байна. ЗХДТХ-ийн хүрээнд үйлчилгээг 149 байнга авдаг бол 20% хааяа авдаг байна. 40% нь огт авч байгаагүй бол 26% нь бараг авч байгаагүй буюу мартсан, санахгүй байна. Эндээс үзвэл залууст чиглэсэн төрийн үйлчилгээ тэгш хүртээмжтэй байхад анхаарах шаардлагатай байна.

21.1.Бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ залуучуудын хөгжлийг дэмжих талаар дараах чиг үүрэгтэй: 21.1.1.харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа залуучуудын салбар зөвлөлийг тэргүүлэх;	Хэрэгжилт хангалттай. 100%
21.1.2.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;	Хэрэгжилт дундаж. 50%
21.1.3.залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;	Хэрэгжилт дундаж. 50%
21.1.4.энэ хуулийн 11.1.7 дахь заалт, 13, 14, 15 дугаар зүйлд заасан арга хэмжээг залуучуудын оролцоог дэмжих тусгай хөтөлбөрийн дагуу харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;	Хэрэгжилт дундаж. 60%
21.1.5.энэ хуулийн 9.5 дахь хэсэг, 11.1.7 дахь заалт, 20.8 дахь хэсэгт заасан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгах;	Хэрэгжилт дундаж. 60%
21.1.6.хууль тогтоомжид заасан бусад.	



22-р зүйл. Залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөл

- 22.1.Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд, орон нутагт залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга тус тус тэргүүлнэ.
- /Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./
- 22.2.Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг төрийн байгууллага, залуучуудын иргэний нийгмийн байгууллага, залуучуудын төлөөллийг оролцуулан Зөвлөлийн тэргүүн батална.
- 22.3.Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална.
- 22.4.Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөл нь дараах чиг үүрэгтэй:
 - 22.4.1.залуучуудын хөгжлийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газарт болон холбогдох бусад байгууллагад зөвлөх, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шаардлагатай арга хэмжээ авах;
 - 22.4.2.залуучуудын хөгжлийг дэмжих, эрх ашгийг хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд залуучууд, залуучуудын иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах, гаргасан санаачилгыг дэмжих;
 - 22.4.3.залуучуудын хөгжлийг дэмжих асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;
 - 22.4.4.залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн дүрэмд заасан бусад

Шалгуур үзүүлэлт. Чиг үүрэг бүхий байгууллагуудын баталсан бодлого, шийдвэр, журам, тушаалын хэрэгжилт

Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрмийг баталсан.

Хууль, бодлогын хүрээнд Залуучуудын хөгжлийн Үндэсний болон салбар зөвлөл, хот, аймаг, дүүргүүдэд Залуучуудын хөгжлийн төвүүдийг тус тус байгуулан үйл ажиллагааг эхлүүлжээ. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны 4 дүгээр тогтоолын 1-р хавсралтаар “Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрэм”, 2-р хавсралтаар “Орон нутгийн салбар зөвлөлийн дүрэм”-ийг тус тус баталснаар хууль эрх зүйн орчин төгөлдөржиж, бүтэц тогтолцоо бий болох эхлэл тавигджээ. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 22.3-д заасны дагуу Ерөнхий сайдын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны 04 тоот захирамжаар Ерөнхий сайдаар ахлуулсан 29 хүний бүрэлдэхүүнтэй Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийг байгуулсан байна.

Үндэсний хэмжээнд 21 аймаг, 8 дүүрэг, 56 сум, 124 хороо, төрийн захиргааны байгууллагын дэргэд 78, ААНБ-ын дэргэд 133, Сонирхлын 3 нийт 436 залуучуудын зөвлөл байгуулагдаж 7000 гаруй залуучуудыг бүртгэсэн байна.



... Залуучуудын хөгжлийн тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны төлөвлөгөөг яаралтай 4 эсвэл 6 жилээр засгийн газар баталж хэрэгжүүлэх шаардлагатай байгаа. МУ-ын ерөнхий сайдын тэргүүлдэг Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг байнгын ажиллагаатай болоход засгийн газар нэн тэргүүнд анхаарч ажиллах шаардлагатай Дээрх бүтцүүд тогтвортой ажилласнаар залуучуудад тулгамдаж байгаа асуудлуудыг цаг алдалгүй шийдвэрлэх боломж бүрдэнэ гэж харж байна.

Чанарын судалгааны явцад иргэний нийгмийн байгууллагатай хийсэн ярилцлагаас...

... Залуучуудын салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаа бас л хэцүү ш дээ. Ялангуяа хороон дээр бол байгуулаад л орхисон байдаг. Идэвхжүүлэх хөшүүрэг сул тул хуралдах, үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй. Байнгын ажиллагаатай бүтэц биш тул яаралтай санал өгөх асуудлаар л уулзах нь түгээмэл байдаг даа...

...Залуучуудын зөвлөл олон гээд л байгаа бас тэр залуучуудын хөгжлийн төвүүд байна. Яг очоод залуус хөгждөг үү гэвэл үгүй, зарим газар 2 компьютер, 2 ширээ л байгаа ш дээ. Тэрийг төв гэхэд хэцүү...

Чанарын судалгааны явцад ЗХТ-ийн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас...

Зөвлөлүүд байгуулагдсан хэдий ч тогтвортой хуралдах, мэдээлэл солилцох нь дутмаг байна. Жишээлбэл, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөл өнгөрсөн хугацаанд ганцхан удаа цахимаар хуралдсан байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

Залуучуудын салбар зөвлөлийг идэвхжүүлэх, залуусын хөгжил, оролцоог дэмжих тэгш хүртээмжтэй олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр салбар дундын уялдааг хангах ажил дутмаг байна. Ялангуяа сум орон нутаг, алслагдсан хөдөөгийн залуусын хөгжлийг дэмжих, тэднийг урамшуулах, оролцоог хангах чиглэлээр салбар зөвлөлд арга зүйн дэмжлэг хэрэгцээтэй байна. Цаашид залуусын хөгжлийн асуудлыг түүчээлэх иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, үндэсний боловсон хүчнийг бэлтгэх, манлайлагч нарыг бэлтгэх асуудал ч бодлогын төвд байх шаардлагатай байна.

Чанарын судалгаанаас үзвэл залуучуудын салбар зөвлөлийн дарга нар төрийн ажлын хажуугаар залуучуудын салбар зөвлөлийн ажлыг анхаарч үзэх боломжгүй байдаг тал байна.

... Засаг дарга нар ойлгох ойлгохгүй байх асуудал их байна. Төсөв үйл ажиллагаандаа жоохон ажил тусгаж өгвөл ер нь их юм дөө...


Чанарын судалгааны явцад ЗХТ-ийн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас...



<p>22.1.Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд, орон нутагт залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга тус тус тэргүүлнэ.</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 100%</p>
<p>22.2.Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг төрийн байгууллага, залуучуудын иргэний нийгмийн байгууллага, залуучуудын төлөөллийг оролцуулан Зөвлөлийн тэргүүн батална.</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 100%</p>
<p>22.3.Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална.</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 100%</p>
<p>22.4.Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөл нь дараах чиг үүрэгтэй: 22.4.1.залуучуудын хөгжлийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газарт болон холбогдох бусад байгууллагад зөвлөх, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шаардлагатай арга хэмжээ авах;</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 100%</p>
<p>22.4.2.залуучуудын хөгжлийг дэмжих, эрх ашгийг хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд залуучууд, залуучуудын иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах, гаргасан санаачилгыг дэмжих;</p>	<p>Хэрэгжилт дундаж. 60%</p>
<p>22.4.3.залуучуудын хөгжлийг дэмжих асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;</p>	<p>Хэрэгжилт дундаж. 60%</p>
<p>22.4.4.залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн дүрэмд заасан бусад.</p>	



2.4 ТАВДУГААР БҮЛЭГ: ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН



**ЗАЛУУЧ
ХӨГЖЛ**

23-р зүйл. Залуучуудын хөгжлийг дэмжих сан

- 23.1. Залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дэргэдээ Залуучуудын хөгжлийг дэмжих сан /цаашид "сан" гэх/ -тай байна.
- 23.2. Сангийн үйл ажиллагааны дүрмийг Засгийн газар батална.
- 23.3. Сангийн хөрөнгийн удирдлагыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

Шалгуур үзүүлэлт. Засгийн газар баталсан залуучуудын хөгжлийг дэмжих сангийн үйл ажиллагааны дүрэм хэрэгжсэн байдал

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар бүлэгт “Залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дэргэдээ Залуучуудын хөгжлийг дэмжих сантай байна” гэж заасан хэрэгжилт хангалтгүй буюу огт хэрэгжүүлээгүй байна.

Үнэлгээ:

23.1. Залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дэргэдээ Залуучуудын хөгжлийг дэмжих сан /цаашид "сан" гэх/ -тай байна.	Хэрэгжилт хангалтгүй. 0%
23.2. Сангийн үйл ажиллагааны дүрмийг Засгийн газар батална.	Хэрэгжилт хангалтгүй. 0%
23.3. Сангийн хөрөнгийн удирдлагыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.	Хэрэгжилт хангалтгүй. 0%



ГУРАВ. ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ЗХДТХ-ийн хэрэгжилтийн үнэлгээг хийхдээ хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээг хийдэг үндсэн шалгуур болох дараах 3 шалгуурын хүрээнд 100 гаруй дэд шалгуур үзүүлэлтийг баримталж хийлээ. Үүнд:

- Зорилгод хүрсэн түвшин
- Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
- Практикт нийцэж байгаа байдал

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд нь уг үнэлгээний зорилгын дагуу дараах зүйлсийг тодруулахад чиглэгдсэн. Үүнд:

1. Хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах;
2. Гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг тодорхойлох;
3. Нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх;
4. Цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх зөвлөмж тодорхойлох;

Хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийхдээ асуулга анкетын арга, чанарын судалгааны арга, бусад аргуудыг ашигласны зэрэгцээ дараах байгууллагуудын тайлан мэдээнд үндэслэсэн болно. Үүнд: ХНХЯ, ГБХЗХГ, Авлигатай тэмцэх газар, ХХААХҮЯ, ШУА, ЗГХЭГ, Соёлын яам, Сангийн яам, ГХЯ, БХБЯ, Хөвсгөл аймаг, Дархан-Уул аймаг, Төв аймаг, Баян-Өлгий аймаг, Дундговь аймаг, Дорнод аймаг, Булган аймаг

Хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийхэд тохиолдсон бэрхшээлтэй асуудал нь яамдын хувьд ЗХДТХ-ийн хэрэгжилтийн талаар хийсэн ажлын тухайлсан тайлан мэдээ ирүүлэх боломжгүй байсны зэрэгцээ он тус бүрээр хийсэн тогтмол ажлууд бага байв. ЗГХЭГ-ын тайланд ХНХЯ-ын тайлан давтагдах, ГБХЗХГ-ын тайлан ХНХЯ-ы тайлан дээр давтагдах байдал их байв. БШУЯ энэхүү хууль хамааралгүй гэх утгатай хариу өгсөн бол Батлан хамгаалах яам холбогдох тайлан мэдээ нууц тул илгээх боломжгүй гэв. Хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийх цаг хугацаа Залуучуудын асуудал хариуцсан төрийн байгууллагын бүтэц орон тоог хэлэлцэж байх үетэй давхацсан нь мэдээлэл цуглуулахад уур амьсгалын хувьд хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байв.

3.1 Хуулийн ололттой тал

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг баталсан нь дараах ололттой байна.

Үүнд:

1. Монгол Улс Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг баталсан нь төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих, нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоо, эрх, үүргийг хуулиар баталгаажуулахын зэрэгцээ залуучуудад чиглэсэн төрийн бодлого, үйлчилгээ, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангах, хяналт үнэлгээ хийх боломжтой болсон ач холбогдолтой байна.
2. Хуульд залуучуудын ялгаатай хөгжлийн хэрэгцээнд хүрч үйлчлэх боломжийг бүрдүүлж "зорилтот бүлгийн залуучууд"-ад чиглэсэн үйлчилгээг тусгаж өгсөн нь өнөөгийн нийгэм, эдийн засгийн хүнд үед хэрэгцээтэй заалт болжээ.
3. Монгол улсад "сайн дурын ажил" -ын эрх зүйн зохицуулалтыг анх удаа тусгаж залуучууд болон иргэний нийгмийн байгууллагуудыг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд оролцох боломж олгожээ. Энэ нь төрийн байгууллагын зарим чиг



үүрэгт дэмжлэг болохоос гадна олон улсын жишгээр сайн дурын ажлыг хөгжүүлэх сайн туршлага хуримтлуулах ололттой байна.

4. Хуульд залуучуудын улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжил, шийдвэр гаргах түвшинд үзэл бодлоо илэрхийлэх, оролцох үйл явцыг баталгаажуулахын зэрэгцээ, түүнийг хэрэгжүүлэх "залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөл"-ийг шат шатанд байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн нь хэрэгжилт сайтай байна.
5. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах ЗХТ 21 аймаг, 9 дүүрэг, 5 сумд байгуулагдан ажиллаж байгаа нь залуучуудад чиглэсэн тодорхой төрийн үйлчилгээг хүргэх бүтэц болж төлөвшиж байгаа сайшаалтай.
6. Хуулийн 2-дугаар бүлгийн 8-р зүйл “Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих” заалтын хувьд залуу хүнийг түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие дааж амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд чиглэсэн амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хөтөлбөрийн дагуу явуулж байгаа сургалтын үйл ажиллагаанууд хэрэгжилт сайн, хамрах хүрээ өргөнтэй байна.
7. Хуулийн 10-р зүйл “Залуучуудын эрүүл мэндийг хамгаалах” заалтын хүрээнд хорт зуршил, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл дадал, хэвшилтэй иргэн болгож төлөвшүүлэх зорилгоор залуучуудын эрүүл мэндийг дэмжих сургалт, нөлөөллийн ажлууд тогтмолжсон үр дүнтэй байна.
8. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд оюутан залуус цагаар хөдөлмөр эрхлэх эрх зүйн үндэс баталгаажсаны зэрэгцээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, ажлын байранд зуучлах үйл ажиллагаа илүү олон талын оролцоотой болсон байна.
9. Залуус болон иргэний нийгмийн байгууллагууд залуучуудын хөгжлийн талаар төрийн бодлого, шийдвэр боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд оролцох, санал дэвшүүлэх, төлөөлөх эрх зүйн үндэс баталгаажсан байна.
10. Залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх, чиг үүрэг хуулиар тодорхойлогдсон ач холбогдолтой байна.

3.2 Хуулийн хэрэгжилтийн хүндрэл бэрхшээл

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэхэд дараах хүндрэл бэрхшээлүүд байна. Үүнд:

1. Санхүүжилтийн эх үүсвэр буюу ЗХДС байгуулагдаагүйтэй холбоотой 5-р бүлгийн заалтууд болон зарим бүлгийн тодорхой заалт хэрэгжээгүй.
2. Нийслэл, дүүрэг, аймгуудын ГБХЗХГ, хэлтэс болон ЗХТ-ийн мэргэжилтнүүд буюу хүний нөөц тогтворгүй. Хуулийн хүрээнд мэргэшсэн үйлчилгээ үзүүлэх тогтвортой мэргэшсэн боловсон хүчин дутмаг.
3. ЗХТ-үүд нь холбон зуучлах, сургалт нөлөөлөл гэсэн үндсэн хоёр ажлаас бусад чиг үүргийн ажлыг хийхэд санхүүжилт болон хүний нөөц хүрэлцээгүй байдаг.
4. Хуулийг хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллагуудын уялдаа, чиг үүргийг тодорхой зааж өгөөгүйгээс, салбар дундын уялдаа холбоо ойлгомжгүй.
5. Төсөв санхүүжилт хангалтгүйн улмаас ЗХТ болон ГБХЗХГ, хэлтсээс явуулж буй үйл ажиллагаанууд тогтвортой, өргөн хүрээг хамарсан байж чаддаггүй.
6. ЗХТ-үүд нь одоогийн санхүүжилт болон хүний нөөцөөр цаашид ажиллах нь үр дүнгүй.



7. ЗХТ нь залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр төвийн түвшинд ажиллах орчин нөхцөл, барилга байгууламжгүй.
8. ЗХДТХ-ийн зарим заалтууд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулиудын зарим зүйл заалтуудтай давхацдаг тул ЗХТ-үүдийн үйл ажиллагаанд бэрхшээл учруулдаг. Хууль тогтоомжийн харьцуулсан судалгааг хийх, уялдаа холбоо, заагийг тодорхой тусгах өгөх шаардлагатай.
9. ЗХДТХ-д заасан насны хязгаараас хамаарч ГБХЗГ, хэлтэс дотор үл ойлголцол, бэрхшээл үүсдэг.
10. ЗХДТХ-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахад ЗХДТ-үүдэд арга зүйн дэмжлэг сул.
11. Сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Залуучуудын зөвлөл, байгууллагуудад намчирхах, залуусыг ялгаварлах байдал түгээмэл болсон.

3.3 Хуулийг боловсронгуй болгох зөвлөмж

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг цаашид боловсронгуй болгох чиглэлээр дэвшүүлж буй зөвлөмж: Үүнд:

1. Монгол Улсын залуучуудын хөгжлийн хэрэгцээг тодорхойлох, монгол залуу хүний нийгэм, эдийн засгийн байдал, гэр бүл, хувь хүний хөгжил, оюун санаа, ёс суртахуун, мэдлэг, боловсролын түвшин, бие махбод болон сэтгэл зүйн эрүүл мэнд, үнэт зүйлийг тодорхойлох суурь судалгааг хийх.
2. Залуучуудын хэрэгцээнд суурилсан хөгжлийн хөтөлбөр боловсруулж ЗХДТ-ийн тогтмол үйл ажиллагаагаар хэрэгжүүлж үр дүнд хүргэх.
3. Орчин үеийн нийгмийн хөгжлийн хурд, шинжлэх ухаан, инноваци, технологийн дэвшлийг ашиглах чадамжтай орчин үеийн монгол залуу хүнийг бүтээхэд залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээг чиглүүлэх.
4. ЗХДТХ-д тусгагдсан “Зорилтот бүлгийн залуучууд”-ыг дэмжих зүйл, заалтуудыг тусад нь бүлэг болгож зааглаж өгөх.
5. Монгол орны өргөн уудам газар нутаг, байгаль цаг уурын эрс тэс нөхцөл, суурин болон нүүдлийн амьдралын хосолмол хэв маяг, нийгэм, эдийн засаг, соёлын онцлог, нүүдэлчдийн өв соёлыг хадгалах хамгаалах бодлогын хүрээнд бүс нутгийн онцлог бүхий залуучуудын хөгжлийн бодлого эрх зүйн орчныг бүрдүүлэх.
6. ЗХДТХ-нь дан ганц залуучуудын хөгжлийг дэмжихэд чиглэх бус монгол залуу хүний үнэт зүйл, үүрэг хариуцлагыг хамтад нь хуульчилсан байх.
7. Дэлхий нийтийн өмнө тулгамдсан асуудал болоод буй цөлжилттэй тэмцэх, ногоон дэлхийг бүтээхэд залуучуудын үнэт оролцоо, үүрэг хариуцлагыг хуульчлах.
8. ЗХТ-үүдийн чиг үүргийг бусад байгууллагын чиг үүрэгтэй давхцалгүй байхаар тодорхойлох,
9. ЗХДТХ-ийг хэрэгжүүлэхэд салбар дундын уялдаа холбоог тодорхой тогтоож өгөх,
10. ЗХДТХ-ийг хэрэгжүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогчдын оролцоо, үүргийг нэмэгдүүлэх,
11. 10-р зүйлийн хүрээнд Залуучуудад гэр бүл төлөвлөлт, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг боловсрол, эрүүл мэнд болон залуучуудын асуудал



- эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран зохион байгуулах гэсэн заалтын хэрэгжилтийг сайжруулж талуудын оролцоог адил тэгш нэмэгдүүлэх.
12. Зорилтот бүлгийн залуучуудад чиглэсэн биеийн тамир, спорт, сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ хүртээмжтэй, үр дүнтэй болгох ажлыг анхаарах.
 13. Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт залуучуудад архи, тамхи, мансууруулах бодисын хор уршгийг ойлгуулах, эрүүл, зөв амьдралын хэвшлийг төлөвшүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ тусгах, хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх, энэ талын мэдээллээр сэтгүүлч, уран бүтээлчдийг хангах.
 14. 12 дугаар зүйл “Аюулгүй амьдрах, хөгжих орчныг бүрдүүлэх” гэсэн заалтын хүрээнд залуучуудын орлоготой нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлөөр орон сууц худалдаж авах, түрээслэх, зорилтот бүлгийн залуучууд, залуу гэр бүлийг орон сууцжуулах тусгай нөхцөл бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлэх.
 15. Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн, соёл, урлаг, биеийн тамир, спортын цогцолбор, хөгжлийн төв, цэцэрлэгт хүрээлэн, дэд бүтцийг шинээр барьж байгуулах, өргөтгөх төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх.
 16. Залуучуудын оролцоог нэмэгдүүлж, тэдэнд зөв хөрөнгө оруулалт хийх замаар эдийн засгаа тэлэх, нийгмийн эерэг өөрчлөлтүүдийг нэмэгдүүлэх, байгаль орчны тогтвортой байдлыг хангах, технологийн шинэчлэлийг авчрах.
 17. Орон нутаг, үндэсний болон дэлхийн түвшний үйл хэрэгт залуусыг татан оролцуулах, бодлогод залуучуудын хувь нэмрийг тусгах замаар улс үндэсний хөгжлийн үйл явц хийгээд олон талт байгууллагуудын шийдвэрийг сайжруулах.
 18. Монголын бүх залуучуудад тэгш, хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн тунхагдалын бус бодитой үйлчилгээг бүрдүүлэх.
 19. Залуучууд язгуур эрхээ эдлэх, хамгаалах боломжийг бүрдүүлэх эрх зүйн орчныг ЗХДТХ-д баталгаажуулах.
 20. Иргэний нийгмийн байгууллагууд болон төрийн холбогдох байгууллагууд залуучуудын одоогийн бүтцийг хадгалах хүсэлтэй байгаа тул энэ талаар хэлэлцүүлэг зохион байгуулах
 21. Монгол Улс үндэсний хэмжээнд залуучуудын хөгжил оролцоог дэмжиж, жил бүр 140 сая төгрөг баталж байгаа нь үйл ажиллагаагаа явуулах, өргөжүүлэхэд хангалтгүй байгаа тул дэмжлэгийг нэмэгдүүлэх



3.4 Хуулийн хэрэгжилтийн үнэлгээний нэгтгэл

Хуулийн заалт	Хуулийн хэрэгжилт (Түвшин болон хувиар)
8.1.Залуучуудын хувь хүний хөгжлийг дараах чиглэлээр дэмжинэ: 8.1.1.ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн боловсролын төв, багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хичээлийн агуулгыг тусгах;	Хэрэгжилт дундаж. 50%
8.1.2.залуучуудад зориулан хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих;	Хэрэгжилт хангалттай. 80%
8.1.3.түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие дааж амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд чиглэсэн амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хөтөлбөрийн дагуу цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны залуучуудыг хамруулах;	Хэрэгжилт хангалттай. 100%
8.1.4.залуучуудын гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа, уламжлал, зан заншлын тухай утга зохиол, уран сайхны бүтээлийг дэмжих;	Хэрэгжилт хангалтгүй. 0%
8.1.5.залуучуудын хөгжлийг дэмжсэн, хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт тусгах; 8.1.6.энэ хуулийн 8.1.5-д заасан агуулга, хөтөлбөрийг зохицуулсан журмыг Засгийн газар батална.	Хэрэгжилт хангалтгүй. 0%
8.2.Энэ хуулийн 8.1.1-д заасан хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Хэрэгжилт дундаж. 50%.
8.3.Энэ хуулийн 8.1.3-т заасан цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны эмэгтэйчүүд сайн дурын үндсэн дээр хамрагдаж болно. 8.4.Энэ хуулийн 8.1.3 дахь заалт, 8.3 дахь хэсэгт заасан залуучуудад цэргийн мэргэжил олгох журмыг Засгийн газар батална.	Хэрэгжилт хангалттай. 100%.
8.5.Энэ хуулийн 8.1.4-т заасан бүтээлийг сонгон шалгаруулах журмыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Хэрэгжилт хангалтгүй. 0%
8.6.Энэ хуулийн 8.5-т заасан журмын дагуу шалгаруулсан бүтээлийг, Залуучуудын хөгжлийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.	Хэрэгжилт хангалтгүй. 0%



Хуулийн заалт	Хуулийн хэрэгжилт (Түвшин болон хувиар)
9.1.Залуучуудын хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй, чанартай боловсрол эзэмшүүлэхийг дараах чиглэлээр дэмжинэ: 9.1.1.үндэстний цөөнх, шилжин суурьшигч, зорилтот бүлгийн залуучуудын боловсролын хэрэгцээнд суурилсан сургалтыг насан туршийн боловсролын хөтөлбөрийн дагуу эзэмшүүлэх;	Хэрэгжилт хангалттай. 100%
9.1.2.залуучуудыг эх орондоо болон гадаад улсад мэргэжил эзэмших, мэргэших боломжийг бүрдүүлэх;	Хэрэгжилт хангалттай. 100%
9.1.3.номын сангийн үйлчилгээг залуучуудад хүртээмжтэй болгох арга хэмжээ авч, цахим номын сан хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	Хэрэгжилт хангалттай. 100%
9.1.4.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь хугацаат цэргийн алба хаасан, цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан суралцагчийн амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийн багц цагийг нөхөн тооцох;	Хэрэгжилт хангалтгүй. 0%
9.1.5.энэ хуулийн 8.1.3 дахь заалт, 8.3 дахь хэсэгт заасан цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан, их, дээд сургуульд элсэн суралцах болзол хангасан залуучуудыг Боловсролын зээлийн сангаас олгох оюутны хөгжлийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулах.	Хэрэгжилт хангалтгүй. 0%
9.2.Энэ хуулийн 9.1.1, 9.1.2, 9.1.3-т заасан хөтөлбөрийг залуучуудын болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлнэ.	Хэрэгжилт хангалттай. 100%
9.3.Энэ хуулийн 9.1.4-т заасан багц цаг нөхөн тооцох журмыг боловсролын болон батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.	Хэрэгжилт хангалтгүй. 0%
9.4.Залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, нас, сэтгэхүй, бие бялдар, түүх соёлын хөгжлийг судлахад чиглэсэн залуучууд судлалыг хөгжүүлнэ. 9.5.энэ хуулийн 9.4-т заасан арга хэмжээг Шинжлэх ухааны академи хэрэгжүүлж, Засгийн газарт тайлагнана.	Хэрэгжилт дундаж. 50%
9.6.Залуучуудыг соёл, урлаг, шинжлэх ухааны шинэ бүтээл туурвихыг дэмжинэ.	Хангалтгүй. 30%
9.7.Шинжлэх ухаан, өндөр технологи, инновац, шинжилгээ, судалгааны чиглэлээр үндэсний тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Хэрэгжилт дундаж. 50%
9.8.Энэ хуулийн 9.6, 9.7-д заасан үйл ажиллагааг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж, Залуучуудын хөгжлийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.	Хангалтгүй. 0%.



Хуулийн заалт	Хуулийн хэрэгжилт (Түвшин болон хувиар)
<p>10.1.Хорт зуршил, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл дадал, хэвшилтэй иргэн болж төлөвшүүлэх зорилгоор залуучуудын эрүүл мэндийг дараахь чиглэлээр дэмжинэ: 10.1.1.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагын суралцагчийг харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах ажлыг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран зохион байгуулах;</p>	Хэрэгжилт хангалттай. 100%
<p>10.1.2.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь оюутан, суралцагчийг эрүүл мэндийн даатгалд хамруулах;</p>	Хэрэгжилт хангалттай. 100%
<p>10.1.3.өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, цахим эрүүл мэндийн үйлчилгээг нэвтрүүлэх;</p>	Хэрэгжилт хангалттай. 100%
<p>10.1.4.залуучуудад гэр бүл төлөвлөлт, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг боловсрол, эрүүл мэнд болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран зохион байгуулах;</p>	Хэрэгжилт хангалттай. 100%
<p>10.1.5.зорилтот бүлгийн залуучуудад чиглэсэн биеийн тамир, спорт, сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх;</p>	Хэрэгжилт хангалттай. 100%
<p>10.1.6.олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт залуучуудад архи, тамхи, мансууруулах бодисын хор уршгийг ойлгуулах, эрүүл, зөв амьдралын хэвшлийг төлөвшүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ тусгах, хэрэгжилтийг зохион байгуулах.</p>	Хэрэгжилт дундаж. 50%



Хуулийн заалт	Хуулийн хэрэгжилт (Түвшин болон хувиар)
11.1.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дараах чиглэлээр дэмжинэ: 11.1.1.оюутан, залуучуудыг ажилд зуучилсан хөдөлмөрийн биржийг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх асуудлыг хөдөлмөрийн болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран хэрэгжүүлэх;	Хэрэгжилт дундаж. 60%
11.1.2.залуучуудыг хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэхийг дэмжих;	Хэрэгжилт хангалттай. 70%
11.1.3.гадаад улсын тэргүүн туршлага, өндөр технологи, шинэ санааг үндэсний технологи болгон нутагшуулах, гарааны компани эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх;	Хэрэгжилт хангалттай. 50%
11.1.4.хөдөлмөрийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран малчин залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;	Хэрэгжилт хангалттай. 30%
11.1.5.гадаад улсад өндөр технологи, нарийн мэргэжил, ур чадвар эзэмшсэн залуучуудыг эх орондоо ажиллахыг дэмжих хөтөлбөрийг гадаад харилцааны болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлэх;	Хэрэгжилт дундаж. 50%
11.1.6.мэргэжлийн ур чадвараа сайжруулах, шинэ мэргэжил эзэмших сургалтад ажилгүй залуучуудыг хамруулах;	Хэрэгжилт хангалттай. 100%
11.1.7.орон нутгийн захиалгат ажлын байранд ажиллахаар очсон залуучуудыг дэмжих;	Хэрэгжилт хангалттай. 80%
11.1.8.ажил олоход хүндрэлтэй болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгссөн төгсөгчдийг дадлагажуулан байнгын ажлын байраар хангасан ажил олгогчийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжих;	Хэрэгжилт хангалттай. 60%
11.1.9.хувийн хэвшлийн байгууллага /100 ба түүнээс дээш ажилтантай/ нийт ажилтнуудын 5 хувьтай тэнцэхүйц оюутны цагийн ажлын орон тоо гаргах;	Хэрэгжилт хангалттай. 80%



Хуулийн заалт	Хуулийн хэрэгжилт (Түвшин болон хувиар)
<p>12.1.Залуучуудын аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг дараах чиглэлээр дэмжинэ: 12.1.1.орлоготой нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлөөр орон сууц худалдаж авах, түрээслэх, зорилтот бүлгийн залуучууд, залуу гэр бүлийг орон сууцжуулах хөтөлбөрийг залуучуудын болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлэх;</p>	Хэрэгжилт дундаж. 50%
<p>12.1.2.залуучуудыг гэмт хэрэгт татагдан орохоос урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгмийн оролцоотой зохион байгуулах;</p>	Хэрэгжилт дундаж. 60%
<p>12.1.3.хорих болон засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож байгаа залуучуудад зориулсан сэтгэл заслын үйлчилгээ, соёл, спорт, хүмүүжлийн арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотой зохион байгуулах;</p>	Хэрэгжилт хангалттай. 70%
<p>12.1.4.гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлсэн залуучуудад боловсрол, мэргэжил олгох, хорих ангиас суллагдах үед ажлын байраар хангах талаар төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн гаргасан санаачилгыг дэмжих;</p>	Хэрэгжилт хангалттай. 70%
<p>12.1.5.хөдөө, орон нутгийн бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулж, үр бүтээлтэй ажиллаж, амьдарч байгаа залуучуудыг дэмжих, алдаршуулах;</p>	Хэрэгжилт дундаж. 60%
<p>12.3.Залуучуудын өөрийгөө хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг дараах чиглэлээр дэмжинэ:</p>	
<p>12.3.1.залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн, соёл, урлаг, биеийн тамир, спортын цогцолбор, хөгжлийн төв, цэцэрлэгт хүрээлэн, дэд бүтцийг шинээр барьж байгуулах, өргөтгөх төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх;</p>	Хэрэгжилт хангалтгүй. 30%
<p>12.3.2.залуучуудын авьяас чадвар, бие бялдар, сэтгэхүйг хөгжүүлэхэд шашин болон улс төрөөс ангид урлаг, соёл, спортын арга хэмжээнд залуучууд оролцох, эдгээр арга хэмжээг зохион байгуулсан хуулийн этгээдийг дэмжих;</p>	Хэрэгжилт дундаж. 70%
<p>12.3.3.түүх, соёлын өвийг хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ардын урлаг, ёс заншил, уламжлалт зан үйлийг хөгжүүлэхэд залуучуудын оролцоог хангах;</p>	Хэрэгжилт дундаж. 60%
<p>12.3.4.залуучуудын дунд гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэх, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх, сурталчлах үйл ажиллагааг дэмжих;</p>	Хэрэгжилт хангалттай. 90%
<p>12.3.5.байгаль орчныг хамгаалах, ардын зан үйлийг сурталчлах, төлөвшүүлэх санаачилгыг дэмжих.</p>	Хэрэгжилт дундаж. 60%



Хуулийн заалт	Хуулийн хэрэгжилт (Түвшин болон хувиар)
13.1.Төрөөс залуучуудын оролцоог дараах чиглэлээр дэмжинэ: 13.1.1.залуучууд өөрсдийн эрх ашигт нөлөөлөх аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох, хэрэгжилтийг хамтран зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;	Хэрэгжилт хангалттай. 100%
13.1.2.залуучуудын иргэний нийгмийн байгууллагын нийтэд тустай үйл ажиллагааг дэмжих;	Хэрэгжилт хангалттай. 70%
13.1.3.залуучуудын хүмүүнлэгийн болон сайн дурын ажилд оролцох оролцоог дэмжих.	Хэрэгжилт хангалттай. 70%
14.1.Залуучуудыг шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцуулах талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ: 14.1.1.шийдвэр гаргах, нөлөөлөл үзүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд шууд болон өөрийн төлөөллийн байгууллага, хуулийн этгээдээр дамжуулан оролцох боломжийг бүрдүүлэх;	Хэрэгжилт хангалттай. 100%
14.1.2.сайн засаглалыг хөгжүүлэх, авлигатай тэмцэх, түүнийг бууруулах үйл ажиллагаанд залуучуудын оролцоог дэмжих.	Хэрэгжилт хангалттай. 80%
15.1.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага залуучуудын иргэний нийгмийн байгууллага, нийтэд тустай үйл ажиллагаа, хөдөлгөөнийг дараахь чиглэлээр дэмжинэ: 15.1.1.залуучуудыг бие даан амьдрах, нийгэм, эдийн засгийн эрсдэлээс хамгаалахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр зохион байгуулах;	Хэрэгжилт хангалттай. 80%
15.1.2.залуучуудын соёл, боловсрол, иргэний үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;	Хэрэгжилт хангалттай. 90%
15.1.3.зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагааг сайн дурынхны оролцоотойгоор зохион байгуулах;	Хэрэгжилт хангалттай. 90%
15.1.4.хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамж, халамжийн үйл ажиллагаанд сайн дурынхан, аж ахуйн нэгж, байгууллага хамтран ажиллахыг дэмжих.	Хэрэгжилт хангалттай. 70%
15.2.Энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т заасан сайн дурын ажилд оролцсон цагийг бүртгэж, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.	Хэрэгжилт хангалттай. 80%
16.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т заасан сайн дурын болон хүмүүнлэгийн ажилд оролцсон залуучууд болон залуучуудын иргэний нийгмийн байгууллагын сайн туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан алдаршуулж, олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ.	Хэрэгжилт хангалттай. 100%



Хуулийн заалт	Хуулийн хэрэгжилт (Түвшин болон хувиар)
<p>17.1.Улсын Их Хурал залуучуудын хөгжлийг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 17.1.1.залуучуудын хөгжлийг хангах төрийн бодлогыг тодорхойлох; 17.1.2.залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлах; 17.1.3.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих; 17.1.4.хууль тогтоомжид заасан бусад.</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 100%</p>
<p>18.1.Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 18.1.1.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах; 18.1.3.залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагаа болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, өргөн мэдүүлэх; 18.1.4.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих; 18.1.5.хууль тогтоомжид заасан бусад.</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 100%</p>
<p>19.1.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр дараах чиг үүрэгтэй:</p>	
<p>19.1.1.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тайлагнах;</p>	<p>Хэрэгжилт дундаж. 60%</p>
<p>19.1.2.залуучуудын асуудал хариуцсан бүх шатны байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;</p>	<p>Хэрэгжилт дундаж. 60%</p>
<p>19.1.3.залуучуудын хөгжил, оролцооны чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;</p>	<p>Хэрэгжилт дундаж. 50%</p>
<p>19.1.4.залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, үнэлэмжийг нэмэгдүүлэх, тухайн салбарт ажилласан байдлыг ажлын туршлагад тооцох тогтолцоог бий болгох;</p>	<p>Хэрэгжилт хангалтгүй. 30%</p>
<p>19.1.5.оюутан, суралцагчид цагийн ажил хийх тогтолцоог бий болгож, хэрэгжилтийг зохион байгуулах;</p>	<p>Хэрэгжилт хангалттай. 100%</p>
<p>19.1.6.хууль тогтоомжид заасан бусад.</p>	
<p>19.2.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цэргийн насны залуучуудын цэргийн алба хаах хүсэл, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.</p>	<p>Хэрэгжилт дундаж. 50%</p>



Хуулийн заалт	Хуулийн хэрэгжилт (Түвшин болон хувиар)
20.1.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр дараах чиг үүрэгтэй: 20.1.1.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Хэрэгжилт дундаж. 50%
20.1.2.орон нутгийн салбар, нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, ажлын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авах, ажлын гүйцэтгэлийн тайланг үнэлэх;	Хэрэгжилт дундаж. 50%
20.1.3.залуучуудын асуудал эрхэлсэн бүх шатны байгууллагад ажиллаж байгаа ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;	Хэрэгжилт хангалттай. 70%
20.1.4.залуучуудын талаар мэдээллийн сан бүрдүүлж, хөтлөх;	Хэрэгжилт дундаж. 60%
20.1.5.залуучуудын хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан хуулийн этгээдийг алдаршуулах, шагнаж, урамшуулах;	Хэрэгжилт хангалтгүй. 0%
20.1.6.залуучуудын үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих;	Хэрэгжилт дундаж. 50%
20.1.7.залуучуудын хөгжлийн чиглэлээр хууль тогтоомжийн хүрээнд гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;	Хэрэгжилт дундаж. 50%
20.1.8.энэ хуулийн 8.1.2, 8.1.5 дахь заалт, 9.4 дэх хэсэг, 10.1.4 дэх заалтад заасан чиг үүрэг, арга хэмжээг гэрээний үндсэн дээр төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;	Хэрэгжилт дундаж. 50%
20.1.9.хууль тогтоомжид заасан бусад.	
20.2.Энэ хуулийн 20.1.4-т заасан мэдээллийн санг бүрдүүлэх журмыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Үндэсний статистикийн хороо, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллага хамтран батална.	Хэрэгжилт дундаж. 60%
20.3.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь орон нутагт залуучуудад зориулсан нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх залуучуудын хөгжлийн төвтэй байна.	Хэрэгжилт хангалттай. 70%
20.4.Энэ хуулийн 20.3-т заасан залуучуудын хөгжлийн төвийн дүрмийг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.	Хэрэгжилт дундаж. 50%
20.5.Залуучуудын хөгжлийн төв нь дараах чиг үүрэгтэй: 20.5.1.залуучуудад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт явуулах;	Хэрэгжилт дундаж. 70%
20.5.2.залуучуудын эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд бүх түвшинд оролцож, саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллээр хангах;	Хэрэгжилт хангалттай. 70%
20.5.3.залуучуудын хүсэл, сонирхол, эрэлт, хэрэгцээнд тулгуурласан сонирхлын клуб, зөвлөл, бүлгийн үйл ажиллагааг дэмжих;	Хэрэгжилт хангалттай. 70%



20.5.4.залуучуудыг хууль зүйн туслалцаа болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд холбон зуучлах;	Хэрэгжилт хангалттай. 80%
20.5.5.залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, залуу гэр бүл тулгамдсан бэрхшээлээ хамтран даван туулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлгийн уулзалт, чөлөөт ярилцлага зохион байгуулах санал, санаачилгыг дэмжих;	Хэрэгжилт дундаж. 50%
20.5.6.зорилтот бүлгийн залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, мэдээллээр хангаж, ажилд зуучлах;	Хэрэгжилт хангалттай. 60%
20.5.7.залуучуудын гарааны компани эрхлэхийг дэмжих чиглэлээр орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай хамтран ажиллах.	Хэрэгжилт дундаж. 50%
20.6.Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь орон нутаг дахь залуучуудын хөгжлийн төвийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.	Хэрэгжилт дундаж. 50%
20.7.Залуучуудын хөгжлийн төв нь залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн ажлын алба байна.	Хэрэгжилт хангалттай. 80%
20.8.Залуучуудын хөгжлийн төв нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжнэ.	Хэрэгжилт дундаж. 50%



Хуулийн заалт	Хуулийн хэрэгжилт (Түвшин болон хувиар)
21.1.Бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ залуучуудын хөгжлийг дэмжих талаар дараах чиг үүрэгтэй: 21.1.1.харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа залуучуудын салбар зөвлөлийг тэргүүлэх;	Хэрэгжилт хангалттай. 100%
21.1.2.залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;	Хэрэгжилт дундаж. 50%
21.1.3.залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;	Хэрэгжилт дундаж. 50%
21.1.4.энэ хуулийн 11.1.7 дахь заалт, 13, 14, 15 дугаар зүйлд заасан арга хэмжээг залуучуудын оролцоог дэмжих тусгай хөтөлбөрийн дагуу харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;	Хэрэгжилт дундаж. 60%
21.1.5.энэ хуулийн 9.5 дахь хэсэг, 11.1.7 дахь заалт, 20.8 дахь хэсэгт заасан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгах;	Хэрэгжилт дундаж. 60%
21.1.6.хууль тогтоомжид заасан бусад.	
22.1.Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд, орон нутагт залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга тус тус тэргүүлнэ.	Хэрэгжилт хангалттай. 100%
22.2.Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг төрийн байгууллага, залуучуудын иргэний нийгмийн байгууллага, залуучуудын төлөөллийг оролцуулан Зөвлөлийн тэргүүн батална.	Хэрэгжилт хангалттай. 100%
22.3.Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална.	Хэрэгжилт хангалттай. 100%
22.4.Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөл нь дараах чиг үүрэгтэй:	
22.4.1.залуучуудын хөгжлийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газарт болон холбогдох бусад байгууллагад зөвлөх, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шаардлагатай арга хэмжээ авах;	Хэрэгжилт хангалттай. 100%
22.4.2.залуучуудын хөгжлийг дэмжих, эрх ашгийг хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд залуучууд, залуучуудын иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах, гаргасан санаачилгыг дэмжих;	Хэрэгжилт дундаж. 60%
22.4.3.залуучуудын хөгжлийг дэмжих асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;	Хэрэгжилт дундаж. 60%
22.4.4.залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн дүрэмд заасан бусад.	



23.1.Залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дэргэдээ Залуучуудын хөгжлийг дэмжих сан /цаашид "сан" гэх/ -тай байна.	Хэрэгжилт хангалтгүй. 0%
23.2.Сангийн үйл ажиллагааны дүрмийг Засгийн газар батална.	Хэрэгжилт хангалтгүй. 0%
23.3.Сангийн хөрөнгийн удирдлагыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.	Хэрэгжилт хангалтгүй. 0%

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН СУДАЛГАА

Улаанбаатар 2026 он

Судалгааны захиалагч:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам

Судалгааг гүйцэтгэсэн:

Монголын эрх зүйн судалгаа хөгжлийн дэвшил төв ТББ

Судалгааны багийн ахлагч:

Р.Лхагвабаяр

Судалгааны багийн гишүүн:

О.Төрболд
Б.Жавхлан
З.Янжинлхам

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
УДИРТГАЛ.....	4
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	5
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох	5
1.2 Үнэлгээ хийх хүрээг тогтоох.....	6
1.3 Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох.....	9
1.4 Харьцуулах хэлбэрийг сонгох	11
1.5 Шалгуур үзүүлэлтийг томъёолох.....	11
1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.....	12
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	13
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	14
3.1. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал..	14
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	50
4.1 ДҮГНЭЛТ	50
4.2. ЗӨВЛӨМЖ	50
ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ	53

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГБХЗХХ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс
УИХ	Улсын Их Хурал
ЗХДтХ	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль
ЗГ	Засгийн газар
ЗЗИ	Залуучуудын засаглалын индекс
ТББ	Төрийн бус байгууллага

УДИРТГАЛ

Энэхүү судалгааны хүрээнд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу үнэлгээ хийв.

Тус судалгааны зорилго нь 2017 оны ЗХДтХ-н хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, тулгарч буй хүндрэл, бэрхшээлүүд, тэдгээрийн үр дагаврыг тодорхойлон эрх зүйн зохицуулалтыг цаашид сайжруулж боловсронгуй болгох талаар дүгнэлт, санал дэвшүүлэхэд оршино.

Энэ хүрээнд судалгааны багийн зүгээс сонгон авсан хуулийн зүйл, заалтуудын хүрээнд ярилцлага хийх замаар байгаа түвшинд болон онолын буюу байх ёстой түвшний үнэлгээ хийх, хууль хэрэгжүүлэгчдэд практикт тэдгээр зохицуулалтуудыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг тодруулах зорилтуудыг дэвшүүлэн хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

ЗХДТХ-н зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох;

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний 2.1-т “Хууль тогтоомж нь Монгол Улсын хөгжлийн бодлогын уялдаа, залгамж чанарыг хангасан, харилцан туршлага, судалгаа, нотолгоо, хууль хэрэглээний практикт суурилсан байна.”, 2.2-т “Монгол Улсын Их Хурал хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлж, хууль тогтоомжийн үр нөлөөг тогтмол судлан, түүний үр дүнг үндэслэн хууль тогтоомжийг боловсронгуй болгож хэвшинэ.”, 2.3-т “Нийгэм, эдийн шинэ тутам үүсэж байгаа харилцаа, цаг үеийн хэрэгцээ, шаардлагыг тогтмол шинжлэн судлах, түүнд үндэслэн хууль тогтоомжийн төслийн санал боловсруулах урт хугацааны санах ой бүхий байнгын тогтогтолцоог бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль нь 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан бөгөөд 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн. Уг хуулийн хүрээнд 15-34 насны залуучууд хэмээн тодорхойлж, төрөөс залуучууды хөгжлийг дэмжих үйл ажиллагааг хуульд (i) хувь хүний хөгжил, (ii) боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан (iii) эрүүл мэнд (iv) хөдөлмөр эрхлэлт (v) аюулгүй амьдрах, хөгжих орчин гэсэн үндсэн таван чиглэлээр зохион байгуулахаар тусгасан байна.¹

Уг хууль хэрэгжиж эхэлснээс хойш 9 жилийн хугацаа өнгөрөөд байгаа боловч практикт хууль хэрэгжүүлэгчид болон судлаач нарын дунд хуулийн зарим зүйл, заалт бодит байдал дээр хангалттай хэрэгжихгүй, хүний эрхийн үнэт зүйлстэй зөрчилдөж байгаа талаар шүүмжлэл өрнөсөөр байна. Мөн ЗХТ-ийн үйл ажиллагаа тогтвортой биш, хөрөнгө санхүүгийн хувьд бэхжээгүй, ажиллаж буй мэргэжилтнүүдийн цалин хангамж тааруу, төрөөс үзүүлж буй зарим үйлчилгээ давхардалтай, институт хоорондын уялдаагүй байдал үйлчилгээний чанарт таагүй нөлөө үзүүлж байгаа бол, нөгөө талаас төвийн байршил, үйлчлүүлэгчийн тоо зэрэг хүчин зүйлс үйлчилгээг хүртээмжтэй хүргэхэд сөргөөр нөлөөлж байна. Тэрчлэн төрийн байгууллага, институцийн үйл ажиллагаа, удирдлагын идэвхи, онцлогоос хамаарч дүүрэг, орон нутагт ЗХТ-ийн үйл ажиллагаа харилцан адилгүй, хуулийн хэрэгжилт хангалттай биш байгаа юм. ЗХТ-өөс үзүүлж буй үйлчилгээний нэр төрөл хэт олон, тодорхой биш, төрийн бусад үйлчилгээтэй давхцах явдал хааяагүй тохиолдож байна.

Тодруулбал, 2021 онд Монгол Улсын Засгийн газрын захиалгаар хийгдэж байсан “Залуучуудад чиглэсэн зарлагын шинжилгээ” судалгааны тайланд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг суурь судалгаа тооцоог хангалттай хийгээгүй, оролцогч

¹ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль (2017)

байгууллагуудын үүргийг нарийн зааглаагүй, хөтөлбөр бодлогыг санхүүжүүлэх хууль эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй хэмээн дүгнэсэн байна.²

Залуучууд бол нийгэм, улс төрийн идэвх оролцооны хувьд өвөрмөц нийгмийн хүн ам зүйн бүлэг юм. Энэ ч үүднээс судлаачид залуучуудын нийгэм, улс төрийн идэвх, оролцооны онцлог, төлөв байдлыг гаргахдаа тухайн орны нийгэм, улс төрийн нөхцөл байдал, түүнд гарч буй эерэг сөрөг өөрчлөлттэй нь холбон судалж ирсэн. Өөрөөр хэлбэл залуучууд нь нийгмийн бусад бүлгүүдээс нийгэм сэтгэл зүйн болон хөгжлийн хэрэгцээ шаардлагаараа онцгой ялгарах бүлэг болохын хувьд тэдэнд тулгамддаг нийгмийн асуудал нь ч бусад насны хүн амын бүлгээс онцлог ялгаатай байдаг. Мөн залуучууд нь хүн амын томоохон хэсгийг бүрдүүлдгийн хувьд нийт нийгмийн асуудлыг ч давхар илэрхийлж байдаг.

Улмаар энэхүү залуучуудын хөгжлийг дэмжих харилцааг зохицуулсан холбогдох эрх зүйн орчин, давхардал хийдлийг судлах, тулгамдсан асуудлыг илрүүлэх, түүнийг шийдвэрлэхэд чиглэсэн судалгааг боловсруулах шаардлагатай гэж үзлээ.

Иймээс энэхүү судалгааны хүрээнд ЗХДТХ-н зарим зүйл, заалтуудыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг судлан тодорхойлж, бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалж дотоодын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар дүгнэлт, саналыг дэвшүүлэхийг зорилоо.

1.2 Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо дээрх хууль зүйн үндэслэл, практик шаардлагыг харгалзан үзэж дараах зүйл, заалтыг сонгон авсан болно.

Хүснэгт №1. Үнэлэх зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	1 дүгээр зүйл.Хуулийн зорилт	1.1. Энэ хуулийн зорилт нь төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг тогтоож, нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоо, эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино
2	3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ	3.1. Энэ хууль Монгол Улсын иргэн 15-34 насны залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд үйлчилнэ.
3	6 дугаар зүйл. Залуучуудын эрхэмлэх зүйл	6.1.Залуучууд нийгмийн хөгжил, бүтээн байгуулалтад оролцохдоо дараахь зүйлсийг эрхэмлэнэ: 6.1.1.эх оронч үзлийг эрхэмлэж, ёс заншил, өв уламжлалаа дээдлэх; 6.1.2.эрүүл, чадварлаг, бүтээлч, ёс зүйтэй, боловсролтой, соёлтой иргэн болж төлөвших, өөрийгөө хөгжүүлэх; 6.1.3.нийтэд тустай сайн дурын ажилд манлайлан оролцох; 6.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох;

² С.Амартүвшин, З.Баярхүү, "Залуучуудад чиглэсэн зарлагын шинжилгээ"(судалгааны танилцуулга), 2021, 12 дахь тал

		<p>6.1.5.амьдрах ухааны болон санхүүгийн мэдлэг, чадвар эзэмшиж, сахилга баттай байх;</p> <p>6.1.6.хэвлэл мэдээллийн болон цахим орчинд бусдыг гутаан доромжлохгүй байх.</p>
4	7 дугаар зүйл. Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих чиглэл	<p>7.1.Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг дараахь чиглэлээр зохион байгуулна:</p> <p>7.1.1.хувь хүний хөгжил;</p> <p>7.1.2.боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан;</p> <p>7.1.3.эрүүл мэнд;</p> <p>7.1.4.хөдөлмөр эрхлэлт;</p> <p>7.1.5.аюулгүй амьдрах, хөгжих орчин.</p>
5	8 дугаар зүйл. Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих	<p>8.1.Залуучуудын хувь хүний хөгжлийг дараахь чиглэлээр дэмжинэ:</p> <p>8.1.1.ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн боловсролын төв, багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хичээлийн агуулгыг тусгах;</p> <p>8.1.2.залуучуудад зориулан хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих;</p> <p>8.1.3.түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие дааж амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд чиглэсэн амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хөтөлбөрийн дагуу цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны залуучуудыг хамруулах;</p> <p>8.1.4.залуучуудын гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа, уламжлал, зан заншлын тухай утга зохиол, уран сайхны бүтээлийг дэмжих;</p> <p>8.1.5.залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт тусгах;</p> <p>8.1.6.энэ хуулийн 8.1.5-д заасан агуулга, хөтөлбөрийг зохицуулсан журмыг Засгийн газар батална.</p> <p>8.2.Энэ хуулийн 8.1.1-д заасан хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.</p> <p>8.3.Энэ хуулийн 8.1.3-т заасан цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны эмэгтэйчүүд сайн дурын үндсэн дээр хамрагдаж болно.</p> <p>8.4.Энэ хуулийн 8.1.3 дахь заалт, 8.3 дахь хэсэгт заасан залуучуудад цэргийн мэргэжил олгох журмыг Засгийн газар батална.</p> <p>8.5.Энэ хуулийн 8.1.4-т заасан бүтээлийг сонгон шалгаруулах журмыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.</p>

		<p>8.6.Энэ хуулийн 8.5-т заасан журмын дагуу шалгаруулсан бүтээлийг Засгийн газрын холбогдох тусгай сангаас санхүүжүүлнэ.</p>
6	<p>20 дугаар зүйл. Залуучуудын хөгжлийг дэмжих төвийн чиг үүрэг</p>	<p>20.1.Орон нутагт залуучуудад үйлчилгээ үзүүлэх залуучуудын хөгжлийн төвийг ажиллуулна. Залуучуудын хөгжлийн төвийн дүрмийг залуучуудын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>20.2.Залуучуудын хөгжлийн төв дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>20.2.1.залуучуудад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт явуулах;</p> <p>20.2.2.залуучуудын эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргахтай холбоотой саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх, мэдээллээр хангах;</p> <p>20.2.3.залуучуудын хүсэл, сонирхол, эрэлт, хэрэгцээнд тулгуурласан сонирхлын бүлгийн үйл ажиллагааг дэмжих;</p> <p>20.2.4.залуучуудыг хууль зүйн туслалцаа болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд холбон зуучлах;</p> <p>20.2.5.гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцаа, тулгамдсан бэрхшээлийг даван туулах талаар залуучуудад сургалт явуулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх;</p> <p>20.2.6.зорилтот бүлгийн залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, мэдээллээр хангаж, ажилд зуучлах;</p> <p>20.2.7.залуучуудыг гарааны компани эрхлэхийг дэмжих чиглэлээр орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн байгууллагатай хамтран ажиллах;</p> <p>20.2.8.хууль тогтоомжид заасан бусад.</p> <p>20.3.Энэ хуулийн 20.2-т заасан чиг үүргийг магадлан итгэмжлэгдсэн залуучуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах залуучуудын иргэний нийгмийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.</p> <p>20.4.Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааны зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.</p>
7	<p>22 дугаар зүйл. Залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөл</p>	<p>22.1. Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд, орон нутагт залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга тус тус тэргүүлнэ.</p> <p>22.4. Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөл нь дараахь чиг үүрэгтэй:</p> <p>22.4.1.залуучуудын хөгжлийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газарт болон холбогдох бусад байгууллагад зөвлөх, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шаардлагатай арга хэмжээ авах;</p>

	<p>22.4.2.залуучуудын хөгжлийг дэмжих, эрх ашгийг хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд залуучууд, залуучуудын иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах, гаргасан санаачилгыг дэмжих;</p> <p>22.4.3.залуучуудын хөгжлийг дэмжих асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;</p> <p>22.4.4.залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн дүрэмд заасан бусад.</p>
--	---

1.3 Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

ЗХДТХ-н 1, 3, 6, 7, 8, 20, 22 дугаар зүйлүүдийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг харгалзан аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт заасан 6 шалгуур үзүүлэлтээс: 3.4.1-д заасан “зорилгодоо хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлт, 3.4.4-д заасан “хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлт, 3.4.5 -д заасан “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгон, үнэлгээг хийсэн ба энэхүү шалгуур үзүүлэлтүүд нь хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэх болоод тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг. Сонгосон зүйл заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2. “Зорилгодоо хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	1 дүгээр зүйл	1.1. Энэ хуулийн зорилт нь төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг тогтоож, нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоо, эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино

Хүснэгт 3. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
2	3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ	3.1. Энэхууль Монгол Улсын иргэн 15-34 насны залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд үйлчилнэ.
3.	6 дугаар зүйл. Залуучуудын эрхэмлэх зүйл	6.1.Залуучууд нийгмийн хөгжил, бүтээн байгуулалтад оролцоходоо дараахь зүйлсийг эрхэмлэнэ: 6.1.1.эх оронч үзлийг эрхэмлэж, ёс заншил, өв уламжлалаа дээдлэх; 6.1.2.эрүүл, чадварлаг, бүтээлч, ёс зүйтэй, боловсролтой, соёлтой иргэн болж төлөвших, өөрийгөө хөгжүүлэх; 6.1.3.нийтэд тустай сайн дурын ажилд манлайлан оролцох; 6.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох;

		<p>6.1.5.амьдрах ухааны болон санхүүгийн мэдлэг, чадвар эзэмшиж, сахилга баттай байх;</p> <p>6.1.6.хэвлэл мэдээллийн болон цахим орчинд бусдыг гутаан доромжлохгүй байх.</p>
--	--	--

Хүснэгт 4. "Практикт нийцэж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
4	7 дугаар зүйл. Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих чиглэл	<p>7.1.Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг дараахь чиглэлээр зохион байгуулна:</p> <p>7.1.1.хувь хүний хөгжил;</p> <p>7.1.2.боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан;</p> <p>7.1.3.эрүүл мэнд;</p> <p>7.1.4.хөдөлмөр эрхлэлт;</p> <p>7.1.5.аюулгүй амьдрах, хөгжих орчин.</p>
5	8 дугаар зүйл. Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих	<p>8.1.Залуучуудын хувь хүний хөгжлийг дараахь чиглэлээр дэмжинэ:</p> <p>8.1.1.ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн боловсролын төв, багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хичээлийн агуулгыг тусгах;</p> <p>8.1.2.залуучуудад зориулан хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих;</p> <p>8.1.3.түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие дааж амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд чиглэсэн амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хөтөлбөрийн дагуу цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны залуучуудыг хамруулах;</p> <p>8.1.4.залуучуудын гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа, уламжлал, зан заншлын тухай утга зохиол, уран сайхны бүтээлийг дэмжих;</p> <p>8.1.5.залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт тусгах;</p> <p>8.1.6.энэ хуулийн 8.1.5-д заасан агуулга, хөтөлбөрийг зохицуулсан журмыг Засгийн газар батална.</p> <p>8.2.Энэ хуулийн 8.1.1-д заасан хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.</p> <p>8.3.Энэ хуулийн 8.1.3-т заасан цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27, насны эмэгтэйчүүд сайн дурын үндсэн дээр хамрагдаж болно.</p> <p>8.4.Энэ хуулийн 8.1.3 дахь заалт, 8.3 дахь хэсэгт заасан залуучуудад цэргийн мэргэжил олгох журмыг Засгийн газар батална.</p> <p>8.5.Энэ хуулийн 8.1.4-т заасан бүтээлийг сонгон шалгаруулах журмыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.</p>

		8.6.Энэ хуулийн 8.5-т заасан журмын дагуу шалгаруулсан бүтээлийг Засгийн газрын холбогдох тусгай сангаас санхүүжүүлнэ.
6	20 дугаар зүйл. Залуучуудын хөгжлийг дэмжих төвийн чиг үүрэг	20.1.Орон нутагт залуучуудад үйлчилгээ үзүүлэх залуучуудын хөгжлийн төвийг ажиллуулна. Залуучуудын хөгжлийн төвийн дүрмийг залуучуудын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
7	22 дугаар зүйл. Залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөл	22.1. Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд, орон нутагт залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга тус тус тэргүүлнэ. 22.4. Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөл нь дараахь чиг үүрэгтэй: 22.4.1.залуучуудын хөгжлийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газарт болон холбогдох бусад байгууллагад зөвлөх, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шаардлагатай арга хэмжээ авах; 22.4.2.залуучуудын хөгжлийг дэмжих, эрх ашгийг хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд залуучууд, залуучуудын иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах, гаргасан санаачилгыг дэмжих; 22.4.3.залуучуудын хөгжлийг дэмжих асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах; 22.4.4.залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн дүрэмд заасан бусад.

1.4 Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

1.5 Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Шалгуур үзүүлэлтийг томъёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн сонгон авсан зүйл, заалтуудад тохируулан дараах таамаглал дэвшүүлж асуулт боловсрууллаа.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт зорилгодоо хүрсэн эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтын хүлээн зөвшөөрөгдөх байдал хэр байна вэ?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын хүлээн зөвшөөрөгдөх байдал хэр байна вэ?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6 дахь заалтууд практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 6. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 7. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.4 дэх заалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, холбогдох ярилцлага, хууль тогтоомж, эрх зүйн актуудтай танилцаж, аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсноос дараах аргыг сонгон үнэлгээ хийх мэдээллийг цуглуулсан болно.

1. Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд: Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, холбогдох эрх зүйн акт, сонин сэтгүүл, телевизд өгсөн ярилцлага, онолын ном, гадаад улсын туршлага болон бусад эх сурвалжаас мэдээлэл цуглуулж, үнэлгээ хийхэд ашиглав. Гадаад улсын туршлагын тухайд олон улсын залуучуудын хөгжлийн индексээр 1-р байранд орсон орон учир Сингапур /бие даасан хуульгүй/, Женевийн судалгааны хүрээлэнгээс явуулсан судалгаагаар залуучуудын хөгжилд чиглэсэн бодлого, эрх зүйн орчны үнэлгээгээр өндөр оноо авсан ХБНГУ, БНХАУ болон ОХУ-г тус тус сонгон авсан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх мэдээллийг цуглуулахдаа баримт бичиг судлах, задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх, ярилцлагын аргад тулгуурлаж энэхүү судалгааг гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ дор дурдсан хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаач, салбарын мэргэжилтэн нарын ярилцлага, нийтлэлийг ашигласан болно. Үүнд:

Хууль, эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль (2017)
3. Хууль тогтоомжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2015)
4. Боловсролын ерөнхий хууль
5. Хөдөлмөрийн тухай хууль
6. Хүүхэд хамгааллын тухай хууль
7. Монгол Улсын Засгийн газар. "Алсын Хараа" 2020-2050. Улаанбаатар, 2019
8. Монгол Улсын Засгийн газар. "Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр." Улаанбаатар, 2019
9. Монгол Улсын Засгийн газар. "Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030"
10. Монгол Улсын Засгийн газар. "Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого 2016-2025"
11. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай
12. Залуучуудын хөгжлийн зөвлөлийн ажиллах журам

Ном, гарын авлага, сэтгүүл

1. Монгол Улсын Засгийн газар, НҮБХС. "МУ-ын Хүний хөгжлийн илтгэл: Нийгмийн сайн сайхны төлөө. МУ-ын хөгжилд Залуучуудын оролцоо 2016." Улаанбаатар, 2016
2. С.Туяа. Залуучуудын хөгжлийн төвийн ажлын байрны чиг үүргийн шинжилгээ (урьдчилсан тайлан). 2020. 32 дахь тал
3. Эй Ай СиЭй ХХК. Хот, хөдөөгийн залуучуудад тулгарч буй асуудал (Судалгааны танилцуулга). 2024. 7 дахь тал
4. Н.Хавх. Залуучуудын нийгэм сэтгэл зүйн судалгаа (докторын диссертацийн судалгааны ажил)
5. ЮНЕСКО, Залуучуудын дуу хоолой /судалгааны тайлан/, 2022, 32 дахь тал.
6. ЮНЕСКО. Монгол улсын боловсролын салбарын тойм шинжилгээ. Улаанбаатар, 2019.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд ЗХДтХ-н 1, 3, 6, 7, 8, 20, 22 дугаар зүйлүүдийг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийсэн.

3.1. “Зорилгодоо хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт зорилгодоо хүрсэн эсэх?

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг тогтоож, нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоо, эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Үнэлгээ:

Аль ч улс орны хувьд хөгжил дэвшил, бүтээн байгуулалтыг бий болгогч нийгмийн хүчирхэг бүлэг бол залуучууд байдаг. Чухамдаа энэ бүлгийн нийгэм, улс төр, эдийн засаг, оюун санаа, соёлын амьдралд оролцож буй түвшин, тэдгээрийн хөгжилд оруулж буй хувь нэмрээс улс орны хувь заяа хамаарах учиртай. Судлаачдын тэмдэглэснээр Монгол Улс бол залуучуудын орон хэмээн нэрлэгдэж ирсэн нь дан ганц хүн ам зүйн утга бус, өмнөх тогтолцооны үед ч, өөрчлөлт шинэчлэлтийн үйл явцад ч, өнөөдрийн энэ өдрүүдэд ч улс орны хөгжлийн түүчээ нь залуучууд байж ирсэн, байсаар байгаатай холбоотой. Нийгмийн хөгжлийн тулгуур болсон энэхүү бүлэг, нийтлэгийн хэрэгцээ, сонирхол, хөгжил, хандлага, асуудал бэрхшээлийн талаар “Залуучуудын хөгжлийн хэрэгцээ”-г тодорхойлох, нийгмийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх үндэсний хэмжээний суурь судалгаа хэд хэдэн удаа хийгдсэн бөгөөд хууль эрх зүйн орчин сайжирсаар байна. Тодруулбал, 1997 онд “Төрөөс залуучуудын талаар баримтлах бодлого”, 2005 онд “Хүн амыг орон сууцаар хангах үндэсний хөтөлбөр”, “Итгэлийн мөнгө”, “Залуу гэр бүл, шинээр төрсөн хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж” 2006 онд “Өсвөр үе, залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр”-г хэрэгжүүлсэн байна.

Улмаар 2016 онд нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоо, эрх, үүргийг тодорхойлж, төрөөс залуучуудад үзүүлэх дэмжлэг, чиглэл, хэлбэр, арга зам, залуучуудын хөгжлийг дэмжих төрийн болон залуучуудын байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох³ үүднээс Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг өргөн барьсан. Хууль санаачлагчдын зүгээс дээрх хууль батлагдсанаар залуучуудын нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх замаар тэдний эх оронч, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, эрдэм боловсролтой, соёлч боловсон, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэх, улс орны бүтээн байгуулалт, хөгжилд хувь нэмрээ оруулах боломж бүрдэх бөгөөд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлснээр эдийн засгийн өсөлтийг хангах боломж бүрдэхээс гадна ирээдүйд хүн амын бүтцэд үүсэх насжилтын асуудлыг шийдвэрлэх ач холбогдолтой хэмээн үзэл баримтлалдаа тусгасан байна.⁴

Гэвч хуульд заасан залуучуудын хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа нь тэр бүр хангалттай хэрэгжиж залуучуудын өмнө тулгарч байгаа олон асуудлыг туйлбартай шийдвэрлэж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл хүн амын суурь бүлэг болсон залуучуудад тусгайлан

³ Монгол Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, 191 дэх тал <https://www.parliament.mn/nc/213/>

⁴ 2017 оны Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн үзэл баримтлал

баримжаалсан оновчтой, үр өгөөжтэй бие даасан бодлого, үйлчилгээ илт үгүйлэгдэж байгаа юм. Тодруулбал,

Коммонвелс Секретариат (Commonwealth Secretariat)-с гаргадаг Залуучуудын Хөгжлийн Индексийн 2020 оны тайланд нийт 181 орны дотроос Монгол Улс **58 дугаар байр** эзэлж, **0.758** оноо авсан бөгөөд Монгол улс Ази-Номхон Далайн бүсийн орнуудын дундаас нэлээд өндөр байрлалд орсон байна.⁵ 2023 онд онооны хэмжигдэхүүн болон судалгааны дэд хэмжигдэхүүний мэдээллийг шинэчилэн гаргахад **63 дугаар байр** эзэлсэн байна. Тус тайланд дурдсанаар байрлалд нөлөөлөх шалгуур үзүүлэлтийг зургаан хэсэгт хуваан авч үзсэн бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүр дээр Монгол Улсын гол давуу тал болон оноо алдахад нөлөөлсөн сөрөг хүчин зүйлийг нэгтгэвэл:

Хүснэгт 5. Залуучуудийн хөгжлийн индексийн дэд хэмжигдэхүүн тус бүр дээр оноо авах болон алдахад нөлөөлсөн хүчин зүйлс

Дэд хэмжигдэхүүн	Монгол Улсын гол давуу тал	Оноо алдахад нөлөөлсөн хүчин зүйл
Боловсрол	Бичиг үсгийн мэдлэг 99.18%; дунд ангийн хүйсийн тэгш байдал	Хот-хөдөөгийн ялгаа; эрэгтэйчүүдийн боловсролын хоцрогдол
Ажил эрхлэлт	Банкны дансны эзэмшилт өссөн	Ажилгүйдэл
Эрүүл мэнд ба сайн амьдрал,	ЭМД-ийн тогтолцоотой	Амиа хорлолт өндөр ⁶ агаарын бохирдол; тамхи, архи
Тэгш байдал ба оролцоо	Эмэгтэйчүүдийн дээд боловсрол өндөр	Гэр бүлийн хүчирхийлэл; ажлын байрны ялгаварлал их
Аюулгүй байдал	GPI 44-р байр; зэвсэгт мөргөлдөөнгүй	Гэр бүлийн хүчирхийлэл; цахим хүчирхийлэл
Улс төрийн ба иргэний оролцоо	Иргэний идэвхтэй нийгэм; жагсаал цуглаан	Институциональ оролцоо сул; залуусын бодлогод нөлөөлөл хязгаарлагдмал

Хэдийгээр Монгол улсын залуучуудын хөгжлийн ерөнхий индекс дундаж үзүүлэлттэй бусад орнуудаас өндөр байгаа ч ажил эрхлэлт, улс төрийн ба иргэний оролцоо, эрүүл мэнд ба сайн амьдрал дэд хэмжигдэхүүнүүдэд гол сул тал нь байна. Ялангуяа залуучуудын

⁵ Commonwealth Secretariat, "Youth Development Index (YDI)," 2020 Global YDI Table, <https://thecommonwealth.org/innovation/youth-development-index>.

⁶ Амиа хорлолтын түвшин дэлхийн дунджаар 100 000 хүн амд 9.2 байна. Харин Номхон далай баруун эргийн бүсийн улс орнуудаас Солонгос улсад 100 000 хүн амд 27.5 болж тэргүүлж, Монгол улс 18.5 буюу бүсдээ хоёрдугаарт бичигдэж байна. Эрүүл мэндийн яам, "Амиа хорлох оролдлогыг бууруулах, сэргийлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө" боловсруулав /мэдээ/, <https://moh.gov.mn/news/7396>

сэтгэл зүйн эрүүл мэнд, амиа хорлолтын түвшин өндөр, хот-хөдөөгийн тэгш бус байдал нь цаашид нэн тэргүүнд анхаарах шаардлагатай асуудлууд болж байна.

Дээрх индексд дурдсан тулгамдсан асуудлаас гадна залуучуудын хөгжил, тулгардаг асуудлуудтай холбоотойгоор цөөнгүй судалгаан хийгдэж байсан бөгөөд дээрх судалгааны тайлангуудад тусгагдсан асуудлыг тоймлон авч үзье:

2019 онд ЮНЕСКО-оос гаргасан МУ-ын боловсролын бодлогын тойм шинжилгээний тайлангаас харахад МУ-ын ЕБС-ийн сургалтын түвшний болон хүйсийн ялгаатай байдал өндөр байгаа учир чанар, тэгш боломжийн асуудалд анхаарал хандуулах хэрэгцээ байна гэсэн дүгнэлт гарчээ.⁷

Мөн НҮБХХ-с 2021 хийж гүйцэтгэсэн судалгаагаар "...хууль, эрх зүй, бодлогын хүрээнд ахиц дэвшил гарч байгаа ч залуучуудын хөгжилд чиглэсэн институцүүдийн эрх, үүргийн давхцал их, санхүүжилт, төсвийн хүрэлцээ сул хэвээр байна. Өөрөөр хэлбэл, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль нь хэт ерөнхий, залуучуудын хөгжилд чиглэсэн тодорхой бодлого, арга хэмжээнүүдийг хариуцаж буй институц тус бүрийн үүргийг нарийн зааглаагүйн улмаас Залуучуудын хөгжлийн төвүүдийн үйл ажиллагаа нь бусад байгууллагууд тухайлбал Хөдөлмөр, халамж үйлчилгээний төвийн чиг үүрэгтэй давхцах, улмаар институц хооронд үл ойлголцол үүсч төлөвлөгөөт ажлууд орхигдох, ЗХТ-үүдийн үйл ажиллагаа удаашрах эрсдэл ажиглагдаж байна. Түүнчлэн, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дэргэдээ Залуучуудын хөгжлийг дэмжих сантай байна гэсэн заалт тусгагдсан боловч одоог хүртэл хуулийг хэрэгжүүлж санг байгуулаагүй байна..."⁸ гэж дүгнэсэн байна.

2022 онд Юнеско-ийн захиалгаар хийгдсэн "Залуучуудын дуу хоолой" судалгааны үр дүнгээс харахад хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран залуучуудад нийгмийн амьдралд оролцоход бэрхшээл тулгарч байгаа бөгөөд тодруулбал судалгаанд оролцогчдын 17.7% нь нийгмийн амьдралд хэвийн оролцоход ямар нэгэн байдлаар сорилт тулгардаг гэж хариулсан бол 30.8% нь уг асуултад хариулахаас татгалзсан байна. Уг судалгаагаар судалгаанд оролцогчдын 31% нь ажилгүйдлийг Монголын залуучуудад хамгийн ихээр тулгамдаж буй асуудал хэмээн үзэж байна. Залуучууд уг асуудлыг сонгохдоо ажлын туршлага байхгүй учир ажлын байр олдоггүй, эсвэл шинэ төгсөгч учир цалин бага, ажлын байр олдсон ч хэт олон цагаар ажиллуулдаг, ажлын байрны аюулгүй орчин хангалттай биш байдаг гэх зэрэг асуудлуудыг нэрлэсэн байна.⁹ Улмаар залуучуудад нийгмийн амьдралд хэвийн оролцоход саад болж буй дараах бэрхшээлүүд байна хэмээн хариулсан байна. Үүнд, санхүүгийн боломж, нөхцөл тааруу, хүмүүсийн харилцаа, хандлага, насаар ялгаварлан гадуурхах, хүүхэд харах хүнгүй байх, дэд бүтэц, хот төлөвлөлт, замын түгжрэл, гудамжинд үг хэлэхдээ хүмүүсээс болгоомжилдог, хөдөө, орон нутагт дахь хязгаарлагдмал бололцоо, орчин нөхцөл тааруу, аюулгүй орчин нөхцөл байхгүй (золбин нохой) гэх мэт шалтгаануудын улмаас нийгмийн харилцаанд идэвхтэй оролцоход хүндрэлтэй байдаг байна.¹⁰

2024 онд хийгдсэн Хот, Хөдөөгийн залуучуудад тулгарч буй асуудал судалгаагаар залуучуудад тулгарч буй боловсрол эзэмшил, хөдөмөр эрхлэлт, эрүүл мэндтэй

⁷ ЮНЕСКО. Монгол улсын боловсролын салбарын тойм шинжилгээ. Улаанбаатар, 2019.

⁸ С.Амартүвшин, З.Баярхүү, "Залуучуудад чиглэсэн зарлагын шинжилгээ", 2021, 13 дахь тал

⁹ ЮНЕСКО, "Залуучуудын дуу хоолой /судалгааны тайлан/, 2022, 32 дахь тал.

¹⁰ ЮНЕСКО, "Залуучуудын дуу хоолой /судалгааны тайлан/, 2022, 10 дахь тал.

холбоотойгоор дараах нийтлэг асуудлууд тулгарч байна хэмээн тодорхойлсон байна.¹¹ Тодруулбал, Боловсролын тухайд үе тэнгийн дээрэлхэлт их, өсвөр насны хүүхдүүдэд хичээл, даалгавраа хийх номын сан хүрэлцээгүй байдаг (ЕБС,МСҮТ,Коллеж), багш нарын зүгээс хүүхдийг ялгаварлах хандлагатай, суралцагчид залхуу, цагийн менежмент хийх, харилцааны ур чадвах муу, хичээлдээ дур сонирхолгүй байх хандлагатай, залуучуудын мэргэжлийн ур чадвар хангалтгүй (мэргэжлийн сонголтоо буруу хийх нь мэргэжлийн ур чадвар хангалтгүй байхад нөлөөлөх хандлагатай), залуучууд мэргэжил дээшлүүлэх, чадавжих, мэргэжлийн сургалтад хамрагдахад цаг хугацаа, мөнгө санхүүгийн асуудал их, залуучуудад хүүхэд хүмүүжүүлэх арга, гэр бүл төлөвлөлт, мөнгө санхүүгээ хэрхэн удирдан зохион байгуулахтай холбоотой мэдлэг, мэдээлэл хангалтгүй, сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын үйлчилгээ чанаргүй байгаа нь залуучуудын ур чадвар хангалтгүй байхад нөлөөлдөг, төрийн албаны ажлын байрны сонгон шалгаруулалт шударга бус байдаг зэрэг асуудлыг хөндсөн байна.

Харин эрүүл мэндийн тухайд¹² шүд, амны хөндийн өвчлөл ихтэй, ходоод, нойр булчирхайн үрэвсэл, шархлаа их, цусны өтгөрөл их, таргалалттай, үүнээс шалтгаалсан элэгний өөхлөлттэй, эмнэлгийн очир, дараалал их, ажлын цаг нь эмнэлгийн үйлчилгээ авах цагтай давхцдаг, малчин, хөдөлмөр эрхлэхгүй байгаа, хувиараа хөдөлмөр эрхлэгч залуучууд эрт илрүүлэх үзлэгт хамрагдах нь бага, эрүүл мэндийн мэдлэг дадал, хандлага төлөвшөөгүй гэсэн бол хөдөлмөр эрхлэлт, санхүүтэй холбоотойгоор¹³ Улаанбаатар хот-д оюутан, залуучууд хөдөлмөрийн мөлжлөгт өртөх (ХТХ-ийн хэрэгжилт муу) хандлагатай, залуучуудын ажлын ачаалал их, уян хатан бус, байр, оффисын түрээсийн төлбөр өндөр, ихэнх оюутан цагийн ажил хийх сонирхолтой болсон бөгөөд энэ нь хичээл, сурлагын чанарт сөргөөр нөлөөлдөг, залуучууд завгүй амьдралын хэв маягтай, Аймаг-т хувиараа хөдөлмөр эрхлэгч залуучуудад тогтвортой үйл ажиллагаа явуулах оффис байр хангалтгүй, төсөл хөтөлбөрийн санхүүжилт шударга бус олгогддог, цагийн ажлын хүрэлцээ муу, залуучуудын бүтээлч сэтгэлгээ, жижиг дужкнд үйлдвэрлэл эрхлэхэд шаардагдах мэдлэг чадвар дутагдалтай байдаг, Улаанбаатар хотоос шилжин очиход хангалттай ажлын байр байдаггүй. Суманд залуучууд төрийн албанд ажиллах, мал маллах гэсэн үндсэн 2 төрлийн хөдөлмөр эрхлэлттэй ажлын байр хомсдолтой, зарим төрийн алба хаагчдын ажлын ачаалал бага, цагийн уян хатан зохицуулалт дутагдалтай, иргэдийн худалдан авах чадвар муу, малчдын зарлага, орлогоо давдаг (малын түүхий эд хямд, хаядаг), боловсруулсан бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэх бизнесийн систем бүрдээгүй зэрэг асуудлуудыг хөндсөн байна.

Эдгээр судалгаануудаас гадна 2024 онд НҮБ-ын Хүн амын сангаас “Монгол Улсын Залуучуудын нөхцөл байдлын шинжилгээ хийх тайлан боловсруулах” ажлыг i) эрүүл мэнд, (ii) боловсрол, (iii) хөдөлмөр эрхлэлт (iv) улс төрийн болон иргэний оролцоо гэсэн дөрвөн үндсэн чиглэлээр шинжилгээ хийсэн бөгөөд дээрх судалгааны үр дүнг чиглэл тус бүрээр нь тоймлон авч үзвэл:¹⁴

Эрүүл мэнд

¹¹ Эй Ай Си Эй ХХК, Хот, хөдөөгийн залуучуудад тулгарч буй асуудал (Судалгааны танилцуулга), 2024, 7 дахь тал

¹² Эй Ай СиЭй ХХК, Хот, хөдөөгийн залуучуудад тулгарч буй асуудал (Судалгааны танилцуулга), 2024, 8 дахь тал

¹³ Эй Ай СиЭй ХХК, Хот, хөдөөгийн залуучуудад тулгарч буй асуудал (Судалгааны танилцуулга), 2024, 5-6 дахь тал

¹⁴ Златко Никольски, Х. Энхжаргал нар, Монголын Залуучуудын нөхцөл байдлын шинжилгээ, 2024, 8-15 дахь тал.

- Монгол Улсад эрүүл мэндийн тусламжид зориулсан зардал багаас гадна бүсүүдэд тэгш бус хуваарилалттай байгаа нь эрүүл мэндийн тусламжийн дэд бүтэц болон хүний нөөцийн хангамж орон даяар тэгш бус болоход нөлөөлж байна.
- Осол, гэмтэл, хордлого бусад гадны шалтгаан залуучуудын (15-34 насны) нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна. Гэхдээ хавдрын шалтгаант нас баралт залуучуудын дунд, ялангуяа 30-34 насныхны дунд нэмэгдэж байна.
- Залуу эрчүүд тамхи татах, архи уух гэх мэт эрсдэлт хүчин зүйлст залуу эмэгтэйчүүдээс илүү өртөмтгий байна. Үүнээс гадна архины хэрэглээ нас ахих тутам нэмэгдсээр байгаа бол тамхины хэрэглэдэг залуусын хувь 20-34 насны насны залуучуудын бүлгүүдэд бараг адил түвшинд байна.
- Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллийн тархалт өндөр хэвээр байгаа бөгөөд 30-34 насны гурван залуу эмэгтэй тутмын нэг нь амьдралынхаа туршид наад зах нь нэг удаа гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байжээ. Цаашилбал, ахлах ангийн гурван суралцагч тутмын нэг нь аль нэг хэлбэрийн хүчирхийлэлд өртдөг байна (зодуулсан эсвэл дээрэлхүүлж байсан гэх мэт).
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлуудын (сэтгэл гутрал ба сэтгэл түгшилт) тархалт залуучуудын дунд харьцангуй бага хэдий ч эдгээр эмгэг шинж тэмдэг илэрч буй залуучуудын зөвхөн тал орчим хувь нь л хэн нэгнээс тусламж хүссэн байгаа нь сэтгэл зовоож байна.

Боловсрол

- Боловсролын нийт зардал эрүүл мэндтэй харьцуулахад өндөр хэдий ч Монголтой хөрш зэргэлдээ зарим улстай харьцуулахад бага хэвээр байна.
- Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй өсвөр насныханд ерөнхий боловсрол эзэмшихэд тодорхой саад бэрхшээлүүд тохиолддог. Түүнчлэн боловсролын зардал нь ядуу өрхийн дотоодын төсөвт дарамт учруулдаг тул ядуу өрхийн залуучууд сургуулиа орхих магадлал өндөр байна.
- Насан туршийн боловсролын (НТБ) төвүүд нь хөрөнгө оруулалт бага, дэд бүтэц тааруу, үйл ажиллагаа нь жигдрээгүй
- Хөгжиж буй ихэнх орноос ялгаатай нь Монголд охид боловсролын үр дүнгийн хувьд хөвгүүдээс илүү гарах хандлагатай байдаг (үүнд боловсролын байгууллагад элссэн байдал, мөн олж авсан нийт мэдлэг).

Хөдөлмөр эрхлэлт

- Залуучууд болон дунд түвшний боловсролтой хүмүүсийн дунд ажилгүйдлийн түвшин онцгой өндөр байна. Ялангуяа залуу эрэгтэйчүүдийн (20-24 нас) дунд ажилгүйдлийн түвшин залуу эмэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр байна.
- Өмнөх дүгнэлттэй холбоотойгоор, олон залууст хөдөлмөрийн зах зээлд шилжих үйл явц сайнгүй байна.
- Олон төгсөгч ажилд ороход урт хугацаа зарцуулж байгаа нь одоогийн сургалтын хөтөлбөрүүд болон залуучуудын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хооронд тодорхой хэмжээний зөрүү байгааг харуулж байна.
- Түүнчлэн, залуучуудын эрхэлж буй ажлын хувьд ихэвчлэн бичгээр хийсэн гэрээгүй, ажилллах ёстой хамгийн бага цагийг гэрээнд заагаагүй, ээлжийн амралт болон өвдөж гэмтсэн үеийн цалинтай чөлөөгүй байна. Мөн, Залуучууд энтрепренер байх тохиолдол бага бөгөөд үүний шалтгаан нь зээл авахад тулгардаг саад бэрхшээлтэй холбоотой байна.

Улс төрийн болон иргэний оролцоо

- Монгол Улсад залуучуудын улс төрийн оролцоог хуулиар баталгаажуулсан байдаг ч улс төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд залуучуудын оролцоо бага байна.
- Зарим залуучууд улс төрийн намуудад элсэж, намын үйл ажиллагаанд оролцдог, түүний дотор намын идэвхтэн болох, албан тушаалд өрсөлдөх зэрэг үйл ажиллагаанд оролцдог ч авлигатай тэмцэх, удирдлагын үр дүнг дээшлүү-лэхэд тэдний оролцоо харьцангуй хязгаарлагдмал байдаг.
- Залуучуудыг улс төрд идэвхтэй оролцоход саад болох олон хүчин зүйл байдаг ч байгаа баримтуудаас харахад төр засагт итгэх итгэлгүй байгаа нь залуучуудын улс төрийн оролцоо сул байгаагийн нэг гол шалтгаан болж байна.

Судалгааны үр дүнгүүдээс харвал хууль батлагдаж байх үед залуучуудад тулгардаг асуудлууд 2020, 2021, 2022, 2024 онд ч тулгарсаар байгаа нь уг хуулийн хэрэгжилт хангалтгүй буюу 2017 онд байсан асуудлууд одоо ч хэвээрээ байхаас гадна улам нэмэгдсэн болох нь харагдаж байгаа нь хуулийн зорилго биелээгүй, залуучуудад тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэж чадахгүй байна хэмээн дүгнэж болох юм.

Шигтээ 1

...Гол асуудлын нэг бол залуучуудын ажил эрхлэлтийн асуудал байгаа. 2016 оны байдлаар ажилгүйдлийн хэмжээ 10.4 хувьтай байгаагийн 38.5 хувь нь 25-34 насны залуучууд эзэлж байна. Тэгэхээр манай хуулийн төсөл дээр хамгийн гол нь ажил олгогчдоо дэмжсэн асуудлуудыг нь оруулж ирж байгаа нь чухал байгаа. Тэгэхээр залуучууд эхлээд ажил орохдоо ажил олгогчид маань мэргэжлээрээ 1-2 жил ажилласан байх шаардлага тавьдаг. Дөнгөж дээд сургууль төгссөн залуучууд ажил ороход нэлээн хязгаарлагдмал байдаг. Тэгэхээр энэ хуулийн төсөлд маань тухайн жилд нь ажлын байраар хангасан ажил олгогчийг дэмжих заалтууд хуулийн төсөлд оруулж ирсэн нь бас талархалтай хандаж байна.

*Монгол Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы
2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаан
УИХ-н гишүүн Б.Саранчимэг-н хэлсэн үгнээс¹⁵*

Шигтээ 2

... Өнөөдөр энэ 2016 оны статистик мэдээнээс харахад ажилгүйчүүдийн маань тоо 10.6 хувьд хүрсэн нь сүүлийн 20 жилийн хамгийн дээд үзүүлэлт болоод байгаа. Гэтэл 10.6 дотроо нөгөө бидний өнөөдөр ярьж байгаа 15-34 насны залуучууд маань 57.6 хувь буюу бараг 60-аад хувийг нь эзэлж байна. Энэ бол үнэхээр эмгэнэлтэй тоо.

*Монгол Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы
2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаан
УИХ-н гишүүн М.Оюунчимэг-н хэлсэн үгнээс¹⁶*

Шигтээ 3

... Нийтдээ 27300 орчим залуучуудыг хамарсан судалгаа хийхэд залуучуудын дунд тулгамдаж байгаа тэргүүний асуудал 45 хувьтайгаар орон сууц гэж гарч ирсэн.

Тэгэхээр үүнийг бид аюулгүй амьдрах хөгжих орчин гэж сая Ж.Энхбаяр гишүүн бас 5 бодлогыг дурдсан. 5 дахь бодлого болгож оруулж ирсэн байгаа. Энэ нь бас хэтдээ даатгалын шинэчлэлийн хууль түүнийг дагалдах хуулиудтайгаа бас уялдаж олон улсын жишиг болсон нийгмийн даатгалын шимтгэл төлж байхдаа тодорхой хэмжээнд орон

¹⁵ Монгол Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, 201 дэх тал <https://www.parliament.mn/nc/213/>

¹⁶ Монгол Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, 114 дэх тал <https://www.parliament.mn/nc/213/>

сууцны санхүүжилтээр бас үр шимийг нь хүртдэг байх ийм зохицуулалтуудыг бол бусад хууль эрх зүйн хүрээнд хийх мөн Засгийн газрын тусгай хөтөлбөрүүдийг хүрээнд зохион байгуулах бүрэн дүүрэн боломжтой байгаа.

*Монгол Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы
2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаан
УИХ-н гишүүн Н.Номтойбаяр-н хэлсэн үгнээс¹⁷*

Иймд ЗХДТХ-р залуучуудын өмнө тулгарч буй олон асуудлуудыг шийдэх гарцыг олох, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, уялдаа холбоог сайжруулж, ажлын үр дүнг нэмэгдүүлэх хүрээнд гадаад улсын туршлагыг судлан харьцуулах нь зүйтэй хэмээн үзсэн тул энэхүү хэрэгжилтийн үр дагаврын судалгааны хүрээнд дараах харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэлээ.

Женевийн Их Сургуулийн дэргэдэх Альберт Хиршман Ардчиллын Төвөөс (Albert Hirschman Centre on Democracy, Geneva Graduate Institute) 2025 оны 1 дүгээр сард нийтэлсэн "Mapping Youth Policies across 32 Countries: Legal Frameworks and Strategies for Education, Employment, and Well-being" хэмээх судалгааны ажилд дэлхийн 32 орны залуучуудын хөгжлийг дэмжихэд чиглэсэн "эрх зүйн орчин, боловсрол, ажил эрхлэлт, сайн сайхан байдал" хэмээх үндсэн 4 хүрээний бодлогын орчинд харьцуулсан үнэлгээ хийж Залуучуудын Засаглалын Индекс (Youth Governance Index, цаашид ЗЗИ гэх)-ийг боловсруулсан байна. Уг индекс нь улс орнуудын залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн институцийн бүтэц, эрх зүйн орчин, хэрэгжилтийн механизмыг нэгдсэн шалгуураар үнэлэх боломжийг олгодог тул энэхүү судалгааны хүрээнд харьцуулан судлах улс орнуудыг сонгон авах суурь нөхцөл болгон ашиглав.¹⁸

Уг индексээр улс орнуудыг долоон шалгуураар үнэлжээ. Үүнд: (1) залуучуудын асуудал эрхэлсэн тусгай яам/агентлагтай эсэх, (2) үндсэн хуулинд залуучуудын хөгжлийн бодлогод холбогдох заалт тусгагдсан эсэх, (3) залуучуудын хөгжлийн стратеги/хөтөлбөртэй эсэх, (4) залуучуудын насны хязгаарлалтын зохистой байдал, (5) залуучуудын хөгжлийн асуудлаар бие даасан хуультай эсэх, (6) залуучуудын зохицуулалтын нөлөөллийн үнэлгээг (Youth RIA) хэрэгжүүлдэг эсэх, (7) залуучуудын бодлогын цогц байдал зэрэг багтана.

Дээрх шалгуур үзүүлэлтүүдээр хэмжихэд нийт оноогоор ХБНГУ 5/7 оноо буюу хамгийн өндөр үнэлгээ авч нэгдүгээр байранд орсон байх ба БНХАУ болон ОХУ тус бүр 3.4/7 оноо авчээ. Эдгээр гурван улсыг ЗЗИ-д эзэлсэн байр болон нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, эрүүл мэнд, боловсрол, хүн ам зүйн бүтэц, соёл зэрэг хүчин зүйлсээр тэргүүлэгч бөгөөд түүхэн хөгжил, эрх зүйн тогтолцооны хувьд Монгол Улстай төсөөтэй талуудыг харгалзан харьцуулан судлахаар сонгож авав. Мөн НҮБ-ын Хамтын нөхөрлөлийн байгууллагаас 3 жил тутамд гаргадаг Олон Улсын Залуучуудын Хөгжлийн Индексээр (Global Youth Development Index) 2023 онд дэлхийн 180 гаруй орноос хамгийн өндөр оноо авсан Сингапур Улсын эрх зүйн орчин, тогтолцоог харьцуулан судлав.

¹⁷ Монгол Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, 201 дэх тал <https://www.parliament.mn/nc/213/>

¹⁸Monti, L., Cioffi, C., Ghazi Zarshoi, H., & Lutringer, C. (2025). Mapping youth policies across 32 countries: Legal frameworks and strategies for education, employment, and well-being. AHCD Working Paper No. 4, Albert Hirschman Centre on Democracy, Geneva Graduate Institute. Энэхүү ажил нь Залуучуудын Засаглалын Индекс гэх индекс боловсруулсан.

Нэг. Холбооны Бүгд Найрамдах Герман улс (ХБНГУ)

1.1. Эрх зүйн зохицуулалт

ХБНГУ нь Женевийн судалгааны хүрээлэнгээс 2025 онд нийтлэгдсэн тайлангаар ЗЗИ-ээр 32 улсаас хамгийн өндөр буюу 5/7 оноо авч нэгдүгээр байранд жагссан бөгөөд залуучуудын бодлого, эрх зүйн зохицуулалтын хувьд дэлхийд тэргүүлэгч улс юм. Тус улсын залуучуудын бодлого нь Нийгэм хамгааллын салбар хуулийн VIII ном (Sozialgesetzbuch Aches Buch – SGB VIII)¹⁹-д үндэслэн боловсруулсан Хүүхэд, залуучуудын тусламжийн тухай хуулиар (Kinder- und Jugendhilfegesetz) зохицуулагддаг онцлогтой.²⁰

Нийгэм хамгааллын салбар хууль тогтоомжийн нэгдсэн ном (Sozialgesetzbuch) хэмээх эрх зүйн актын онцлог нь тус улсад нийгмийн хамгааллын бүхий л салбарыг хамарсан эрх зүйн нэгдсэн тогтолцоог бүрдүүлдэг бөгөөд нийгмийн хамгааллын бүхий л салбарыг боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн бусад хуулиудтай харилцан уялдааг хангах зорилготой. Энэхүү онцлог зохицуулалтын хэлбэр нь Монгол Улсын ЗХДТХ-тай адил бие даасан хуулиар зохицуулах хэлбэрээс ялгаатай хандлага юм.²¹

Хүүхэд залуучуудын тусламжийн тухай хууль нь 1990 онд батлагдсан бөгөөд 2021 онд шинэчлэн найруулж Хүүхэд, залуучуудын хөгжлийг баталгаажуулах тухай хууль (Kinder- und Jugendstärkungsgesetz, цаашид “ХЗХБТХ” гэх) хэмээх нэршлээр батлагджээ. ХЗХБТХ нь хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг нийгмийн амьдралд тэгш оролцуулах, хамгаалалт шаардлагатай хүүхэд, залуучуудын эрхийг баталгаажуулах, насанд хүрээгүй дүрвэгсдийн хамгаалалт, асран хамгаалалтын тогтолцоог сайжруулах зэрэг олон чухал шинэчлэлийг агуулсан. Уг хуулиар хамгаалалт шаардлагатай хүүхэд, залуучуудын омбудсманы (Ombudsperson) институцийг хуулийн түвшинд баталгаажуулсан нь залуучуудын эрхийн хамгаалалтад чухал ахиц дэвшил болсон гэж үздэг байна.²²

1.2. Бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо

ХБНГУ-ын залуучуудын хөгжлийн бодлогын тогтолцоо нь Холбооны Засгийн газар, муж, орон нутгийн гэсэн гурван түвшинд хуваагддаг. Холбооны түвшинд Боловсрол, Гэр бүл, Ахмад настан, Эмэгтэйчүүд, Залуучуудын асуудал эрхэлсэн яам (Bundesministerium für Bildung, Familie, Senioren, Frauen und Jugend – BMBFSFJ) залуучуудын бодлого хариуцсан гол байгууллага бөгөөд бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэсэн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлдэг. 2025 оноос яамны нэр өөрчлөгдөж Боловсролын асуудлыг нэмж хариуцах болсон нь залуучуудын бодлого, боловсролын бодлогын уялдааг бэхжүүлсэн чухал алхам болсон гэж үздэг.²³

Муж бүр өөрийн Залуучуудын халамжийн газар (Landesjugendamt)-тай байх ба Нийгмийн хамгааллын салбар хуулиудын VIII номын 85 дугаар зүйлд заасан чиг үүргийг

¹⁹ Англи орчуулга: “Book Eight of the Social Code: Child and Youth Services” Танилцах холбоос: https://www.gesetze-im-internet.de/sgb_8/BJNR111630990.html (Сүүлд үзсэн: 2026.05.20)

²⁰ Sozialgesetzbuch (SGB) Aches Buch (VIII) – Kinder- und Jugendhilfe (Германы Нийгмийн хуулийн VIII ном – Хүүхэд, залуучуудын тусламж), 1990 оны 6 дугаар сарын 26-нд батлагдсан, BGBl. I S. 1163. 2007 оноос хойш 41 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон.

²¹ Youth Wiki, Germany: National Youth Law. European Commission / Education, Audiovisual and Culture Executive Agency (EACEA), 2024–2026. <https://national.policies.eacea.ec.europa.eu/youthwiki/chapters/germany/12-national-youth-law> (сүүлд үзсэн: 2026 оны 5 дугаар сар).

²² Kinder- und Jugendstärkungsgesetz (KJSG) [Хүүхэд, залуучуудыг бэхжүүлэх тухай хууль], 2021 оны 6 дугаар сарын 3-нд батлагдсан, BGBl. I S. 1444. Тус хуулиар SGB VIII-д өргөн хүрээний нэмэлт, өөрчлөлт оруулсан.

²³ Bundesministerium für Familie, Senioren, Frauen und Jugend (2025). Children and Youth – Policy Overview. <https://www.bmbfsfj.bund.de/bmbfsfj/meta/en/youth> (сүүлд үзсэн: 2026 оны 5 дугаар сар).

хэрэгжүүлдэг. Харин орон нутгийн түвшинд Залуучуудын халамжийн алба (Jugendamt) нь залуучуудын халамжийн үйлчилгээг шууд хэрэгжүүлэгч байгууллага юм. Залуучуудын халамжийн хороо (Jugendhilfeausschuss) нь бодлого хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн оролцоог хангах үүрэгтэй. Энэхүү хороо нь орон нутгийн парламент, мэргэжлийн байгууллага, залуучуудын ТББ-ын төлөөллөөс бүрдэх ба залуучуудын халамжийн бодлогын шийдвэр гаргахад идэвхтэй оролцдог онцлогтой. Германд нийт 580 орчим Jugendamt үйл ажиллагаа явуулдаг ба тус бүр нь Нийгэм хамгааллын салбар хуулийн VIII номын хүрээнд хүүхэд, залуучуудын халамж, хамгааллын бүх үйлчилгээг хариуцдаг байна.²⁴

Энэхүү гурван түвшний засаг захиргааны тогтолцоо нь залуучуудын бодлогыг орон нутагт ойр, залуучуудын бодит хэрэгцээнд нийцүүлэн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж, мөн дээрээс доошоо (top-down) бус доороос дээшээ (bottom-up) бодлогын орчныг бүрдүүлдэг давуу талтай.

1.3. Залуучуудын хөгжлийг дэмжих үндсэн чиглэлүүд

ХБНГУ-ын залуучуудын хөгжлийн бодлого нь олон салбарыг хамарсан цогц тогтолцоог бүрдүүлдэг. Нийгмийн хамгааллын салбар хуулиудын VIII ном нь 10 гаруй үндсэн чиглэлд залуучуудын тусламжийн үйлчилгээг зохицуулсан бөгөөд голлох чиглэлүүдийг дурдвал:

Боловсрол, мэргэжлийн сургалт. Герман Улс мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн тогтолцоо (Duale Ausbildung)-оор дамжуулан залуучууд ажлын байр дээрх дадлага болон мэргэжлийн сургуулийн сургалтыг хослуулан эзэмшүүлдэг. Энэ тогтолцоо нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн бодит чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнтэй механизм юм. Залуучуудын ажил эрхлэлтийн агентлаг (Jugendberufsagenturen) нь боловсрол, нийгмийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн агентлаг, аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааг зохицуулан бэхжүүлж залуучуудыг боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн хүртээмжтэй байдлыг бүрдүүлэх (NEET), ажилгүйдлээс урьдчилан сэргийлэхэд үйл ажиллагаа нь чиглэдэг байна. Германд мэргэжлийн сургалтын тогтолцоонд жил бүр шинээр 480,000 гаруй гэрээ байгуулагдаж, нийт 1.2 сая гаруй залуу сурагч сургалтад хамрагддаг бөгөөд энэ нь залуучуудын дундах ажилгүйдлийг бууруулахад чухал нөлөөтэй байдаг.

Нийгмийн оролцоо, иргэний нийгмийн хөгжил. Сайн дурын үйлчилгээний хөтөлбөрүүд (Freiwilligendienste) болох Холбооны сайн дурын үйлчилгээ (Bundesfreiwilligendienst – BFD), Сайн дурын нийгмийн жил (Freiwilliges Soziales Jahr – FSJ), Сайн дурын экологийн жил (Freiwilliges Ökologisches Jahr – FÖJ) зэрэг нь залуучуудын нийгмийн оролцоог дэмжих гол арга хэрэгсэл юм. Жил бүр 100,000 гаруй залуучууд эдгээр хөтөлбөрт хамрагдаж, нийгэмд хувь нэмрээ оруулахын зэрэгцээ өөрийн мэргэжлийн чиг баримжааг тодорхойлж, нийгмийн ур чадвараа хөгжүүлдэг. FSJ болон FÖJ нь ихэвчлэн 12 сар үргэлжилдэг бөгөөд оролцогчдыг нийгмийн даатгал, тэтгэлэгт хамрагдах боломжоор хангадаг.

Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал. Хүүхэд, залуучуудын эрүүл мэндийн талаарх Холбооны бодлого (Kinder- und Jugendgesundheit) нь залуучуудын бие бялдар, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэдэг. Сэтгэцийн эрүүл мэнд, дээрэлхэлтээс (bullying) урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг идэвхтэй хэрэгжүүлдэг бөгөөд нэн ялангуяа Ковид-19 цар тахлын дараагаас эхлэн залуучуудын сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд онцгой

анхаарал хандуулж байгаа аж. Мөн ХЗХБтХ-аар хүүхэд, залуучуудын сайн сайхан байдлыг хамгаалах тогтолцоог бэхжүүлж, хүүхдийн эмнэлэг, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэмэгдүүлжээ.

Тэгш хүртээмж. ХЗХБтХ-ийн шинэчлэлээр хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг нийгмийн амьдралд тэгш хамруулах, нийгмийн эмзэг бүлгийн залуучуудад бие дааж амьдрахад туслах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг. Нийгмийн хамгааллын салбар хуулиудын VIII номын 13 дугаар зүйлд заасан нийгмийн хамгаалал шаардлагатай залуучуудын тусламжийн тогтолцоо (Jugendsozialarbeit) нь залуучуудын нийгмийн эмзэг бүлгийг дэмжих чухал механизм юм.

Орон сууц, амьдралын орчин. Залуучуудын орон сууцны асуудал нь Германд нийгмийн чухал сэдэв болсон бөгөөд ялангуяа том хотуудад залуучуудын орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Нийгмийн хамгааллын салбар хуулиудын VIII номын 13.3-р зүйлд зорилтот бүлгийн залуучуудад нийгмийн бүрэн тусламж, дагалдах үйлчилгээ (betreutes Jugendwohnen) үзүүлэхийг заасан. Мөн 27 нас хүртэлх залуучуудад тусгайлсан дэмжлэг (Hilfen für junge Volljährige) үзүүлэх боломжтой бөгөөд ХЗХБтХ-аар энэ заалтыг бэхжүүлсэн.

Залуучуудын ажил эрхлэлтийн хөтөлбөрүүд. Залуучуудыг бэхжүүлэх (JUGEND STÄRKEN) хөтөлбөр нь нийгмийн эмзэг бүлгийн 12–26 насны залуучуудад чиглэсэн бөгөөд сургуулиас ажлын байранд шилжихэд нь тусалдаг. Уг хөтөлбөрийн үргэлжлэл болох "JUGEND STÄRKEN im Quartier" дэд хөтөлбөр нь хотын орлого багатай бүсүүд дэх залуучуудад ганцаарчилсан зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, нийгмийн ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн бөгөөд Европын Нийгмийн Сангаас санхүүждэг байна.

Ардчилал, эрх зүйн боловсрол. Ардчиллаар амьдрах! ("Demokratie leben!") хөтөлбөр нь залуучуудын дунд ардчиллын үнэт зүйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн Холбооны засгийн газрын томоохон хөтөлбөр юм. 2015 оноос хэрэгжиж эхэлсэн уг хөтөлбөр нь 2020-2024 оны хоёрдугаар үеийн санхүүжилтээр жилд 182 сая еврогийн санхүүжилттэйгээр 200 гаруй төслийг дэмжиж, хэрэгжүүлжээ. Харин 2025 онд эхэлсэн 3-р үеийн санхүүжилтээр (2025-2032) ойролцоогоор 580 төслийг дэмжихээр төлөвлөжээ.

Олон улсын хамтын ажиллагаа. Герман-Франц, Герман-Польш, Герман-Израиль зэрэг хоёр талт залуучуудын солилцооны хөтөлбөрүүд нь ХБНГУ-ын залуучуудын хөгжлийн бодлогын олон улсын хэмжээний нэг чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Erasmus+ хөтөлбөрийн хүрээнд жил бүр мянга мянган залуучууд Европын бусад улсуудтай солилцоонд хамрагддаг байна.

Цахим орчин, мэдээллийн аюулгүй байдал. Тус улсын залуучуудын хамгааллын тогтолцоонд цахим орчны аюулгүй байдал чухал байр суурь эзэлдэг. залуучуудыг хор хөнөөлтэй контентоос хамгаалах зорилготой "Залуучуудын хэвлэл мэдээллийн хамгааллын гэрээ" (Jugendmedienschutz-Staatsvertrag) хэмээх баримт бичгийг боловсруулсан бөгөөд энэ нь 2024 оноос шинэчлэгдсэн хэлбэрээр мөрдөгдөж байна.

1.4. Залуучуудын нөлөөллийн үнэлгээ (Jugend-Check)

ХБНГУ нь залуучуудын нөлөөллийн үнэлгээ (Jugend-Check)-ний тогтолцоог нэвтрүүлсэн цөөн тооны улсуудын нэг юм. 2017 онд байгуулагдсан Залуучуудын нөлөөллийн үнэлгээний чадавхийн төв (Kompetenzzentrum Jugend-Check) нь Германы төрийн удирдлагын судалгааны хүрээлэн (Forschungsinstitut für öffentliche Verwaltung)-гийн дэргэд ажилладаг бие даасан нэгж бөгөөд Холбооны засгийн газрын хууль тогтоомжийн

төслүүдийн 12–27 насны залуучуудад үзүүлэх нөлөөг шинжилж, үнэлгээний тайлан гаргадаг.²⁵

Уг төв нь хоёр үе шаттайгаар үнэлгээг хэрэгжүүлдэг. Нэгдүгээр шатанд preliminary assessment буюу хуулийн төсөл залуучуудад нөлөөлөх эсэхийг урьдчилан үнэлж, хэрэв нөлөөтэй бол хоёрдугаар шатны main assessment буюу дэлгэрэнгүй шинжилгээ хийдэг. Дэлгэрэнгүй шинжилгээнд залуучуудын амьдралын зургаан хүрээ (боловсрол, ажил мэргэжил, гэр бүл, эрүүл мэнд, чөлөөт цаг, нийгмийн оролцоо) болон арван нэгэн нөлөөллийн хэмжигдэхүүнийг ашигладаг. Энэхүү бүтэцлэгдсэн арга зүй нь хуулийн төслийн зорилтот ба зорилтот бус нөлөөллийг аль алиныг нь тодорхойлох боломжийг олгодог.²⁶

Европын Нийгэм, Эдийн засаг хөгжлийн байгууллага (OECD)-ын судалгаагаар зөвхөн Австри, Франц, Шинэ Зеланд зэрэг улсууд ХБНГУ-тай адил залуучуудын урьдчилсан (ex-ante) зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ хэрэгжүүлдэг бөгөөд Европын Холбооны түвшинд ч уг үнэлгээг (EU Youth Test) нэвтрүүлэх асуудал 2022 оноос хойш идэвхтэй хэлэлцэгдэж байна. Залуучуудын үнэлгээний төв нь 2023 оноос хойш тогтмол санхүүжилттэй болсноор институцийн тогтвортой байдлыг баталгаажуулах чухал алхам болжээ.²⁷

1.5. Бие даасан залуучуудын бодлого (Eigenständige Jugendpolitik)

2010-аад оноос хойш ХБНГУ-д залуучуудын хөгжлийн бодлогыг “бие даасан залуучуудын бодлого” (Eigenständige Jugendpolitik) хэмээн тодорхойлж, салбар хоорондын уялдаа холбоотойгоор хэрэгжүүлж эхэлсэн байна. 14 дүгээр Хүүхэд, залуучуудын тайланд (14. Kinder- und Jugendbericht) залуучуудыг бие даасан амьдралын үе шат (Lebensphase Jugend) хэмээн хүлээн зөвшөөрч, гурван үндсэн бэрхшээлд анхааралаа хандуулсан. Үүнд амьдралын чадвар эзэмших (Qualifizierung), нийгэмд өөрийн байр суурийг олох (Selbstpositionierung), бие дааж хариуцлага хүлээх чадвартай болох (Verselbständigung) гэсэн гурван чиглэл багтана.²⁸

Холбооны засгийн газраас баталдаг Залуучуудын стратеги (Jugendstrategie) нь энэхүү бие даасан залуучуудын бодлогын үзэл баримтлалд суурилсан бөгөөд 12–27 насны бүх залуучуудад чиглэгддэг. Уг стратеги нь есөн үйл ажиллагааны чиглэлтэй ба залуучуудыг тэдэнд нөлөөлөх бүх шийдвэрт идэвхтэй оролцуулахыг зорьдог. Тус стратеги нь тогтмол шинэчлэгддэг баримт бичиг ба 2024 онд залуучуудын оролцооны үр дүнтэй хэлбэрүүдийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, 2025 оны эхээр анхны үр дүнг нийтэлжээ.²⁹

²⁵Kompetenzzentrum Jugend-Check (KomJC). About the Youth-Check. Deutsches Forschungsinstitut für öffentliche Verwaltung [Германы Төрийн удирдлагын судалгааны хүрээлэн], Speyer. <https://jugend-check.de/english/> (сүүлд үзсэн: 2026 оны 5 дугаар сар).

²⁶European Commission / EACEA / Youth Wiki (2024). Youth mainstreaming, youth impact assessment and youth checks. A comparative overview. Luxembourg: Publications Office of the European Union. ISBN: 978-92-9484-561-8.

²⁷OECD (2020). Governance for Youth, Trust and Intergenerational Justice: Fit for All Generations? OECD Public Governance Reviews, OECD Publishing, Paris. <https://doi.org/10.1787/c3e5cb8a-en>

²⁸Youth Wiki, Germany: National Youth Strategy and the concept of Eigenständige Jugendpolitik. European Commission / EACEA, 2025. <https://national-policies.eacea.ec.europa.eu/youthwiki/chapters/germany/13-national-youth-strategy>

²⁹Bundesministerium für Familie, Senioren, Frauen und Jugend (BMFSFJ) (2019). Jugendstrategie der Bundesregierung – In gemeinsamer Verantwortung für ein jugendgerechtes Deutschland [Холбооны засгийн газрын Залуучуудын стратеги: Залуучуудад ээлтэй Германы төлөөх хамтын хариуцлага]. Berlin.

ХБНГУ-ын залуучуудын бодлогын нэг онцлог давуу тал нь нотолгоонд суурилсан бодлого (evidence-based policy)-ын хандлага юм. Холбооны Засгийн газраас тогтмол Хүүхэд, залуучуудын тайлан (Kinder- und Jugendbericht)-г парламентад танилцуулдаг бөгөөд энэ нь бие даасан шинжээчдийн бэлтгэсэн, залуучуудын бодит нөхцөл байдлыг тусгасан чухал суурь баримт бичиг юм. Хамгийн сүүлд 17 дахь тайланг 2024 онд нийтэлсэн байна.³⁰

Хоёр. Бүгд найрамдах Хятад ард улс (БНХАУ)

2.1. Эрх зүйн зохицуулалт

БНХАУ нь Залуучуудын Засаглалын Индексээр яам/агентлаг, үндсэн хуулийн заалт, стратеги, хууль, бодлого гэсэн шалгууруудаар харьцангуй өндөр оноо авчээ. БНХАУ-ын залуучуудын хөгжлийн бодлогын гол баримт бичиг нь 2017 оны 4 дүгээр сард Хятадын Коммунист намын төв хороо, Төрийн зөвлөлөөс баталсан “Дунд болон урт хугацааны залуучуудын хөгжлийн төлөвлөгөө (2016–2025)” (中长期青年发展规划) юм.³¹

Энэхүү төлөвлөгөөг Шинэ Хятадын түүхэнд залуучуудын хөгжилд зориулсан анхны улсын түвшний тусгай төлөвлөгөө гэж үздэг ба залуучуудын хөгжлийн бодлогод чиглэсэн удирдамж баримт бичгийн шинж чанартай. Төлөвлөгөөнд залуучуудын насыг 14–35 хэмээн тодорхойлжээ.

Үүнээс гадна БНХАУ-д Насанд хүрээгүй хүмүүсийн хамгаалалтын тухай хууль (未成年人保护法, 2020 онд шинэчлэгдсэн), Насанд хүрээгүй хүмүүсийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх тухай хууль (预防未成年人犯罪法) зэрэг хуулиуд хэрэгждэг бөгөөд эдгээр нь 18 нас хүртэлх хүмүүсийг эрх зүйн хамгаалалтад тэгш хамруулахад чиглэдэг.

2.2. Залуучуудын хөгжлийн үндсэн чиглэл

БНХАУ-ын залуучуудын хөгжлийн төлөвлөгөө нь дараах арван үндсэн чиглэлийг хамарна:³²

1) Үзэл суртал, ёс суртахуун – нийгмийн үнэт зүйл, эх оронч үзлийг бэхжүүлэх. Хятадын онцлог социализмын үнэт зүйлийг залуучуудад төлөвшүүлэх нь энэ чиглэлийн гол агуулга байна:

2) Боловсрол – боловсролын тэгш байдлыг хангах, шинэ ажиллах хүчний дундаж боловсролын хугацааг 13.5 жил, дээд боловсролын хамрагдалтыг 50 хувиас дээш байлгахыг гол зорилт болгодог. 2022 оны байдлаар дээд боловсролын хамрагдалт 59.6 хувьд хүрсэн нь зорилтот түвшнээс давсан үзүүлэлттэй гарчээ;

³⁰Bundesministerium für Familie, Senioren, Frauen und Jugend (2017). 15. Kinder- und Jugendbericht – Bericht über die Lebenssituation junger Menschen und die Leistungen der Kinder- und Jugendhilfe in Deutschland [Германы Хүүхэд, залуучуудын 15 дахь тайлан]. Berlin.

³¹中共中央、国务院 [Хятадын Коммунист Намын Төв хороо, БНХАУ-ын Төрийн зөвлөл] (2017). 中长期青年发展规划 (2016–2025 年) [Залуучуудын дунд болон урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө (2016–2025)]. Бээжин, 2017 оны 4 дүгээр сарын 13.

³²State Council Information Office of the People's Republic of China (2022). Youth of China in the New Era. White Paper. Бээжин, 2022 оны 4 дүгээр сарын 21. <http://english.scio.gov.cn/whitepapers/>

3) Эрүүл мэнд – залуучуудын бие бялдар, сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулахыг гол зорилт болгодог. Залуучуудын эрүүл мэндийн даатгалын хамрагдалт 95 хувиас дээш үзүүлэлттэй гарчээ;

4) Соёл – соёлын хөгжлийг дэмжих, уламжлалт соёлыг залуучуудад түгээх, нийгмийн хэвлэл мэдээллийн зөв ашиглалтыг хөхиүлэн дэмжих;

5) Хөдөлмөр эрхлэлт, бизнес эрхлэлт – залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, гарааны бизнесийг дэмжихийг гол зорилт болгодог. “Mass Entrepreneurship and Innovation” бодлогоор залуучуудын гарааны бизнесийг идэвхтэй дэмжиж байна;

6) Нийгмийн нэгдэл – эмзэг бүлгийн залуучуудын нийгмийн оролцоог дэмжих, ялгаварлан гадуурхалтыг арилгах;

7) Хууль эрхийн хамгаалал – залуучуудын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, насанд хүрээгүй хүмүүсийн хамгаалалтыг бэхжүүлэх;

8) Нийгмийн аюулгүй байдал – залуучуудын нийгмийн хамгааллыг бэхжүүлэх, нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх;

9) Нийгмийн оролцоо – залуучуудын улс төр, нийгмийн оролцоог өргөжүүлэх;

10) Хил дамнасан солилцоо – олон улсын харилцаа, солилцооны хөтөлбөрүүдийг хөгжүүлэх, Бүс, замын санаачилга зэрэг төслүүдэд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх.

Монгол Улсын ЗХДТХ-ийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан таван чиглэлтэй (хувь хүний хөгжил; боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан; эрүүл мэнд; хөдөлмөр эрхлэлт; аюулгүй амьдрах, хөгжих орчин) харьцуулахад БНХАУ-ын арван чиглэл нь хамрах бөгөөд хүрээний хувьд илүү өргөн хэмжээнд тогтоосон бөгөөд ялангуяа цахим орчин, олон улсын солилцоо, нийгмийн аюулгүй байдал зэрэг чиглэлүүдийг тусдаа ангилж тусгасан нь ажиглагдаж байна.³³

2.3. Бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо

БНХАУ-ын залуучуудын бодлогын хэрэгжилтийг зохицуулах Яам хоорондын хамтарсан хурлын механизм (部际联席会议) бий бөгөөд Коммунист Залуучуудын Эвлэлийн Төв хороо (共青团中央) нь уг асуудлаар зохицуулах, хянах үүргийг хүлээдэг. Энэхүү механизм нь 45 гаруй яам, агентлаг, байгууллагын хамтын оролцооноос бүрддэг бөгөөд муж, хот, шүүхийн түвшинд ч ижил зохицуулалтын механизм ажилладаг байна.³⁴

Бүх Хятадын Залуучуудын Нэгдсэн Холбоо (中华全国青年联合会) нь залуучуудын оролцооны гол байгууллага бөгөөд төрийн бодлогод залуучуудын дуу хоолойг хүргэх, залуучуудын эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэй. Мөн Залуучуудын тэтгэлэгийн сан (China Youth Development Foundation) нь “Найдварын хөтөлбөр” (Project Hope) зэрэг том хэмжээний хөтөлбөрүүдээр хөдөө, нэн ядуу бүс нутгийн залуучуудын боловсролыг

³³ Монгол Улсын Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан. Төрийн мэдээлэл сэтгүүл, 2017 №21. 2021, 2022, 2023 оны нэмэлт, өөрчлөлттэйгээр.

³⁴ БНХАУ-ын Залуучуудын дунд болон урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх Яам хоорондын хамтарсан хурлын механизм (中长期青年发展规划实施工作部际联席会议) нь 51 яам, агентлагийн оролцоотойгоор зохион байгуулагддаг.

дэмжсээр иржээ. 1989 оноос хэрэгжиж эхэлсэн Найдварын төсөл нь нийт 6 сая залуу сурагчдад тусалж, 20,000 гаруй сургууль барихад хувь нэмрээ оруулсан байна.³⁵

Яам хоорондын зохицуулалтын механизмын нэг онцлог нь хэрэгжилтийн тайлагналтын тогтолцоо юм. Муж, хот, шүүхийн бүх түвшинд залуучуудын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг жилд нэг удаа дээд шатны засаг захиргааны байгууллагад тайлагнах үүрэгтэй. Мөн залуучуудын хөгжлийн статистикийн үзүүлэлтийг үндэсний статистикийн тогтолцоонд оруулж, тоон мэдээлэлд суурилсан хяналтын тогтолцоог бүрдүүлсэн. Энэхүү дээрээс доош чиглэсэн хяналтын тогтолцоо нь БНХАУ-ын төрийн удирдлагын онцлогтой нийцсэн бөгөөд хэрэгжилтийн хариуцлагыг хангахад үр дүнтэй гэж үнэлэгддэг.

БНХАУ-ын залуучуудын бодлогын бас нэг онцлог нь арван тусгай төсөл (项目) юм. Эдгээр нь: 1) Залуучуудын марксист үзэл суртлын хүмүүжлийн төсөл; 2) Залуучуудын соёл боловсролын төсөл; 3) Залуучуудын эрүүл мэндийн төсөл; 4) Залуучуудын бизнес эрхлэлтийг дэмжих төсөл; 5) Залуу шинжлэх ухаантныг хөгжүүлэх төсөл; 6) Залуучуудын интернет дэх эерэг орчинг бүрдүүлэх төсөл; 7) Залуучуудын нийгмийн оролцооны төсөл; 8) Залуучуудын хууль эрхийн хамгаалалтын төсөл; 9) Залуучуудын сайн дурын үйлчилгээний төсөл; 10) Хил дамнасан залуучуудын солилцооны төсөл зэрэг болно. Эдгээр төсөл нь арван чиглэл хоорондын уялдаа холбооны үндсэн дээр хэрэгждэг бөгөөд тодорхой зорилт, хариуцах байгууллага, санхүүжилтийн эх үүсвэртэй.

Хэрэгжилтийн нэг чухал үзүүлэлт нь залуучуудын бодлогын үйлчилгээний цэг (青年之家 – Youth Home) байгуулсан явдал юм. 2022 оны байдлаар улс даяар 130,000 гаруй Youth Home ажиллаж байгаа бөгөөд эдгээр нь залуучуудад мэдээлэл, зөвлөгөө, хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэг, сэтгэл зүйн тусламж зэрэг үйлчилгээ үзүүлдэг. Энэ нь Монгол Улсын аймаг, нийслэлийн Залуучуудын хөгжлийн төвтэй (ЗХДТХ-ийн 24 дүгээр зүйл) төстэй зорилготой боловч хамрах хүрээ, хүртээмжийн хувьд эрс ялгаатайг дурдах нь зүйтэй.

Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх механизмыг тусгайлан бий болгосон бөгөөд бүх шатны засаг захиргааны нэгж залуучуудын ажлыг өндөр ач холбогдол өгч, хэрэгжилтийн тайланг тогтмол гаргадаг. 2022 онд Коммунист Залуучуудын Эвлэлийн төв хорооноос нийтэлсэн хэрэгжилтийн тайлангаас харахад тус төлөвлөгөө нь залуучуудын боловсрол, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд зэрэг чиглэлээр бодит үр дүнд хүрч байгааг тэмдэглэсэн.³⁶

Гурав. Оросын Холбооны улс (ОХУ)

3.1. Эрх зүйн орчны ерөнхий тойм

ОХУ нь Залуучуудын Засаглалын Индексээр 3.4/7 оноо авсан бөгөөд 2020 оны 12 дугаар сарын 30-нд батлагдсан "Оросын Холбооны Улсын залуучуудын бодлогын тухай" Холбооны хууль (Федеральный закон № 489-ФЗ) нь ОХУ-ын залуучуудын бодлогын гол хууль юм. Энэ хууль нь 2021 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон

³⁵ 中华全国青年联合会 [Бүх Хятадын Залуучуудын Нэгдсэн Холбоо]. Албан ёсны цахим хуудас. БНХАУ-ын залуучуудын төлөөллийн дээд байгууллага бөгөөд 56 үндэстэн, ястан, нийгмийн бүх давхаргын залуучуудын төлөөллөөс бүрддэг.

³⁶ 共青团中央 [БНХАУ-ын Коммунист Залуучуудын Эвлэлийн Төв Хороо] (2022). 中长期青年发展规划实施情况报告 [Залуучуудын дунд болон урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан]. Бээжин.

бөгөөд ЗХУ-ын уналтаас хойших 30 гаруй жилийн хугацаанд залуучуудын бодлогын чиглэлээр батлагдсан анхны холбооны түвшний бие даасан хууль юм.³⁷

Түүнчлэн ОХУ-ын Үндсэн хуульд 2020 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийн 72 дугаар зүйлд залуучуудын бодлогын асуудлыг тусгайлан нэмж тусгаснаар залуучуудын бодлогыг үндсэн хуулийн түвшинд хүлээн зөвшөөрсөн анхны алхам болсон. Энэхүү 72 дугаар зүйлд залуучуудын бодлогыг хүмүүжил, боловсрол, нийгмийн дэмжлэгийг хамруулан Холбооны болон бүс нутгийн хамтарсан эрх мэдлийн асуудал болгожээ.³⁸

Зөвлөлт Холбоот Улсын үед залуучуудын бодлого нь Коммунист Залуучуудын Эвлэл (Комсомол)-ийн хүрээнд хэрэгжиж байсан бол 1991 оноос хойш энэхүү тогтолцоо задарч, залуучуудын бодлого нь удаан хугацааны турш хуулийн бүрэн зохицуулалтгүй явсаар 1995 онд “Залуучуудын болон хүүхдийн нийгмийн нэгдлийг төрөөс дэмжих тухай” Холбооны хууль (№ 98-ФЗ)-ийг баталсан боловч уг хуулийн хамрах хүрээ харьцангуй хязгаарлагдмал байсан тул 2020 оны “Оросын Холбооны Улсын залуучуудын бодлогын тухай” хууль нь энэ салбарт чухал дэвшил болсон гэж үздэг.

3.2. Хуулийн зорилго, зарчим

Оросын Холбооны Улсын залуучуудын бодлогын тухай хуулийн зорилт нь залуучуудын бодлогын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй субъектуудын хоорондын харилцааг зохицуулж, залуучуудын бодлогын зорилго, зарчим, үндсэн чиглэл, хэрэгжүүлэх хэлбэрийг тодорхойлоход оршино. Хуулиар залуучуудыг 14–35 насны иргэд гэж тодорхойлсон бөгөөд 2020 оноос өмнө 14–30 нас гэж тогтоосон байсныг нэмэгдүүлсэн. Ийнхүү насны хазгаарыг нэмэгдүүлсэн нь илүү олон залуучуудыг хуулийн хамгаалалтад хамруулах зорилготой байжээ.

Залуучуудын бодлогын зорилго нь: а) Залуучуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах; б) Оюун санааны, соёлын, оюуны, сэтгэл зүйн, мэргэжлийн, нийгмийн болон бие бялдрын хөгжлийг нэмэгдүүлэхэд тэгш нөхцөлөөр хангах; в) Залуучуудын улс төр, нийгэм-эдийн засаг, шинжлэх ухаан, спорт, соёлын амьдралд оролцох нөхцөлийг бүрдүүлэх; г) Үндэсний болон шашны зөвшилцлийг дэмжих; д) Гэр бүлийн харилцааны соёлыг бий болгох, залуу гэр бүлийг дэмжих зэрэг болно. Хуулиар “залуу гэр бүл” гэж 35 хүртэлх насны гэрлэгчид бүхий гэр бүлийг, “залуу мэргэжилтэн” гэж 35 хүртэлх насны, мэргэжлийн боловсролтой, анх удаа ажилд орж буй иргэнийг тусгайлан тодорхойлсон байна.

3.3. Бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо

ОХУ-ын залуучуудын бодлогын тогтолцоо нь Холбооны, бүс нутгийн (субъект), орон нутгийн зэргэсэн гурван түвшинд хуваагддаг. Холбооны түвшинд Залуучуудын асуудал эрхэлсэн Холбооны агентлаг (Росмолодежь) нь залуучуудын бодлогыг хэрэгжүүлэх гол байгууллага юм. Уг институци нь 2008 онд бие даасан агентлаг болж байгуулагдсан бөгөөд 2018 оноос Засгийн газарт шууд харьяалагддаг болсноор тус агентлагийн бие даасан байдал, статус нэмэгджээ.³⁹

³⁷ Федеральный закон от 30 декабря 2020 г. № 489-ФЗ «О молодежной политике в Российской Федерации» [ОХУ-ын Холбооны хууль 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн №489-ФЗ «Оросын Холбооны Улсын залуучуудын бодлогын тухай»]. Российская газета, 2020.12.31, № 296 (8350).

³⁸ Конституция Российской Федерации (1993, 2020 оны нэмэлт, өөрчлөлттэй) [ОХУ-ын Үндсэн хууль], 72 дугаар зүйлийн 1-ийн «е¹» хэсэг: «залуучуудын бодлогын ерөнхий асуудлууд».

³⁹ Федеральное агентство по делам молодежи (Росмолодежь) [Залуучуудын асуудал эрхэлсэн Холбооны агентлаг]. Албан ёсны цахим хуудас: <https://fadm.gov.ru/>. ОХУ-ын Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн №724 тоот зарлигаар бие даасан агентлаг болгож шинэчилсэн.

Залуучуудын асуудал эрхэлсэн Холбооны агентлаг төсөв сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц нэмэгдсэн байдаг. Тухайлбал, 2019 онд төсвийг 7 дахин нэмэгдүүлж ойролцоогоор 42 сая ам.долларт хүргэсэн бол 2024 онд залуучуудын бодлогын нийт төсвийн 96 хувь буюу 54 тэрбум рублиас дээш хөрөнгийг тус агентлаг захиран зарцуулсан байна.⁴⁰

Хуулиар залуучуудын бодлогыг хэрэгжүүлэгч субъектуудад: залуучууд, залуу гэр бүл, залуучуудын нийгмийн нэгдэл, Холбооны засгийн газрын байгууллагууд, бүс нутгийн засаг захиргааны байгууллагууд, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд, иргэний нийгмийн институцууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, иргэд зэрэг олон талт оролцогчид хамаарна. Бүс нутгийн түвшинд 85 субъект тус бүр залуучуудын бодлогын хэрэгжилтийг хариуцдаг бөгөөд тус тусын хууль тогтоомж, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлдэг байна.

3.4. Бодлогын үндсэн чиглэлүүд

Залуучуудын бодлогын тухай хуулийн 6 дугаар зүйлд залуучуудын бодлогыг хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлсон. Үүнд: боловсрол, хүмүүжлийг дэмжих; мэдээлэл түгээх; эрүүл мэндийг хамгаалах; хөдөлмөр эрхлэлтийг дэмжих; бизнес эрхлэлтийг дэмжих; нийгмийн оролцоог хөгжүүлэх; залуу гэр бүлийг дэмжих; олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг чиглэлүүд багтана.⁴¹

Түүнчлэн 2024 оны 8 дугаар сарын 17-нд Засгийн газрын тогтоолоор "Оросын Холбооны Улсын залуучуудын бодлогын хэрэгжүүлэх стратеги 2030 он хүртэл" хэмээх урт хугацааны хөгжлийн баримт бичгийг баталжээ. Энэхүү стратеги нь залуучуудын бодлогыг 2030 он хүртэл хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ, хариуцах байгууллага, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон.⁴²

Энэ хүрээнд Залуучуудын асуудал эрхэлсэн Холбооны агентлагаас боловсруулсан голлох хөтөлбөрүүдийн нэг болох "Бүх Оросын залуучуудын амжилтын шагнал" (Время молодых) буюу жил бүрийн залуучуудын бодлогын шилдэг төслийг шалгаруулах шагнал; "Залуучуудын нийслэл" (Молодежная столица России) буюу залуучуудын бодлогоор тэргүүлэгч хотыг жил бүр сонгох; олон нийтийн форум зэргийг зохион байгуулдаг.

Залуучуудын асуудал эрхэлсэн Холбооны агентлагаас хэрэгжүүлдэг хөтөлбөрүүд дотроос "Росмолодежь.Гранты" (Rosmolodezh.Grants) буюу агентлагийн нэрэмжит грант шалгаруулах хөтөлбөр нь залуучуудын санаачилгыг дэмжих гол арга хэрэгсэл болдог. Жил бүр 10,000 гаруй төсөлд грант олгодог бөгөөд грантын хэмжээ 100,000-аас 1.5 сая рубль хүртэл сантай байна. Гол төлөв боловсрол, шинжлэх ухаан; нийгмийн оролцоо; бизнес эрхлэлт; соёл, урлаг; экологи; эх оронч хүмүүжил зэрэг чиглэлээр грант олгодог. Энэхүү грантын тогтолцоо нь залуучуудын санаачилгыг дотроос дээшээ чиглэлд дэмжих арга хэрэгсэл боловч грантын шалгуур, сонгон шалгаруулалтын ил тод байдал нь шүүмжлэлд өртдөг байна.

Мөн ОХУ-ын залуучуудын бодлогын нэг онцлог нь "Залуу Арми" (Юнармия) хөтөлбөр юм. 2016 онд байгуулагдсан энэ хөтөлбөр нь 8–18 насны хүүхэд, залуучуудад цэргийн-эх

⁴⁰Almenda Center for Civic Education (2024). Funding youth policy in Russia through the prism of the war in Ukraine. <https://almenda.org/en/finansuvannya-molodizhnoi-politiki-v-rosii/>

⁴¹Youthpolicy.org (2024). Russia Country Factsheet. Youth Policy Press. <https://www.youthpolicy.org/factsheets/country/russia> (сүүлд үзсэн: 2026 оны 5 дугаар сар).

⁴²Распоряжение Правительства Российской Федерации от 17 августа 2024 г. № 2233-р «Об утверждении Стратегии реализации молодежной политики в Российской Федерации на период до 2030 года» [ОХУ-ын Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн №2233-р тоот тогтоол].

оронч хүмүүжил олгох зорилготой бөгөөд 2024 оны байдлаар 1.3 сая гаруй элсэгтэй болжээ. Олон улсын байгууллагуудын зүгээс уг хөтөлбөрийг залуучуудыг улс төрийн зорилгоор ашиглаж буйн илрэл гэж шүүмжлэгддэг боловч ОХУ-ын Засгийн газар үүнийг залуучуудын хувь хүний хөгжил, эх оронч сэтгэлгээ төлөвшүүлэх чухал арга хэрэгсэл гэж үздэг байна.⁴³

Түүнчлэн 2022 оноос хойш ОХУ-д "Нэгдүгээр хөдөлгөөн" (Движение первых) нэртэй шинэ залуучуудын хөдөлгөөн байгуулагдсан бөгөөд энэ нь 6–18 насны хүүхэд, залуучуудын нийгмийн оролцоог дэмжих зорилготой. 2024 оны байдлаар 6 сая гаруй гишүүнтэй болжээ. Энэхүү хөдөлгөөний зорилго нь залуучуудыг нийгэмд идэвхтэй оролцуулах, сайн дурын ажилд хамруулах, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд оршино. Монгол Улсын хувьд ЗХДТХ-ийн 13 дугаар зүйлд заасан нийгмийн оролцоог дэмжих чиглэлтэй холбон авч үзэх боломжтой боловч бүтэц, агуулгын хувьд ялгаатай.

Дөрөв. Сингапур улс

Сингапур Улс залуучуудын хөгжлийн бодлогоо тодорхойлохдоо зөвхөн эрх зүйн зохицуулалт бус, цогц тогтолцооны загвар, төрийн санхүүжилт, иргэний нийгмийн оролцоо, нотолгоонд суурилсан бодлого боловсруулалт зэрэг олон талт арга барилыг баримталдаг онцлогтой.⁴⁴

Тус улсын хувьд залуучуудыг дэмжих бодлогын чиглэлээр бие даасан хууль батлаагүйгээрээ харьцуулсан судалгааны хүрээнд судалсан бусад орнуудаас ялгаатай. Бие даасан хуулийн оронд Сингапур Улс нь Үндэсний Залуучуудын Зөвлөл (National Youth Council), Соёл, нийгмийн хамтын ажиллагаа, залуучуудын асуудал эрхэлсэн яам (Ministry of Culture, Community and Youth), бодлогын баримт бичгүүд (SG Youth Action Plan, SG Youth Plan), цогц хөтөлбөрүүд (SkillsFuture, Youth Corps, Outward Bound Singapore) зэргийг хослуулсан загвараар залуучуудын хөгжлийг дэмждэг байна.⁴⁵

4.1. Залуучуудын хөгжлийг дэмжих институциуд байгуулагдаж эхэлсэн үе

1988 оны 2 дугаар сард тухайн үеийн Дэд Ерөнхий сайд Гох Чок Тонг (Goh Chok Tong) бригадын генерал Ли Шиэн Лун (Lee Hsien Loong)-аар тэргүүлүүлэн Залуучуудын Зөвлөл Зөвлөл (Advisory Council on Youth)-ийг байгуулжээ. Тус Зөвлөлийн зорилго нь залуу сингапурчуудын сонирхол, хэрэгцээ, эрмэлзлийг судлах, тэдний боломжийг тэлэхийн төлөө хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрийн санал боловсруулах байв. Нэг жилийн дотор тус Зөвлөл нь Засгийн газарт залуучуудыг дэмжих дөрвөн чиглэл бүхий саналыг хүргүүлсэн бөгөөд гол санал нь Үндэсний Залуучуудын Зөвлөл (цаашид ҮЗЗ гэх)-ийг бие даасан статустайгаар байгуулах тухай байжээ.⁴⁶

Улмаар 1989 оны 11 дүгээр сарын 1-нд ҮЗЗ нь Ардын Холбоо (People's Association)-ны нэг хэлтэс болж байгуулагдсан. ҮЗЗ нь засгийн газрын яам, хууль ёсны зөвлөл, залуучуудын байгууллагуудаас бүрдсэн гишүүдтэй байсан бөгөөд анхны даргаар тухайн үеийн Эрүүл мэндийн сайдын үүрэг гүйцэтгэгч Йео Чёов Тонг (Yeo Cheow Tong) томилогджээ. Эхэн үед ҮЗЗ-ийн үзүүлэх нөлөө хязгаарлагдмал байсан тул 1993 онд

⁴³Freedom House (2019). Russia's War on Youth: Repressing Civic Engagement and Independent Activism. Freedom House Special Report. <https://freedomhouse.org/article/russias-war-youth>

⁴⁴National Library Board (NLB) Singapore Infopedia. "National Youth Council." <https://www.nlb.gov.sg/main/article-detail?cmsuuid=e541c0e3-ece9-4543-a8bf-e697294ae26c> (сүүлд үзсэн: 2026.05).

⁴⁵Monti, L., Cioffi, C., Ghazi Zarshoi, H., & Lutringer, C. (January 2025). "Mapping youth policies across 32 countries: Legal frameworks and strategies for education, employment, and well-being." AHCD Working Paper No. 4, Albert Hirschman Centre on Democracy, Geneva Graduate Institute, Geneva. <https://www.graduateinstitute.ch/sites/default/files/2025-01/AHCD-Working-Paper-No-4.pdf>

⁴⁶National Library Board (NLB) Singapore Infopedia, op. cit.

Ерөнхий сайд Гох Чок Тонг ҮЗЗ-ийг олон нийтэд илүү танигдаж, нөлөөгөө нэмэгдүүлэхийг уриалсан байна.⁴⁷

1996 онд Үндэсний Залуучуудын Төв (National Youth Centre) болон Залуучуудын Цэцэрлэгт хүрээлэн (Youth Park)-г албан ёсоор нээснээр залуучуудад зориулсан анхны нэгдсэн орон зайг бий болгосон бөгөөд дотор нь залуучуудад зориулсан танхим, залуучуудын байгууллагуудад зориулсан үйл ажиллагааны байрыг байгуулж өгчээ.⁴⁸

2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ҮЗЗ нь Ардын Холбооноос тусгаарлагдан Соёл, нийгмийн хамтын ажиллагаа, залуучуудын асуудал эрхэлсэн яамны харьяа бие даасан агентлаг (autonomous agency)-ийн хэмжээнд шинэчлэн зохион байгуулагджээ. Энэхүү бүтцийн өөрчлөлтөөр Outward Bound Singapore буюу Сингапурын залуучуудын манлайллын хөгжлийн төв болон Youth Corps Singapore буюу Залуучуудын сайн дурынхны корпус гэсэн хоёр шинэ үйл ажиллагааны хэлтсийг ҮЗЗ-д нэгтгэсэн. Энэхүү шинэчлэл нь ҮЗЗ-ийн залуучуудын хөгжил, оролцоог дэмжих үндэсний агентлагийн чиг үүргийг бэхжүүлж, залуучуудад илүү хүрч ажиллах боломжийг өргөжүүлсэн гэж үздэг байна.⁴⁹

Харин Залуучуудын асуудал эрхэлсэн яам нь 2012 оны 11 дүгээр сарын 1-нд Засгийн газрын бүтцийн шинэчлэлийн хүрээнд Нийгмийн хөгжил, залуучууд, спортын асуудал эрхэлсэн яам (Ministry of Community Development, Youth and Sports)-ийг байгуулсан бөгөөд соёл, урлаг, өв соёлоос гадна залуучуудын бодлого, спорт, олон нийтийн оролцооны асуудлуудыг хариуцдаг байна. Яамны харьяанд Үндэсний Залуучуудын Зөвлөл (National Youth Council), Иргэдийн холбоо (People's Association), Спортын Холбоо (Sport Singapore), Үндэсний Урлагийн Зөвлөл (National Arts Council), Үндэсний Өв соёлын Зөвлөл (National Heritage Board) зэрэг 12 зөвлөл, агентлаг ажилладаг.⁵⁰

4.2. Залуучуудын хөгжлийг дэмжихэд чиглэсэн бодлогын институциуд

Соёл, нийгмийн хамтын ажиллагаа, залуучуудын асуудал эрхэлсэн яам (MCCY)

Соёл, нийгмийн хамтын ажиллагаа, залуучуудын асуудал эрхэлсэн яам нь залуучуудын бодлогыг боловсруулах, чиглүүлэх ерөнхий чиг үүрэгтэй ба тус яамны дэргэд дээр дурдсан 12 зөвлөл, агентлаг ажилладаг. Тэдгээр нь тус бүр өөрийн чиг үүрэгтэй.⁵¹ Жишээлбэл:

Үндэсний Залуучуудын Зөвлөл (NYC)

ҮЗЗ нь Сингапур Улсын залуучуудын асуудал хариуцсан үндэсний зохицуулагч агентлаг бөгөөд олон улсын залуучуудын төсөл, үйл ажиллагаанд оролцох гадаад харилцааг хөгжүүлэг чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус Зөвлөлийн алсын хараа нь "Сингапурын бүх залуучуудын дуу хоолойгоо сонсох, эрх нөлөөгөө нэмэгдүүлэх, өөрчлөлт авчрах боломжийг бий болгох" хэмээн тодорхойлсон байна. Энэ хүрээнд ҮЗЗ нь залуучуудын эрх ашгийг өмгөөлөгч (advocate), хөгжих оломжийг бүрдүүлэгч (enabler), хамтрагч (partner) гэсэн гурван үндсэн үүрэгтэйгээр ажилладаг.⁵²

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд ҮЗЗ нь дараах бүтэцтэй үйл ажиллагаа явуулдаг. Дурдвал, Залуучуудын оролцооны хэлтэс (Youth Engagement Division), Судалгаа, шинжилгээний хэлтэс (Research & Engagement Division), Сингапурын залуучуудын

⁴⁷National Library Board (NLB) Singapore Infopedia, op. cit.

⁴⁸National Library Board (NLB) Singapore Infopedia, op. cit.

⁴⁹Grokipedia. "National Youth Council." https://grokipedia.com/page/national_youth_council (сүүлд үзсэн: 2026.05).

⁵⁰ Wikipedia. "Ministry of Culture, Community and Youth." https://en.wikipedia.org/wiki/Ministry_of_Culture,_Community_and_Youth (сүүлд үзсэн: 2026.05).

⁵¹ Ministry of Culture, Community and Youth (MCCY), Singapore. "About MCCY." <https://www.mccy.gov.sg/about-us/> (сүүлд үзсэн: 2026.05).

⁵²National Youth Council Singapore, op. cit.

манлайллын хөгжлийн төв, Залуучуудын сайн дурынхны корпус, Залуучуудын хөгжлийн хэлтэс гэх зэрэг болно.⁵³

Залуучуудын хөгжлийн дэд агентлагууд:

Outward Bound Singapore буюу Сингапурын залуучуудын манлайллын хөгжлийн төв нь 1967 онд байгуулагдсан ба Пулау Убин арал дээрх бааз төв дээр үйл ажиллагаа явуулдаг, туршлагад суурилсан гадаад сургалт, манлайллын хөтөлбөрүүдийг хариуцан явуулдаг агентлаг юм. Тус төвийг 2014 онд ҮЗЗ-ийн харьяанд нэгтгэжээ

Харин Youth Corps Singapore буюу Залчуудын сайн дурынхны корпус нь 2014 онд Залуучуудын хөгжлийн яам болон ҮЗЗ-ийн санаачлагаар үүсгэн байгуулагдсан, залуучуудын сайн дурын үйл ажиллагааг тэргүүлэх үндэсний институци юм. Тус корпус нь нийгмийн оролцоотой иргэнийг төлөвшүүлэхэд гол чиг үүрэгтэй агентлаг бөгөөд залуучуудын оролцоотой, идэвхтэй байдлыг дэмжиж нийгэмд эерэг өөрчлөлт бий болгоход дэмжлэг үзүүлж чиглүүлэхэд үйл ажиллагаа нь чиглэдэг.

*SCAPE буюу Сингапурын залуучуудын бүтээлч байдлыг дэмжих төв нь 2007 онд байгуулагдсан ашгийн төлөө бус төрийн бус байгууллага бөгөөд Олон нийтийн ач холбогдол бүхий байгууллагын (Institution of a Public Character) статустай. Тус байгууллага нь залуучуудын авьяас, сонирхлыг хөгжүүлэх зорилготой бөгөөд тэдэнд хөтөлбөр, орон зай, ижил сонирхол, зорилго бүхий хүрээлэл, орчныг бүрдүүлж өгөхөд гол чиг үүрэг нь оршдог. Статистик мэдээллээс харахад 2025 оны 11 дүгээр сард шинэчлэн байгуулагдсанаас хойш *SCAPE нь жил бүр 40,000 гаруй залуучуудад бүтээлч урлаг, кино, контент бүтээх, хотын спорт, ажил мэргэжил, бизнес эрхлэлт, эрүүл амьдрал, тогтвортой байдлын чиглэлээр хамтран хөгжих, бүтээх боломжийг бүрдүүлж үйл ажиллагаа явуулжээ.⁵⁴

4.3. Бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүд

Сингапур Улсын хувьд залуучуудын хөгжлийн дэмжих бодлогын орчныг хуулиар бус хэд хэдэн хөтөлбөр, бодлогын баримт бичгүүдийн нэгдмэл хэлбэрээр бүрдүүлдэг. Голлох баримт бичгүүдийг дурдвал:

SG Youth Action Plan (SG YAP) 2025

SG Youth Action Plan (SG YAP) буюу Сингапурын Залуучуудын Үйл ажиллагааны төлөвлөгөө нь Сингапур Улсын залуучуудын бодлогын анхны системтэй баримт бичгүүдийн нэг бөгөөд 2019 оны 5 дугаар сард Залуучуудын хөгжлийн яам болон ҮЗЗ-ийн санаачлагаар эхэлсэн. Энэхүү төлөвлөгөө нь залуучуудын "дуу хоолойгоо сонсгох, эрх нөлөөгөө нэмэгдүүлэх, өөрчлөлт авчрах боломжийг бий болгох" (be heard, be empowered, be the change) гурван зарчимд суурилжээ. Уг төлөвлөгөөг боловсруулахдаа 2018 онд Залуучуудын Хэлэлцүүлгээс (Youth Conversations) гарсан 8,000 гаруй залуучуудын саналд тулгуурлан боловсруулсан.⁵⁵

Мөн уг төлөвлөгөөний хүрээнд 400,000 гаруй залуучуудыг хамруулж, 70,000 орчим залуучуудыг шууд оролцуулан Сингапурын 2025 оны алсын хараа (Youth Vision 2025)-г хамтран бүтээжээ. Алсын харааны баримт бичигт тусгасан гол төслүүдийн нэг нь дээр

⁵³National Youth Council Singapore, op. cit.

⁵⁴ Ministry of Culture, Community and Youth, Singapore (9 November 2025). "SCAPE relaunch." <https://www.mccy.gov.sg/about-us/news-and-resources/scape-relaunch/>

⁵⁵ Ministry of Culture, Community and Youth, Singapore (1 July 2019). "Youths come together under SG Youth Action Plan to envision future of Singapore." <https://www.mccy.gov.sg/about-us/news-and-resources/youths-come-together-under-sg-youth-action-plan-to-envision-future-of-singapore/>

дурдсан Сомерсетийн бүсийг (Somerset Belt) залуучуудын олон талт, нэгдмэл орон зай болгон өөрчлөн зохион байгуулсан явдал байв.⁵⁶

SG Youth Plan (SGYP) – SG60-ийг тохиолдуулсан 5 жилийн төлөвлөгөө

Сингапур Улсын тусгаар тогтнолын 60 жилийн ой (SG60, 2025)-г тохиолдуулан Залуучуудын хөгжлийн яам болон ҮЗЗ нь Иргэдийн Холбоо (People's Association)-той хамтран SG Youth Plan (SGYP) буюу Сингапурын Залуучуудын төлөвлөгөөг боловсруулж байна. Тус төлөвлөгөө нь залуучууд өөрсдөө болон залуучуудын төлөө бүтээх 5 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө бөгөөд залуу сингапурчуудын өөрсдийн болон Сингапурын төлөөх итгэл найдвар, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Уг төлөвлөгөөг 2025 оны 1 дүгээр сараас эхлэн боловсруулж байгаа⁵⁷ ба 100,000 гаруй залуучуудын саналыг үндэс болгосон. Эдгээр санал нь сэтгэцийн эрүүл мэнд, олон үндэстэн, шашны эв нэгдэл, байгаль орчны тогтвортой байдлын зэрэг чиглэлүүдэд голчлон төвлөржээ. Эдгээр санаа нь Залуучуудын Дүрэм (Youth Charter)-д нэгтгэгдэх бөгөөд тэр нь залуучуудын эрмэлзэл, амлалтыг агуулсан баримт бичиг юм.⁵⁸

Дээрх харьцуулсан судалгаанаас дүгнэн үзвэл эрх зүйн зохицуулалтын хэлбэрийн хувьд ХБНГУ залуучуудын бодлогыг нийгмийн хамгааллын нэгдсэн хуулийн бүтэцтэй уялдуулан зохицуулдаг бол ОХУ 2020 онд анхны бие даасан холбооны хуулиа баталж, залуучуудын хөгжлийг бодлогын дэмжих зарчмыг Үндсэн хуульдаа бэхжүүлсэн. БНХАУ-д намын баримт бичиг, тусгай төлөвлөгөөний хэлбэрийг, Сингапур Улсад бие даасан хуулийн оронд институцийн тогтолцоо болон бодлогын баримт бичгүүдийн нэгдмэл загварыг баримталдаг. Ийнхүү ялгаатай хандлагыг баримталдаг боловч ЗЗИ болон Олон Улсын залуучуудын хөгжлийн Индексээс харахад зохицуулалтын арга хэлбэрээс үл хамааран залуучуудын хөгжлийг дэмжих бодлогын орчин нь зөвхөн бие даасан хууль, эрх зүйн зохицуулалтын бүтцэд бус, хэрэгжилтийн механизм, институцийн чадавх, санхүүжилтийн тогтвортой байдлын цогц хослол зэрэг олон хүчин зүйлсээс хамааралтай болохыг харж болохоор байна.

Бүтэц, зохион байгуулалтын хувьд ХБНГУ болон ОХУ нь гурван түвшний тогтолцоотой байх ба орон нутгийн нэгж хүртэл чиг үүрэг тодорхой хуваарилагдсан онцлогтой. БНХАУ-д 130,000 гаруй Youth Home буюу залуучуудад туслах үйлчилгээний цэгүүдээр дамжуулан залуучуудад үйлчилгээ хүргэдэг бол Сингапурт бие даасан агентлагуудын уян хатан сүлжээн дээр тулгуурладаг.

Түүнчлэн ХБНГУ-д залуучуудын нөлөөллийн урьдчилсан үнэлгээний тогтолцоо нь судалсан орнуудын дотроос хамгийн системтэй хэрэгжиж байгаа ба 2017 оноос Jugend-Check аргачлалаар хуулийн төсөл бүрийг залуучуудад үзүүлэх нөлөөллийн хувьд шинжилдэг. Австри, Франц, Шинэ Зеланд зэрэг улсуудад ч ижил практик нэвтэрсэн бөгөөд Европын Холбооны түвшинд хэлэлцэгдэж байна. Ийм үнэлгээний механизмыг Монгол Улсын бодлого боловсруулалтад нэвтрүүлэх нь залуучуудын эрх ашгийг хуульчлалын шатанд хамгаалах үр дүнтэй арга хэрэгсэл болох боломжтой.

⁵⁶Ministry of Culture, Community and Youth, Singapore (1 July 2019), op. cit. (зүүлт тайлбар №24-ыг үзнэ үү).

⁵⁷SG Youth Plan official website (2025). "About SG Youth Plan." National Youth Council Singapore. <https://www.youthplan.gov.sg/about-sg-youth-plan/> (сүүлд үзсэн: 2026.05).

⁵⁸ SG60 official website (2025). "SG60 Youth Engagements." <https://www.sg60.gov.sg/sg60-youth-engagements/>

3.2. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтын хүлээн зөвшөөрөгдөх байдал хэр байна вэ?

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль Монгол Улсын иргэн 15-34 насны залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд үйлчилнэ.

Үнэлгээ:

Нийгмийн асуудлыг нийгмийн институцээр эсвэл нийгмийн асуудлын тодорхой төрөл, хэлбэрүүдээр авч үзэхдээ нийгэм хүн ам зүйн нийтлэг бүхий томоохон бүлгүүдийн хүрээнд нарийвчлан судлах практик түгээмэл бий. Тухайлбал, залуучуудын нийгмийн асуудлыг нийгмийн бусад бүлгүүдээс тусгайлан авч үзэх үндэслэл бий. Голлох үндэслэлүүдийг дурдвал:

1. Нас, бие физиологийн онцлогийн хувьд авч үзэхэд ч залуучууд нь нийгэм, хүн ам зүйн хувьд жин дарахуйц нөлөө бүхий бүлэг мөн. Залуучуудыг тусгайлан судлахад тэргүүн зэргийн ач холбогдол өгөхийн анхдагч шалтгаан бол Монгол улс хүн ам зүйн төдийгүй нийгмийнхээ үзүүлэлтээр “хүүхэд-залуучуудын орон” байхаа больж харин “залуучуудын орон болсон явдал юм”
2. Залуучууд нь мэргэжил боловсрол эзэмших, ажилд орох, орлогын эх үүсвэр, бие даан амьдрах, амьдрах орон байртай болох зэрэг хөгжлийн суурь хэрэгцээгээрээ нийгмийн бусад бүлгүүдээс ихээхэн ялгаатай, үндсэндээ тэдэнд тулгамддаг асуудал бэрхшээл нь өөр юм.
3. Залуучууд нь хүн ам зүйн хувьд бусад бүлгээс нийгэм сэтгэл зүйн онцлог шинж чанараараа ялгаатай. Залуучуудын нийгэм сэтгэл зүйн онцлог шинж чанаруудыг илэрхийлсэн олон тодорхойлолт бий. Жишээлбэл, доктор Н.Хавх тодорхойлохдоо, залуучуудын психологийн онцлог нь тэдний үзэлд шингэсэн байх агаад тэдний сэтгэл, үзэл хоёрын нэгдлийг илэрхийлсэн дараах өвөрмөц үзлүүд бий. Үүнд: 1. залуу насны өрөөсгөл үзэл, 2. залуу насны хамтач үзэл, 3. залуу насны эвлэрэнгүй үзэл, 4. залуу насны шүүмжлэлт үзэл, 5. залуу насны гутранги үзэл, 6. залуу насны мөрөөдөлт үзэл, 7. залуу насны эрч хүч буюу бэрхшээлийг туулах чадвар гэжээ.⁵⁹

Дээрхээс дүгнэн үзвэл залуу үе нь юуны өмнө нийгмийн нэг үе болохын хувьд амьдралын нэг мөчлөгөөс нөгөө мөчлөгт шилжиж буй, амьдралын туршлага хомс, нийгмийн статус, үүрэг нь төлөвшөөгүй, эсвэл сул төлөвшсэн, өөрийн гэсэн гэр бүлийн амьдрал эхэлж буй, нийгмийн баталгаа бэхжээгүй, нийгмийн дэд соёл болохын хувьд өвөрмөц үнэт зүйл, амьдралын хэв маяг, зан үйлийн хэв загвар, хэрэглээ бүхий, нийгэм сэтгэл зүйн хувьд өөдрөг дэврүүн сэтгэл, туйчлан үзэх, хуучныг үгүйсгэх хандлагатай гэх зэрэг шинж чанартай байна.⁶⁰ Энэ ч үүднээс дэлхийн улс орнууд өөрсдийн онцлогт тааруулан залуучууд гэх нийгмийн бүлэгт тохирсон тэдгээрийг төрийн бодлогоор дэмжсэн хууль, эрх зүйн акт батлах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна.

⁵⁹ Н.Хавх, “Оюутан залуучуудын нийгмийн харилцааны гүн ухааны агуулга”, 2002, 13 дахь тал.

⁶⁰ М.Энхбадрал, Орон нутгийн залуучуудын нийгмийн асуудалд хийсэн социологийн шинжилгээ: Өмнөговь аймгийн жишээн дээр /социологийн магистрын зэрэг горилсон дипломын ажил/, 2018, 11 дэх тал.

Насны ангиллын хувьд залуучууд гэх нийгмийн бүлгийг улс орнууд харилцан адилгүй зохицуулсан бөгөөд ихэвчлэн 12–30 насны хүрээг хамарч байна. Тухайлбал, Шинэ Зеланд болон Австрали улс 12–24 нас, Норвеги 12–25 нас, Швед 13–25 нас, Турк 14–29 нас, Чили болон Индонези 15–30 насны иргэдийг залуучуудын бүлэгт хамруулжээ. Мөн ОХУ, Шри Ланк, Бразил улс 15–29 нас, Саудын Араб 15–24 нас, БНХАУ 14–28 насны ангиллыг ашигласан байна. Энэ нь улс орнуудын залуучуудын хөгжлийн бодлого, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, хүн амын бүтэцтэй уялдан насны хязгаар ялгаатай тогтоогдож байгааг харуулж байна.⁶¹

Монгол Улсын тухайд залуучуудын насыг бусад улсаас бараг 10 насаар өндөр авч үзсэн байна. Энэ нь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих төрийн бодлого хэт өргөн хүрээг хамрах, хавтгайрсан бодлого хэрэгжүүлэх, зорилтот бүлэгтээ тэр бүр хүрч чадахгүй сул талтайгаас гадна 15-18 насны залуусыг ЗХДТХ-н хамрах хүрээнд багтааснаар Хүүхдийн эрхийн тухай хуулийн хамрах хүрээ, үйл ажиллагаатай давхардах нөхцөлийг бүрдүүлж байх тул хуулийн давхардлыг арилгаж, үйлчлэх хүрээг тодорхой болгох үүднээс 18-34 хэмээн насны хязгаарыг тогтоох нь зүйтэй байж болох юм.

Монгол Улсын хэмжээнд 2025 оны байдлаар 15-34 насны 1,014,970 хүн амьдарч байгаа нь нийт хүн амын 28.2% буюу нийт хүн амын гуравны нэгийг эзэлж байгаа бол 18-34 насны 818,573 хүн амьдарч байгаа нь нийт хүн амын 22.7%-г эзэлж байна.⁶²

Хүснэгт 6. 15-34 насны залуусын тоо болон 18-34 насны залуусын тооны харьцуулалт

Он	15–34 нас			18–34 нас		
	Нийт тоо	Өмнөх оноос	Өмнөх оноос %	Нийт тоо	Өмнөх оноос	Өмнөх оноос %
2021	1,020,150	–	–	884,595	–	–
2022	1,015,775	-4,375	-0.4%	867,378	-17,217	-1.9%
2023	1,015,862	+87	+0.0%	848,682	-18,696	-2.2%
2024	1,018,554	+2,692	+0.3%	829,907	-18,775	-2.2%
2025	1,014,970	-3,584	-0.4%	818,573	-11,334	-1.4%

Иймд дээрх шалгуур үзүүлэлтийн хүрээнд ЗХДТХ-н хамрах хүрээг 18-34 болгосон нь хуулийн давхардлыг арилгаж үр дүнтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх сайн талтай байж болох юм.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын хүлээн зөвшөөрөгдөх байдал хэр байна вэ?

⁶¹ С.Амартүвшин, З.Баярхүү, “Залуучуудад чиглэсэн зарлагын шинжилгээ”(судалгааны танилцуулга), 2021, 11 дэх тал

⁶² Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, <https://www.1212.mn/mn>

6 дугаар зүйл.Залуучуудын эрхэмлэх зүйл

6.1.Залуучууд нийгмийн хөгжил, бүтээн байгуулалтад оролцохдоо дараахь зүйлсийг эрхэмлэнэ:

6.1.1.эх оронч үзлийг эрхэмлэж, ёс заншил, өв уламжлалаа дээдлэх;

6.1.2.эрүүл, чадварлаг, бүтээлч, ёс зүйтэй, боловсролтой, соёлтой иргэн болж төлөвших, өөрийгөө хөгжүүлэх;

6.1.3.нийтэд тустай сайн дурын ажилд манлайлан оролцох;

6.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох;

6.1.5.амьдрах ухааны болон санхүүгийн мэдлэг, чадвар эзэмшиж, сахилга баттай байх;

6.1.6.хэвлэл мэдээллийн болон цахим орчинд бусдыг гутаан доромжлохгүй байх.

Үнэлгээ:

Шалгуур үзүүлэлт 1-д дурдсанчлан ЗХДтХ-н зорилт нь төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг тогтоохыг зорьдог. Харин 6 дугаар зүйл нь залуучуудаас юу хийхийг хүлээж байгааг тоочдог. Энэ нь уг заалтыг хуулийн зорилгод нийцэхгүй хэмээн дүгнэх боломжтой. Учир хуулийн төслийн гол үзэл баримтлал нь "Засгийн газар, байгууллагууд залуучуудыг хөгжүүлэхийн тулд юу хийх вэ?" гэдгийг тогтоохыг зорьсон байтал 6 дугаар зүйл нь "залуучуудын хэн болох ёстой вэ?" гэдгийг зааж байгаа нь тохиромжгүй юм.

Судалгааны хүрээнд дээрх үнэлгээ хийж буй 6 дугаар зүйлийн заалтууд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасан хуулийн төслийн агуулгад тавигдах нийтлэг шаардлагыг хангасан эсэхийг дүгнэн үзэхэд дараах үр дүн харагдаж байна. Үүнд: ХТтХ-н 29.1.3-д "тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс мөргөхгүй тусгахгүй байх;" гэж заасан. Гэтэл ЗХДтХ-н 6.1.4-д гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох талаар 6.1.6-д хэвлэл мэдээллийн болон цахим орчинд бусдыг гутаан доромжлохгүй байх талаар тусгасан байна. Энэ нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Эрүүгийн хуулийн зохицуулалтуудтай давхцах боломжтой тул дээрх шаардлагыг зөрчсөн хэмээн үзэж болохоор байна.

ХТтХ-н 29.1.6-д "хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;" гэж заасан бөгөөд дээрх ЗХДтХ-н 6.1.1-ийн "эрхэмлэх", 6.1.2-ийн "төлөвших", 6.1.3-ийн "оролцох", 6.1.4-ийн "оролцох", 6.1.5-ийн "эзэмших" гэсэн үгнүүдт нь бүгд тунхаглалын шинж чанартай. Эдгээрт хэмжигдэхүйц хэм хэмжээ тогтоогоогүй, хэрэгжилтийг хариуцах байгууллага тодорхойлогдоогүй, биелэлтийг хянах, хийгээд хангахуулах механизм байхгүй. Заалт бүр нь "юу хийх ёстой вэ" гэдгийг нэрлэх хэмжээнд л "биелэгдсэн бөгөөд "хэн хийх вэ", "хэрхэн хийх вэ", "биелэгдээгүй тохиолдолд юу болох вэ" гэдгийг огт тайлбарлаагүй байна.

Мөн ХТтХ-н 29.1.8-д "тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх." талаар тусгасан. ЗХДтХ-н 6 дугаар зүйл нь залуучуудаас юу хүлээж байгааг нэрлэсэн боловч хэрэгжилтийг хариуцах нийтийн эрх зүйн этгээд (яам, агентлаг, аймаг, нийслэл гэх мэт) нэг ч заалтад тодорхойлогдоогүй байна. Хэрэгжилтийн журам тусгагдаагүй. Зөрчил гарсан тохиолдолд хэрэглэх арга хэмжээ байхгүй. Хяналтын механизм дурдаагүй байгаа нь уг шаардлага бүхэлдээ хангагдаагүй хэмээн үзэж болохоор байна.

Дээрхээс дүгнэн үзвэл хуулийн дээрх заалт нь хүлээн зөвшөөрөгдсөн байдлын шалгуурыг хангаагүй байна. Тодруулбал, хуульд "эрхэмлэх", "төлөвших", "оролцох" гэсэн ёс суртахууны хэм хэмжээ нэрлэгдсэн ч тэдгээрийг иргэд яаж биелүүлэх, биелэлтийг хэн хянах, биелээгүй тохиолдолд ямар үр дагавар гарах нь тодорхойгүй байгаа нь хуулийн заалтыг нийгэм сайн дураар хүлээн авч биелүүлэх боломжийг хязгаарлаж байна. Өөрөөр хэлбэл, хүлээн зөвшөөрөгдсөн байдал нь иргэд хуулийг ойлгож, учир холбогдлыг нь хүлээн зөвшөөрч, дагах нийгмийн нөхцөл бүрдсэн тохиолдолд бий болдог бол 6 дугаар зүйл нь нийгмийн харилцааг зохицуулах бодит агуулгагүй, зөвхөн хүсэл зоригийн тунхаглал хэмжээнд хуульчлагдсан тул хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг иргэд хэрхэн хүлээн авч байгааг хэмжих ч боломжгүй байна.

3.3. "Практикт нийцэж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

7 дугаар зүйл. Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих чиглэл

7.1. Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг дараахь чиглэлээр зохион байгуулна:

- 7.1.1. хувь хүний хөгжил;
- 7.1.2. боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан;
- 7.1.3. эрүүл мэнд;
- 7.1.4. хөдөлмөр эрхлэлт;
- 7.1.5. аюулгүй амьдрах, хөгжих орчин.

Үнэлгээ:

Залуучуудын хөгжлийг дэмжих тогтолцоо нь олон талт оролцоо, хамтын ажиллагаанд суурилсан цогц механизм байх шаардлагатай. Энэхүү тогтолцоонд төрийн болон төрийн бус байгууллага, орон нутгийн удирдлага, боловсролын байгууллага, гэр бүл, хувийн хэвшил, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мөн залуучууд өөрсдөө үндсэн оролцогч талуудын хувьд хамтран оролцоно. Улмаар залуучуудын хөгжлийг дэмжих тогтолцооны үр нөлөө нь оролцогч талуудын хамтын ажиллагаа, чиг үүргийн уялдаа холбоо, хариуцлагын механизм болон залуучуудын бодит оролцоог хэрхэн хангаж байгаагаас шууд хамаарах юм.

Өөрөөр хэлбэл залуучуудын хөгжлийн үйлчилгээ нь өөр өөр үүрэг бүхий төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа хамаарлаас шалтгаалж байдаг. Иймд эдгээр төрийн байгууллагуудын хувьд чиг үүргийн хүрээ, зааг, хязгаарыг нарийн тогтоох, давхардал, хийдэл үүсэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм. Учир нь залуучуудын асуудал нь салбар дундын асуудал бөгөөд бодлогын хэрэгжилт, ололт, амжилт нь салбар хоорондын үр дүнтэй зохицуулалтаас ихээхэн хамаарна.⁶³ Тухайлбал, залуучуудын дунд архидалт буурах нь тэдний эрүүл мэндийг сайжруулаад зогсохгүй гэмт хэрэг, хүчирхийлэл, замын хөдөлгөөний осол буурахад мөн нөлөөлнө. Түүнчлэн залуучууд ажил олох,


⁶³ Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Залуучуудын хөгжлийг дэмжих нийтлэг үйлчилгээний стандарт боловсруулах төсөл /зөвлөх үйлчилгээний тайлан/, 2020, 39.

тогтвортой ажиллах боломжийг бий болгохын зэрэгцээ улмаар орлогоо нэмэгдүүлж, гэр бүлийн харилцаанд эерэг өөрчлөлт авчирна. Үүнийг зургаар үзүүлвэл:

Зураг 1. Залуучуудын хөгжлийн 5 чиглэлийн харилцан хамаарал

Залуучуудын хөгжлийн 5 чиглэлийн харилцан хамаарал

Монгол Улсын Залуучуудыг дэмжих тухай хууль — 7.1 дүгээр зүйл



Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх, үүрэг хүлээгчдийн үйл ажиллагааны үр дүнгээр хуулийн үнэлгээг хийснээр хуулийг сайжруулах, хэрэгжилт муу байгаа заалтуудын учир шалтгааныг оношлох чухал ач холбогдолтой бөгөөд залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиар дараах этгээдүүд үүрэг хүлээж байна. Үүнд:

- Улсын Их Хурал
- Засгийн газар
- Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- Залуучуудын хөгжлийг дэмжих төв
- Шинжлэх ухааны академи
- Их, дээд, сургууль, коллеж, мэргэжлийн боловсруулын байгууллага
- Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын тамгын газар
- Залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөл

Эдгээр төрийн байгууллагууд нь залуучуудын хөгжлийн бодлого, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, санхүүжилт болон институцийн дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Харин иргэний нийгмийн байгууллага болон олон улсын байгууллагууд нь залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, сайн туршлага нэвтрүүлэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, эрхийг хамгаалах чиглэлээр дэмжлэг үзүүлдэг. Хувийн хэвшил нь хөдөлмөр эрхлэлт, дадлага, гарааны бизнес, инновацын орчныг бүрдүүлэхэд чухал оролцоотой. Түүнчлэн хэвлэл мэдээлэл, цахим орчин нь залуучуудад чиглэсэн мэдээлэл түгээх, нийгмийн эерэг хандлагыг төлөвшүүлэхэд нөлөө үзүүлдэг.

Дээрх үүрэг хүлээсэн этгээдүүдийн хийгдсэн үйл ажиллагааны тайланд дүн шинжилгээ хийхэд дараах үр дүн харагдаж байна.

Хүснэгт 7. Яамдын хэрэгжилтийн нэгтгэл⁶⁴

Яам / байгууллага	Холбогдох зүйл	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Ирүүлсэн мэдээллийн утга
Эрүүл мэндийн яам	10 дугаар зүйл	Өсвөр үеийн эрүүл мэнд дэмжих арга хэмжээ	Хамрагдах хүрээ өргөн, тоон мэдээлэл дэлгэрэнгүй
Боловсролын яам	8.1.1, 9.1.1–9.1.5	Амьдрах ухааны хичээл, оюутны зээл, номын сан	2018–2023 он тус бүрийн тайлан бий
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хөдөлмөр эрхлэлт	Гарааны бизнес, ажилд зуучлал, залуу малчдыг дэмжих	2023 оны тоон мэдээ бий
Хууль зүй, дотоод хэргийн яам	12.1.2, 12.1.3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хоригдлын сургалт	2024 оны 10 сарын мэдээ бий
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	9.7–9.8	Олон улсын шалгалт, сургалт	2024 оны 9 сарын мэдээ бий
Батлан хамгааллын яам	8.1.3, 8.3, 8.4, 9.1.4, 9.1.5, 19.2	Оюутан-цэрэг, эх оронч үзэл, ажилд зуучлал	2014–2024 оны тоо хүснэгтлэгдсэн

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2023 оны жилийн эцсийн байдлаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна:

- Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаанд 635 иргэн хамрагдаж, 741,000,000 төгрөгийг зарцуулсан.
- Малчдыг малжуулах үйл ажиллагаанд нийт 1,994 иргэн хамрагдаж, 5,515,853,750 төгрөгийг зарцуулсан.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих үйл ажиллагаанд нийт 5,479 иргэн хамрагдаж, 10,501,815,300 төгрөгийг зарцуулсан.
- Залуучуудын хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх сургалт, зөвлөгөөнд 1,970 иргэн хамрагдаж, 124,800,000 төгрөгийг зарцуулсан.

⁶⁴ Холбогдох яамдаас 2024 оны 11–12 дугаар сард ирүүлсэн тайлан мэдээлэл

Их дээд сургууль төгсөгчдийн 76.9 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагаас 66.5 хувь нь мэргэжлээрээ, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага төгсөгчдийн 71.5 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагаас 51 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байна.⁶⁵

- Эрүүл мэндийн яамны тухайд 2018–2024 оны хооронд өсвөр үеийн клиник, төв, кабинетаар дамжуулан нийт 33,285 хүүхэд, залуучуудад үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнийг газар зүйн хуваарилалтаар авч үзэхэд үйлчлүүлэгчдийн 38.6 хувь хөдөөгийн орон нутагт, 61.4 хувь нь нийслэлийн өсвөр үеийн клиникт үйлчлүүлсэн байна. Мөн дараах анхаарал татахуйц асуудлуудыг тайландаа тусгасан байна. Үүнд 2023 онд өсвөр үеийн клиникт үйлчлүүлэгчдийн 1.9 хувь (n=62) нь 10–24 насны жирэмсэн эмэгтэй байсан бөгөөд тэдгээрийн дундаж нас 16.8 байсан нь насанд хүрээгүй охид нилээдгүй жирэмсэлсэн байгааг харуулж байна.
- 15–19 насны өсвөр үеийнхний нийт нас баралтын 23.6 хувь буюу 4 хүн тутмын 1 нь амиа хорлосон байна.
- БЗДХ оношлогдсон өсвөр үеийнхэн 2021 оноос буурах хандлагатай болсон ч трихомоназ өвчний тохиолдол нэмэгдсэн хэвээр байна.⁶⁶

Боловсролын яамны тухайд хуулийн 8.1.1, 9 дүгээр зүйлтэй холбоотой ажлын тайланг 2018–2024 оны хугацаагаар нэгтгэн ирүүлсэн бөгөөд тус тайланд дурдсанаар 2019–2020 оны хичээлийн жилээс эрнхий боловсролын сургуулийн 1–12 дугаар ангид "Иргэний ёс зүйн боловсрол" сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн талаар дурдсан байна.

Эдгээр тайлангуудаас үзэхэд дараах алдаа дутагдлууд хуулийн хэрэгжилтийн явцад гарсан байна. Тодруулбал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны тайланд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 9.7–9.8-ын хэрэгжилтийн тухай тайлагнасан ч тухайн заалттай тусгайлан уялдуулсан мэдээлэл хязгаарлагдмал буюу хуулийн заалтын хүрээнд хийгдсэн ажил уу эсхүл үндсэн чиг үүргийн хүрээнд хийгдсэн ажлаа уялдуулан тайлагнаж байгаа эсэх нь тодорхойгүй байгаа бөгөөд үүнтэй адил алдааг бусад яамдууд ч гаргасан байна. Сургалтын үйл ажиллагаа нь хуулийн зорилтот бүлгийн 15–34 насны залуучуудад хамаарах боловч хамрах хүрээний тоон мэдээ тусад нь ангилагдаагүй байна. Мөн хуулийн 9.3-д заасан цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан иргэдийн амьдрах ухааны сургалтын багц цагийг нөхөн тооцох журмыг Боловсролын яамтай хамтран батлаагүй хэвээр байгааг Батлан хамгааллын яам тайландаа тусгасан байна. Хуулийн 19.2-т заасан цэргийн насны залуучуудын цэргийн алба хаах хүсэл, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ залуучуудын асуудал эрхэлсэн байгууллагатай хамтран хийгдээгүй байна.

Дүгнэн үзвэл оролцогч байгууллагууд буюу ЗХДТХ-р үүрэг хүлээсэн этгээдүүдийн үйл ажиллагаа хангалтгүй, хамтын ажиллагаа байхгүй, үндсэн чиглэлд хамаарах тодорхой төрлийн үйл ажиллагааг ямар байгууллага хариуцах нь тодорхойгүй байгаа нь тус хуулийг тунхагийн шинжтэй хэмээн үнэлэх нөхцөл байдлыг бодитоор бий болгож байна.

Үүнээс гадна ЗХДТХ-ийн хүрээнд тусгасан үндсэн 5 чиглэл, дүрэм журмыг хэрэгжүүлэх, орон нутаг, хороо, дүүргийн хэмжээнд залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн, төрийн бус байгууллагын оролцоотойгоор хүргэдэг байсан ажил үйлчилгээг

⁶⁵ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. "Хариу хүргүүлэх тухай." Албан бичиг № 01/1481. Улаанбаатар, 2024, 2.

⁶⁶ Эрүүл мэндийн яам. "Өсвөр үе залуучуудын эрүүл мэнд, 2019–2023 он." Албан бичиг № 19/14949-ын хавсралт.

олон талт оролцоо, салбар дундын хамтын түншлэлээр дамжуулан хүргэх чиг үүрэг бүхий институцийг цаашид ч бэжжүүлэх хэрэгцээ байсаар байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 5. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6 дахь заалтууд практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

8 дугаар зүйл. Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих

8.1. Залуучуудын хувь хүний хөгжлийг дараахь чиглэлээр дэмжинэ:

8.1.1. ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн боловсролын төв, багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хичээлийн агуулгыг тусгах;

8.1.2. залуучуудад зориулан хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих;

8.1.3. түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие дааж амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд чиглэсэн амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хөтөлбөрийн дагуу цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны залуучуудыг хамруулах;

8.1.4. залуучуудын гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа, уламжлал, зан заншлын тухай утга зохиол, уран сайхны бүтээлийг дэмжих;

8.1.5. залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт тусгах;

8.1.6. энэ хуулийн 8.1.5-д заасан агуулга, хөтөлбөрийг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

8.2. Энэ хуулийн 8.1.1-д заасан хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

8.3. Энэ хуулийн 8.1.3-т заасан цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны эмэгтэйчүүд сайн дурын үндсэн дээр хамрагдаж болно.

8.4. Энэ хуулийн 8.1.3 дахь заалт, 8.3 дахь хэсэгт заасан залуучуудад цэргийн мэргэжил олгох журмыг Засгийн газар батална.

8.5. Энэ хуулийн 8.1.4-т заасан бүтээлийг сонгон шалгаруулах журмыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

8.6. Энэ хуулийн 8.5-т заасан журмын дагуу шалгаруулсан бүтээлийг Засгийн газрын холбогдох тусгай сангаас санхүүжүүлнэ.

Үнэлгээ:

Өнөөгийн Монголын залуучуудын хувьд ажил хөдөлмөр эрхлэхэд ажлын байрны бодитой бус шаардлага, ялгаварлан гадуурхалаас үүдэлтэй зарим нэг бэрхшээлүүд тохиолдож байна. Ер нь аливаа улс орны хөдөлмөрийн зах зээл дээр нийгмийн бүлэг болон хувь хүнийг ялгаварлан гадуурхах явдал тулгарч байдаг. Хөдөлмөрийн зах зээлийн нэг онцлог бол ажил олгогч эрхэлж буй үйл ажиллагаанаас хамаарсан бодит шаардлагын улмаас ажилтан авах, ажлын байрны зар гаргахдаа зарим нэг тодорхой хязгаарлалтууд тавих тохиолдол бий. Жишээ нь, шинэ ажлын байрны зар гаргахдаа насны бүлгийг заасан байдаг. Энэ тохиолдолд ажил хайгч нь ажил олгогчийн зүгээс тавьсан "шаардлагад нийцэх" сул тал бүхий хүмүүс болж хувирдаг. Хөгжингүй орнуудад шашин шүтлэг, үндэс угсаа, арьс өнгө цаашилбал бэлгийн чиг баримжаагаар ялгаварлахгүй байхад анхаарч буй бол, хөгжиж буй орнуудад нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй эсэх зэрэг асуудлууд илүү тулгамдсан

шинжтэй байгаа юм. Монгол Улсад гэхэд хөдөлмөрийн зах зээл дээр ажил олгогчийн зүгээс нас, бие бялдар, царай зүс гэх мэт зүйлсээр хязгаарлалт тавих тохиолдол нийтлэг байгаа нь институцийн сул хөгжил, түүний чиг үүргийн тодорхойгүй байдалтай холбоотой.

Энэ ч үүднээс ЗХДТХ-н 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтад тусгасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндсэн чиглэлийг тусгасан. Гэсэн хэдий ч хуулийн бичиглэлтэй холбоотой дараах хүндрэлүүд үүсэж болохоор байна. Тодруулбал, 8.1.2 дахь заалтад амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжихээр заасан хэдий ч хэн дэмжих, хэн зохион байгуулах талаар ямар нэг субъект заагдаагүй байна. "Дэмжих" гэсэн үйл үгийн ард хэн нэгэн тодорхой этгээд дурдагдаагүй 7 дугаар зүйлд зөвхөн төр хэмээн оруулсан нь уг заалтын хэрэгжүүлэгч тодорхойгүй болж цаашлаад хэрэгжилтийг үнэлэх, хэрэгжүүлээгүй субъектэд хариуцлага тооцох боломжгүй нөхцөл байдлыг бий болгоод байна. Мөн ямар агуулгын сургалт явуулах, ямар үр дүнд хүрэх зэрэг шалгуур тусгагдаагүй нь хэрэгжилтийн үнэлгээг субъектив шинжтэй болгох эрсдэлтэй байна, 8.1.4 дахь заалтад гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжсэн бүтээлийг дэмжихээр заасан хэдий ч жилд хэдэн бүтээлийг дэмжих, ямар шалгуурын дагуу сонгох, хэдий хэмжээний санхүүжилт олгох зэрэг тооцоолол хуульд байхгүй байна. Үүнтэй адил алдааг хуулийн 8.1.5 дахь заалтад хэвлэл мэдээллийн агуулгад хөтөлбөр тусгахаар заасан хэдий ч агуулгын тоо, хүрэх үзэгчдийн тоо, нэвтрүүлгийн давтамж зэрэг ямар нэг тоон шалгуур бичээгүй зэрэг нь дээрх заалтуудын практикт хэрэгжихэд хүндрэл учруулж, хэмжих боломжгүй нөхцөл байдлыг бий болгож байна.

ХНХЯ-ны Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг баримтлан бичсэн 2018-2022 оны нийгмийн хамгааллын салбарт хамаарах хуулийн хэрэгжилтийн тайлангаас үзвэл 8.1.4 -т заасан бүтээлийг сонгон шалгаруулах "Утга зохиол, уран сайхны бүтээл шалгаруулах журам"-ыг ХНХСайдын 2019 оны 3 дугаар сарын 28 өдрийн А1129 дүгээр тогтоолоор баталсан ч "Залуучуудын хөгжлийг дэмжих сан" байгуулагдаагүйн улмаас хэрэгжээгүй байна. Мөн дээрх тайланд дурдсанаар 8.1.5, 8.1.6 заалтыг журамд тусгах боломжгүй, үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөмж хэлбэрээр хүргэж хамтран ажиллах байр суурийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос ирүүлсэн тухай дурджээ.⁶⁷

Олон улсын түвшинд хийгдэж буй залуучуудын ихэнх хөтөлбөр, үйлчилгээний агуулга, үйл ажиллагаа нь сургууль дээр хэрэгждэг ба үндсэн хичээлүүдийн агуулгад интеграцчилж багтаан агуулгыг тараан суулгасан байдаг боловч хэрэгцээт хөтөлбөр, үйлчилгээг хичээлээс гадуурх спорт, сонирхлын клуб хэлбэрээр багш, нийгмийн ажилтны удирдлаган дор хэрэгжүүлж болдог. Дээрх үйлчилгээг хэрэгжүүлэхдээ өсвөр залуучуудын эцэг эхэд мэдээлэл өгөх, тэднийг үйл ажиллагаандаа татан оролцуулах, бие биедээ туслах найз нөхдийн нөхөрлөл, дэмжлэгийг хэрхэн бий болгох, харилцааны ур чадвар, хүчирхийллийн эсрэг асуудалд давхар төвлөрөх нь үр дүнтэй байдаг байна.⁶⁸

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 6. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

⁶⁷ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2023, 44 дэх тал.

⁶⁸ С.Туяа, Залуучуудын хөгжлийн төвийн ажлын байрны чиг үүргийн шинжилгээ (урьчилсан тайлан), 2020, 32 дахь тал

20 дугаар зүйл. Залуучуудын хөгжлийг дэмжих төвийн чиг үүрэг

20.1. Орон нутагт залуучуудад үйлчилгээ үзүүлэх залуучуудын хөгжлийн төвийг ажиллуулна. Залуучуудын хөгжлийн төвийн дүрмийг залуучуудын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Үнэлгээ:

Залуучуудын хөгжлийн төв (ЗХТ) нь НҮБ-ын Хүн амын сан болон Монгол Улсын Засгийн газрын хамтарсан "Залуучуудын хөгжил 2013–2017" төслийн хүрээнд анх байгуулагдаж байсан. Улмаар 2017 оны хуулиар залуучуудад насан туршийн боловсрол олгох, амьдрах ухааны сургалтыг явуулах, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх, хөгжлийн төвөөрөө дамжуулж гарааны бизнесийг дэмжин, бизнесийн инкубаторыг дэмжих, бизнесийн зөвлөгөө өгөх⁶⁹ зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор албан ёсоор хуульд тусгасан нь хуулийн хэрэгжилтийн тулгуур бүтэц болон өргөжсөн байна. Ингэснээр өмнө олон нийт, төрийн бус байгууллагаар хүргэдэг байсан ажил үйлчилгээг төр хариуцах болжээ.

Дээрх хуулийн заалтаас үзвэл залуучуудын хөгжлийн төв ажиллуулах талаар болон Залуучуудын хөгжлийн төвийн дүрмийг батлахтай холбоотой эрх зүйн асуудлыг зохицуулсан байна. Иймд дээрх хоёр үндсэн асуудлын хүрээнд тус бүрд нь шинжилгээ хийж авч үзье:

Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ

2016–2017 онд НҮБ-ын төслөөр байгуулагдсан 16 төв ажиллаж байсан⁷⁰ бол 2018 онд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль хэрэгжиж эхэлснээр орон нутгийн төсвөөс санхүүжсэн 16 нэмэлт төв байгуулагдан улсын хэмжээнд нийт 32 болж өссөн байна.⁷¹ Цаашид 2021 онд 35⁷², 2022 онд 38⁷³ болтлоо өссөн нь хуулийн хэрэгжилтийн эхний шатанд төвийн үйл ажиллагаа идэвхтэй явагдсаныг харуулж байна. Гэсэн хэдий ч 2022 оноос үйл ажиллагаа нь оцом муудаж идэвх буурсан байна. Тодруулбал, 2016 онд дан тоогоор 12,154 залуучуудад хүрч байсан бол 2017 онд давхардсан тоогоор 159,614 болж хурдацтай өссөн байна. 2018 онд ЗХТ-ийн тоо хоёр дахин нэмэгдсэнтэй хамт давхардсан тоогоор 349,505 залуучуудад хүрч, амьдрах ухааны 12 модуль хичээлд 42,519, нөлөөллийн ажилд 101,722 залуу тус тус хамрагдсан нь хамгийн өндөр өсөлтийн жил болсон байна. 2021 онд 35 төвөөр дамжуулан нийт 427,290 залуучуудад буюу нийт залуучуудын 41.4 хувьд хүрч үйлчилсэн нь ЗХТ-ийн хамрах хүрээний дээд үзүүлэлт болжээ. Харин 2022 онд хамрах хүрээ буурч 333,779 буюу нийт залуучуудын 40.3 хувь болсон нь 2021 оноос 93,511 залуучаар буюу 21.9 хувиар буурсан үр дүн юм.

2024 оны байдлаар зөвхөн 17 аймгийн өгөгдлийг харахад нийт үйлчлүүлэгчийн тоо 55,708 болсон байна.⁷⁴ Аймгийн дунджаар тооцвол 2022 онд аймаг тус бүрт ойролцоогоор 9,000–10,000 залуучуудад хүрч байсан бол 2024 онд дундажаар 3,277 болсон байна. Энэ харьцаа нь аймгийн түвшний үйлчилгээний цар хүрээ гурав дахин буурсныг илтгэж байна. Энэ бууралт нь зөвхөн нэг шалтгаанаас бус, харин санхүүжилтийн суурь өөрчлөлт буюу

⁶⁹ Монгол Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, 111 дэх тал <https://www.parliament.mn/nc/213/>

⁷⁰ Залуучуудын хөгжлийн төвийн 2016 оны жилийн эцсийн тайлан — "2016 оны байдлаар нийт 16 ЗХТ-үүдээр дамжуулан дан тоогоор 12,154 залуучуудад хүрч ажилласан... Амьдрах ухааны сургалтад нийт 3,184 залуучууд хамрагдаж..."

⁷¹ Залуучуудын хөгжлийн төвийн 2018 оны жилийн эцсийн тайлан

⁷² Залуучуудын хөгжлийн төвийн 2021 оны жилийн эцсийн тайлан

⁷³ Залуучуудын хөгжлийн төвийн 2022 оны жилийн эцсийн тайлан

⁷⁴ Залуучуудын хөгжлийн төвийн 2024 оны аймгийн мэдээлэл — 17 аймгийн нэгтгэл: нийт үйлчлүүлэгч 55,708, сургалтад хамрагдагч 21,667.

Залуучуудын хөгжлийг дэмжих сан татан буугдсан, ажилтны тогтворгүй байдал, Ковидын дараах идэвхжлийн суурьшил удаашрал зэрэг олон хүчин зүйлийн нийлсэн нөлөөний үр дүн байх боломжтой юм.

Үйл ажиллагааны чиглэл хийгдсэн ажлыг дэлгэрүүлэн авч үзвэл 2020 оны байдлаар төрөөс залуучуудыг дэмжих үндсэн 5 чиглэлийн хүрээнд залуучуудын хөгжлийн төв нь дараах үйлчилгээнд залуучуудыг хамруулан ажилласан байна. Тодруулбал:⁷⁵

Хувь хүний хөгжил: Сэтгэл зүйн зөвлөгөө; Сайн дурын ажлыг бүртгэх баталгаажуулах үйлчилгээ; Залуу малчдыг дэмжих; Амжилт гаргасан залуучуудыг алдаршуулах; Зорилтот бүлгийн залуучуудад нийгэм, сэтгэл зүйн чадвар эзэмшүүлэх сургалт явуулах, дэмжих бүлэг, оролцооны зөвлөлийг ажиллуулах; Залуу хүн бүрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх; Зорилтод бүлгийн залуучуудад зориулсан сургалт, зөвлөгөө нийгмийн үйлчилгээний болон халамжийн үйлчилгээнд холбон зуучлах; Амьдрах ухааны боловсрол олгох сургалтын үйлчилгээ; Цахимаар дамжуулан залуучуудад боловсрол олгох (гитар бүжиг, фотошоп); Сэжигтэн, яллагдагч татагдан үед соён гэгээрүүлэх сургалт нөлөөлөл, захиргааны хяналтад байгаа залуучуудад хүмүүжил төлөвшлийн талаар үнэлгээ өгөх, сургалт хийх; Хорихоос сулагдсан, хорих ял эдлэж байгаа залуучуудыг нийгэмшүүлэх холбон зуучлах, судалгаа хийх; Хувь хүний хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ; Залуу аав, залуу ээжүүдэд зориулсан явуулын сургалтын үйлчилгээ /би халамжтай ээж, аав/; Угийн бичиг хөтлөхөд дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө, зөвлөмж өгөх; Залуучуудын ур чадварын үнэлгээг хийх орон нутгийн залуучуудынхаа ур чадварын судалгааг гаргах, холбон зуучлах; Их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн дэргэд ажилд холбон зуучлах, зөвлөл клуб нээж ажиллуулах;

Боловсрол, урлаг, спорт, шинжлэх ухаан: Хорих ял эдэлж байгаа болон асрамж олгох халамжийн төвийнхөнд цахим номын сантай болгох; Онлайн ном баяжилт болон подкаст хийх; Өсвөр үе залуучуудад түүхэн замаар явган болон дугуйтай аялалыг зохион байгуулах, байгаль орчныг хамгаалах, өв уламжлалын боловсрол олгох; Зорилтод бүлгийн залуучуудад сургалт, нөлөөллийн үйлчилгээ; Залуучуудын сонирхолын клуб дугуйлан байгуулах, дэмжих; Өв уламжлал болон зан заншлын боловсрол олгох, утга зохиол, уран бүтээлийг дэмжих үйлчилгээ; Боловсролын үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээ; Залуучуудад олон улсын хэлний боловсрол олгох "Залуу хөтөч" үйлчилгээ; Цэргийн ангиудын залуучуудад гэр бүлийн боловсрол олгох үйлчилгээ; Залуучуудын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг дэмжих; Өсвөр үе, залуучуудын өмнө тулгамдсан асуудлын хүрээнд судалгаа хийх; Залуучууд судлал, эрдэм шинжилгээ, судалгааг дэмжих; Залуучуудын хөгжлийн төвийн ажлын байрны чиг үүргийн шинжилгээ Урлаг, спортоор дамжуулан залуучуудын хөгжил, оролцоог дэмжих; Цахим номын сангийн үйлчилгээ;

Эрүүл мэнд: Залуучуудыг эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээ; Залуучуудын эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ (ХДХВ-халдварт өвчин);

Хөдөлмөр эрхлэлт: Ажил хөдөлмөрт холбон зуучлах; Гарааны бизнесийг дэмжих, үйлчилгээ (сургалт, оффисын байраар хангах); Мэргэжил сонголтыг дэмжих үйлчилгээ (сорилын тест, ажил мэргэжлийн зөвлөгөө); Оюутан залуучуудыг ажилд зуучилсан хөдөлмөрийн биржийг дэмжих; Залуучууд хувиараа болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих; Орон нутгийн захиалгат ажлын байранд очсон залуучуудыг дэмжих (ажил мэргэжлийн зөвлөхийг байгууллага бүрт дадлагажуулагч хэлбэрээр

⁷⁵ С.Туяа, Залуучуудын хөгжлийн төвийн ажлын байрны чиг үүргийн шинжилгээ (урьчилсан тайлан), 2020, 24-25 дахь тал

хэрэгжүүлэх); Залуучуудын цахим ажил үйлчилгээ эрхлэх, гарааны бизнес эрхлэх замаар орлогоо нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, холбон зуучлах; Залуу ажилтнуудад ажлын байран дахь эрхийг хангах, тогтвортой ажиллуулахад чиглэсэн сэтгэл зүйн таатай орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сургалт, сурталчилгаа хийх; Хөдөлмөрийн биржийг туршилтаар хэрэгжүүлэх, залуучуудад ажлын байрны мэдээлэл өгөх үйлчилгээ; Залууст ээлтэй аж ахуй нэгж байгууллагад дэмжих, шилдэг залуучуудыг олон нийтэд алдаршуулах; Өсвөр үеийнхний мэргэжил сонголтыг дэмжих тестээр болон онлайнаар дамжуулан мэргэжил сонголтын үнэлгээ хийх үйлчилгээ; Ментор хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ажил олгогчдод байгууллагуутай хамтран хэрэгжүүлэх;

Аюулгүй амьдрах: Хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, холбон зуучлах; Залуу гэр бүлийг дэмжих үйлчилгээ (гэрлэлтийн гэрчилгээ олгох, залуу гэр бүлүүдэд зориулсан сургалт, зөвлөгөө); Гэмт хэрэгт татагдахаас урьдчилан сэргийлэх ажлын хэвлэл мэлээллийн байгууллага, иргэний нийгмийн оролцоотой зохион байгуулах; Орлоготой нь нийцсэн уян хатан төлбөрийн нөхцөлтэй орон сууцны талаарх мэдээллээр хангах; Залуу гэр бүлүүдэд эвлэрүүлэн зуучлах болон зөвлөгөө мэдээлэл сургалт хийх, гэрлэх ёслолыг хийх үйлчилгээ; Асрамж, халамжийн төвөөс 18 насанд хүрээд гарч байгаа өсвөр үе, залуучуудыг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх, холбон зуучлах; Урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил (архи тамхи, мансууруудах бодис); Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан залуучуудыг соён гэгээрүүлэх;

Дээрх үйлчилгээнээс харахад хуульд тусгагдсан үйлчилгээнээс гадна нөхцөл байдлын үнэлгээ хийх, кейс багт ажиллах, зорилтот бүлгийн судалгаа хийх олон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, залуу гэр бүлийн асуудлыг тодорхойлох зэрэг хуульд тусгагдаагүй үйлчилгээг давхар эрхлэн хэрэгжүүлж байгааг ЗХТ-ийн мэргэжилтнүүд дурдсан байна.

Тулгамдаж буй асуудал, бэрхшээлүүд⁷⁶

- Хүний нөөц, орон тоо бага
- Төсөв, цалин ихээхэн бага
- Хүмүүст ЗХТ-ийн чиглэлээр ойлголт байхгүй, суманд хариуцсан хүн хэрэгтэй
- Байр, орчны асуудал шийдвэрлэгдээгүй
- Үйлчилгээний давхцал байна
- Эрх мэдэл сул
- Бүтэц, зохион байгуулалт тааруу
- Байгууллага хоорондын хамтран ажиллах, хамтын ажиллагаа тааруу
- Үйлчилгээний орчин нөхцөл хангагдаагүй
- Тоон мэдээлэл зөрүүтэй, яг таг гаргахад хэцүү. Цэргийн насны залуучуудын тоог гаргах боломжгүй/нууц гээд өгдөггүй/
- Өргөн цар хүрээтэй маш олон сургалт явуулдаг, үр дүн нь мэдэгддэггүй • Гэрээт ажилтан хэлбэрээр явах нь ЗХТ-ийн мэргэжилтэн болон цаашдын үйл ажиллагаанд ач холбогдолгүй
- Стартап-инкубатор төвийг ажиллуулах хэрэгцээ бий боловч мэдлэг, ур чадвар хангалтгүй
- Хорихоос суллагдсан хүмүүс/эрсдэл гаргасан тохиолдолд асуудлыг хэн хариуцах вэ?/
- Шатахуун, томилолт гм төсвийн асуудлууд байнга тулгамддаг
- Төрийн үйлчилгээ үзүүлж буй 6,7 байгууллага санамж бичиг байгуулсан. Хөдөлмөр халамж ойлголцохгүй байна. Архинд хамааралтай, архинаас гаргах чин сэтгэлтэй

⁷⁶ Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Залуучуудын хөгжлийг дэмжих нийтлэг үйлчилгээний стандарт боловсруулах төсөл /зөвлөх үйлчилгээний тайлан/, 2020, 18-19.

хүмүүст тусламж, дэмжлэг үзүүлэх шаардлагатай боловч мэдлэг чадвар дутагдаж байна.

- Ажил үүрэг нь Төрийн үйлчилгээ байх уу, төрийн захиргаа байх уу? гэдэг асуудал байна. Хэрэв ЗХТ гэсэн нэртэй байвал Төрийн захиргаа байх боломжгүй
- Орон тооны эсвэл гэрээт байх уу? гэдэг асуудал тулгамдсан хэвээр байна.
- Төсөв хөрөнгө байхгүй учраас/сайн дурын даатгалд хэдэн залуус хамрагдаж байна, ажил эрхэлж буй залуусын тоо бүртгэл зэргийг гаргах боломжгүй/, эрх мэдэл байхгүй байна

Залуучуудын хөгжлийн төвийн дүрэмд хийсэн шинжилгээ:

Дээрх заалтын дагуу Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааны дүрмийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлан гаргасан байна.⁷⁷ Уг дүрэм нь Залуучуудын хөгжлийн төвийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, зорилго, удирдлага, зохион байгуулалт, хариуцлага болон бусад холбогдох харилцааг зохицуулахад чиглэгдсэн. Тодруулбал, тухайн аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийн дэргэд харьяалагдан ажилладаг төвийн өдөр тутмын үйл ажиллагаа, ажилтнуудын эрх үүрэг, санхүүжилт, хяналтын харилцааг цогцоор нь тусгасан байна. Мөн дүрэм нь төвийн үйл ажиллагааны явцад хориглох зүйлс, байр, хөрөнгө, санхүүтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулснаараа ач холбогдолтой юм. Тодруулбал, залуучуудын өрсөлдөх чадвар, амьдралын чанарыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулан, тэдний оролцоонд тулгуурлан хөгжих болон салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд энэхүү дүрэм чухал үүрэг гүйцэтгэж байна. Үүнтэй нэгэн зэрэг төвийн үйл ажиллагааны 13 чиглэлийг тодорхой жагсааснаар залуучуудад үзүүлэх үйлчилгээний хүрээ болон стандартыг тогтмолжуулсан гэдэг утгаараа ч ач холбогдолтой юм. Ялангуяа хуулийн зүйн тусламж, эрүүл мэндийн зөвлөгөө, гэр бүлийн боловсрол, бизнес эрхлэлтийн мэдээлэл зэрэг олон төрлийн үйлчилгээг нэг байгууллагаас хүргэхээр заасан нь орон нутагт үйлчилгээний нэгдсэн тогтолцоо бий болгох бодлогын чухал алхам болсон гэж үзэж болно. Гэсэн хэдий ч энэхүү дүрэм нь дараах сул талтай байна. Үүнд:

- Үйл ажиллагааны үр дүнг хэмжих, үнэлэх механизм тодорхойгүй байдалд оршино. Төвийн ажилтнууд тайлан, биелэлтийг агентлагт хүргүүлэхээр заасан хэдий ч тайланг ямар шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх, үр дүн муу тохиолдолд ямар арга хэмжээ авах талаар дүрэмд тусгагдаагүй байна.

- Ажилтнуудын тоо, мэргэшлийн шаардлага хангалттай нарийвчлагдаагүй байна. Дүрмийн 4.1 дэх заалтад нарийн бичгийн ажил, сургалт, оролцоо, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан /гэсэн орон тоо заасан хэдий ч тэдгээрт тавигдах мэргэшлийн нарийвчилсан шаардлага, ажлын ачааллын хуваарилалтын тухай зохицуулалт дутмаг байна.

- Сум, хороо түвшинд байгуулагдах төвийн тухай зохицуулалт маш товч, тодорхойгүй байна. Дүрмийн 1.3 дахь заалтад сум, хороонд төв байгуулж болно гэж зааснаас цааш тэдгээрийн зохион байгуулалт, санхүүжилт, хяналтын тухай нарийвчилсан заалт байхгүй нь практик хэрэгжилтэд хүндрэл учруулж болзошгүй юм.

⁷⁷ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/07 дугаар тушаал, <https://mlsp.gov.mn/eng/uploads/files/6d2bba5040a835da319f4ad4169a523e9e4c0152.pdf>

- Хориглох зүйлсийн заалт харьцангуй ерөнхий шинжтэй байна. Хуульд заасан бусад зүйлийг хориглоно гэсэн ерөнхий томъёолол нь тодорхой нөхцөл байдалд хэрхэн хэрэглэх талаар тодорхойгүй байдал үүсгэж болзошгүй юм.

ЗХТ-ийн үйлчилгээний чанар, хүртээмжид дүн шинжилгээ хийж үзэхэд залуучуудад олон тооны үйлчилгээ үзүүлэх гэхээсээ хагас нарийн мэргэжлийн үйлчилгээ дутагдаж байна. ЗХТ-ийн мэргэжилтнүүдээс үзүүлж буй үйлчилгээнд дүн шинжилгээ хийж үзэхэд хагас мэргэжлийн болон үндсэн биш салбарын үйлчилгээнүүд давамгайлж, сэтгэлзүйн болон нийгмийн ажлын хагас мэргэжлийн үйлчилгээ бараг үзүүлээгүй. Энэ нь ЗХТ-д ажиллаж буй боловсон хүчний мэргэжил, үйлчилгээний стандартад тавигдах шаардлагыг эргэн харахад хүрч байна. Тухайлбал, ЗХТ-д ажиллаж буй мэргэжилтнүүд нийгмийн үйлчилгээг хүргэх наад захын мэдлэг чадваргүй, мэргэжлийн биш хүмүүс зонхилж байгаа нь залуучуудад үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлөх болно.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 7. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.4 дэх заалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

22 дугаар зүйл.Залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөл

22.1. Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд, орон нутагт залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга тус тус тэргүүлнэ.

22.4. Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөл нь дараахь чиг үүрэгтэй:

22.4.1.залуучуудын хөгжлийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газарт болон холбогдох бусад байгууллагад зөвлөх, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шаардлагатай арга хэмжээ авах;

22.4.2.залуучуудын хөгжлийг дэмжих, эрх ашгийг хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд залуучууд, залуучуудын иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах, гаргасан санаачилгыг дэмжих;

Үнэлгээ:

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 22.1, 22.4.1-22.4.4-т тус тус заасны дагуу “Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл”-ийг тухайн орон нутгийн Засаг дарга нар тэргүүлж, залуучуудын хөгжлийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газарт болон холбогдох бусад байгууллагад зөвлөх, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шаардлагатай арга хэмжээ авах; залуучуудын эрх ашгийг хамгаалах, иргэний нийгмийн байгууллага, аж ахуй нэгж байгууллагыг оролцуулах; олон улсын байгууллагатай хамтран ажиллах зэрэг чиг үүрэгтэй байна.

Шигтгээ 1

...Хууль өөрөө дэд бүтцийнхээ хувьд харьцангуй шийдэгдсэн гэж харж байгаа. Яагаад вэ гэхээр Ерөнхий сайдын дэргэд залуучуудын зөвлөл байгаа бол аймаг орон нутгийн түвшинд нутгийн захиргааны байгууллага дээрээ Засаг дарга нь өөрөө залуучуудынхаа салбар зөвлөлийг тэргүүлнэ гэдгийг хуульчлаад өгч байна. Тэгэхээр залуучуудын асуудалд анхаарал хандуулах субъектүүд нь тодорхой болоод өгнө. Дээрээс нь нутгийн өөрөө удирдах байгууллага нь төсвийнхөө тодорхой хувийг залуучуудынхаа асуудалд зарцуулна гэдгийг хуульчлаад өгч байгаа учраас залуучууд дээр тодорхой төсөв мөнгө нь тавигдаад явахаар ер нь бид бүхний цаашдаа санаа зовоод байгаа, нийгэмд үүсээд байгаа энэ сэтгэлгээний хямралыг хэрхэн эмчилж, хэрхэн залуучуудаа бэлтгэх вэ,

залгамж холбоогоо хэрхэн зөв авч явах вэ гэдэг нь эндээс бодитоор биеллээ олоод явна гэдэгт эргэлзэхгүй байна.

Мөн энэ хуулийг хэрэгжүүлэхэд залуучуудын асуудал бүх л салбартай холбоотой. Нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргаа, төрийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд хүн бүрд залуучуудын асуудал холбоотой учраас хүн бүр үүнд сэтгэл гаргаж хамтарч сайн ажиллаж чадах юм бол энэ хууль бодитойгоор хэрэгжиж гар хөл нь бэхэжнэ гэдэгт итгэлтэй байна.

*Монгол Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы
2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаан
УИХ-н гишүүн Н.Учрал-н хэлсэн үгнээс⁷⁸*

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр ЗХДТХ-н 22.3-т заасныг үндэслэн “Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөл”-н дүрмийг баталсан⁷⁹ хэдий ч Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үндэслэн “Зарим үндэсний хороо, зөвлөлийг татан буулгах тухай” 22 дугаар тогтоолыг баталсан бөгөөд уг тогтоолын 5 дахь заалтаар 2018 оны “Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөл”-н дүрмийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.⁸⁰

Өөрөөр хэлбэл залуучуудын хөгжлийн бодлогын чиглэлээр чухал үүрэг оролцоотой хууль зүй, боловсрол, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, цагдаа, төсөв санхүүгийн салбарууд хамтран хэрэгжүүлэх олон салбар дамнасан үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан ажиллах ёстой бөгөөд энэ арга зүй, аргачлал байхгүйгээс аль салбартай хэрхэн хамтрах, хэрхэн хийх вэ гэдэг асуудал үүснэ. Ийм нөхцөл байдал ЗХТ-ийн үйл ажиллагаанд бас харагдаж байна. ЗХДТХ-д заасан залуучуудын хөгжлийг дэмжих чиглэл, ЗХТ-ийн үйл ажиллагааны чиглэлд зарим салбар, хэлтэс, албаны чиг үүрэг, үйлчилгээтэй давцсан, ялангуяа хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбарын зарим чиг үүрэг, үйлчилгээтэй үйл ажиллагааг уялдуулан холбож хамтын түншлэл, олон салбарын хамтарсан нэгдмэл төлөвлөлтийг бий болгох нь чухал.⁸¹

Залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, бусад салбар нэгж, хэлтэстэй чиг үүргийн давхцал үүсэхгүй байхаар ажлын төлөвлөлт, зохион байгуулалт хийх, салбарын хамтын ажиллагааг сайжруулах хэрэгтэй байна. Түүнчлэн орон нутгийн залуучуудын идэвхи оролцоо, хүсэл сонирхол хангалтгүй байдаг гэсэн хандлагаас бус залуучуудад хүрч очиж ажил үйлчилгээгээ таниулах, эрэлт хэрэгцээ, сонирхол, асуудлыг судлах, мэдээллээр хангах өөрөөр хэлбэл нийгмийн үйлчилгээний маркетинг хийх, залуучуудын сүлжээг орон нутагтаа бий болгох шаардлагатай. Энд Залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөлийн гүйцэтгэх үүрэг маш их бөгөөд ЗХДТХ-ийн 22 дугаар зүйл, Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг уялдуулах Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрмийн 1.1, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн дүрмийн 1.1-д тус тус тодорхой заалтуудыг хуульчилсан. Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг улсын болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг хангалтгүй байгаа нь ЗХТ-

⁷⁸ Монгол Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, 201 дэх тал <https://www.parliament.mn/nc/213/>

⁷⁹ Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 4 дүгээр тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=13099>

⁸⁰ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 22 дугаар тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=13099>

⁸¹ С.Туяа, Залуучуудын хөгжлийн төвийн ажлын байрны чиг үүргийн шинжилгээ (урьчилсан тайлан), 2020, 32 дахь тал

ийн үйл ажиллагааг удирдлагаар хангах, үйлчилгээг жигд хүргэхэд бэрхшээл үүсгэж, шийдвэрлэх шаардлагатай асуудал хуримтлагдахад хүргэж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1 ДҮГНЭЛТ

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн (ЗХДтХ) хэрэгжилтийн үр дагаварт хийсэн энэхүү судалгааг долоон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх ажлын хүрээнд хуулийн 1, 3, 5, 6, 7, 13, 22, 24 дүгээр зүйлүүдэд дүн шинжилгээ хийж, баримт бичгийн судалгаа, харьцуулсан шинжилгээ болон холбогдох байгууллагын ажилтнуудтай хийсэн ярилцлагын мэдээлэлд тулгуурлав. Судалгааны үр дүнгийн нэгтгэл нь дараах дүгнэлтийг бий болгож байна.

Зоршлогоо хүрсэн түвшний үнэлгээ

Хуулийн зорилт нь "төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг тогтоох" гэж тусгасан боловч энэхүү зорилт хангалттай хэрэгжиж чадаагүй байна. Залуучуудын Засаглалын Индексийн 2020 оны тайланд (Коммонвелс Секретариат) Монгол Улс нийт 181 орноос 58-р байранд жагссан нь дундажаас дээгүүр ч гэсэн ажил эрхлэлт, улс төрийн болон иргэний оролцоо, эрүүл мэнд ба сайн амьдрал гэсэн дэд хэмжигдэхүүнүүдэд тодорхой сул тал илэрч байна. НҮБХХ-с 2021 онд хийсэн судалгааны дүгнэлтэд "хууль, эрх зүй, бодлогын хүрээнд ахиц дэвшил гарч байгаа ч залуучуудын хөгжилд чиглэсэн институцүүдийн эрх, үүргийн давхцал их, санхүүжилт, төсвийн хүрэлцээ сул хэвээр байна" гэж тэмдэглэсэн нь хуулийн зорилт бодит үр дүнд хүрч чадахгүй байгааг нотолж байна.

2024 оны байдлаар тус хуулиар үүрэг хүлээсэн байгууллагуудын тайлагналд хийсэн шинжилгээгээр оролцогч байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа хангалтгүй, хуулийн хэрэгжилт зохицуулалтгүй хэрэгжиж байгаа нь тодорхой харагдав. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн мөн залуучуудын хөгжлийн чиглэлээр тайлагнасан яамдуудын (ЭМЯ, БСШУЯ, ГБХЗХЯ, ХЗДХЯ, ЦДТХЯ, БХЯ) тайлан дэд бүтцийн хэрэгжилтийн мэдээллийг нэгтгэн дүгнэх, үр дүнг хэмжих механизмаар дутмаг байсан нь гол дутагдал болж байна.

Хүлээн зөвшөөрөгдөх байдлын үнэлгээ

Хуулийн 3.1 дэх заалтад тусгасан 15-34 насны хүрээ нь олон улсын харьцуулсан судалгааны дүнгээс харахад хэт өргөн хүрээтэй байна. Судалсан улс орнуудын дотроос ихэнх нь 12-30 насны хүрээг хамарч байна: Шинэ Зеланд, Австрали 12-24 нас, Норвеги 12-25 нас, Швед 13-25 нас, Турк 14-29 нас, Чили, Индонез 15-30 нас. Монгол Улс нийт дунджаас бараг 10 насаар өндөр хүрээ тогтоосон нь залуучуудын хөгжил, оролцоог дэмжих төрийн бодлого хэт хавтгайрч, зорилтот бүлэгтээ үр нөлөөтэй хүрч чадахгүй байгаад нөлөөлж байна. Цаашлаад, Монгол Улсын тухайд 15-18 насны хүрээ Хүүхдийн эрхийн тухай хуулийн хамрах бүлэгтэй ижил байгаа нь хоёр хуулийн хоорондын давхардлыг бий болгож, хариуцлагын чиглэлийг тодорхойгүй болгож байна.

2025 оны байдлаар 15-34 насны хүн ам нийт хүн амын 28.2% буюу 1,014,970 байгаа бол 18-34 насны хүрээнд авч үзвэл 818,573 хүн амьдарч байна. Хуулийн хамрах хүрээг 18-34 насанд тогтоох нь хуулийн давхардлыг арилгаад зогсохгүй бодлогын зорилтот бүлэгт тохирсон, нарийвчилсан арга хэмжээ авах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

Практикт нийцэж байгаа байдлын үнэлгээ

Хуулийн 7 дугаар зүйлд залуучуудын хөгжлийг дэмжих таван чиглэл буюу хувь хүний хөгжил, боловсрол-соёл-урлаг-спорт-шинжлэх ухаан, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй амьдрах орчин гэж тусгасан боловч эдгээрийн хэрэгжилт практикт хүндрэлтэй байна. 2024 онд хийсэн "Хот, хөдөөгийн залуучуудад тулгарч буй асуудал" судалгааны

дүнгээр ажилгүйдэл, боловсролын чанарын асуудал, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, орон сууцны хомсдол зэрэг нь залуучуудын тулгамдсан асуудал болсоор байна.

Онцлон тэмдэглэхэд, уг асуудлуудын ихэнх нь тухайн хуулийг анх хэлэлцэж байсан 2016-2017 оны УИХ-ын нэгдсэн хуралдааны хэлэлцүүлгийн үеэс аль хэдийн тулгамдсан байсан бөгөөд одоо ч хэвээрээ байгаа нь асуудал шийдэгдэж чадаагүй гэдгийг харуулж байна. 2022 онд ЮНЕСКО-ийн захиалгаар хийгдсэн "Залуучуудын дуу хоолой" судалгаанд оролцогчдын 31% нь ажилгүйдлийг залуучуудад хамгийн ихээр тулгамдаж буй асуудал гэж үзсэн байна.

Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааны үнэлгээ

Залуучуудын хөгжлийн төвүүд (ЗХТ) 2016-2017 онд НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр 16 төвөөс эхлэн 2021 оны байдлаар 50 гаруй болтлоо өргөжсөн нь зэрэг хөгжил байв. Гэвч 2024 оны байдлаар зөвхөн 17 аймгийн мэдээллийг харахад нийт үйлчлүүлэгчийн тоо 55,708 болж, аймаг дунджаар 3,277 болсон нь 2022 оны 9,000-10,000-тай харьцуулахад мэдэгдэхүйц буурсан байна. Энэ нь хүний нөөц, санхүүжилт, байр орчны асуудал, байгууллага хоорондын хамтын ажиллагааны сул байдал зэрэг бүтцийн хүндрэлүүдтэй холбоотой байна. Дүрмийн хувьд ч ажилтнуудын мэргэшлийн шаардлага, үйл ажиллагааны үр дүнг үнэлэх механизм, сум-хороо түвшний зохицуулалт тодорхойгүй байна.

Салбар зөвлөлийн тогтолцооны үнэлгээ

Хуулийн 22 дугаар зүйлд Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлэн ажиллуулах, орон нутагт салбар зөвлөл ажиллуулахаар заасан боловч 2025 оны 7 дугаар сарын 9-нд Засгийн газраас "Төрийн хэмнэлтийн" бодлогын хүрээнд Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрмийг хүчингүй болгосон нь хуулийн заалтын хэрэгжилтийг бодитой зогсоосон алхам болов. Залуучуудын хөгжлийн бодлого нь бүх салбарын хамтын ажиллагааг шаарддаг боловч салбар дамнасан нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах тогтолцоо хангалттай бүрдээгүй хэвээр байна.

Олон улсын харьцуулсан судалгааны дүгнэлт

Женевийн Их Сургуулийн 2025 оны судалгааны тайланд Монгол Улстай харьцуулан судалсан улс орнуудын туршлагаас гол дүгнэлтүүд дараах байдлаар нэгтгэгдэж байна. ХБНГУ нь 32 улсаас хамгийн өндөр оноо (5/7) авч, нийгмийн хамгааллын нэгдсэн хуулийн бүтэцтэй уялдуулсан олон шатлалт тогтолцоо, "Jugend-Check" буюу залуучуудад үзүүлэх нөлөөллийн турьдчилсан үнэлгээний механизм, нотолгоонд суурилсан бодлогын тогтолцоогоор дэлхийд тэргүүлж байна. БНХАУ болон ОХУ (тус бүр 3.4/7) нь гурван шатлалт бүтэц, хэрэгжилтийн тайлагналын тогтолцоотой боловч залуучуудын бодлогын институцийн бие даасан байдал харьцангуй хязгаарлагдмал байна. Сингапур бие даасан бичиг хуулгүйгээр хэд хэдэн бодлогын баримт бичиг, институцийн цогц тогтолцоогоор залуучуудын бодлогыг хэрэгжүүлж байна.

Эдгээр туршлагатай харьцуулахад Монгол Улсын ЗХДТХ нь хуулийн зорилт тодорхой ч хэрэгжүүлэх механизм, институцийн тогтолцоо, санхүүжилтийн зохицуулалт дутмаг байна. Хуулийн хамрах хүрээний асуудал, байгууллага хоорондын чиг үүргийн тодорхойгүй байдал, үр дүнг хэмжих шалгуурын дутагдал зэрэг нь хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг бууруулж байгаа гол хүчин зүйлүүд болж байна.

Ерөнхий дүгнэлт

Нэгтгэн дүгнэхэд, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт 2017-2025 оны хугацаанд хуулийн тавьсан зорилтод хангалтгүй хүрч байна. Хуулийн зорилт нь эрх зүйн хэмжээнд тодорхой тусгагдсан ч хэрэгжилтийн механизм, хяналтын тогтолцоо, санхүүжилтийн баталгаа дутмаг байгааг судалгаа харуулж байна. Залуучуудад тулгарч буй хөдөлмөр эрхлэлт, боловсрол, эрүүл мэнд, орон сууц зэрэг гол асуудлууд нь хуулийг баталж хэрэгжүүлж эхэлснээс хойш мэдэгдэхүйц сайжраагүй байгаа нь хуулийн үр дүн хангалтгүйн тодорхой илрэл болж байна. Иймд хуулийн шинэчлэл, хэрэгжилтийн тогтолцооны сайжруулалт зайлшгүй шаардлагатай байна.

4.2. ЗӨВЛӨМЖ

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэсний үндсэн дээр дараах зүйлсийг сайжруулах зүйтэй гэж судлаачдын багийн зүгээс үзэж зөвлөмжийг хэргүүлж байна. Үүнд:

- Хуулийн 3.1 дэх заалтын насны хүрээг 15–34-өөс 18–34 болгон өөрчилж, Хүүхдийн эрхийн тухай хуультай давхардлыг арилгах шаардлагатай. Нэгэн зэрэг хуулийн 1.1 дэх зорилтод "залуучуудын боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх" гэсэн хэмжигдэхүйц зорилтуудыг тусгаж, хуулийн үр дүнг жил бүр хэмжих шалгуур үзүүлэлтийг Засгийн газрын тогтоолоор тогтоох хэрэгтэй.
- Холбогдох яамдын нэгдсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр боловсруулж, хэрэгжилтийг тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хуульчлах нь зайлшгүй.
- Залуучуудын хөгжлийн төвийн орон тооны ажилтны цалинг төрийн үйлчилгээний жишигт нийцүүлэн нэмэгдүүлж, мэргэшлийн тодорхой шаардлагыг дүрмэнд тусгах хэрэгтэй.
- ХБНГУ-ын "Jugend-Check" загварыг үндэс болгон шинэ хуулийн төсөл болон хуульд оруулах нэмэлт өөрчлөлт бүрийн залуучуудад үзүүлэх нөлөөллийг урьдчилан үнэлдэг механизм нэвтрүүлэх шаардлагатай. Энэ нь ЗХДТХ-д хийгдэх шинэчлэлийн төлөвлөгөө суурь болохоос гадна хуулийн хэрэгжилтийг хоёр жилд нэг удаа бие даасан байгууллагаар дүн шинжилгээ хийлгэж Улсын Их Хуралд танилцуулах тогтолцоог ХБНГУ-ын Хүүхэд, залуучуудын тайлангийн загвараар нэвтрүүлэх
- Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн гишүүдийн тодорхой хувийг залуучуудын иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчдөөс бүрдүүлэхийг хуулиар зохиоцгоонож, Сингапурын SG Youth Action Plan загварын адил залуучуудыг бодлогын баримт бичиг боловсруулах үйл явцад шууд оролцуулдаг механизм нэвтрүүлэх хэрэгтэй. Залуучуудын санал, хэрэгцээг тогтмол хугацаанд судлан дүн шинжилгээ нь хийж бодлогын засч залруулалтын үндэс болгох нь хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг бодитой нэмэгдүүлэх гол арга зам болно.

ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ

А. Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль (2017)
- Хууль тогтоомжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2015)
- Боловсролын ерөнхий хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Монгол Улсын Засгийн газар. "Алсын Хараа" 2020-2050. Улаанбаатар, 2019
- Монгол Улсын Засгийн газар. "Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр." Улаанбаатар, 2019
- Монгол Улсын Засгийн газар. "Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030"
- Монгол Улсын Засгийн газар. "Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого 2016-2025"
- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай
- Залуучуудын хөгжлийн зөвлөлийн ажиллах журам

Б. Монгол хэл дээрх ном, судалгаа, тайлан

- Монгол Улсын Засгийн газар, НҮБХС. "МУ-ын Хүний хөгжлийн илтгэл: Нийгмийн сайн сайхны төлөө. МУ-ын хөгжилд Залуучуудын оролцоо 2016." Улаанбаатар, 2016
- С.Туяа. Залуучуудын хөгжлийн төвийн ажлын байрны чиг үүргийн шинжилгээ (урьдчилсан тайлан). 2020. 32 дахь тал
- ЭЙ-АЙ СиЭй ХХК. Хот, хөдөөгийн залуучуудад тулгарч буй асуудал (Судалгааны танилцуулга). 2024. 7 дахь тал
- Н.Хавх. Залуучуудын нийгэм сэтгэл зүйн судалгаа (докторын диссертацийн судалгааны ажил)
- ЮНЕСКО, Залуучуудын дуу хоолой /судалгааны тайлан/, 2022, 32 дахь тал.
- ЮНЕСКО. Монгол улсын боловсролын салбарын тойм шинжилгээ. Улаанбаатар, 2019.

В. Гадаад хэл дээрх ном, судалгаа, тайлан

- Albert Hirschman Centre on Democracy, Geneva Graduate Institute. "Mapping Youth Policies across 32 Countries: Legal Frameworks and Strategies for Education, Employment, and Civic Engagement." Geneva, January 2025
- Commonwealth Secretariat. Youth Development Index 2020. London, 2020

- UNDP Mongolia. Report on Analysis of Youth Conditions in Mongolia. Ulaanbaatar, 2021
- OECD. Youth Policy Reviews and Regulatory Impact Assessment Practices. Paris
- Sozialgesetzbuch (SGB) VIII – Kinder- und Jugendhilfe. Germany
- Kinder- und Jugendstärkungsgesetz (KJStG). Germany, 2021
- Federal Law No. 489-FZ "On Youth Policy in the Russian Federation." Moscow, December 2020
- National Youth Council Singapore. SG Youth Action Plan (SG YAP). Singapore, 2019



МОНГОЛ УЛСЫН СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН
САЙДЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/243

Улаанбаатар хот

Удирдамж, төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.31 дэх зорилтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Залуучуудын хувь хүний манлайлал, ур чадварыг хөгжүүлэх замаар нийгмийн хөгжилд оролцохыг дэмжих "Залуусын оролцоо хөтөлбөр"-ийг улсын хэмжээнд зохион байгуулсугай.
2. Хөтөлбөрийг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Холбогдох арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, тайлагнахыг Биеийн тамир, спорт, залуучуудын бодлого зохицуулалтын газар (Д.Жаргалсайхан)-т үүрэг болгосугай.

САЙД

Ж.АЛДАРЖАВХЛАН



14190010572

“ЗАЛУУСЫН ОРОЛЦОО ХӨТӨЛБӨР”-ИЙН УДИРДАМЖ

1. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Монгол Улсад 2025 оны байдлаар 15-34 насны иргэн 1,015.0 мянга байгаа нь нийт хүн амын 28.2 хувийг эзэлж байна. Залуучуудын боловсрол, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн ур чадвар, нийгмийн идэвх оролцоо, иргэний хариуцлагыг нэмэгдүүлэх нь улсын хөгжлийн бодлогын чухал зорилт юм.

Бүх түвшинд залуучуудын санал хүсэлт, хэрэгцээ, шаардлагыг сонсож хөдөлмөрийн насны хүн ам их байх үеийг зөв зохистой ашиглан эдийн засгаа тэлэх, орлогын өсөлт бий болгоход залуучуудын ур чадварыг сайжруулж, өрсөлдөх чадамжтай болоход дэмжих хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Залуучуудын нийгмийн оролцоо, манлайллыг дэмжсэнээр тэдний утга учиртай, бодит оролцоог нэмэгдүүлж, интерпренершип ур чадварыг нэмэгдүүлэн, залуучуудын нийгмийн сайн сайхны төлөө болон нийтэд тустай, сайн дурын ажил эрхлэх эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, дэмжих нь маш чухал хэрэгцээтэй.

Иймд залуучуудын оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх төрийн бодлогыг сайжруулж, салбар дундын хамтын ажиллагааны уялдааг хангах, төр иргэний нийгэм, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлэх нь цаг үеэ олсон чухал алхам болно.

2. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Монгол Улсын залуучуудын нийгмийн оролцоо, манлайлал, иргэний хариуцлагыг нэмэгдүүлэх замаар тэдний өрсөлдөх чадварыг сайжруулж, тогтвортой хөгжил болон эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах, төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурласан залуучуудын хөгжлийг дэмжих таатай орчин бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

3. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Парламентын ардчилал, түүний үнэт зүйл, хууль тогтоох ажиллагааны талаарх залуучуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, улмаар төрийн бодлого тодорхойлоход тэдний оролцоог хангах;
2. Залуучуудын мэдлэг, ур чадвар, инновац, интерпренершип чадавхыг дээшлүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
3. Иргэний оролцоо, сайн дурын ажил, олон нийтийн санаачилгыг дэмжих механизмыг бий болгох;
4. Залуучуудын хөгжлийн байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулж, хамтын ажиллагааг бэхжүүлэх.

4. ХАМРАХ ХҮРЭЭ, ЗОРИЛТОТ БҮЛЭГ

4.1 Хамрах хүрээ

- 15-34 насны залуучууд;
- Суралцагч, шинээр төгсөгч;
- Ажилгүй болон хөдөлмөр эрхлэлтийн шилжилтийн үеийн залуучууд;
- Орон нутгийн болон эмзэг бүлгийн залуучууд;
- Төр-хувийн хэвшил-төрийн бус байгууллага, олон улсын байгууллага.

5. ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

5.1 Залуучуудын парламент хөтөлбөр

- Залуучууд парламентын боловсрол олгох танхим болон цахим хосолсон хичээлд хамрагдаж хууль тогтоох, шийдвэр гаргах үйл ажиллагааны талаар мэдлэгтэй болно;
- Залуучуудад парламентын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх сургагч багш нарыг бэлтгэнэ;
- Залуучууд өөрсдөд тулгамдсан асуудлынхаа хүрээнд дуу хоолойгоо хүргэх боломжийг олгоно;
- Улсын их хурал нь иргэдэд, тэр дундаа залуучуудад хүртээмжтэй, ил тод байх боломжийг олгоно.
- Үр дүн, туршлага солилцох “Залуучуудын хөгжлийн форум” 2 жил тутамд зохион байгуулах.

5.2 “Залуучуудын Ко:Лаб: Монгол залуусын үр чадвар, оролцоо, нийгмийн интерпренершипийг дэмжих нь”

- Ажил олгогч байгууллагатай уулзалт, дадлага хөтөлбөр;
- Мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалт;
- Төр-хувийн хэвшил-төрийн бус байгууллага-клубүүдийн хамтарсан үйл ажиллагаа;
- Залуучуудын санаачилсан жижиг төслийг шалгаруулан санхүүжүүлэх;
- Төсөл хэрэгжүүлэхэд ментор, зөвлөх үйлчилгээ үзүүлэх.

5.3 “Vol+Plus” сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөр

- Сайн дурын үйл ажиллагааны мөн чанар, ач холбогдол, нийгмийн хувь нэмрийн тухай залуучуудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх
- Байгаль орчин болон нийгэм-хүмүүнлэгийн чиглэлийн сайн дурын ажлаар дамжуулан залуучуудыг бүтээн байгуулалт, хөгжилд татан оролцуулах
- Аймаг, дүүргийн байгууллагуудын сайн дурын үйл ажиллагааны удирдлага, менежментийн чадавхыг бэхжүүлж, нэгдсэн стандартыг нэвтрүүлэх

6. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

- Парламентын ардчилал, түүний үнэт зүйл, хууль тогтоох ажиллагааны талаарх залуучуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлнэ;
- Сайн дурын үйл ажиллагааны үндэсний стандартыг батлуулж, олон нийтийн ойлголт хандлагыг нэгтгэнэ;
- Залуучуудын мэдлэг, үр чадвар, инновац, интерпренершип чадавхыг нэмэгдүүлнэ.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын
сайдын 2026 оны ᠒ дугаар сарын 12-ны
өдрийн ᠕ дугаар тушаалын 2 дугаар хавсралт

“ЗАЛУУСЫН ОРОЛЦОО ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт	Нийт санхүүжилтийн н дүн сая.төг	Тухайн жилд шаардагдах санхүүжилт	Санхүүжилтийн эх үүсвэр	Үндсэн хариуцагч	Хамтран хариуцагч
1	1.1. Парламентын ардчилал, түүний үнэт зүйл, хууль тогтоох ажиллагааны талаарх залуучуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлнэ.	АХ-2.3.3 МҮХТЖҮЧ-4.2.3.1 ЗГҮАХ-2.1.1.30 МУЖХТ-4.2.2.2	1.1.1. Залуучуудын парламент хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрт хамрагдсан залуучуудын н тоо	Тоо	0	50	-	НҮБ-ын Хүн амын сан	УИХ-ын Тамгын газар, НҮБ-ийн Хүн амын сан	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
2	2.1. Сайн дурын үйл ажиллагааны үндэсний стандартыг батлуулж, олон нийтийн ойлголт хандлагыг нэгтгэх.	АХ-2.3.3 МҮХТЖҮЧ-4.2.3.1 ЗГҮАХ-2.1.1.30 МУЖХТ-4.2.2.2	2.1.1. "Vol+Plus" сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Сайн дурын үйл ажиллагааны үндэсний стандартын төслийг батлуулах	Тоо	0	1	7,850,000	Улсын төсөв НҮБ-ийн Хүн амын сан НЭДТГ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	НЭДТГ Монголын сайн дурынхны төв ТББ
3	3.1. Залуучуудын мэдлэг, ур чадвар, инновац, энтрепренершип чадавхыг нэмэгдүүлнэ.	АХ-2.3.3 МҮХТЖҮЧ-4.2.3.1 ЗГҮАХ-2.1.1.30 МУЖХТ-4.2.2.2	3.1.1. "Залуучуудын Ко.Лаб. Монгол залуусын ур чадвар, оролцоо, нийгмийн интерпренершилийг дэмжих нь" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрт хамрагдсан залуучуудын н тоо	Тоо	0	500	250,000,000₮	Улсын төсөв НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр